

“ЦАГДАА-СУДЛАЛ”ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга: С.Жанцан Монгол Улсын Гавъяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор(Sc.D), профессор

Зөвлөлийн гишүүд:

- **Ж.Долгорсүрэн** Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор
- **Б.Пүрэв** Хууль зүйн доктор(Ph.D), хүндэт профессор
- **Ж.Заанхүү** Түүхийн шинжлэх ухааны доктор, (Sc.D), дэд профессор
- **Б.Бат-Эрдэнэ** Хууль зүйн ухааны доктор (Ph.D) , профессор
- **Д. Зүмбэрэлхам** Хууль зүйн ухааны доктор(Ph.D) , профессор
- **Г.Гантөмөр** Хууль зүйн ухааны доктор,(Ph.D), профессор
- **Ж.Болдбаатар** Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор
- **З.Төрмандах** Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

Сэтгүүлийн эрхлэгч: Цагдаагийн сургуулийн захирал Б.Бат-эрдэнэ
Хууль зүйн ухааны доктор\Ph.D\, профессор

Нарийн бичгийн дарга: Г.Бямбадорж докторант

Сэтгүүлийн редакцийн зөвлөл:

- **Т.Бямбаа** Хууль зүйн ухааны доктор(Ph.D)
- **Ц.Нямдорж** Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор
- **Ж.Мөнхболд** Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
- **Т.Оюунчимэг** Хууль зүйн ухааны доктор(Ph.D)
- **К.Женисгүл** Хууль зүйн ухааны доктор(Ph.D)
- **Д.Нямдорж** Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
- **О.Цэцэгмаа** Эдийн засгийн ухааны доктор(Ph.D)
- **Д.Энхжаргал** Хэл шинжлэлийн ухааны доктор\Ph.D\, дэд профессор
- **Д.Мягмарцэрэн** Хууль зүйн ухааны доктор(Ph.D)
- **Ш.Ариунбилэг** Хууль зүйн ухааны доктор(Ph.D)
- **Б.Баянмөнх** докторант
- **Б.Лхагвасүрэн** докторант
- докторант
- **Г.Оюунболд** докторант

Манай хаяг: Дотоод хэргийн их сургууль БЗДүүрэг, Академийн өргөн чөлөө, хилчиний гудамж-1, утас 70155011, 70155039, факс 976-11-70155039

E-mail:ps@uia.mn

DDC
363.2
Б-342

Энэхүү сэтгүүлийг цагдаагийн алба хаагч, эрдэмтэн багш, судлаачид, мэргэжилтнүүд, их дээд сургуулийн оюутан сонсогч, магистрант, докторант хуульч, эрх зүйч, сонирхон уншигч хэн бүхэнд зориулав.

Хэвлэлийн хуудас 13,6 х/х
Цаасны хэмжээ: В5
Хэвлэсэн тоо
Хэвлэсэн газар: “КИТАБ” ХХК

ISBN 978-99962-8882-2-7

АГУУЛГА

1. **С.ЖАНЦАН** ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ЭТГЭЭДИЙГ БАРИВЧЛАХ, СААТУУЛАХ ҮЕД ГЭМ ХОР УЧРУУЛАХ ҮЙЛ ЯВДЛЫН НИЙГМИЙН ХОР АЮУЛЫГ ҮГҮЙСГЭХ НӨХЦӨЛ БАЙДАЛ.....
2. **Б.ЖАРГАЛСАЙХАН** МОНГОЛЫН КРИМИНАЛИСТИКИЙН ТҮҮХИЙН ХУУДАСНАА НЭМЭРЛЭХҮЙ: ХҮН СУДЛАЛЫН ХЭМЖИЛ ЗҮЙН АРГЫГ ХЭРЭГЛЭЖ БАЙСАН БАРИМТ
3. **Ю.БАДАМХАНД** ХҮҮХЭД, НАСАНД ХҮРЭЭГҮЙ ЭТГЭЭД, НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮН ГЭСЭН НЭР ТОМЪЁОНУУДЫГ ХУУЛЬ ТОГТООМЖИД ХЭРЭГЛЭСЭН БАЙДАЛ.....
4. **Р.БАЯРМАГНАЙ** МАНСУУРУУЛАХ БОЛОН СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТАСЛАН ЗОГСООХ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ.....
5. **Г.БЯМБАДОРЖ** АРХИДАН СОГТУУРАХ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ.....
6. **Ж.ГАНБААТАР** ОЙ ХЭЭРИЙН ТҮЙМРИЙН ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГ ХИЙХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ.....
7. **С.ГАНТУЛГА** ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС ИРГЭД ГАЛТ ЗЭВСЭГ, СУМ ХЭРЭГСЭЛ ҮЙЛДВЭРЛЭХ, ЗАХИАЛАХ, ХУДАЛДАХ, ТЭЭВЭРЛЭХ, ЭЗЭМШИХ ЖУРМЫН БИЕЛЭЛТЭНД ТАВИХ ХЯНАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ.....
8. **Б.ЛХАГВАСҮРЭН** ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТОГТОЛЦООНД КРИМИНАЛИСТИКИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ.....
9. **Т.МӨНХДАЛАЙ** ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ БА ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН НИЙГМИЙН АСУУДАЛ.....
10. **Ш. ЧУЛУУН** ОЛОН ХҮНД НӨЛӨӨЛӨХ ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ.....
11. **Б.БАТХУЯГ** НИЙГМИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХАД МОРЬТ ЭРГҮҮЛИЙГ АШИГЛАЖ БАЙГАА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ
12. **Н.БУЯНХҮҮ** ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ХУУЛЬ ЁСНЫ ШААРДЛАГЫГ ҮЛ БИЕЛҮҮЛЭХ, ЗАНАЛХИЙЛЭХ ЗӨРЧЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТҮҮНД ХИЙСЭН СУДАЛГААНЫ ДҮН.....
13. **Р.ГАНТУЛГА** ХЭСГИЙН БАЙЦААГЧИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ
14. **Д.ГАНДОЛГОР** ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС ХАРАА ХЯНАЛТГҮЙ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЖ БҮЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БАЙГАА АСУУДАЛ, ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ.....

15. **Г.НАНСАЛ** МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН ЗАХИРГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТ, ОНОЛ-ПРАКТИКИЙН ЗАРИМ АСУУДАЛ
16. **А.НАСАНЖАРГАЛ** ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧААС НОГДУУЛАХ ЗАХИРГААНЫ ШИЙТГЭЛИЙН ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ.....
17. **М.НЯМЖАРГАЛ** КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ.....
18. **Т.ОЮУНЖАРГАЛ** УТАСЛАГ ЭДЛЭЛД ХИЙХ МЕХАНОСКОПИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ.....
19. **О.ТҮМЭНБАЯР** ХОРИХ ЯЛ ЭДЛЭЭД СУЛЛАГДСАН ИРГЭДЭД ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС ТАВИХ ЗАХИРГААНЫ ХЯНАЛТЫН ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ
20. **С.ТЕЛЕУБЕРДИ** ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ГЭМТ ХЭРГИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗАМУУД.....
21. **Б.ЭРДЭНЭХҮҮ** БИЧИГ СУДЛАЛЫН ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ НОТЛОХ БАРИМТЫН ЭХ СУРВАЛЖ БОЛОХ НЬ.....
22. **Л.И.БЕЛЯЕВА** ЭРҮҮГИЙН ОРЧНЫ НИЙГЭМД ХАРШ СУРГАН ЗҮЙ (орчууллагын нийтлэл).....
23. **Л.И.БЕЛЯЕВА** НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮҮХДИЙГ ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ, ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХ АРГА ЗАМ (орчууллагын нийтлэл).....

**ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ЭТГЭЭДИЙГ БАРИВЧЛАХ, СААТУУЛАХ ҮЕД
ГЭМ ХОР УЧРУУЛАХ ҮЙЛ ЯВДЛЫН НИЙГМИЙН ХОР
АЮУЛЫГ ҮГҮЙСГЭХ НӨХЦӨЛ БАЙДАЛ**

Суурийн Жанцан

ДХИС-ийн ЭШХ-ийн тэргүүлэх ажилтан, хууль зүйн
шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, цагдаагийн хурандаа

Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлуудын түгээмэл төрөл болох энэ институтцийг анх 1961 оны Эрүүгийн хуулийн 9-р зүйлийн “б”-д “Хохирогч буюу бусад хүмүүсээс гэмт хэрэг нэгэнт үйлдсэн этгээдийг засаг төрийн зохих байгууллагад хүргэж өгөх зорилгоор хориглон тогтоохын тулд хүч хэрэглэсэн үйлдэл нь уг хэрэгтнийг хориглон тогтоох аргагүй шаардлагатай байсан ба уул гэмт хэргийн хор аюул, тухайн нөхцөл байдалд тохирч байгаа бол аргагүй хамгаалалттай адилтгаж үзнэ”¹ гэж хуульчилсан байна. энэ заалтаас харахад гэмт хэрэг үйлдсэн этгээдийг түүний халдлагад өртөгдсөн хохирогч болон бусад хүмүүс хуульд заасан зорилгын дагуу хүч хэрэглэж хохирол учруулсан нь хууль ёсны болох нь тодорхой байна. Энэ хуулийн шинэчлэн найруулсан 1986 оны Эрүүгийн хуулийн 12-р зүйлийн 3 дахь хэсэгт “Гэм буруутай этгээдийг саатуулахын тулд хохирогч буюу бусад хүнээс энэ хуулийн тусгай ангид заасан үйлдлийг хийсэн бол аргагүй хамгаалалттай адилтгаж үзнэ”² гэж өөрчлөн найруулав.

2002 оны Эрүүгийн хуулийн 41-р зүйлд анх удаа энэ институцийг тусгайлан хуульчлахдаа “Гэмт хэрэг үйлдсэн этгээд болон оргосон ялтан шинээр гэмт хэрэг үйлдэх боломжийг таслан зогсоох, түүнийг төрийн байгууллагад хүргэхийн тулд баривчлах, саатуулах үед энэ хуулийн тусгай ангид заасан үйлдлийг хийж гэм хор учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй” гэж цоо шинэ агуулгаар хуульчилсан нь гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд халдлагад өртөгдсөн иргэд төдийгүй бусад иргэдийг өргөнөөр татан оролцуулах боломж олгосон чухал зохицуулалт юм.

Гэмт хэрэг үйлдсэн этгээд, оргосон ялтанг дахин гэмт хэрэг үйлдэхийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, тэднийг зохих байгууллагад хүргэхийн тулд аргагүйн эрхээр баривчлах, саатуулах үйл ажиллагааны явцад тэдэнд гэм хор учруулах нь ямагт нийгэмд ашигтай, хууль ёсны үйлдэл байдаг.

Гэмт хэрэг үйлдсэн этгээд, оргосон ялтныг баривчлах нь аргагүй хамгаалалттай дор дурдсан шинжүүдээрээ төсөөтэй. Үүнд:

а/ Үйл явдлын нийгмийн хор аюулыг үгүйсгэх эдгээр нөхцөл байдлуудыг хэрэгжүүлэх үндэслэл нь хүний хууль бус зан үйл байна.

б/ Хоёр нөхцөл байдал Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхолд хор хохирол учруулах довтолгоон гэмт үйлдлийн эсрэг чиглэсэн байдаг

в/ Баривчлах, албадан саатуулах, хамгаалах ажиллагааг хэрэгжүүлж байгаа хүмүүсийн зан байдал, үйлдэл гадна байдлаараа гэмт хэрэгтэй төсөөтэй байна.

г/ Дээр дурдсан хоёр нөхцөл байдал нь нийгэмд ашигтай зорилгод үндэслэгдсэн байдаг.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах албадан саатуулах нь эрх зүйн мөн чанар, агуулгаараа хамгаалалтаас ялгагдана. Албадан саатуулах баривчлах үйл ажиллагааг зөвхөн гэмт хэрэг үйлдэгдсэн дор нь эсхүл хэсэг хугацааны дараа явуулдаг бол аргагүй хамгаалалтыг нийгэмд аюултай халдлага эхэлсэн, дуусаагүй, үргэлжилж байгаа үед хэрэгжүүлнэ. Баривчлах, албадан саатуулах нь гэмт хэрэг үйлдсэн этгээд, оргосон ялтны шинээр гэмт хэрэг үйлдэх боломжийг таслан зогсоох, төрийн байгууллагад хүргэх зорилготой байдаг бол аргагүй хамгаалалтыг хуулиар хамгаалагдсан эрх ашиг, сонирхолд тулгарсан бодит заналхийлэл, довтолгооныг няцаах

¹ Д.Адъяабазар. Монгол Улсын 1921 оноос хойшхи эррийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ.,1998. 152-153 дахь тал

зорилгоор хэрэгжүүлдэг. Албадан саатуулах баривчлах санаачлага ямагт ийм эрхтэй этгээдээс гардаг бол аргагүй хамгаалалтын үед хамгаалагч өөрийн санаачлагаар бус аргагүйн эрхэнд халдагчид хохирол учруулахад хүрдэг. Албадан саатуулах, баривчлах үед гэмт хэрэг үйлдсэн этгээд, оргосон ялтаны хууль бус үйлдлийг өөр аргаар зогсоох боломжгүй тохиолдолд гэм хор учруулдаг бол хамгаалагч төрийн байгууллага, бусад хүмүүст халдах боломжтой байсан эсэхээс хамааралгүй хамгаалалт хийж гэм хор учруулдаг.

Гэмт хэрэг үйлдсэн этгээд гэж Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан ямар нэгэн гэмт хэргийг үйлдэж дууссан хүнийг ойлгоно.

Оргосон ялтан гэдэгт Эрүүгийн хуулийн 48-53-р зүйлд заасан үндсэн ба нэмэгдэл ял шийтгэсэн шүүхийн тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш ял эдлэхээс санаатай зайлсхийсэн этгээдийг ойлгоно.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хуульд заасан зорилгоор баривчлах, албадан саатуулах эрхийг бүх иргэд эдлэх бөгөөд тагнуул, цагдаа, дотоодын цэрэг, ШШГБ, Онцгой байдлын болон авилгатай тэмцэх байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд, харуул хамгаалалтын ажилтнуудын хувьд эрх төдийгүй, хууль тогтоомжийн бусад актаар хуулиар хүлээлгэсэн заавал биелүүлэх үүрэг байдаг.²

Иргэд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, албадан саатуулах ажиллагааг холбогдох төрийн байгууллагад хандах боломж байсан эсэхээс үл хамааран бие даан хэрэгжүүлэх эрхтэй. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цаг алдалгүй шуурхай баривчлах, албадан саатуулснаар холбогдох эрх бүхий байгууллага, түүнийг эрүүгийн хариуцлагад татах боломж бүрдэнэ.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цаг алдалгүй баривчлаагүй, албадан саатуулаагүйгээс гэмт хэрэгтэнг оргон зайлах, нуугдах боломжтой болгож гэмт хэргийн үл мөрийг баллах,зэвсэг хэрэгсэл, гэмт хэргийн замаар олсон мөнгө, эд зүйлийг нуух,гэрчүүдэд сөрөг нөлөө үзүүлэх, цаашилбал, гэмт үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх зэрэг хортой үр дагавар үүсгэдэг.

Холбогдогч нь тогтоогдоогүй гэдэг үндэслэлээр түдгэлзэгдсэн хүнийг алсан 100 гаруй хавтаст хэргийг судалж үзэхэд 48 этгээд оргож явахдаа 140 хэргийг шинээр үйлдсэн нь тогтоогдлоо. Энэ нь гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд оргон зайлах явдал ихсэж байгааг харуулж байна.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн 33.2 хувийг иргэд, өөрөөр хэлбэл, хохирогчид, 10.2 хувийг хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчид, 6.4 хувийг мэргэжлийн хяналтын болон байгаль хамгаалах байцаагчид, 40.2 хувийг хууль сахиулах байгууллагын ажилтнууд баривчилсан, албадан саатуулсныг бидний судалгаа харууллаа. Энэ нь гэмт хэрэгтэй тэмцэхэд иргэд, байгууллагын оролцоо ямар чухал болохыг нотолж байна.

ЭБШХ-ийн 58-р зүйлийн 1 дэх хэсэгт “Сэжигтэн оргон зугтахыг завдсан, эсхүл хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдэх хангалттай баримт байгаа бол түүнийг баривчлана”, 59-р зүйлийн 1 дэх хэсэгт “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь сэжигтнийг баривчлах тухай тогтоол үйлдэж, түүнийг прокурорт хүргүүлэх бөгөөд прокурор нь шүүхэд танилцуулж батлуулна” гэж сэжигтэнг баривчлах эрх зүйн үндэслэлийг заасан.³

Гэхдээ энэ нь гэмт хэрэг үйлдсэн этгээд, оргосон ялтанг баривчлах, албадан саатуулах нь харилцан адилгүй ойлголт юм. Сэжигтэнг хуульд заасан үндэслэлээр баривчлах ажиллагаанд зөвхөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч оролцдог бол гэмт хэрэг үйлдсэн этгээд, оргосон ялтныг хохирогч, бусад иргэд хууль сахиулах байгууллагын ажилтан хэн боловч баривчлах эрхтэй.

Баривчлах ажиллагаа гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн этгээд, оргосон ялтан, сэжигтэн, яллагдагч, ялтанг саатуулах, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, түүнчлэн тэдгээрийг төрийн холбогдох байгууллагад хүргэх зорилгын

² Төрийн мэдээлэл. 1993. №8. 947 дахь тал; Төрийн мэдээлэл. 1994. №1. 6 дахь тал

³ Монгол Улсын хуулиуд. УБ.,2002. 4, 25 дахь тал

хүрээнд хохирогч, бусад иргэд, эрх бүхий албан тушаалтнуудаас хэрэгжүүлж буй идэвхтэй үйлдэл юм.

Хууль зүйн магистр Б.Намсрай, баривчлах ажиллагааг хэрэгжүүлж байгаа субъектүүдийн эрх зүйн байдлыг харгалзан:

а/ Нийтлэг баривчлах ажиллагаа

б/ Тусгай баривчлах ажиллагаа гэж ангилжээ.⁴

Нийтлэг баривчлах ажиллагааг иргэд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 10-р зүйлд заасан эрх, үүргийнхээ дагуу хэрэгжүүлнэ. Энэ хуулийн 10-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар иргэд:

- Нийгмийн хэв журам сахихыг бусдаас шаардах
- Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд шаардлага тавих
- Архидан согтуурч нийгмийн хэв журмын зөрчил гаргаж буй этгээдийг эрүүлжүүлэх байргүй газар амь нас, эрүүл мэндэд нь хохирол учруулахгүйгээр эрүүлжүүлэх, үйлдлийг нь таслан зогсоох арга хэмжээ авах /баривчлах нэгэн адил хамаарна. С.Ж/
- Гэмт халдлагаас эд хөрөнгө, өөрийн буюу бусдын амь нас, эрүүл мэндийг хуулийн хүрээнд хамгаалах эрхийг хэрэгжүүлдэг.⁵

Иргэд гэмт хэрэгтэй тэмцэх үүргээ хэрэгжүүлсэн олон тохиолдол байдаг. Жишээ нь, Иргэн Р байрны орцын жижүүр хийхдээ байрныхаа эргэн тойронд эргүүл хийж явахад хоёр согтуу залуу нэг танхай хүүхдийг барьж аваад зодож байхтай тааралдаж үйлдлээ зогсоохыг шаардахад “Чамд хамаагүй”, “Бусдын хэрэгт хошуу бүү дүр”, “Чамайг ч бас ингэнэ” гэж сүрдүүлээд хохирогчийг зодож гэмтээгээд зугтахад нь араас нь барьж хөөж аваад нэгд хүндэвтэр гэмтэл учруулан баривчилжээ. Иргэн Р-ийн үйлдлийг хуулийн хүрээнд баривчлах үйл ажиллагаа явуулсанд тооцжээ.

Тусгай баривчлах ажиллагааг цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, авилгатай тэмцэх байгууллагын ажилтнууд хуульд заасан үндэслэл, журмыг баримтлан хэрэгжүүлдэг. Тусгай баривчлах ажиллагааны эрх зүйн үндэс нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан тушаал, заавар, дүрэм байна. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 24-р зүйлийн 1 дэх хэсэгт “... Цагдаагийн эрх бүхий алба хаагч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах эсэхийг шийдвэрлэхийн тулд хойшлуулшгүй үйл ажиллагаа явуулж болно” гэж заасан. Хойшлуулшгүй үйл ажиллагаа явуулахад саад учруулсан, гэмт хэрэг үйлдсэн нь илэрхий байгаа, зугтан зайлах оролдлого хийсэн этгээдийг түр хугацаагаар саатуулах буюу баривчилж болно. Тагнуулын байгууллагын тухай хуулийн 27-р зүйлийн 3 дахь хэсэгт тагнуулын ажилтан гэмт үйлдэл, эрх зүйн бусад зөрчлийг таслан зогсоох, түүнийг өдүүлсэн этгээдийг баривчлан албадан саатуулах үүргээ өөр аргаар биелүүлэх боломжгүй бол биеийн хүч, гардан тулааны мэх хэрэглэж болно. Мөн зүйлийн 4.1-д нэг бүрийн, 4.3-д хамгаалах тусгай хэрэгсэл, 5-р хэсэгт заасан тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болохыг хуульчилсан.⁶

Жишээ нь, 1996 оны 1-р сарын 2-3-нд шилжих шөнө Авдрантын онцгой дэглэмтэй хорих ангиас Лхагвасүрэн, Чулуунбаатар нарын рецидив ялтнууд тэнд ял эдэлж байсан эмэгтэй Цагаанмаам, Бямбасүрэн, хоёр харуулын хянагчийг хүлж хаяад эмнэлгийн сувилагчийг барьцаалан оргосон байна. Оргосон ялтнууд Төв аймгийн Баянчандмань сумын нутгийн ой модтой ууланд зэвсэглэж бүгж байхад цагдаа, тагнуул, дотоодын цэргийн хүч нэмэгдүүлсэн баривчлах бүлэг баривчлах саатуулах ажиллагааг оргосон ялтнуудад ямар нэг хохирол учруулахгүйгээр явуулах оролдлого хийсэн боловч тэд зэвсэглэж эсэргүүцсэн тул галт зэвсэг хэрэглэж ялтнуудын нэгийг нь газар дээр нь буудсан. Нэг нь баривчлагдаж ирээд шархаа даалгүй нас барсан. Энэ тохиолдолд

⁴ Б.Намсрай. Дурдсан зохиол. УБ.,2003. 45 дахь тал

⁵ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. УБ.,2008. 80 дахь тал

⁶ Тагнуулын үйл ажиллагаанд холбогдох хуулийн эмхтгэл. УБ.,2003. 81, 82 дахь тал

баривчлах бүлгийн явуулсан ажиллагааг тэр үеийн Эрүүгийн хуулийн 12-р зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцөлийг харгалзан нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдал гэж үзсэн болно.

Гэмт хэрэг үйлдсэн тухай үндэслэлтэй мэдээлэл авагдсан, гэмт хэрэгтэн этгээдийг баривчлах, саатуулах ажиллагаа явуулж байна гэж итгэл төгс байгаа нөхцөлд хууль ёсны болох юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 35-р зүйлд гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдэд эрүүгийн хэрэг үүсгэж, сэжигтнээр тооцох үндэслэлүүдийг тодорхой заасан. Тухайлбал:

а/ Уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдсэн дор нь барьсан /ЭБШХ-ийн 35.1.1/

б/ Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан /ЭБШХ-ийн 35.1.2/

в/ Уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон /ЭБШХ-ийн 35.1.3/

г/ Уг этгээд хэргээ илчлэн ирсэн /ЭБШХ-ийн 35.1.4/

д/ Гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол /ЭБШХ-ийн 35.1.5/

е/ Гэмт хэрэг үйлдээд оргон зайлсан эсхүл оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанг эрэн сурвалжлах тухай тогтоол гарсан

ё/ Үйлдсэн гэмт хэрэгт нь ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол гарсан зэрэг тохиолдолд баривчилна.

Саатуулах⁷ гэдэг гэмт хэрэг үйлдсэн нь тодорхой болсон, оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанг хуульд заасан үндэслэл, шаардлагаар эрх чөлөөг нь хязгаарлахыг хэлнэ. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 24-р зүйлийн 1 дэх хэсэгт “Хүний нэр, насыг тодруулах зорилгоор бичиг баримтыг шалгах”, 2 дахь хэсэгт “Хүний бие, тээврийн хэрэгсэл, ачаа тээшинд үзлэг хийх”, 5 дахь хэсэгт “Шүүх эмнэлэг криминалистикийн болон бусад шинжилгээнд зориулж дээж, хуруу, мөрний хэв авах”, 6 дахь хэсэгт “Согтууруулах ундаа, мансууруулах, хордуулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах” зэрэг зорилгоор саатуулж болно. Эдгээр ажиллагааг хэрэгжүүлэхэд холбогдох этгээд хүч хэрэглэж эсэргүүцсэн тохиолдолд эрх бүхий албан тушаалтан түүнд гэм хор учруулсан нь гэмт хэрэг болохгүй юм. Дээр дурдсан хуулийн 24-р зүйлийн 3 дахь хэсэгт “Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдсэнд сэрдэгдсэн этгээдийн хаягийг тодруулах, албадан саатуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоохын тулд уул этгээдийг 6 цаг хүртэл хугацаагаар түр саатуулж болно” гэж заасан саатуулах ажиллагааны гол эрх зүйн үндэслэл юм.

Монгол улсын Хилийн тухай хуулийн 33-р зүйлийн 9-р зүйлд “Хэрэг бүртгэх эрх бүхий албан тушаалтан улсын хилийн болон хил орчмын дэглэм зөрчсөн этгээдийг тэмдэглэл үйлдэх зорилгоор гурван цаг хүртэл, зөрчил гаргагчийн хувийн байдлыг тогтоох, зөрчлийн шинж байдлыг тодорхойлохын тулд энэ тухай прокурорт мэдэгдэж гурав хоног хүртэл, хэрэг зөрчил гаргагчийн хувийн байдлыг нотлох баримт бичиггүй тохиолдолд прокурорын зөвшөөрөлтэйгээр 10 хоног хүртэл хугацаагаар албадан саатуулах эрхтэй”⁸ гэж заасан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10-р зүйлийн 2 дахь хэсгийн 3-д иргэн хүн “Архидан согтуурч, нийгмийн хэв журмын зөрчил гаргаж байгаа /гэмт хэрэг үйлдсэн С.Ж/ этгээдийг эрүүлжүүлэх байргүй газар амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахгүйгээр эрүүлжүүлэх, үйлдлийг таслан зогсоох арга хэмжээ авах эрхтэй”-г заасан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 9-р зүйлийн 1 дэх хэсгийн 5-д

⁷ Я.Цэвэл. “Саатах”-ыг ажил явдалд саад тохиолдох, саад учирсан, “саатуулах”-ыг саатахын үйлдлэл хэв, саад учруулах, “зогсоох” гэж тайлбарласан. Дурдсан зохиол. УБ.,1966. 457 дахь тал

⁸ Тагнуулын байгууллагын ажиллагаанд холбогдох хуулиудын эмхтгэл. УБ.,2003. 128 дахь тал

цагдаагийн байгууллага “Шаардлагатай гэж үзвэл хүчирхийлэл үйлдэгчийг хууль тогтоомжийн дагуу албадан саатуулах”⁹ эрхтэйг заасан.

Дээр дурдсан хуулийн холбогдох заалтууд нь саатуулах ажиллагааны эрх зүйн үндэслэл болох ёстой гэж үзэж байна. Үүнтэй холбогдуулан Эрүүгийн хуулийн 41-р зүйлд зөвхөн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах боломжтой гэж заасан хэтэрхий өрөөсгөл амьдралаас тасархай зохицуулалт болсон учир эрх зүйн зөрчил, гэмт хэрэг үйлдсэнд үндэслэлтэй сэжиглэгдэж байгаа, оргон зайлахыг завдсан этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулсан бол нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдал болохоор өөрчлөн найруулах шаардлагатай.

Баривчлах, саатуулах ажиллагааны үед холбогдох этгээд бие махбодын болон материалын хохирол учруулдаг, зарим тохиолдолд түүний амь насанд хүрэх үе байдаг учир нэг талаас, баривчлах, саатуулах ажиллагаа хуульд нийцсэн байх нөхцөл, нөгөө талаас баригдаж байгаа этгээдэд учруулсан хохирол хууль ёсны байх гэсэн хоёр талын нөхцөлүүд нэгэн зэрэг хангагдсан байх шаардлагатай юм.

Баривчлах ажиллагааны хууль ёсны байх нөхцөлүүд /шаардлага/. Үүнд:

Нэг. Гэмт хэрэг үйлдсэн этгээд, оргосон ялтанг баривчлах саатуулах ажиллагаа нь нийгэм, иргэдийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах, хангах, өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн этгээд, оргосон ялтан шинээр гэмт хэрэг үйлдэх боломжийг таслан зогсоох, түүнийг төрийн байгууллагад хүргэж гэм буруутай эсэхийг шийдвэрлүүлэх зорилгоор хэрэгжинэ.

Гэмт хэрэг гэдэг нь Эрүүгийн хуулийн 1.16-р зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, төрийн байгууллагын хэвийн ажиллагаа, нэр хүнд, мэдээллийн аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, нийгмийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, цэргийн эрх зүйн журам, энхтайван, хүн төрөлхтний аюулгүй байдалд халдсан, гэмт хэрэг үйлдсэн, оргосон ялтан баривчлах, саатуулах ажиллагааг эсэргүүцэх, улмаар хүч хэрэглэж довтолсон бол тэдэнд аргагүй хамгаалалт хийх шаардлагатай болно.

Баривчлах, саатуулах үед холбогдох этгээдэд гэм хор учруулах нь үйлдсэн гэмт хэргийн хүнд, хөнгөн, гэм буруугийн хэлбэр ямар байхаас огт хамааралгүй юм. Үүнтэй холбогдуулан зарим судлаачид зөвхөн хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах ёстой.¹⁰ Тэдгээрийн эсрэг нэг хэсэг судлаачид болохоор болгоомжгүйгээр болон хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах шаардлага байхгүй¹¹ гэж өөр өөрөөр үзэж байгааг зөвшөөрөх боломжгүй юм.

Эрүүгийн хуульд хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй юм. Хууль тогтоогч Эрүүгийн хуулийн 41-р зүйлд “Гэмт хэрэг үйлдсэн этгээд” гэж онцолсон учир захиргааны болон бусад эрх зүйн зөрчил гаргасан этгээдийг баривчлах, саатуулах асуудал хамаарахгүй байгааг дээр дурдсанаар эргэж харах шаардлагатай.

Иргэд, хууль сахиулах байгууллагын ажилтнууд ихэнх тохиолдолд хүнийг гаднаас нь хараад гэмт хэрэг үйлдсэн этгээд гэж таних нь төдийдөн боломжгүй юм. Түүнчлэн иргэд, албан тушаалтнууд гэмт хэрэг үйлдээгүй хүнийг баривчлах саатуулахдаа гэм хор учруулах тохиолдол гарахгүй гэх баталгаа байхгүй юм. Гэмт хэрэг үйлдээгүй байхад андуурлын улмаас баривчилж гэм хор учруулбал бодит байдлын асуудалд хамаарах үндэслэлээр асуудлыг шийдвэрлэнэ. Иймд “Гэмт хэрэгт үндэслэлтэй сэрдэгдсэн этгээд” гэж хуульчлах нь илүү оновчтой байна. учир нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болохыг зөвхөн шүүх нотлох үүргийг хүлээнэ. Энэ талаар Эрүүгийн

⁹ Цагдаагийн байгууллагын ийл ажиллагаанд холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. УБ.,2008. 98 дахь тал

¹⁰ И.С.Тишкевич. Условия и пределы необходимой обороны. М.,1969. 184 дэх тал; Л.Бат-Очир. Дурдсан зохиол. УБ.,2007. 15 дахь тал

¹¹ В.И.Ткаченко. Дурдсан зохиол. М.,1970. 39 дэх тал; Kenny. Outlines of criminal law. 1965. P.64

хуулийн 4-р зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээнэ” гэж тодорхой заасан.

Иймд бидний дээр дурдсан ЭБШХ-ийн 35-р зүйлд заасан үндэслэлүүд нь тодорхой хүнийг гэмт хэрэг үйлдсэн болохыг баталж байгаа бөгөөд тэр чанараараа баривчлах, саатуулах ажиллагааг хуульд нийцсэн гэж үзэх үндэслэл болж байгаа юм.

Оргосон ялтан гэдэг нь үйлдсэн гэмт хэрэгтээ хорих болон хорихоос бусад төрлийн ял шийтгүүлсэн, тухайн ялаа эдлэхээс зайлсхийх зорилгоор хорих анги, баривчлах байрнаас эргэж ирэхгүйгээр бүрмөсөн явсан, түүнчлэн хорихоос бусад төрлийн ял эдлэхтэй холбогдон үүссэн үүргээ биелүүлэхээс ноцтой зайлсхийсэн этгээд юм.

Хоёр. Баривчлах албадан саатуулах ажиллагаа хууль ёсны байх нэг нөхцөл бол цаг үеэ олсон байх явдал юм.

Гэмт хэрэг үйлдсэн этгээд, оргосон ялтныг баривчлах ажиллагааг гэмт хэрэг үйлдсэн дор нь төдийгүй түүнд бэлтгэх болон завдах урьдчилсан шатанд цаг алдалгүй хэрэгжүүлэх хойшлуулшгүй ажиллагаа байдаг. Хойшлуулшгүй ажиллагаа гэдэг нь гэмт хэргийн тухай мэдээ авсан үеэс цаг алдалгүй гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтооход чиглэгдсэн цагдаагийн байгууллагын албадаас хэрэгжүүлдэг цогц ажиллагаа юм. Энэ ажиллагааны үр дүнд гэмт хэрэг үйлдэх бололцоо нөхцөлийг таслан зогсоох, гэмт хэрэг үйлдэхээр санаархаж бэлтгэж болон завдаж буй үйлдлийг урьдчилан сэргийлж, таслан зогсоох зорилтыг шийдвэрлэх бололцоотой.¹²

Хэрэв тухайн этгээд зугтаж амжсан бол гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хуулийн 72-р зүйлийн 1 дэх хэсгийн 1-4-д зааснаар:

а/ Хөнгөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш зургаан сар өнгөрсөн

б/ Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн

в/ Хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван таван жил өнгөрсөн

г/ Онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин таван жил өнгөрсөн бол түүнийг эрүүгийн хариуцлагад татах хугацаа өнгөрсөн гэж үзэх учир гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, албадан саатуулахгүй. Зөвхөн дээр дурдсан хугацааны дотор л баривчлах, саатуулах ажиллагаа хууль зүйн үндэслэлтэй байна.

шүүхийн шийтгэх тогтоолоор хорих болон хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан оргон зайлсан тохиолдолд Эрүүгийн хуулийн 76-р зүйлийн 1 дэх хэсгийн 1-4-д заасан шийтгэх тогтоол биелүүлэх хугацаа өнгөрсөн бол түүнийг баривчлах, албадан саатуулах шаардлага /эрх/ дуусгавар болно.

Учир нь хууль тогтоогч Эрүүгийн хуулийн 41-р зүйлд баривчлах, саатуулах тухай заахдаа гэмт хэргийн ангилал, гэм буруугийн хэлбэр, гэмт хэрэг үйлдсэн этгээд, оргосон ялтны хувийн байдалтай холбоотой ямар нэгэн зохицуулалт хийгээгүй байгаа нь бидний үндэслэлийг давхар нотолж байна. тухайлбал, гэмт хэрэгтэй тэмцэх ажлын практикт тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, техник ашиглалтын журмыг зөрчсөнөөс болгоомжгүйгээр хүний амь хохироосон, бусад хүнд хор уршиг учруулсан этгээдийг баривчлах явцад гэм хор учруулах тохиолдол түгээмэл байдаг.

Гурав. Баривчлах, албадан саатуулах ажиллагаа хууль ёсны байх нэг нөхцөл бол гэмт хэрэг үйлдсэн этгээд, оргосон ялтан цагдаагийн байгууллагад очих, хүргэгдэх шаардлагыг илт эсэргүүцсэн, биелүүлэхээс эрс татгалзсан, баривчлах саатуулах ажиллагааг хэрэгжүүлж байгаа хүмүүст хүч хэрэглэж зодсон, хэргийн газраас зугтан зайлахыг элдэв аргаар оролдсон, зэвсэг тусгай хэрэгсэл хэрэглэхийг урьдчилан сануулсаар байхад эсэргүүцсэн тохиолдолд түүнийг баривчлах, саатуулах шаардлагатай болно. Хүч хэрэглэж эсэргүүцээгүй, оргон зугтахыг завдаагүй, тавьсан шаардлагыг биелүүлж байхад баривчлах, саатуулах нэрийн дор тухайн этгээдэд гэм хор учруулж хэрхэвч болохгүй. Энэ талаар хууль зүйн магистр Б.Намсрай “Баривчлах ажиллагааг хэрэгжүүлэхэд хувийн ашиг сонирхол, үзэл бодлыг баримтлах нь баривчлах ажиллагааны шаардлагад хориглох ба баривчлах ажиллагаа хууль ёсны байх шинж

¹² Х.Доржпалам, Ж.Сайнжаргал. Гэмт хэрэг илрүүлэх хойшлуулшгүй ажиллагаа. УБ.,1996. 8 дахь тал

чанарыг алдагдуулна. Хувийн өш хонзонгоор гэм буруугүй хүнийг баривчлан саатуулах явцад гэм хор учруулах нь үйлдлийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл болохгүй”¹³ гэж бичсэн нь үндэслэлтэй юм.

Проф Г.Совд “Хүчирхийлсэн ажиллагаа нь хүний эрхэнд халдах эрхийг олгож байгаа учраас далимдуулсан ажиллагаа байж болохгүй. Өөрөөр хэлбэл, хүн алсан гэмт хэрэгтнийг саатуулахын тулд алж болохгүй гэсэн үг. Гэтэл аргагүй хамгаалалтын үед хүн алах довтолгооны эсрэг хамгаалалт хийж довтлогчийг алсан тохиолдол байж болдог”¹⁴ гэж оновчтой бичжээ.

Баривчлагдаж, саатуулагдаж буй этгээдэд хамаарах нэг дэх нөхцөл /шаардлага/ бол тэр этгээд гэмт хэрэг үйлдсэн болон оргон зайлах, гэмт хэрэг шинээр үйлдэх нь үндэслэлтэй тогтоогдож байгаа явдал юм.

Гэмт хэрэг үйлдсэн этгээд, оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанд тухайн үед хүч хэрэглэхгүй, бие махбодод нь гэмтэл учруулахгүйгээр баривчлах, албадан саатуулах ямар ч боломжгүй байх нь бас нэг биеэ даасан нөхцөл юм.

Баривчлах саатуулах ажиллагааны явцад баривчлагдаж, саатуулагдаж байгаа этгээдэд гэм хор учирсан байх нь нэг биеэ даасан нөхцөл болдог. Энэ үед учруулсан хохирол нь хуульд нийцсэн байх ёстой. Эрүүгийн хуулийн 41-р зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэн этгээд, оргосон ялтанг хуульд заасан зорилгоор баривчлах саатуулах үед энэ хуулийн тусгай ангид заасан үйлдлийг хийж гэм хор учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй” гэж шууд зааж байна.

“Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан үйлдэл” гэдгийг тус хуулийн бүлэг, зүйл, хэсэгт заасан, тухайлбал, хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учруулах, бусдын эд хөрөнгийг эвдэх, устгах гэх мэт материаллаг гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжүүдийг агуулсан үйлдэл /эс үйлдэхүй/ гэж ойлгох нь зүйтэй.

“Гэм хор” гэдэг ойлголт нь хор уршигын нэг төрөл юм. Хор уршиг гэдгийг Улсын дээд шүүхийн 2003 оны 07 сарын 09-ний өдрийн зөвлөмжид “Эрүүгийн хуулийн тусгай ангийн тухайн зүйл, хэсэгт гэмт хэргийн шинж /бүрэлдэхүүний С.Ж/ болгон заасан нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бий болсон үр дагавар”¹⁵ гэж заажээ.

“Гэм хор” гэдгийг Я.Цэвэл “Гэм” - ёс зүйгээс ангид хийсэн явдал, түүний уршиг, үр нөлөө¹⁶, “Хор” - хөнөөл аюул зовлон¹⁷ гэж тайлбарласан байдаг.

“Гэм хор” гэдгийг проф Т.Мөнхжаргал “тодорхой этгээдийн эрх зөрчигдсөнөс түүнд бий болсон эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус сөрөг үр дагавар юм. Үүнд эд хөрөнгө устгасан, гэмтээсэн, иргэний эрүүл мэндэд гэмтэл учруулснаас эмчилгээний зардал гарсан, цалин дутуу авсан, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас олох ёстой байсан орлого алдагдсан, зарлага гарсан, биеийн болон сэтгэл санааны шаналал зэрэг ордог”¹⁸ гэж тайлбарлажээ.

Гэм хорыг судлаачид “Материаллаг болон материаллаг бус гэж ангилан авч үздэг бөгөөд материаллаг гэдэгт алдагдал, олох байсан орлого, зардлыг, харин материаллаг бус гэдэгт амь нас, эрүүл мэндийг хохироосон, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан зэрэг үнэ өртөгөр илэрхийлэгддэггүй, хохирогчийн санаа сэтгэлийн дарамтанд оруулсан үр дагаврыг ойлгоно. Энэ нь хохирогчийн амин хувийн болон эд хөрөнгийн эрхийг ямар нэгэн байдлаар зөрчсөн явдлаар илэрдэг”¹⁹ гэж үзсэн байна.

Эрүүгийн хуулийн 41-р зүйлд заасан гэм хор нь баривчлагдаж, саатуулагдаж буй этгээдийн хувьд бол материаллаг бус, дээрх ажиллагаа явуулах үед өртөгдсөн гуравдагч этгээдэд бол материаллаг ба материаллаг бус гэм хорын аль алин нь учрах магадлалтай юм.

¹³ Б.Намсрай. Дурдсан зохиол. УБ.,2003. 49 дэх тал

¹⁴ Г.Совд. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ.,2002. 56 дахь тал

¹⁵ Улсын Дээд шүүхийн мэдээлэл. УБ.,2004. 01

¹⁶ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.,1966. 169 дэх тал

¹⁷ Мөн бигээлийн 272 дахь тал

¹⁸ Т.Мөнхжаргал. Иргэний эрх зүй. Тусгай анги. УБ.,1997. 48 дахь тал

¹⁹ Д.Наранчимэг. Иргэний эрх зүйн индсэн асуудал. УБ.,1999. 89 дэх тал

Гэмт хэрэг үйлдсэн этгээд, оргосон ялтанг төрийн холбогдох байгууллагад хүргэх, дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг таслан зогсоох зорилгоор хийгдсэн баривчлах, саатуулах ажиллагааны үед гэм хор зөвхөн баривчлагдаж, саатуулагдаж байгаа этгээдэд учирсан байх ёстой. Гэмт хэргийг албадан саатуулах үед гэм хор аргагүйдэж учруулах нь төр, засгийн байгууллагад хүргэх гэхэд эрс татгалзсан, идэвхтэй эсэргүүцэл үзүүлсэн үед хийгдсэн байх ёстой.

Хөндлөнгийн бусад хүмүүст гэм хор учруулсан бол хариуцлагын асуудлыг хэрэг гарах үеийн нөхцөл байдлыг харгалзан нийтлэг үндэслэлээр буюу гарцаагүй байдлын нөхцөлөөр шийдвэрлэнэ. Үүнтэй холбогдуулан профессор Н.Жанцан “Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах явцад учруулах гэм хор зөвхөн оргон зайлсан ялтан, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хамаарахгүй. Иргэдээс гэмт хэрэг үйлдэх гэж байгаа хүмүүсийг хорьсон, үйлдлийг нь таслан зогсоосны улмаас хохирсон хүмүүс байдаг”²⁰, хууль зүйн магистр Б.Намсрай “Баривчлах ажиллагааны явцад урьдчилан төлөвлөгдөлгүйгээр бий болсон бүхий л хор уршгийг гэмт хэрэг үйлдсэн этгээд, оргон зайлсан ялтанг баривчлан саатуулах үед гэм хор учруулах асуудалд хамруулна. Хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээд, оргон зайлсан ялтанг баривчлах, саатуулах явцад зөвхөн гэмт хэрэг үйлдсэн этгээд төдийгүй, гэмт хэрэгт огт хамаарахгүй иргэдийн бие махбод эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх чөлөөнд гэм хор учрахыг үгүйсгэхгүй”²¹ гэж бичсэнийг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна. учир нь баривчлах, саатуулах үедээ хөндлөнгийн бусад хүмүүст гэм хор учруулсан бол хариуцлагын асуудлыг тухайн үеийн нөхцөл байдлыг харгалзан нийтлэг үндэслэлээр, тухайлбал, бусдад болгоомжгүйгээр гэм хор учруулсан буюу гарцаагүй байдлын нөхцөлөөр шийдвэрлэнэ.

Гэмт хэрэг үйлдээгүй хүнийг андуурч баривчилсан бол гэм буруу, эрүүгийн хариуцлагад нөлөөлдөг бодит байдлын андуурлын дүрмээр хариуцлагын асуудлыг шийдвэрлэнэ. Энд болгоомжгүйгээр гэм хор учруулсан гэдэг асуудал үүснэ. Баривчлах, саатуулж байгаа этгээд гэмт хэрэг үйлдээгүй хүнийг андууран баривчилж байгаа гэдгээ ухамсарлаагүй /мэдээгүй/, ухамсарлах ямар ч боломжгүй байсан нь тогтоогдвол гэм буруугүйгээр хохирол учруулсанд тооцогдоно.

Гэмт хэрэг үйлдсэн этгээд, оргосон ялтныг баривчлах явцад түүний амь насыг хохироож болох эсэх талаар судлаачид өөр өөр үзэл баримталж ирсэн. ОХУ-ын эрдэмтэд В.И.Ткаченко, Ю.М.Ткачевский нар “гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах нь хууль сахиулах байгууллагад хүргэх зорилготой байдаг тул баривчлах явцад амь насыг хохироож болохгүй”²² гэж үзэж байхад ОХУ-ын эрдэмтэд А.В.Наумов, В.Козак, Г.В.Бушуев нар “Онцгой тохиолдолд гэмт хэрэгтнийг амьдаар нь баривчлах боломжгүй болсон, аргагүйдсэн үед түүнийг алах нь хууль ёсны ажиллагаа болно”²³ гэж үзэж байна. академич С.Нарангэрэл “Хүч хэрэглэсэн үйлдэл ... онцгой тохиолдолд албадан саатуулах этгээдийн амь насыг хохироох зэргээр илэрч болно”²⁴ гэж дээрх үндэслэлийг дэмжжээ.

Эрүүгийн хуулийн 41-р зүйлд “... баривчлах, саатуулах үед энэ хуулийн тусгай ангид заасан үйлдлийг хийж гэм хор учруулсан ...” гэж зааснаас үзэхэд баривчлах саатуулах үеийн онцгой нөхцөлөөс хамаарч ямар ч гэм хор, тэр тусмаа амь насыг хохироож болох нь тодорхой байна. жишээ нь, 1996 оны 1-р сард Авдрантын хорих ангиас хэд хэдэн хүнийг алж, зэвсэглэж оргосон бүлэг этгээдүүд ууланд бүгэж, галт зэвсэг хэрэглэж эсэргүүцэж байсан тул баривчлахын тулд аргагүйдэн галт зэвсэг хэрэглэснээс нэг ялтныг амийг хохироосон нь хуульд нийцсэн ажиллагаа байв. Тэгээд ч

²⁰ Н.Жанцан. Гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ. УБ.,1986. 289 дэх тал

²¹ Б.Намсрай. Дурдсан зохиол. УБ.,2003. 54-55 дахь тал

²² Советские уголовные право. Общ.часть. 1981. 227 дахь тал; В.И.Ткаченко. Дурдсан бигээл. М.,1996. 319 дэх тал

²³ А.В.Наумов. Указ. Соч. М.,1996. 344 дэх тал; В.Козак. Задержания преступника и крайняя необходимость. М.,1982. 12 дахь тал; Г.В.Будушев. Социальная и уголовно-правовая оценка причинения вреда преступнику при его задержании. Горький.1976. 10 дахь тал

²⁴ С.Нарангэрэл. Дурдсан бигээл. УБ.,1999. 199 дэх тал

цагдаа, тагнуул, төрийн хамгаалалт, дотоодын цэргийн тухай хуульд гэмт хэрэгтэй тэмцэх, тухайлбал, бүлгээр зэвсэглэж эсэргүүцсэн, довтолсон тохиолдолд галт зэвсэг хэрэглэн няцаалт өгөх эрхийг хуульчилсан.

Баривчлах, албадан саатуулах ажиллагааны явцад холбогдох этгээдэд учруулсан гэм хор хуульд нийцсэн байх нэг нөхцөл бол түүний үйлдсэн гэмт хэргийн хор уршигтай тохирч байх, өөрөөр хэлбэл, хэтэрхий хүнд байх ёсгүй.

Баривчлах саатуулахад шаардлагатай арга хэмжээг хэтрүүлэн онцын шаардлагагүй, их хэмжээний гэм хор учруулах нь гэмт хэрэгт үгүйсгэх нөхцөл байдал болохгүй бөгөөд нийтлэг үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёстой. Гэтэл манай Эрүүгийн хуульд баривчлах саатуулах арга хэмжээг санаатай хэтрүүлсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын асуудлыг зохицуулаагүй орхигдуулсан нь учир дутагдалтай юм.

Хүч хэрэглэхгүйгээр гэмт хэрэг үйлдсэн этгээд, оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг баривчлах саатуулах бүрэн боломжтой байхад хүч хэрэглэсний улмаас дээр дурдсан хүмүүст учирсан гэм хор нь үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулын хэр хэмжээ, хүнд, хөнгөн, түүний хувийн байдал, баривчлах албадан саатуулах үеийн нөхцөл байдалд илт нийцээгүй бол дээр дурдсан арга хэмжээг хэтрүүлсэн гэж үзнэ.

Академич С.Нарангэрэл “Гэмт хэрэгтнийг албадан саатуулах үед түүнд учруулсан гэм хор нь түүний үйлдсэн гэмт хэргийн хор уршгаас үлэмж их байж болохгүй. Жишээлбэл, хулгайн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг албадан саатуулахдаа түүний бие махбодод хүнд гэмтэл учруулах буюу эсхүл амь насыг бусниулж болохгүй”²⁵ гэж бичсэн нь үндэслэлтэй юм.

Баривчлагдаж байгаа этгээдэд учруулсан гэм хор нь аль болох бага байх ёстой боловч хүнийг санаатай алах, хүч хэрэглэж дээрэмдэх, хүчиндэх, террор үйлдэх, хүн хулгайлах, барьцаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах үед түүний бие махбодод хүнд гэмтэл учруулах боломжтой. Ингэж хэтрүүлсэн нь санаатай бол эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг нь олон улсад нэгэнт тогтсон жишиг юм. Тухайлбал, ОХУ-ын Эрүүгийн хуулийн 38-р зүйлийн 2 дахь хэсэгт “Гэмт хэрэг нэгэнт үйлдсэн этгээдийг баривчлахдаа үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулын хэр хэмжээ, шинж чанарт илт тохироогүй, тухайн үеийн нөхцөл байдлаас урган гараагүй, тийм бодит шаардлага байхгүй байхад хүч хэрэглэх замаар гэм хор учруулсан бол арга хэмжээг хэтрүүлсэн гэж үзнэ. Баривчлах арга хэмжээг хэтрүүлэхдээ санаатай гэм хор учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ”²⁶ гэж заасан. Болгар улсын Эрүүгийн хуулийн 12а-р зүйлийн 2 дахь хэсэгт ийм зохицуулалт хийгдсэн байна.²⁷ АНУ-д хууль бус баривчилгаа явуулбал Үндсэн хууль, Эрүүгийн хууль зөрчсөн гэж эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Тухайлбал,

а/ Хүрэлцээтэй үндэслэлгүй баривчилсан /Less than “probable cause”/

б/ Гэр оронд нь прокурорын зөвшөөрөлгүй баривчилсан

в/ Баривчлах үедээ онцын шаардлагагүй хүч хэрэглэж гэм хор учруулсан бол хууль зөрчсөн баривчилгаанд тооцогддог Техас мужийн Эрүүгийн хуулийн 9.31-р зүйлийн “n” “c” “d”/

Онцын шаардлагагүй хүч хэрэглэсэн цагдаагийн ажилтанг “түрэмгийлэгч”, баривчлагдаж байгаа этгээдийг “аргагүй хамгаалалтын нөхцөлд байгаа хүн” гэж үздэг.²⁸

Мөн түүнчлэн Голланд улсын Эрүүгийн хуулийн 44-р зүйлд албан тушаалтан /цагдаагийн ажилтан/ өөрт нь хуулиар олгогдсон эрх хэмжээгээ хортойгоор болон хэтрүүлэн ашиглаж бусдад гэм хор учруулбал хууль бус үйлдэлд тооцож хариуцлага хүлээлгэдэг.²⁹ Энэ нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулахад нэгэн адил хамаарах юм.

²⁵ С.Нарангэрэл. Дурдсан бигээл. УБ.,1999. 199 дэх тал

²⁶ Комментарий К. УК Российской Федерации. М.,2007. 53 дахь тал

²⁷ Уголовный кодекс республики Болгарии. СПб.2001. 33 дахь тал

²⁸ Samada J. Criminal law. Paul., Minn.,1993. P. 265; Уголовное право зарубежных стран. М.,2003. 161 дэх тал

²⁹ Уголовный кодекс Голландии. СПб.2001. 174 дэх тал

Баривчлах албадан саатуулах үед гэмт хэрэг үйлдсэн этгээдэд учруулсан гэм хор хуульд нийцсэн эсэхийг тодорхойлоход баривчлах үеийн объектив болон субъектив хүчин зүйлүүд шийдвэрлэх ач холбогдолтой. Баривчлах үеийн объектив хүчин зүйлд баривчлах ажиллагааг явуулж буй газар, орон, цаг үе хамаарах бөгөөд тэдгээр нь гэм хорын шинж чанар, хүнд хөнгөнийг тодорхойлоход ач холбогдолтой. Жишээ нь, шөнийн цагт, хүнгүй газар, эсхүл өдөр олон хүн цугдарсан газар баривчлах нь өөр өөр арга тактикийг шаардана.

Баривчлах үеийн субъектив хүчин зүйлд бол баривчлагдаж байгаа этгээдүүдийн тоо, нас, хүйс зэрэг хувийн байдал, зэвсэглэсэн, өмнө нь удаа дараа хүч хэрэглэсэн гэмт хэрэг үйлдэж байсан, архаг туршлагатай байдал хамаарах бөгөөд ийм этгээдүүд баривчлах үед учруулах хохирол хүнд байхыг үгүйсгэж болохгүй. Гэмт хэрэг үйлдсэн, оргосон бүлэг этгээдүүд зэвсэглэж эсэргүүцэж, улмаар баривчлах ажиллагаанд ноцтой саад учруулж байгаа, эсхүл гэмт үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх нь тодорхой /барьцаалсан хүмүүсийг алах гэх мэт/ байгаа үед тэдэнд аргагүйдэн учруулах гэм хор хүнд байх нь тодорхой. Харин үйлдсэн гэмт хэрэг нь нийгмийн хор аюул багатай, баривчлах, саатуулах ажиллагаанаас зайлсхийх оролдлого хийгээгүй, түүний хувийн байдал, оршин суугаа газар нь хэн бүхэнд тодорхой, тэр орчин тойрны хүмүүст ямар нэгэн заналхийлэл, айдас төрүүлээгүй байхад баривчлах шаардлага гарахгүй юм.

Гэмт хэрэг үйлдсэн этгээд, оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг баривчлах, албадан саатуулах болон аргагүй хамгаалалт хийх үед гэм хор учруулах нь хэд хэдэн шинжүүдээрээ төсөөтэй юм. Үүнд:

а/ Эдгээрийг хэрэгжүүлэх үндэслэл нь хүний хууль бус ажиллагаа байдаг

б/ Баривчлах, албадан саатуулах болон довтолгогч этгээдийн довтолгооныг няцаахдаа эрүүгийн хуулийн тусгай ангид заасан үйлдэл хийж баривчлагдаж буй этгээд, довтолгогчид гэм хор учруулсан байдаг.

в/ Баривчлагдаж буй болон хамгаалж буй хүмүүсийн зан байдал гадна илрэх шинжээрээ төсөөтэй байдаг

г/ Дээр дурдсан хоёр нөхцөл байдлууд нь нийгэмд ашигтай зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэгддэг

д/ Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд баривчлах үед болон аргагүй хамгаалалт хийж учруулсан гэм хор хоёулаа эргэн төлөгдөх учиргүй зэрэг болно.

Гэмт хэргийг үгүйсгэх энэ хоёр нөхцөл байдал нь дараах шинжүүдээрээ хоорондоо зарчмын ялгаатай. Үүнд:

а/ Баривчлах албадан саатуулах эрх бол тодорхой этгээд гэмт хэрэг үйлдсэн болон сэжигтэн яллагдагч, шүүгдэгч, ялтан оргон зайлсан үеэс, харин аргагүй хамгаалалт хийх эрх бол нийгэмд аюултай довтолгоон бодитойгоор эхэлсэн үеэс тус тус үүснэ.

б/ Баривчлах, албадан саатуулах ажиллагааны зорилго бол дээр дурдсан этгээдүүдийг төр, засгийн байгууллагад хүргэх, шинээр гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой байдаг бол аргагүй хамгаалалт нь эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхлыг нийгэмд аюултай довтолгооноос хамгаалах зорилгод чиглэгддэг.

в/ Баривчлах, саатуулах санаачлага нь хуулиар ийм эрхтэй, үүрэг хүлээсэн хүнээс эхэлж гардаг бол хамгаалагч нь өөрийн хүсэл зоригоос ангид бий болсон довтолгооноос хамгаалж, довтолгогчид хохирол учруулахаас аргагүй байдалд орсон байдаг.

г/ Баривчлах, саатуулах ажиллагааг өөр аргаар хэрэгжүүлэх боломжгүй аргагүйдсэн үед гэм хор учруулбал хууль ёсны үндэслэлтэйд тооцогдох бөгөөд аргагүй хамгаалалт хийж довтолгогч этгээдэд хохирол учруулах нь түүнээс зайлсхийх, бусдын тусламж авах боломжтой байсан эсэхээс үл хамаардаг онцлогтой.³⁰

Эдгээр зарчмын ялгаатай шинжүүд нь 2002 оны Эрүүгийн шинэ хуулиар гэмт хэргийг үгүйсгэх энэ нөхцөл байдлыг биеэ даасан зүйлд хуульчлах үндэслэл болсон юм. Гэвч одоогийн хуулийн 41-р зүйлд заасан хэм хэмжээг улам боловсронгуй болгохыг амьдрал шаардаж байгаа юм. Иймд Эрүүгийн хуулийн 41-р зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт

³⁰ Л.Бат-Очир. Дурдсан бигээл. УБ.,2007. 20-21 дэх тал

хэрэг үйлдсэн болон эрх зүйн бусад зөрчил гаргасан этгээд, оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан шинээр гэмт хэрэг үйлдэх боломжийг таслан зогсоох, түүнийг төрийн байгууллагад хүргэх зорилгыг тухайн нөхцөлд өөр арга хэрэгслээр хэрэгжүүлэх боломжгүйгээс энэ хуулийн тусгай ангид заасан үйлдлийг аргагүйдэн хийсний үр дүнд тухайн этгээдэд учирсан гэм хор нь баривчлах, саатуулахад шаардлагатай арга хэмжээнээс хэтрээгүй бол гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал гэж үзнэ” гэж өөрчлөн найруулах санал дэвшүүлж байна.

**МОНГОЛЫН КРИМИНАЛИСТИКИЙН ТҮҮХИЙН ХУУДАСНАА
НЭМЭРЛЭХҮЙ: ХҮН СУДЛАЛЫН ХЭМЖИЛ ЗҮЙН АРГЫГ
ХЭРЭГЛЭЖ БАЙСАН БАРИМТ**

Батчулууны Жаргалсайхан

НЦГ-ын ГХТХ-ийн чиглэлийн ахлах мэргэжилтэн,
докторант, цагдаагийн дэд хурандаа

Монгол орон Манжид дагаар орох үедээ Түшээт хан, Засагт хан, Сэцэн хан хэмээх гурван аймагтай³¹ байсан бөгөөд Манж нар сүүлд Сайн ноён аймгийг шинээр байгуулж, хожим “хан” цол шагнаан бусад аймгийн адил, Сайн ноён хан аймаг гэх болсноор дөрвөн аймагтай болжээ.

Аймгуудыг хошуунд хувааж, хошууны хэргийг хошууг тэргүүлэх засаг хэмээх ноён, хошууг отогт хувааж отгийн хэргийг отгийн дарга тус тус эрхэлж мэдлийнхээ хүрээнд шийддэг байв.

Аймгуудыг аймгийн хан захирч, манжийн хааныг төлөөлөн Хүрээнд суух сайдад шууд захирагддаг байсан аж.

Аймгийн доторхи бүх хэргийг аймгийн чуулган хэмээх, төрийн захиргааны байгууллага хариуцдаг байсан бөгөөд ноёд түшмэдээс бүрдсэн уг чуулган гурван жилд нэгэнтээ чуулж тэр хооронд хурсан хэргийг шийддэг байв³².

Чуулган дарга Манжийн хааныг төлөөлөн Хүрээнд суух сайдад хэргээ мэдүүлэх ба түүнийг Манжийн хааны зарлигаар тохоодог байсан тул “Зарлигаар зарсан, Хүрээнд сууж хэрэг шийтгэх сайд” хэмээн нэрлэдэг байжээ.

Хэдийгээр “цагдаа” гэж нэрлэдэггүй байсан ч эрүүгийн хэрэгт процессын ажиллагааг чуулган дарга, дэд чуулган дарга нар явуулж байсныг Манжийн үеийн архивийн баримт нутлаж байна. Тухайлбал, Үндэсний архивийн газарт хадгалан буй нугалбар бичгийн дотроос эрүүгийн хэрэгт хамаарах хамгийн эртний баримт, бидний одоогоор олж тогтоогоод байгаагаар 1729 онд хамаарах ба энэ нь “Хятадын мал, юмыг хулгайлсан хүмүүсийг шийтгэсэн тухай бичиг”³³ байх хийгээд тухайн үед гарч байсан, өнөөгийн эрх зүйн өндөрлөгөөс харвал сонирхол татахаар зарим хэргээс дурьдвал:

- “Халхын засагт хан Цэвээнжавыг баруун Монголд дагаар орж болзошгүй гэж сэжиглэсэн тухай”³⁴; - “Тайланг буруу гаргаж мөнгө юм ашигласан Манж түшмэл Едүрийн хэргийг байцаах тухай”³⁵; - “Ар Монголд худалдаа хийх хятад хүмүүсийн үнэмлэх болон худал даалах юмыг шалган үзэж байх тухай”³⁶; - “Хорих газраас оргосон, цэргийн албанаас оргосон хүмүүсийг барих тухай”³⁷, - “Хэргийн учир ял шийтгүүлж бусдын боол болж байгаад оргосон зэрэг элдэв оргодол хүмүүсийг барих тухай”³⁸; - “Цагаач ардуудыг уг нутаг хошуунд нь буцаах ба оргодол хүмүүсийг барих тухай”³⁹; - “Монгол хятад хүмүүсийн хооронд болсон хулгай, дээрэм, хүн амины хэргийг яаж шийдэх тухай”⁴⁰, - “Монгол Оросын хилийн ойрхи иргэдийн харилцан алдагдсан мал

³¹ De-, CoiUjixsoroet. Moekgo& oa Hegocia biciet oa SoreeO biciet. Foxegeebegedo*. 1974 oa. 136 dekiA De& t.

³² Proq`ssso* Z-,Necoeedorjk. HeriyedO Hosigoa O Dodo* t DegeJO yeBgoxo* t Doedegea Dosiyeesea FoeegooxoeO biciet oa Fket. Frde^ siejixkea O kebleK FoUxeoeBrk. Foxegeebegedo*.1960. 102 dekiA De& t.

³³ ҮАГ. М-1. Т-1. ХН № 2514. 2 хуудас нугалбар.

³⁴ Мөн тэнд. ХН № 2569. 3 хуудас.

³⁵ Мөн тэнд. ХН № 2599. 6 хуудас.

³⁶ Мөн тэнд. ХН № 2620. 5 хуудас.

³⁷ Мөн тэнд. ХН № 2638. 16 хуудас.

³⁸ Мөн тэнд. ХН № 2662. 8 хуудас.

³⁹ Мөн тэнд. ХН № 2683. 13 хуудас.

⁴⁰ Мөн тэнд. ХН №2540. 3 хуудас.

юмны хэргийг шийтгэх төгсгөөний хэргийн бичиг /орос эхтэйгээ/⁴¹, - Сэцэн хан аймгийн Сан бэйсийн хошуунд байсан хятад худалдаачин нарын бараа, юмыг дээрэмдсэн оросоос уг юмыг эргүүлж авсан тухай⁴², - Хиагтын хил дэх орос, хятад, монгол хүмүүсийн хооронд болсон хүн амь, хулгайн хэргийн талаар⁴³, - Оросын оргодлыг буцаан өгөх, Орос руу оргосон Монгол хүмүүсийг авах тухай⁴⁴; - “Хятадын худалдаачин нараас хураах гаалийн асуудлаар харилцсан бичиг”⁴⁵; - “Хулгайн зэрэг хэргээр хоригдсон хүмүүсийг өвдлөө гэж уг хэргийг дуусгахгүй удаадаг гэмийг арилгах... тухай”⁴⁶; - Өртөөний мал хулгайд алдахаас сэргийлэх... тухай”⁴⁷, - Хүрээний орчин тойронд хулгай дээрмийн хэргийг сэргийлэх⁴⁸; - “Жавзандамба хутагтыг хамгаалах цэргийг татан буулгах...”⁴⁹, - “Бээжинд очих Оросын элчинг хүргэх /орос эх бий/...”⁵⁰; - “Хулгай болон хүний амь, зэрэг хүнд, хөнгөн хэргийн ялтны ялыг хөнгөтгөх зэрэг асуудлаар харилцсан бичиг”⁵¹; - “...нутгийн газраа гадаадаас ирсэн хүнийг удтал сууж худалдаалах, мал адуулах зэрэг явдлыг цаазлах...”⁵²; - Битүү хулгайн хэргийг шийтгэх хууль дүрмийн зарим зүйлд өөрчлөлт оруулах⁵³ зэрэг болно.

Эдгээр хэргийг шийдэж байсан хугацаа 1729-47 онд хамаарах ба түүнд анализ хийвэл хулгайлах, дээрэмдэх, хүнийг алах, оргох, сангийн мөнгө идэх зэрэг хэргийг тэр үед мөнөөхи чуулган шийддэг байсныг нутлах ба криминалистик шинж талаас нь үзвэл өнөөгийн ойлголтоор: - *тагнуул* /ХН №2569/; - *гааль* /2620/; - *шүүхийн шийдвэр гүйцэтгэл* /2638; 2662/; - *иргэний бүртгэл, цагаачлал, гадаадын харъяат* /2683; 5606/; - *төрийн тусгай хамгаалалтын* /2721; 2735/ *процессын хууль мөрдөх* зэрэг чиглэлээр ажиллаж байсан нь лавтай байна.

Тэрчлэн, хор өгч алсан гэж заргалдсан хэрэг /1768/, хуурамч тамга бүхүй бичиг хийж бадарлан явсан лам нарыг шийтгэх тухай /1776/ зэрэг хэрэг, тэр ч байтугай, өнөөг хүртэл манайд огт байгаагүй гэж үздэг байсан, бусдыг боолчлох явдал ч байсан байх /2662/ бөгөөд хорих газарт хорих, цөлөх, боол болгон бусдад өгөх зэрэг нь ялын төрөл байсан байна.

Өнөө ч манайд оршоор байгаа, хэргийн хугацаа алдахаас /2710/ авахуулаад тун саяхнаас Европынхныг зовоох болсон улс хоорондын хийгээд үндэстэн дамнасан шинжийг /2540; 2703; 2709/ агуулсан гэмт хэрэг ч тэр үед гарч байжээ.

Түүнчлэн гэмт хэргийг урьдчилан сэргийлэх /2719; 1774/ ажлыг тэр үед эрхэлж байсан нь тодорхой байх ба нэрийдлийн хувьд ч криминалист-доктор Ж.Хурцгэрэл⁵⁴ агсаны номлодог байсан хийгээд саяханаас ЦЕГ бодлогын хувьд баримтлах болсон – гэмт хэргээс бус, “гэмт хэргийг сэргийлэх” гэж оночтой үгээр нэрлэхийн зэрэгцээ гэмт хэргийг хүнд, хөнгөн гэж ангилан, ялтны ялыг хөнгөлдөг тогтолцоо бас байсан байна /2726/.

Үүнээс арай хожуу буюу, 1850-иад оны үед гэмт хэргийн бүтцэд мэр сэр өөрчлөлт орсны хажуугаар зарим нэрийдэл орчин цагийн шинжийг олж, процессын ажиллагаанд шархач мэтийн мэргэжилтнийг оролцуулах болсон нь тусгай мэдлэгийг ашиглаж байсны гэрч даруй мөн гэж бид үзэж байна. Энэ үеийн, материал нь архивт байгаа хэргийн заримаас дурьдвал:

41 Мөн тэнд. ХН № 2703. 6 хуудас.

42 Мөн тэнд. ХН № 2274. 9 хуудас.

43 Мөн тэнд. ХН № 2694. 7 хуудас.

44 Мөн тэнд. ХН № 1762. 14 хуудас.

45 Мөн тэнд. ХН № 2709. 2 хуудас.

46 Мөн тэнд. ХН № 2710.10 хуудас.

47 Мөн тэнд. ХН № 2719. 11 хуудас.

48 Мөн тэнд. ХН 1774. 4 хуудас.

49 Мөн тэнд. ХН № 2735. 7 хуудас.

50 Мөн тэнд. ХН № 2721. 5 хуудас.

51 Мөн тэнд. ХН № 2726. 7 хуудас.

52 Мөн тэнд. ХН № 5607. Нугалбар № 67. 1 хуудас.

53 Мөн тэнд. ХН № 2968. 1772 оны 10 хуудас нугалбар.

54 Ж. Хурцгэрэл. Криминалистик. I боть. УБ. 2003. 12 дахь тал.

Бусдын юмыг хулгайлж авсан хулгайг мөрдөн байцааж шийтгэсэн тухай⁵⁵; - Булш ухсан этгээдийг ялласан тухай⁵⁶; - Хууль зөрчсөн ба хариуцлага алдсан хүмүүсийг алах, цөлөх, нүүрэнд үсэг шивэх зэрэг шийтгэсэн тухай⁵⁷; - Хулгай зэрэг хэрэг шийтгэхэд түшмэдийн хэрэглэх зүйлийг гаргуулах⁵⁸; - Өөрийгээ хорлож үхсэн хүмүүсийн талаар шархачийн үзлэг⁵⁹; - Хулгай хийж, булаан дээрэмдсэн этгээдийг мөрдөн байцааж баривчлах, тэдгээрийн мэдүүлгийг авах, шийтгэх тухай⁶⁰; - Хүний амины хэрэг буюу битүү хулгай зэрэг хэргийг хятад бичгээр явуулж болохгүй тухай⁶¹; - Хүүхэн Тамжав ямаа хулуу завсар хоолойгоо шархлуулсан тул шархчид үзүүлэх гэсэн хэрэг⁶² /хүний биед үзлэг хийх/; -Нэргүй заалдах бичгийг авч хэлэлцэхгүй⁶³ зэрэг маш олон хэрэг болно.

Энэ үеийн баримтад анализ хийвэл:

- Гэмт хэргийн бүтцэд орсон зарим өөрчлөлт харийнханд дарлуулж байсан Монгол хүний ёс суртахуун илт доройтсоныг харуулж /4619/ байх ба - “мөрдөн байцаах” мэтийн үг хэрэглэдэг болсон /4616/, - хариуцлага алдсан хүний нүүрэнд үсэг шивэх зэрэг өвөрмөц ял хэрэглэдэг байсныг /4618/ харуулахын зэрэгцээ, - процессын ажиллагааны зардлыг зохих түвшинд шийддэг болсон /4643/, - хүний бие болон хүүрэнд үзлэг хийхдээ шүүх эмнэлгийн мэргэжилтнийг оролцуулах болсон /1855; 4616/, - гэмт этгээдийг баривчлах, мэдүүлэг авах, шийтгэх талаар зөвлөмж гарган нугалбар солилцдог /4645/ байсан.

- Хүнд болон “битүү” хэрэгт процессын ажиллагааг Хятад бичгээр явуулахыг хориглож байсан, тодорхойгүй эх сурвалжаас авсан мэдээллээр процессын ажиллагаа явуулдаггүй байсан зэргийг криминалистикийн тактик-арга зүйн зөвлөмж, эрүүгийн процессын эрх зүйн зарчмыг баримтлаж байсан гэж үзэхээс аргагүйн дээр, өнөөг хүртэл бидний нэр оноож чадахгүй мунгинаж яваа “эзэнгүй” гэдэг хэргийг өвөг дээдэс маань бараг хоёр зууны тэртээ “битүү” гэж тун оночтой оноочихсон байсныг харуулж байна.

Процессын ажиллагаанд тусгай мэдлэг ашигласан нэгэн сонирхолтой баримт архивт байгаа нь: Төр Гэрэлтийн 30 дугаар оны /1850/ зуны сүүл сарын шинийн долооноо үйлдсэн “Хэрлэнгийн Барс хотны чуулган дарга, засгийн төрийн бэйл, улсын хошой гүн Гончигжав, дэд чуулганы дарга, улсын түшээ гүн Чойжинжавын бичиг”⁶⁴ бөгөөд түүнд: «Сэцэн ханы харъяат Гунаажав бусдын гурван морийг дараалан хулууж баригдаад сахиулан бүхүйд оргон гарч боож үхсэнд түүний зүсийг байцаан мэдүүлэхээр зурааны /зурганы/ бошго Ахачүйг гаргаж шархач ван Жүн Хэ-г оролцуулан Гунаажавын зүсийг үзэж насыг асууваас, хорин дөрвөн настай, бие урт тийш таван тохой, мөр өргөн тийш найман ямх, цээж өндөр тийш долоон ямх, гэдрэг этгээд нүүрийн царай харавтар улаан, хоёр нүд анимуй, ам ангаймуй, хэл шүднээс гурван пүн⁶⁵ гарчээ. Аминд хүрэх хоолойн доорд дор өөрөө сураар хөвөрхий уяж боосон тэмдэг нэгэн зурвас, сурын гогцоо тойрон дүгрэг тийш баруун этгээд чихний хойд дор хүрч, зангиасны хоёр этгээдэд цөм цус нөжирсөн байгаа тэмдэг газар буй. Зөрүү дээд лүгээ тэмдэг болгож тийнхүү хойд лүгээ түвшин болж чадах үгүй⁶⁶. Толгой зүүн этгээдэд хазайж, хойд дор найман үсэг

⁵⁵ Мөн тэнд. ХН № 4616. 1855. 58 хуудас.

⁵⁶ Мөн тэнд. ХН № 4619. 1855. 40 хуудас.

⁵⁷ Мөн тэнд. ХН № 4618. 1855. 40 хуудас.

⁵⁸ Мөн тэнд. ХН № 4643. 1856. 5 хуудас.

⁵⁹ Мөн тэнд. ХН № 4596. 1855. 13 хуудас.

⁶⁰ Мөн тэнд. ХН № 4645. 1856. 53 хуудас.

⁶¹ Мөн тэнд. ХН № 4685. 1858. 37 хуудас.

⁶² Мөн тэнд. ХН № 4616. Түгээмэл элбэгтийн 5 дугаар он цагаан сарын 16.

⁶³ Мөн тэнд. ХН № 3654. 1818 оны 78 хуудас бичиг

⁶⁴ Мөн тэнд. ХН № 4412. “Өргөх бичиг” хэмээх нугалбар № 19.

⁶⁵ Пүн – нэг ямхыг 10 хуваасны нэг хувь, арван лий. (Я. Цэвэл. Монгол хэлний товч толь. Уб. 1966. 453).

⁶⁶ Хоолойд буй уяаны ормын түвшин хүзүүний орчмын түвшинтэй нэг түвшинд бус, өргөгдсөн гэсэн санаа.

нийлэлцсэнгүй хэмээх тэмдэг үгүйд хүрчээ⁶⁷. Хоолойн доод тэмдэг хөл тийш дөрвөн пүн, өргөн тийш гурван пүн, тойрон урт тийш нэгэн тохой илүү газар буй. Харавтар улаан өнгө хоёр гар атгамуй, хоёр гарын эрхий хуруу унжигар болж цөцгөр /Coicike*/ унагамуй. Гэдэс буумуй. Түрүүлгийн этгээд хоёр хөл жиймүй. Хоёр хөлийн арван хурууны гэдэс унжигар болж унагамуй. Үүнээс гадна бие бүхэн ер өөр шарх үгүй. Өөрөө боож үхсэн нь үнэн хэмээн өргөжээ» гэсэн байна.

Энэ хэсэгт анализ хийвэл, шархач мэргэжилтнийг оролцуулж хийсэн үзлэгийн тэмдэглэлд хүүрийн байгаа байдлыг мэргэжлийн хэлээр, нэлээд дэлгэрэнгүй бичсэний дээр, зөвхөн боож үхсэн хүүрэнд илэрдэг–боолтны ормыг хэмжээний хамтаар нарийвчлан тусгаж, биеийн өндөр, мөрний өргөн, цээжний урт, уяаны ором зэргийг их нарийн тодорхойлж бичсэн байна.

“...Хэл шүднээс гурван пүн гарчээ...” гэсэн болон боолтны ормын түвшин хүзүү, хоолойд зөрүүтэй байгааг бичсэн нь өнөөгийн мөрдөн байцаагчийн тэмдэглэлд ч ховор үзэгдэх баримт бөгөөд дээрхи бүх хэмжилтээс үзвэл Францын криминалист Альфонс Бертильон 1879 онд санаачлан Европын криминалистикт 1884 оноос системтэй хэрэглэж ирсэн, дэлхийн цагдаагийн түүхэнд ашигласан шинжлэх ухаанлаг анхны арга гэж тооцдог хүн судлалын хэмжил зүйн аргыг энэ үед Монголд ашиглаж байсныг бэлхнээ харуулах ажээ.

Бас нэг сонирхолтой нь энэ үзлэгт оролцсон шархач бусдын таних хүний насыг мэддэг хүнээс асууж тэмдэглэлд шууд тусгасан болон “Өөрийгээ боож үхсэн байна” хэмээх дүгнэлтийг газар дээр нь гаргасан баримт, хэдийгээр шинжилгээг газар дээр нь хийлгэх шаардлага одоо ч оршсоор буй ч, манайд өнөөдөр бас л байхгүй хэрэг.

Орчин цагт, үхсэн хүнийг хүүгээ гэж мэдүүлэн, иргэний үнэмлэхийг нь гаргаж өгөөд байхад мөрдөн байцаагч үзлэгийн тэмдэглэлдээ насыг тодорхой бичдэггүй, “30-35 насны...” мэтчилэн, заавал 5 насны заагтай бичих ёстой гэсэн үхширмэл ойлголттой явдаг нь үүнээс дууриал авч, хуульчдын сэтгэлгээг өөрчлөх шаардлагатай байгааг харуулж байна.

Цаашид уг хэргийг Хэрлэн Барс хотны чуулган даргын тамгыг хамаарсан гүн Чойжинжавт даатгаад “Энэ хэрэг доторхи шүүн асууваас зохих ард, дааж сахисан дарга, цэргүүдийг бүрнээ хянан нарийвчлан тодорхойлон шүүж Гунаажав эрхбиш ямар учирт боож үхсэн, үүний дотор бусад хүн цохиж айлган цухалдуулсан ба шоглосон зэрэг гэм учир буй үгүй, басхүү түүнийг зоримогоор тавьж оргуулсан зэрэг газар буй үгүй явдлыг тодорхойлон үнэн учрыг гаргаж хууль ёсоор шийтгэж мэдүүлэн ирүүлье. Хүн амины хэрэг хүнд чухал, хайш яайш оmtгойтон өнгөрүүлвээс хэрхэвч үл болох явдлыг хамтаар тушаан явуулсугай” гэж зааварчилсан нь өнөөгийн криминалистикийн тактик-арга зүйн зөвлөмж юм уу, прокурорын даалгаврын шинжийг агуулжээ.

Энэ зааврын дагуу харъяа тамгын газраас хэрэг тохиосон⁶⁸ Чойжав, Сономпил, хулгай Гунаажав нарыг байцаасан тэмдэглэлд хоёр хохирогч морио яаж алдсанаа мэдүүлж, Гунаажав цагаан морио унаж, морьдыг хэрхэн хулгайлж, худалдсанаа болон сүүлд цагаан морь нь эмгэгтэж үхсэн тухай хэлсэн байх ба Сономпилээс хулуусан улаан морийг олноос өглөг гуйж явсан, урьд үл таних шавь Жамсран гэгчид хулгайн гэдгийг огт хэлэлгүйгээр худалдсан, нэг борлог морины тухайд мэлзэж үзсэн баримт ч байх аж.

Түүнийг байцаасны эцэст яр өвчинд баригдсан нь хүндэрсэн тул огт чангалан шийтгэж үл болох тул хулгай Гунаажавын биеийг сахих, яр өвчнийг сувиалан засуулж эдгээхээр дарга Чимид, хуяг Цог, Раднаа нарт тушаан сахиулсны дараа тэд хулгай Гунаажав зугтан гарч боож үхсэнийг мэдүүлэн иржээ.

Сахиж байсан дарга, хуягуудыг байцаахад тэд Гунаажавын яр өвчнийг эдгэтэл гарыг гавлаж, хөлийг тушин албаны гэрт агуулж, яр өвчний учир өдрийн цагаар хөлийн

⁶⁷ “...найман үсэг нийлэлцсэнгүй хэмээх тэмдэг үгүйд хүрчээ...” гэсний утгыг МУИС-ийн МХС сургуулийн эрдэмтэн багш нартай санал солицоод – дүгрэг дүрс сэтэрхий байгаа нь найман үсэгт хөлөлийн аль нэг буюу хэд хэдэн үсэг дутуу гарахыг хэлж буй хэрэг болов уу гэсэн дүгнэлтэд хүрсэн болно.

⁶⁸ Хэрэг тохиосон хүн – хохирогч

тушааг суллаж, шөнө нь зүүдэг байсан ба тэр үдэш гэрийн зүүн талд хүнс төхөөрч байтал Гунаажав зугтан гарч, баруун талд уяж орхисон байсан морийг унан зугтаж одсон. Ойр хавиас морь олж араас нь явсан боловч шөнийн харанхуйд олсонгүй. Маргааш нь эрж явтал эмээл хазаартай морь цулбуургүй идэж явсныг олж улмаар хулгай Гунаажав боож үхсэн байсныг олсон гэж өчжээ.



Сахин харуулахаар даалгасан дарга, хуяг нар зоримоогоор тавин явуулсан бус, энгийн олтгойтон алдсан; бас энэ мэтийн хэргийг шийтгэх зүйл тогтоосон хууль тусгайлан заасан үгүйн дээр цагаан сарын хишиг тарааж байх үеэр энэ хэрэг болсон тул тэдний ялыг уучлан хэлтрүүлж; бас хулгай Гунаажав Сономпилээс хулуусан морийг Жамсранд худалдахдаа хулгайн учрыг хэлсэнгүй; мөн нөгөө нэг морийг хулуусангүй хэмээн өчсөн; хэрэг тохиосон Чойжав алдсан морио зүсмээр олж хураасан; хулгайн уг уналга эмгэгтэж үхсэн тул эднийг цөм хэлэлцэхгүй болгосугай. Гагцхүү Сономпилийн хулуугдаж арилжигдсан нэгэн морины орыг хулгай Гунаажавын харъяат захирах тайж Ядамдоржид тулгаж төлүүлэе.

Гунаажавын төрсөн эх Дулмаа, төрлийн ах⁶⁹, гэлэн Лувсандорж, дааж сахисан хуягуудыг байцааж эх Дулмаа, төрлийн ах Лувсандорж, харъяа тайж Ядамдорж нараас хүсэн батлах бичиг гаргуулан Хүрээнд сууж хэрэг шийтгэх сайд бэйс, сайдад ирүүлжээ.

Энэ хэсэгт анализ хийж үзвэл: - хүнд өвчтэй ялтанд өвчнийг харгалзан ял эдлүүлэхийг хойшлуулдаг байсан; - хэргээс учирсан хохирол үгүй гэж үзсэн тул ар гэрээс нь хүсэн батлах бичиг гаргуулан авч, амийг нэхэхгүй болгоод хэргийг “хэрэгсэхгүй болгож”; - хохирол гэж үзсэн, худалдсан морины өртгийг хулгайчийн захирах тайжаар төлүүлэх шийдвэр гаргасан нь тэр үеийн процессын ажиллагаанд хариуцлагын тогтолцоо хэрэгжиж байсан хийгээд өнөөгийн “хэрэгсэхгүй болгох”, “нөхөн төлүүлэх” арга хэмжээг авдаг байсныг харуулна.

Мөн, гав, тушаа зэрэг тусгай хэрэгсэл ашиглаж байсныг хийгээд, тодорхой журмаар зүүдэг байсныг ч энэ хэрэг гэрчилнэ. Үүнээс гадна, Сэцэн хан аймгийн чуулганаас Бадруулт төрийн тэргүүн онд /1875/ Хүрээний сайдад явуулсан нэгэн бичигт “...вангийн цэмбэ юмыг хулууж оргосон манай хошууны хулгай Лувсанчүлтэмийг анхны, хоёрдугаар хугацаанд барин эс олсон дарга Гармандалыг шийтгэж торгосон хоёр удаагийн долоон малын оронд тогтоолоор хорин нэгэн лангийн сайн мөнгө бүрнээ даацуулан гаргуулж... сайд бэйс таны яамнаа өргөн мэдүүлэв” гэсэн байгаа нь хариуцлагын тогтолцоо хэнийг ч ялгадаггүй, хатуу чанга байсныг бэлэхнээ харуулж байна.

Хэрлэнгийн Барс хотны чуулган дарга, засгийн төрийн бэйл, улсын хошой гүн Гончигжав, дэд чуулганы дарга, улсын түшээ гүн Чойжинжав нарын бичгийн хэсгээс...



ХҮҮХЭД, НАСАНД ХҮРЭЭГҮЙ ЭТГЭЭД, НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮН ГЭСЭН НЭР ТОМЬЁОНУУДЫГ ХУУЛЬ ТОГТООМЖИД ХЭРЭГЛЭСЭН БАЙДАЛ

Ю.Бадамханд

ОХУ-ын ДЯЯ-ны Москвагийн их сургуулийн
адъюнкт, цагдаагийн дэд хурандаа

Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, насанд хүрээгүй этгээдийг гэмт халдлагаас хамгаалах эрх зүйн орчны асуудлаар судалгааны ажил явуулж, энэ талаархи хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж, эрдэмтдийн ном бүтээлийг судлах явцад бидний анхаарлыг татсан нэг зүйл байсан нь Монгол Улсын хууль тогтоомж, түүн дотроо насанд хүрээгүй этгээдийг гэмт халдлагаас хамгаалах зорилт, агуулга бүхий хууль тогтоомж, эрх зүйн актад насанд хүрээгүй этгээдийг тухайн эрх зүйн харилцааны субъектын хувьд нэрлэн заахдаа “хүүхэд”, “насанд хүрээгүй этгээд”, “насанд хүрээгүй хүн” гэсэн өөр өөр нэршилээр тодорхойлсон байдал юм.

Иймд судлаачийн зүгээс энэ өгүүлэлд үндэсний хууль тогтоомж болон олон улсын эрх зүйн хэм хэмжээнд дээрх ойлголт нэр томьёонуудыг хэрхэн тусгасан, тэдгээрийн агуулга, зааг ялгаа, хууль зүйн хэрэглэнд харьцуулалт, дүн шинжилгээ хийх асуудлыг хөндөн авч үзсэн.

Шинжлэх ухаан бүр тодорхой ойлголт хэрэглэдэг бөгөөд шинжлэх ухааны бий болгож хуримтлуулсан мэдлэг түүнд цогц байдлаар илэрдэг гэж үздэг. Үүнийг термин буюу нэр томьёо хэмээх хэллэгээр илэрхийлдэг хэмээн үзэх хандлага мөн байдаг.

Орчин үед философи болон логикийн шинжлэх ухаанд “ойлголт” гэдгийг дараах – утгаар авч үзсэн.

Хэлийг хэрэглэхтэй холбоотой шатан дахь ертөнцийн тусгалын нэг хэлбэр юмс үзэгдлийг нэгтгэн дүгнэх хэлбэр (арга) мөн.

Зарим бүлэг юмсыг тэдгээрийн өвөрмөц шинжээр (онцлогоор) нь нэгтгэн тусгаж байгаа санаа бодол⁷⁰ мөн гэх хандлагууд юм.

Ойлголт бий болох тусгалын мэдрэхүй хэлбэрээс түүнд шилжих нь харьцуулал, анализ, синтез, хийсвэрлэл, нэгтгэн дүгнэх зэргээр оюун дүгнэлт болгох нарийн төвөгтэй үйл явц байдаг⁷¹.

Олон улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалтаар хүүхэд буюу насанд хүрээгүй этгээд гэдэгт хэн хамаарах тухай асуудлыг тэдгээрийн нас буюу чадамжийн байдлыг харгалзан баталгаажуулсан байдаг.

Хүүхэд хэмээх ойлголтыг олон улсын түвшинд тунхаглан тодорхойлсон хамгийн гол олон улсын эрх зүйн бичиг баримт бол 1989 онд батлагдсан НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц бөгөөд уг баримт бичгийн 1 дүгээр зүйлд “уг конвенцийн зорилгын үүднээс авч үзвэл 18 насанд хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ. Тэгэхдээ тухайн хүүхдийн талаар дагаж мөрддөг хуульд насанд хүрэх хугацааг үүнээс эрт байхаар авч үзээгүй бол тэгэж үзнэ”⁷² хэмээн заасан. Дээрх зохицуулалттай адил байдлаар буюу насны зааг ялгааг харгалзан хүүхэд, насанд хүрээгүй этгээдийн талаархи ойлголт, эрх зүйн байдлыг тодорхойлсон олон улсын бусад олон баримт бичиг байдаг. Тухайлбал, “Хүүхэд” гэдэгт 18 нас хүрээгүй хүн бүрийг хэлнэ⁷³, “Насанд хүрээгүй хүн гэж үйлдсэн хэрэг нь тухайн улсын эрх зүйн тогтолцоо насанд хүрсэн хүнээс ялгаатай хэлбэрээр хариуцлага

⁷⁰ Философийн толь, УБ, 1990 он 302 дахь тал.

⁷¹ Философийн толь, УБ, 1990 он 303 дахь тал.

⁷² НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц. 1989 он., (Хүүхдийн эрх: олон улсын эрх зүйн болон бусад баримт бичгийн эмхэтгэл, ХЗДХЯ, НҮБ-ын Хүүхдийн сан, Улаанбаатар, 2011, ... дахь тал)

⁷³ Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол. 3 дугаар зүйл, d. ., 2003. 112 дахь тал.

хүлээлгэхээр заасан хүүхэд буюу залуу хүнийг хэлнэ”⁷⁴, “Насанд хүрээгүй этгээд гэж 18 насанд хүрээгүй аливаа этгээдийг хэлнэ. Эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглосон насны доод хязгаарыг хуулиар тогтооно”⁷⁵ хэмээн тус тус тодорхойлсоныг энд дурьдаж болно.

Харин Монгол Улсын Үндсэн хуульд “хүүхэд” хэмээх ойлголтыг хууль зүйн ерөнхий утгаар хэрэглэсэн боловч нас болон бусад чадамжийн зааг хүрээг нарийвчлан тодорхойлоогүй болно.

“Хүүхэд” хэмээх ойлголтын тодорхойлолтыг үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулсан гол эх сурвалж бол Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль⁷⁶ бөгөөд уг хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэл хамгаалахад үйлчилнэ” хэмээн заасан нь 18 насанд хүрээгүй этгээдийг хүүхэд гэнэ гэх хүүхдийн эрхийн конвенцтой агуулгын хувьд нийцэж байгаа бөгөөд уг зүйлд мөн “... Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхдэд нэгэн адил хамаарна” хэмээн хуульчилжээ.

Өнөөгийн байдлаар Монгол Улсын хууль тогтоомж, хүүхдийн эрхийн талаархи олон улсын баримт бичгийн албан болон албан бус орчуулга, түүнчлэн хууль эрх зүйн ном бүтээлд насанд хүрээгүй этгээд гэдгийг “хүүхэд”, “насанд хүрээгүй этгээд”, “насанд хүрээгүй хүн” гэсэн нэр томъёонуудыг ашиглан өөр өөрөөр нэршүүлэн хэрэглэж байна.

Тухайлбал Монгол Улсын Эрүүгийн хуульд “насанд хүрээгүй этгээд”, “хүүхэд”, “насанд хүрээгүй хүн” гэсэн “нэр томъёог гурвууланг нь хэрэглэсэн бөгөөд тус хуулийн ерөнхий ангийн ял шийтгэл хөнгөрүүлэх⁷⁷, хүндрүүлэх⁷⁸, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг хойшлуулах⁷⁹, хүмүүжлийн чанартай албадлын арга хэмжээ хэрэглэхтэй⁸⁰ холбоотой зохицуулалт агуулсан хэм хэмжээнүүдэд “насанд хүрээгүй этгээд” гэсэн илүү хууль цаазын шинж давамгайлсан гэж хэлж болохуйц хэллэгийг ашигласан байна.

Харин тус хуулийн тусгай ангид заасан бэлгийн замын халдварт өвчнөө эмчлүүлэхээс зайлсхийх, халдаах⁸¹; хүн хулгайлах⁸²; хүнийг хууль бусаар хорих⁸³; хүнийг барьцаалах⁸⁴; хүн худалдах, худалдан авах⁸⁵; мөн түүнчлэн насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах⁸⁶; насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, биеэ үнэлэх, тэнүүчлэл, гуйланчлалд татан оруулах⁸⁷; садар самууныг сурталчилах⁸⁸; хүчиндэх⁸⁹; мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах⁹⁰ зүйлийн тухайлсан хэсгүүдэд тус тус тодорхой гэмт хэргүүдийн үндсэн болон хүндрүүлэх, онц хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжийг тодорхойлохын тулд тухайн зүйл хэсгийн гепотез, диспозицид “насанд хүрээгүй хүн” гэсэн нэр томъёог ашигласан байна. Тэгвэл мөн

⁷⁴Насанд хүрээгүй этгээдийн холбогдсон хэрэгт байцаан шийтгэх ажиллагаа явуулахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан наад захын жишиг дүрэм (Бээжийнгийн дүрэм), 1985., 2.2.а.

⁷⁵Эрх чөлөөгөө хязгаарлуулсан насанд хүрээгүй этгээдийг хамгаалахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан дүрэм, II. 11. (а), 1990.

⁷⁶Монгол Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 1996 он № 8.

⁷⁷Монгол Улсын Эрүүгийн хууль, 55 дугаар зүйл, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 2002 он № 4

⁷⁸Мөн хууль, 56 дугаар зүйл, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 2002 он № 4

⁷⁹Мөн хууль, 62 дугаар зүйл, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 2002 он № 4

⁸⁰Мөн хууль, 69 дүгээр зүйл, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 2002 он № 4

⁸¹Мөн хууль, 103 дугаар зүйлийн 103.3, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 2002 он № 4

⁸²Мөн хууль, 108 дугаар зүйлийн 108.2.8, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 2002 он № 4

⁸³Мөн хууль, 109 дүгээр зүйлийн 109.2.5, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 2002 он № 4

⁸⁴Монгол Улсын Эрүүгийн хууль, 112 дугаар зүйлийн 112.2.8, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 2002 он № 4

⁸⁵Мөн хууль, 113 дугаар зүйлийн 113.2.5, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 2002 он № 4

⁸⁶Мөн хууль, 114 дүгээр зүйл, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 2002 он № 4

⁸⁷Мөн хууль, 115 дугаар зүйл, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 2002 он № 4

⁸⁸Мөн хууль, 123 дугаар зүйлийн 123.2, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 2002 он № 4

⁸⁹Мөн хууль, 126 дугаар зүйлийн 126.2.4, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 2002 он № 4

⁹⁰Мөн хууль, 192 дугаар зүйлийн 192.2.3, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 2002 он № 4

хуулийн хүүхэд солих, хууль бусаар үрчлэх⁹¹; хүүхэд хаях, төөрүүлэх⁹² зүйлийн тухайн хэсгийн гипотез, диспозицид “хүүхэд” гэсэн нэр томъёог ашиглажээ.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн “ нэр томъёоны тодорхойлолт” гэсэн 5 дугаар зүйлд⁹³ тухайн хуульд хэрэглэгдсэн зарим нэр томъёог тайлбарлахдаа “хүүхэд”, “үр хүүхэд” хэмээн төрөл садан, цусан төрөл, гэрлэлт, гэр бүлийн холбооны шинжийг ашиглан тодорхойлолт өгсөн бол тухайн хуулийн 40 дүгээр зүйл болон өөр хэд хэдэн зүйлд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчийн эрх зүйн байдлыг тодотгохдоо “насанд хүрээгүй” гэсэн хэллэгийг ашигласан байна. Түүнчилэн насанд хүрээгүй этгээдэд явуулах байцаан шийтгэх ажиллагааны онцлог гэсэн 40 дүгээр бүлэгт тухайн харилцааны зохицуулалтын онцлогийг нээн харуулахын тулд “насанд хүрээгүй этгээд⁹⁴” гэсэн нэр томъёог ашигласан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.5 хэсэг, мөн 105, 110, 116, 118, 120, 125, 127 дугаар зүйлүүдэд⁹⁵ ялтны эрх зүйн байдлын онцлогийг тодотгохдоо “насанд хүрээгүй” гэсэн тодотголыг ашигласан бол мөн хуулийн 102,103, дугаар зүйлийн дугаар зүйлүүдэд⁹⁶ “насанд хүрээгүй этгээд” гэсэн нэр томъёог ашиглажээ.

Харин гэрлэлт, гэр бүлийн харилцааг зохицуулсан гол эх сурвалж болох Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд⁹⁷ гэр бүлийн гишүүд гэсэн нэр томъёог тодорхойлохдоо “ ...төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд...” гэсэн хэллэгийг ашиглаж гэрлэлт, үрчлэлтийн харилцаан дахь “хүүхэд” гэсэн ерөнхий ойлголтыг хууль зүйн хувьд тодотгож тухайн хуульд нэг мөр хэрэглэсэн боловч уг хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 44, 64 дүгээр зүйлүүдэд⁹⁸ “насанд хүрээгүй хүн” гэсэн ойлголтыг мөн хэрэглэсэн байна.

Хөдөлмөрийн харилцааг зохицуулсан хууль зүйн гол эх сурвалж болох Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хуульд хөдөлмөрийн харилцааны онцлог субъект болох насанд хүрээгүй ажилтны эрх зүйн байдлыг тодорхойлохдоо буюу уг хуулийн 109, 110, 141 дүгээр зүйлүүдэд⁹⁹ “насанд хүрээгүй хүн” гэсэн нэр томъёог хэрэглэсэн ба хөдөлмөрийн харилцааны онцлогоос шалтгаалж “18 насанд хүрээгүй ажилтан”, “14-15 насны ажилтан” гэсэн тодотголуудыг хэрэглэсэн байна.

Эдгээрээс гадна гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилт бүхий зарим хуулиудад дээрх нэр томъёонуудыг дараах байдлаар ашиглажээ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль¹⁰⁰ (13 дугаар зүйлийн 13.1.9)-д “насанд хүрээгүй хүн”, Тамхины хяналтын тухай хууль (8 дугаар зүйлийн 8.1.2)-д¹⁰¹ “хүүхэд” хэмээн тус тус заасан бол Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль (7 дугаар зүйлийн 7.2.3, 8 дугаар зүйлийн 8.1.3, 10 дугаар зүйлийн 10.2)¹⁰², Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль (8 дугаар зүйлийн 8.1)¹⁰³, Тамхины хяналтын тухай хуулиуд (6 дугаар зүйлийн 6.7.7)-д¹⁰⁴ дээрх гурван томъёолоос өөрөөр “18 насанд хүрээгүй хүн” гэсэн хэллэгийг хууль зүйн техникийн хувьд ашигласан нь сонирхол татаж байна.

⁹¹ Мөн хууль, 116 дугаар зүйлийн 116.1, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 2002 он № 4

⁹² Мөн хууль, 117 дугаар зүйлийн 117.1, 117.2, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 2002 он № 4

⁹³ Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ., 2002 он, № 5

⁹⁴ Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ., 2002 он, № 5

⁹⁵ Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 2002 он, №

⁹⁶ Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 2002 он, №

⁹⁷ Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 1999 он, № 30.

⁹⁸ Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 1999 он, № 30.

⁹⁹ Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 1999 он, № 25.

¹⁰⁰ Монгол Улсын Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 2002 он, № 46.

¹⁰¹ Монгол Улсын Тамхины хяналтын тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 2005 он, № ...

¹⁰² Монгол Улсын Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 1998 он, №

...

¹⁰³ Монгол Улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 2000 он, № ...

¹⁰⁴ Монгол Улсын Тамхины хяналтын тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, УБ, 2005 он, № ...

Мөн дээрх хууль тогтоомжуудад тухайн зохицуулж, хамгаалж буй харилцааны онцлогоос шалтгаалж “нярай хүүхэд”, “бага насны хүүхэд”, “16 насанд хүрээгүй хүүхэд”, “хүнд нөхцөлд байгаа хүүхэд”, “сургуулийн өмнөх насны хүүхэд”, “насанд хүрээгүй бүтэн өнчин хүүхэд” гэх зэргээр нас, нийгэм, сэтгэл зүйн онцлог нөхцөл байдлаар нь тодотгон хэрэглэсэн тохиолдлууд мөн байна.

Насанд хүрээгүй этгээдийг гэмт халдлагаас хамгаалахтай холбоотой харилцаанд хэрэглэгддэг хууль тогтоомжоос бусад салбарын хууль тогтоомжид “хүүхэд” гэсэн нэр томъёо хэллэгийг харьцангуй түвшинд нэг мөр хэрэглэсэн болох нь бидний явуулсан судалгаанаас тодорхой харагдаж байна. Тухайлбал хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль болон боловсролын салбарын тухай хууль тогтоомжид энэ нэр томъёог нэг мөр хэрэглэсэн байдал ажиглагдаж байна.

Хэл зүй, бичвэр судлал, харьцуулалтын аргыг ашиглан бидний явуулсан судалгаагаар дээрх хууль тогтоомжуудад “хүүхэд”, “насанд хүрээгүй хүн”, “насанд хүрээгүй этгээд” гэсэн нэр томъёо хэллэгийг ашиглахдаа дараах байдлаар зааг ялгаа бүхий, ялгамжтайгаар хэрэглэхийг эрмэлзсэн бололтой.

Үүнд хүүхэд гэдгийг цусан төрлийн буюу гэрлэлт, үрчлэлтийн харилцаагаар холбогдсон гэрлэлт, гэр бүлийн эрх зүйн харилцаан дахь тогтвортой холбоо гэдэг утгаар, “насанд хүрээгүй хүн” гэдгийг эрх зүйн субъект бие хүний эрх зүйн байдлын хувьд тодорхой нөхцөлтэй холбоотойгоор, харин “насанд хүрээгүй этгээд” гэдэгт тодорхой эрх зүйн харилцааны факт үүссэний улмаас тухайн харилцаанд тодорхой эрх эдэлж, үүрэг хүлээж оролцож байгаа этгээдийг тус тус илэрхийлэхээр хууль тогтоогчид зорьсон байх магадлалтай. Гэхдээ энэ хандлага зөвхөн эрүүгийн хууль тогтоомжийн техникээс харагдаж байгаа бөгөөд бусад хууль тогтоомжид аль нэг ойлголтыг нэг мөр хэрэглэх боломжтой байхад дээрх ойлголтуудыг аль алинг нь нэрлэх, нэг мөр байх ойлголтыг өөр өөрөөр нэрлэх, хэллэг нэр томъёог буруу хэрэглэсэн байдал ажиглагдаж байна.

Гэвч эдгээр гурван ойлголт агуулгын хувьд 18 насанд хүрээгүй хувь хүнийг илэрхийлсэн гэдэг утгаараа адил агуулга бүхий бөгөөд гол нь хууль зүйн хэрэглээний хувьд нэг мөр нэг нэр томъёо хэрэглэх үү эсхүл дээрх нэр томъёог агуулгын хувьд адил боловч эрх зүйн зохицуулалтын нөхцөл байдлаас шалтгаалан тухай бүрд тусгайлан утгаар хэрэглэх үү гэдгийг тогтоох нь хууль зүйн техникийн төдийгүй хуулийг нэг мөр зөв ойлгож хэрэглэхэд ач холбогдол бүхий юм.

Дээр судлан үзсэн хууль тогтоомжийн агуулгаас харахад “хүүхэд” гэсэн нэр томъёог хууль зүйн хувьд 2 өөр утгаар хэрэглэдэг болох нь ажиглагдаж байна. Энэ нь:

Нэгдүгээрт: Гэрлэлт, гэр бүл, үрчлэлтийн харилцаанаас үүдэл бүхий эцэг, эх, хүүхдийн хоорондох ёс суртахуун, цусан төрөл болон хууль зүйн хувьд холбогдсон тогтвортой холбооноос үүдэл бүхий утгаар. Энэ нь эцэг, эх, үр хүүхдийн тогтвортой хууль зүйн холбоо гэдэг утгаар тэдгээрийн насан турш нэрлэгдэх, хэрэглэгдэх шинжтэй.

Хоёрдугаарт: Олон улсын болон үндэсний эрх зүйн баримт бичгээр хууль зүйн хувьд бататган тогтоосон 18 насанд хүрээгүй хүн бүрийг нэрлэх ерөнхий нэршил гэсэн утгаар. Энэ нь хууль зүйн хувьд тухайн этгээд насанд хүрсэнээр эрх зүйн байдлын хувьд өөрчлөгдөх шинжтэй.

Дээрх дурдсан нөхцөл байдлыг нэгтгэн дүгнэж авч үзвэл:

1. Монгол Улсын хууль тогтоомж түүн дотроо Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжуудад насанд хүрээгүй этгээдийн эрх зүйн байдлыг тодотгон тогтоосон нэр томъёо, хэллэг нь нэг утга агуулга бүхий ойлголтыг өөр өөр байдлаар илэрхийлэх байдал ажиглагдаж байна.

2. Эдгээр нь хууль эрх зүйн актад хэрэглэх нэр томъёо нэг мөр, нэг утгаар хэрэглэгдэх онол, эрх зүйн зохицуулалтын шаардлагатай зарим талаар нийцэхгүй байгааг анхаарч цаашид тухайн харилцааны онцлог шинж агуулгыг харгалзан нэг нэр томъёог тодорхой байдлаар нэг мөр хэрэглэх, эсхүл тухайн ойлголтуудыг ямар тохиолдолд ямар агуулгаар зааг ялгаа, уялдаа холбоотойгоор хэрэглэх асуудлыг судлан шийдвэрлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

**МАНСУУРУУЛАХ БОЛОН СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ
ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТАСЛАН
ЗОГСООХ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ**

Рагчаасүрэнгийн Баярмагнай
ДХИС-ийн Гүйцэтгэх ажлын тэнхимийн
багш, докторант, цагдаагийн ахлах дэслэгч

Мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох асуудалд анхаарлаа хандуулахыг цаг үе биднээс шаардаж байна.

Мансууруулах бодис гэдэгт Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ хэлэлцээр, тухайлбал 1961 оны мансууруулах бодисын тухай НҮБ –ын Нэгдсэн Конвенцийн дагуу тус улсын нутагт хяналтад байлгавал зохих байгалийн болон нийлэгжүүлсэн бодис, бэлдмэл болон ургамлыг ойлгоно.

Сэтгэцэд нөлөөлөх бодис гэдэг нь Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ хэлэлцээр, тухайлбал 1971 оны Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай НҮБ-ын Конвенцийн дагуу тус улсын нутаг дэвсгэрт хяналтад байлгавал зохих байгалийн болон нийлэгжүүлсэн бодис, бэлдмэл юм.¹⁰⁵

НҮБ-ын мансууруулах бодист хяналт тавих Олон улсын хороо нь эмнэлгийн болон шинжлэх ухааны зорилгод шаардлагатай тэр хэмжээгээр нь л мансууруулах бодисыг тарьж ургуулах, үйлдвэрлэх, бэлтгэх, ашиглах явдлыг хязгаарлахын тулд байгуулагдсан, Түүнчлэн, тус Хороо нь мансууруулах бодисыг хууль бусаар тарьж ургуулах, үйлдвэрлэх, бэлтгэх, эргэлтэд оруулах, ашиглахын эсрэг үйл ажиллагаа явуулдаг.

Мансууруулах бодист хяналт тавих талаархи НҮБ-ын Хөтөлбөрт¹⁰⁶ /1990 он/ НҮБ-аас авч хэрэгжүүлэх бух арга хэмжээ тусгагдсан бөгөөд мансууруулах бодисын хууль бус эргэлт, хэрэглээтэй тэмцэх талаар байгуулагдсан олон улсын хэлэлцээрт дараахи үндсэн баримт бичиг хамаарна, Үүнд;

1. НҮБ-ын "Мансууруулах бодисын тухай" 1961 оны Нэгдсэн конвенци¹⁰⁷. "Мансууруулах бодисын тухай" 1961 оны Нэгдсэн конвенцид засвар, өөрчлөлт оруулах тухай" 1972 оны Протокол.

Энэ Конвенцийн 1 дүгээр зүйлд мансууруулах бодис болон түүний хууль бус эргэлтийн тухай ойлголт¹⁰⁸ тусгагдсан нь мансууруулах бодисын борлуулалтыг хууль ёсны ба хууль бус гэж зааглах нөхцөлийг бүрдүүлнэ.

UNODC буюу НҮБ-ын Мансууруулах бодист хяналт тавих албаны тодорхойлсоноор мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисыг үндсэн 4 зүйл анги болгон авч үздэг. Үүнд:

- Cocaine /Кокайн/
- Heroin /Геройн/
- Cannabis /Каннабис/
- Amphetamine /Амфетамин буюу шахмал эм/ гэсэн байдлаар ангилсан байдаг.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанд дараах төрлийн мансууруулах бодисыг хэрэглэж байгаа дүн мэдээ байна.

- Каннабис хэрэглэдэг -166.5 сая хүн
- Амфетаминын төрлийн сэргээх үйлчилгээтэй бодис хэрэглэгч -33.7 сая хүн
- Экстази -24.7 сая хүн

¹⁰⁵ С.Нарангэрэл “Монгол Улсын эрүүгийн эрх зүй”, тусгай анги, УБ, 1998, 288 дахь тал

¹⁰⁶ UN Programme on drug control, 1990

¹⁰⁷ UN United Convention on narcotic drugs, 1961

¹⁰⁸ Дурьдсан конвенци, р.5

- Опиум -16.5 сая хүн
- Геройн -12 сая хүн
- Кокаин -16 сая хүн тус тус бүртгэгдсэн байна.

Монгол улсад дээр дурьдагдсан мансууруулах төрлийн бодисуудаас геройноос бусад төрлийн бодис хэрэглэгдэж байна.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг 3 хэсэгт хувааж болно:

1.Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэдэггүй боловч түүнтэй холбогдолтой гэмт үйлдэл хийсэн этгээд

2. Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодис байнга хэрэглэдэг бөгөөд түүнийг хууль бусаар бэлтгэн, тараах үйлдэл хийсэн этгээд

3. Мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн этгээд

Энэхүү ангилал нь мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус наймаа эрхэлж буй этгээдэд эрүүгийн хариуцлага, ялыг ялгамжтай оногдуулахад чухал ач холбогдолтой. Тодорхой тохиолдолд мансуурах донтой этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах шаардлага гардаг /Монгол Улсын Эрүүгийн хуулийн 65 дугаар зүйл/

Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар борлуулах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагын хэр хэмжээ, шинж чанарт нөлөөлөх байдлыг Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 80.4-т заасны дагуу нотлоход эрүүгийн эрх зүйн хоёр ч хэм хэмжээ тодорхой нөлөө үзүүлнэ. Энэ нь эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал юм. Хууль тогтоогч Монгол Улсын Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “онц их хэмжээгээр, насанд хүрээгүй хүн оролцуулж, онц аюултай гэмт хэрэгтэн , давтан, урьдчилан үгсэж тохиролцсон буюу зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн” бол хариуцлагыг хүндрүүлэхээр тогтоожээ.

Онц их хэмжээгээр үйлдсэн гэдгийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлд заасан хэмжээ, Улсын дээд шүүхийн тайлбар болон шинжээчийн дүгнэлтийг үндэслэн тогтооно. Тэгэхдээ мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисын тоо, хэмжээнээс гадна тэдгээрийн бие организмд нөлөөлөх хүчин чадал, төрөл зүйлийг харгалзан үзэх шаардлагатай. Гадаадын зарим улс орон тухайлбал ОХУ –ын шүүхийн практикаас үзэхэд, марихуан хатаасан 0.1-100 гр гаагүй 0.05-2.5 кг, гашиш /анаша/ 0.1-100 гр: каннабисын давирхай 40 гр хүртэл: гашишын тос 0.05-50 гр: хар тамхи 0.1-10 гр: морфин 0.01-1 гр: героин 0.005 гр: кодеин 0.2-10 гр: промедол 0.03-3 гр: фенимин 3 гр хүртэл: омнопол 0.03-1 гр: пераитин 1.5 гр хүртэл: ноксирон 1.5-25 гр: эфедрон 0.02-3 гр: кокаин 0.01-1 гр: метадон /фенадон/ 0.01-1 гр хүртэлхийг онц их хэмжээнд оруулан тооцсон байна.¹⁰⁹

Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар борлуулах гэмт хэргийг гол төлөв зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлддэг учраас Монгол Улсын Эрүүгийн хуулийн 36 дугаар зүйлд заасан зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлгийн шинжийг илрүүлэн нотолбол зохино. Ингэхдээ бүлгийн бүрэлдэхүүн гүйцэтгэгчид болон бүлгийн зохион байгуулагч, удирдагчийг тогтоох хэрэгтэй.

Монгол улсын хууль, эрх зүйн орчинд Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын эргэлттэй холбоотой асуудлыг зохицуулахаар 2002 оны 11сарын 28ны өдөр "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэнд хяналт тавих тухай хууль", 2002 оны шинэчлэн найруулагдсан Эрүүгийн хуульд холбогдох зүйл заалтуудыг оруулан батлан гаргасан нь нэн чухал байгаа боловч, хэрэгжиж буй хууль, эрх зүйн актуудад хэрэглэгдэж байгаа хуулийн нэр томъёоны оноолт нь нэгдсэн бус, агуулгын хувьд зөрүүтэй байгааг нэг мөр тусган ойлгох шаардлага зүй ёсоор тулгарч байна. Жишээ нь: ..” мансууруулах зүйл” , ...“хар тамхи, мансууруулах буюу хордуулах бодис” ,...“мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис” ,...“мансууруулах, сэтгэц нөлөөт эм” ..“ мансууруулах ундааны зүйл” “мансууруулах болон сэтгэц заслын бодис.”

¹⁰⁹ “Практика Верховного Суда Российской Федерации по уголовным делам за 1992-1994 гг”, с.45

...гэх зэрэг үг хэллэгүүдээр орсон нь дээрхи нэр томёоны асуудал нэг мөр шийдвэрлэгдээгүй байгааг харуулж байна. Мөн хуулиудад суугдсан “ хар тамхи” гэдэг үг нь монгол хэлний тайлбар толь, хууль зүйн тайлбар толиудад “намуу цэцгийн буурцагнаас гаргаж авсан шингэн зүйл”, “опиум” гэсэн үгээр тусгагдсан одоо үед хэрэглэгддэг мансууруулах зүйлс, сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэл бодисуудыг илэрхийлэх нь учир дутагдалтай юм.¹¹⁰

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис түүний түүхий эдийг улсын хилээр хууль бусаар тээвэрлэн оруулж буй арга замуудын талаар:

1. Төрөл бүрийн бараа таваар, эд зүйл дотор нуух байдлаар оруулж ирж байна. Ингэхдээ уг бодисын овор хэмжээ төдийлөн их биш байдагтай холбоотойгоор ямар ч зүйлийн бараа тавааран дотор нуугаад оруулаад ирэх бүрэн боломжтой юм.
2. Улсын хилээр эд зүйлс оруулж ирэхдээ тухайн эд зүйлсийнхээ нэр, тоо хэмжээ зэргийг өөрчлөн бичиж гаалийн мэдүүлийг хуурамчаар үйлдэн оруулж ирдэг явдал нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис, Монгол улсын бүртгэлд бүртгэгдээгүй, онгол улсын стандартад нийцэхгүй, чанарын баталгаажилт хийгдээгүй хуурамч эм, эмнэлгийн хэрэгсэл, түүний түүхий эдийг оруулж ирэх нэг арга хэлбэр нь болж байна.
3. Мөн энгийн анзаарагдахгүйгээр баглаж боосон овор хэмжээ багатай мансууруулах бодисыг биедээ болон хувцас, цүнхнийхээ халаасанд хийн оруулж ирэх.
4. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис, түүний түүхий эдийг тодорхой нэг эд зүйлээр орлуулан хийж байдлаар нэвтрүүлж болох талтай. Тухайлбал: Гадуур болон дотуур хувцасны товчин дотор хийх, мөн бохь, чихэр гэх мэт хүнсний бүтээгдэхүүний оронд мансууруулах бодис орлуулж хийх, хөвөнтэй куртки, өдөн куртки гэх мэт овор хэмжээ ихтэй хувцасны дотор талаар зулсан байдалтайгаар хийх, гутлын ул, өсгий зэрэг төрөл бүрийн хувцсан дотор нуух байдлаар улсын хилээр оруулж ирэх, их хэмжээний гар утас оруулж ирж буй ченжүүд гар утасны ар талынх нь тагны дотор талд нь мөн батарейных нь дор нуух зэрэг арга замаар улсын хилээр хууль бусаар оруулж ирэх.
5. Давхар оруулагатай өмдний тэлээний дотор нь хэсэг утсыг нь ханзлаад чихэж хийх, эсвэл бүрэн задлаад мансууруулах бодисоо тараан байрлуулан дахин оёж өөрийн өмсөж буй өмдөндөө тэлээгээ хийх байдлаар
6. Барилгын материалыг БНХАУ-аас их хэмжээтэйгээр оруулж ирэх болсонтой холбоотойгоор төрөл бүрийн лаазтай будаг, азатон, эмульс гэх мэт зүйлс дотор нууж оруулж ирэх зэрэг арга замууд байна.

НУУХ АРГУУД

- Тээврийн хэрэгсэлд
- Ачаа, бааранд
- Хүний биед
- Шуудан элгээмж, захидал

Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж тухайн этгээдийн сэтгэцийн байдал, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж байдлыг харгалзан нийгэмд аюултай байвал “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ” гэдгээс өөр хүмүүнлэг нэртэй арга хэмжээг зохих байгууллага авах эрх зүйн үндсийг холбогдох хууль тогтоомжинд тусгах нь зүйтэй.

Гүйцэтгэх ажлын шугамаар олж авсан баримт сэлт мэдээллийг нотлох баримт болгох эрх зүйн зохицуулалтыг нягтлан судлавал:¹¹¹

¹¹⁰ Баярмагнай.Р. “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар борлуулах гэмт хэргийг ГТА-р илрүүлэх ажиллагаа” сэдэвт магистрын дипломын ажил., 2009 он.,

¹¹¹ ЭБШ хуулийн 79.3-т “Эрүүгийн хэргийн талаар хуульд заасан үндэслэл, нөхцөл, журмын дагуу прокурорын зөвшөөрлөөр явуулсан гүйцэтгэх ажлын арга хэрэгсэл ашиглаж авсан баримт сэлтийг нотлох

- ✓ Зөвхөн эрүүгийн хэрэг үүсгэсний дараа Гүйцэтгэх ажил явуулна.
- ✓ Прокурорын зөвшөөрлөөр явуулах Гүйцэтгэх ажлын арга хэмжээний үндсэн дээр олж авсан баримт сэлт мэдээлэл нь зөвхөн нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх
- ✓ Хуульд заасан үндэслэл журам нөхцлийн дагуу явуулсан байх шаардлагатай байна.

Энэ нь Гүйцэтгэх ажлын хүч, техник хэрэгсэл хэрэглэх хуульд заасан үндэслэл нь байгаа гэж үзсэн ч гүйцэтгэх ажлын тодорхой арга, хэрэгсэл ашиглаж баримт сэлт мэдээлэл цуглуулах илрүүлэх бэхжүүлэх, шалгах нарийвчилсан журам нөхцөл нь өнөөг болтол Гүйцэтгэх ажлын тухай хууль болон ЭБШХ-д баталгаажуулагдаагүй байна.

Иймээс Гүйцэтгэх ажлын тухай хуульд¹¹² заасан мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх таслан зогсоох явцад өөрөөр хэлбэл гэмт хэргийн тухай гомдол мэдээллийг шалгах явцад олж авсан баримт сэлт мэдээллийг мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нотлогооны процесст ашиглах хууль зүйн үндэслэлгүй байна.

Түүнчлэн Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 23-р зүйлийн 23.5-д “Прокурор гүйцэтгэх ажлын явцад авагдаж, эрүүгийн хэргийн нотлох баримт болгосон баримт сэлтийг хуульд заасан үндэслэл нөхцөл журмын дагуу цуглуулсан эсэхэд хяналт тавина” гэж тусгасан байдаг.

Манай улсын эрүүгийн хууль бусад хууль тогтоомжид мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэж заасан байхад манай төрийн болон төрийн бус байгууллагууд хар тамхи гэж ярьж заншин хэвшсэн байна. Энэ нь Монгол улсын Эрүүгийн хуульд ийм үг үсэг байхгүй хар ярианы хэллэг бөгөөд төрийн болон төрийн бус байгууллагууд одоог хүртэл хэрэглэсээр байна.

Манай цагдаагийн байгууллагын алба хаагчид мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн хүнтэй таараад хэрхэн арга хэмжээ авхаа мэдэхгүй бие биелүүгээ түлхэсээр байтал тухайн хүний хэрэглэсэн бодисын үйлчилэх цаг хугацаа өнгөрч байна.

Мөн цагдаагийн байгууллагын алба хаагчидыг мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх алба хаагчдыг гадаад орнуудын нэгдсэн туршлага, сургалтанд хамруулах. Цагдаагийн байгууллагын алба хаагчидад мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн хүнийг энгийн аргаар яаж таних, түүнийг ямар албан тушаалтанд хүргэж өгөх, хэрхэн шинжилгээ авах, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн тохиодолд хэдий хугацааны дотор цагдаагийн байгууллагын алба хаагч шинжилгээ авах талаар сургалтыг нийт цагдаагийн байгууллагын алба хаагчидад хичээл сургалт оруулах хэрэгцээ шаардлага тулгараад байна.

Манай төрийн болон төрийн бус байгууллагаас мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын талаар янз бүрийн ажил арга хэмжээг зохион хэрэгжүүлж байгаа боловч эдгээр эм бэлдмэл бодисын талаар зурагт ном, гарын авлага ТҮ-ийн нэвтрүүлэг ихээр гаргах нь нөгөө талдаа анхан шатны мэдлэггүй хүмүүст сурталчилгаа болж хүрхээс урьдчилан сэргийлэх.

Манай орны хувь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын шинжилгээ авахдаа тухайн хүний биед зүү зоож шинжилгээ авч шинжилгээ хийдэг нь нөгөө талдаа хүний эрхэнд халдаж байгаа асуудал юм. Гадаадын өндөр хөгжилтэй оронд шүлс, нус, цэр, хөлс гэм мэт зүйлээс нь шинжилгээ авч байгааг нэвтрүүлэх шаардлагатай байна. ШШҮТ-ийн шинжээч нар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын тавьсан асуултанд тийм үгүй гэж хариулдаг бөгөөд өөр нэмэлт асуултанд бие даан хариулт өгөх эрхгүй байдаг. Манай шинжээч нар тухайн хүний биед мансууруулах бодис илэрч байна,

баримтын хэмжээнд үнэлж болох ба ингэхдээ нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх үйл ажиллагааны эх сурвалжийг нууцлана.”

¹¹² Гүйцэтгэх ажлын тухай хууль- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1998 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

илрэхгүй байна гэж хариулж байгаа нь хангалтгүй бөгөөд түүнийг тухайн хүн хэдэн грамм хэрэглэсэн анх удаа юу удаа дараа хэрэглэдэг хүн үү гэдгийг тогтоох шаардлагатай байна.

Монгол улсад мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг шинжилдэг хоёрхон байгууллага байдаг бөгөөд түүний нэг нь Шүүх шинжилгээний үндэсний төвийн лаборатори, Гаалийн ерөнхий газрын лаборатори шинжилгээ хийдэг бөгөөд тэдгээрийн техник нэгэнт хоцрогдсон өнөөгийн цаг үед шаардлага хангахгүй байгаа нь гэмт хэрэгт шалгагдаж буй сэжигтнүүд ял завших, бусдыг тухайн гэмт хэрэгт ухуулга сурталчилгаа хийх, ятгахад хүргэж байна.

Дүгнэлт:

Эдгээр асуудлуудаас хархад Монгол улсад нэгэнт мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэгч, худалдан авагч, борлуулагч бий болсон байна гэдэг дүгнэлтэнд хүрлээ. Тиймээс энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх төрийн болон төрийн бус байгууллагын нэгдсэн бодлого шаардлагатай байна. Монгол Улсын эрүүгийн хууль болон НҮБ-ын конвенцэд мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодос гэж тэмдэглэгдсэн байхад хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон ном зохиолд хар тамхи гэсэн нэр томъёог одоо хүртэл хэрэглэсээр байна. Сэдвийн хүрээнд судлан дараахи санал дэвшүүлж байна.

Санал:

- Мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын эргэлттэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх түүнээс урьдчилан сэргийлэх холбогдох хууль тогтоомжуудад мониторинг үнэлгээ хийж дүгнэлт гаргах. Энэ төрлийн гэмт хэргийг үйлдэгчдэд эрүүгийн хариуцлагыг зөв оновчтой оногдуулж шийдвэрлэх. Цаашид энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх.
- Мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага албадын үйл ажиллагаа хийж гүйцэтгэх ажил мэдээлэл солилцох хяналт тавих чиглэлээр нэг бүрчлэн заасан нэмэлт өөрчлөлтийг оруулах.
- ЭБШ хуульд тухайн этгээдийн хэрэглэсэн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хэмжээг зааж өгөх /Стандарт бий болгох/
- Мансууруулах сэтгэцэд нөлөөлөх бодисын шинжилгээг нус, цэр, хөлс гэх мэт зүйлээс авдаг болох.
- Хар тамхи мансууруулах бодис гэх нэр томъёог нэг мөр ойлгох.
- Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын шинжилгээ хийдэг байгууллагуудын тоног төхөөрөмжийг шинэчлэх.
- Цагдаагийн байгууллагын алба хаагчдын дунд нэгдсэн сургалт зохион байгуулах түүний хор уршиг, шалтгаан нөхцөл, тэдгээртэй тэмцэх анхан болон дараагийн шатны арга хэмжээ гэх мэт.
- Ерөнхий боловсролын сургуулуудад энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой шуурхай зохион байгуулах шаардлагатай байна.

АРХИДАН СОГТУУРАХ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ,ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

Ганбаатарын Бямбадорж

ДХИС-н Цагдаагийн эрх зүйн тэмхимийн багш,
докторант, цагдаагийн ахлах дэслэгч

Монгол улсын үндэсны аюулгүй байдлын үзэл баримтлалд архидан согтуурах, мансуурах зэрэг хүний удмын санд сөрөг нөлөөлөх бүхнээс урьдчилан сэргийлэх асуудлыг монгол хүний аюулгүй байдлыг хангах тэргүүлэх чиглэл болгон тавьсан нь санамсаргүй хэрэг биш юм.

Архидан согтуурах явдал ужид шинжийг олж, сархад хэмээх ундаанд зэрэг зиндаа, нас, хүйс үл харгалзан шимтэх аваас хувь хүн төдийгүй, бүтэн үндэстэн самууран мөхөх аюултайг бэлхэнээ мэдэх атал сүүлийн цөөхөн жилд монгол хүн архинд донтох өвчинд гүн нэрвэгдэв. Дэлхий нийтэд согтууруулах ундааны хэрэглээ жил тутамд буурч байгаа энэ цаг үед, харин Монгол улсад огцом өсөж хэрэглээний түвшингөөрөө толгой цохих боллоо¹¹³.

Учруулж буй хор хөнөөл, аюул занал нь жилээс жилд өсөн нэмэгдэх болсон нийгмийн эл сөрөг үзэгдэл монгол хүний удмын санд мэдэгдэхүйц таагүй нөлөөлөх болсны сацуу, гэмт хэргийн өсөлтийн хувь хэмжээ, криминологи шинжид огцом сөрөг өөрчлөлтийг бий болгож байна. Монгол улсад үйлдэгдэж буй нийт гэмт хэргийн 18,2 хувь нь, онц ноцтой гэмт хэргийн 80 хувь нь согтуугаар үйлдэгдэж аж. Гэмт хэргийн гаралтийн энэхүү нөхцөл байдал нь цаашид тогтвортой хадгалагдвал монгол улсын нийгэм хүн амын аюулгүй байдал учруулах хор хөнөөл нь улам бүл өсөн нэмэгдэж түүнийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэхэд төдий хэмжээгээр бэрхшээлтэй учирна гэдгийг мэргэжилтэн, судлаачид анхааруулсаар буй билээ.

Архи согтууруулах ундаа үүссэн үеийг хүн төрлөхтөн ваар сав хийж ирсэн тэр үеэс улбаатай гэж эрдэмтэн судлаачид үздэг. Ваар саванд хадгалагдсан жимс хадгалалтын явцад исэж задраад бага хэмжээний хатуулагтай дарс мэт болсныг хүмүүс анх мэдэж ууж эхэлсэн нь түүний хэрэглээний эхлэл гэж үздэг.

Монголчуудын хувьд Хүннүгийн үеэс таван хошуу малынхаа сүүг исгэн шимийн архи гарган авч хэрэглэж байсан бөгөөд одоо ч зарим аймаг сумдад энэ аргаар нэрмэл архи гарган авч хэрэглэж байна. Манай ард түмэн Чингис хаанаас эхлээд үе үеийн хаад ноёд тухайн нөхцөлд тохирсон олон арга хэмжээ авч хэрэгжүүлж байсны үр дүнд архийг тодорхой дэг жаяг, хэмжээ хязгаартай хэрэглэж ирсэн түүхтэй билээ. Хаад ноёдын авч хэрэгжүүлж байсан арга хэмжээнүүд заримыг нь дурьдвал “Чингис хаан” архи ууж согтвоос тэргүүнээ цохиулсан мэт, аливаа оюун билэг цөм хэрэггүй болой гэж сургасан бөгөөд уухийг хаацайлахын аргагүй бол сард гурван удаа уу гэж хязгаар тогтоож байжээ¹¹⁴.

Монголын ард түмэн архийг таван тансаг идээний дээж хэмээн хүндэтгэн үзэж, хэн хүнгүй хүртэж хэрэглэх, эс хэрэглэх талаар нарийн дэг журмийг мөрдөж, Хабул хааны үеэс архийг хэрэглэх талаар хатуу ёс журам гаргаж “дөч хүрээд дөнгөж амс, тавь хүрээд тааруулж балга, жар хүрээд жаргаж хүрт” гэж сургасан. Үүнд насыг нарийн зааглахын зэрэгцээ “уу” гэсэн утга санаа үл агуулсан байна. Энэ нь хүн ерөөсөө архи уух нь байтугай “уруулаа бүү хүргэ” гэсэн гүн гүнзгий утга санааг агуулахын зэрэгцээ, хүүхэд багачууд, залуу хүмүүсийг гашуунаар бүү тэтгэ, эцэг хүний найман зүйлд бор дарсанд үл шунах, гашууныг амталбал эмэгтэй хүний хэвлийд хор тогтоно. Архи дарсийг уй гашуу, уйтгар зовлон, гай гамшиг, ном хурах, сүм хийдэд мөргөх, бурхан багш залах, лам санаваартан, эцэг, эх, ахмад настан, авга, нагац, хүүхэд, эмэгтэйчүүд, өрх гэр

¹¹³ Г.Бямбадорж, Архидан согтуурах явдалтай тэмцэх үйл ажиллагаа, УБ., 2011., 5-р тал

¹¹⁴ Л.Эрдэнэбаяр, Архинд донтох өвчин, УБ., 2009., 87-р тал

тусгаарлаагүй залуу хүмүүсийн дэргэд архи сөгнөх, хүртэхийг хатуу цээрлэх ба архи уух нь арван хар нүглийн нэг гэж үзэж сургажээ¹¹⁵.

Монголчууд бид архийг далай шиг их үйлдвэрлэж түүндээ өөрсдөө живж байна. Насанд хүрсэн хүмүүсээс архи уудаггүй хүн гэж бараг үгүй болжээ. Шинэ жил, цагаан сар, мартийн 8, цэргийн баяр, эх үрсийн баяр, баяр наадам, улс тунхагласны баяр, төрсөн өдөр, гэрийн болон одонгийн найр, хурим, хонхны баяр, бүр сүүлдээ аавуудын баяр, анд найзууд уулзсаны баяр гэх зэрэг эцэс төгсгөлгүй баяр цэнгээн наадам, дээр нь нэмэгдээд олимп болон дэлхийн аваргын тэмцээнүүдийг архи, пиво уухгүйгээр төсөөлж ч чадахгүй болсон нь бас л харамсамаар¹¹⁶.

Манай улсад архи согтууруулах ундааг зүй зохистой хэрэглэх ойлголт нийгэмд төлөвшөөгүй байна. Согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэдэг хүмүүс архидан согтуурах явдал өөрийх нь хувьд хэвийн зүйл гэж бодож сэтгэдэг нь стандарт хэрэглээний хэмжээг нийгэмд төлөвшүүлэх шаардлагатай байгааг харуулна.

Төр засгийн зүгээс архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлыг анхааралдаа авч үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, захиргааны харицлагын тухай хууль, гаалийн болон гаалийн тарифийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг батлан гаргаад зогсохгүй эдгээр хууль тогтоомжийг хэрэглжүүлэх чиглэлээр гарсан засгийн газрын тогтоол, төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагын тушаал, шийдвэр гээд бүхэл бүтэн хууль эрх зүйн орчин бүрдсэн ч тодорхой үр дүнд хүрэхгүй байна¹¹⁷.

Архидан согтуурах явдалтай тэмцэх тэмцлийг үр дүнтэй болгох зорилгоор 100 хүнээс архидан согтуурах явдлыг багасгахад ямар арга хэмжээ авах бэ? гэсэн санал асуулга явуулхад 8% нь Архидан согтуурах явдлын эсрэг төр засгийн зүгээс үр дүнтэй иж бүрэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, 6 % нь Архинд донтох өвчтэй хүмүүсийн сэтгэхүйг эрүүл болгох, 12% нь Ард иргэдэд архи хэрэглэх ёс, зан заншилыг ард иргэдэд хүртээмжтэй өргөнөөр сурталчилан, ухуулан ойлгуулах, 22% нь хууль ёс хариуцлагыг чангатгах, 15% нь ажилгүйдэл ядууралыг бууруулах, 15% нь архи согтууруулах ундааг худалдан борлуулах цэг салбарыг цөөлөх, архины үйлдвэрлэл экспортоор оруулж ирэх архи согтууруулах ундааны хэмжээг багасгах, **18% нь архидан согтуурах явдалтай тэмцэх хууль тогтоомжийг боловсронгуй болгох**, 4 % нь архигүй орчин бүрдүүлэх гэж тус тус хариулжээ¹¹⁸.

Дээрхи санал асуулгаас үзвэл архидан согтуурах явдалтай тэмцэх хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага зүй ёсоор тавигдаж байгааг бид бүхэн харж болно.

Өнөөгийн байдлаар архидан согтуурах явдалтай тэмцэх үйл ажиллагааг цагдаагийн байгууллагын алба тасаг дотроос ажлын чиг үүргийн хувьд хэв журмын алба гол үүрэг гүйцэтгэх бөгөөд архидан согтуурах явдлын шалтгаан нөхцөл, тархалт болон түүнтэй тэмцэх ажлын явц байдалд дүн шинжилгээ хийж согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэстэй оновчтой зохион байгуулах ажлыг үндсээр нь сайжруулахыг өнөөгийн нөхцөл байдал зүй ёсоор шаардаж байна.

Архидан согтуурах явдалтай хийх тэмцлийг хүчтэй болгож энэ ажлын үр нөлөөг ЗГ, ЦЕГ, НХЖХГ, НЦГ-н бодлого, чиглэл, зорилго, зорилтийг амьдралд бүтээлчээр хэрэгжүүлэхийн тулд хууль тогтоомжийг боловсронгуй болгож ЦБ-ын алба тасаг бүрийн онцлого, чиг үүрэгт нь тохирсон ажил үүргийн хувиарыг боловсруулах хэрэгтэй гэж бид үзэж байна. ОХУ-н цагдаагийн байгууллага эрүүлжүүлэх үйл ажиллагаагаа эрүүл мэндынхээ байгууллагад шилжүүлжүүлж архинд донтох өвчтэй хүмүүсийг *эмчилж*

¹¹⁵ Л.Эрдэнэбаяр, Архинд донтох өвчин, УБ., 2009., 87-р тал

¹¹⁶ www.google.

¹¹⁷ Г.Бямбадорж, Архидан согтуурах явдалтай тэмцэх үйл ажиллагаа, УБ., 2011., 5-р тал

¹¹⁸ ХУД-ын 4,5,6,7,8,9,10-р хорооны иргэдээс авсан санал асуулгын материал, УБ., 2011 он

эхэлсэн нь үр дүнд хүрч байгаа бөгөөд ОХУ-н цагдаагийн байгууллага эрүүлжүүлэх байргүй гэдгээ нийтэд зарлан мэдээлсэн байна.

Хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал

Эрүүлжүүлэх үйл ажиллагааг ЦБТХ-н 17-р зүйл “Олон нийтийн газар согтуугаар хэвийн бус яваа хүнийг тусгай байрнд эрүүлжүүлэх, эсвэл хамгаалах хүнд нь хүлээлгэн өгнө” гэж заасан нь эрүүлжүүлэх үйл ажиллагааны эрх зүйн үндэсийг заажээ.

Гэвч эрүүлжүүлэх үйл ажиллагааны талаархи ойлголтыг тал бүрээс нь үзэж, энэ ажиллагаанд цагдаагийн байгууллага ямар хэлбэрээр оролцох, гарч болох эерэг болон сөрөг үр дагаварыг судлан тодорхой арга хэмжээ авах саналыг боловсруулах хэрэгтэй болжээ.

“Эрүүлжүүлэх” гэдэг нь нэрийнхээ утга агуулагаасаа болон хүнд үзүүлэх үйлчилгээний талаасаа ч цагдаагийн байгууллагын шууд гүйцэтгэх үүрэг биш гэдэг нь ойлгомжтой байна.

Харин энэ ажлыг эмнэлэгийн тэр тусмаа наркологийн болон хордлого тайлах төвийн эмнэлэгийн нарийн мэргэжилийн эмч, ажилтнуудын хяналтан доор хийж гүйцэтгэх ёстой гэсэн судлаачидын дэвшүүлсэн санаа оновчтой юм¹¹⁹.

Согтууруулах ундаа хэрэглэсэн хүнийг эрүүлжүүлэх үүргийг эмнэлэгийн байгууллага хэрэгжүүлж, энэ ажиллагаандаа цагдаагийн байгууллагын ажилтаныг гэрээгээр ажилуулж байхаар хууль, эрхийн актуудыг өөрчлөх шаардлага зүй ёсоор тавигдах болно. Тухайлбал: “Эрүүл мэндийн тухай хууль”-д Согтсоны улмаас биеэ авч явах чадвараа алдсан, архины хордлогод орсон хүнийг эрүүл ахуйн шаардлага хангасан эмнэлэгийн байрнд, хордлого тайлах төвд эрүүлжүүлнэ гэсэн заалт оруулах.

Түүнчлэн ЦБТХ-н 17-р зүйл буюу “Эрүүлжүүлэх” гэсэн заалтыг өөрчлөн найруулж “Архины хордлого тайлах ажиллагаанд оролцох гэж хуульчлах”

17.1. Олон нийтийн газар согтуугаар хэвийн бус яваа хүнийг архины хордлого тайлах төв эмнэлэгт хүргэх, эсвэл хамгаалах хүнд нь хүлээлгэн өгнө.

17.2. Хордлого тайлах эмнэлэгийн дүрмийг эрүүл мэндийн сайд, ЦЕГ-н даргын хамтарсан тушаалаар батлана гэж өөрчлөн найруулах.

АСТТХ-н 11-р зүйлд заасан “Цагдаагийн байгууллага” гэснийг хасч “эмнэлэгийн байгууллага гэж өөрчлөх, мөн зүйлийн 2 дахь хэсэгт” цагдаагийн байгууллага нь хордлого тайлах ажиллагаанд оролцохдоо тухайн эмнэлэгийн хэвийн үйл ажиллагаа, эмч, ажилтаны ажиллах аюулгүй байдлыг хангах үүрэгтэйгээр оролцоно” гэж нэмэлт өөрчлөлт оруулж болно.

Иргэн өөрийн хүсэлтээрээ ирж эрүүлжүүлэгдсэн тохиолдол цөөн байгаа бөгөөд энэ тохиолдолд тухайн хүнээс эрүүлжүүлэхэд гарсан шууд зардлыг гаргуулан авахгүй байх нь зүйтэй юм.

АСТТХууль тогтоомж зөрчигдсөн тохиолдолд цагдаагийн бага бүрэлдэхүүн “ахлагч бүрэлдэхүүн” АСТТХ зөрчсөн аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтан, иргэнд торгуулийн арга хэмжээ авах боломжгүй байна. Учир нь уг хуулийн 7.1, 7.4, 7.5, 7.2.1, 10.2-д заасан зөрчлөөс бусад зөрчилд 5000 хүртэл төгрөгөөр торгох зөрчил байхгүйд оршиж байна.

Ийм учраас уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулж зарим зөрчилд 5000 төгрөгөөр торгож арга хэмжээ авхаар хуульчлах, эсвэл бага бүрэлдэхүүнийг торгуулийн хуудсаар 50,000 хүртэл төгрөгөөр торгох эрхтэй болгох энэ нь архидан согтуурах явдалтай тэмцэх ажилд тус дөхөм үзүүлэхээс гадна архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиар зөвхөн офицерууд арга хэмжээ авдаг байсан бол бага бүрэлдэхүүн арга хэмжээ тооцсноор уг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажилд ахиц гарч, хяналт шалгалт сайжирч торгуулийн арга хэмжээ авах эрх бүхий субъектүүд нэмэгдснээр улсын төсөвт оруулах хөрөнгө мөнгө ч нэмэгдэж болох юм.

Түүнчлэн АСТТХууль зөрчсөн аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтанд 50,000-с 250,000 төгрөгөөр торгож торгуулийн арга хэмжээ авдаг боловч одоогийн авч

¹¹⁹ Хэсгийн байцаагч 2011 эрдэм шинжилгээний бага хуралын эмхтгэл., УБ., 2011, 5-р тал

байгаа торгуулийн арга хэмжээний мөнгөн дүнгийн хэмжээ маш бага байна. Учир нь уг хууль батлагдснаас хойш манай улсын эдийн засаг өсөж нэг хүнд оногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдсэн, архины үйлдвэр, аж ахуйн нэгжийн ашиг орлого хэдэн зуу дахин өсч, сая саяаар тоологдох ашиг орлого олж байна.

Зөрчил гаргагч нарт торгуулийн арга хэмжээ авдаг боловч энэ нь нөлөөлөлийн ач холбогдолоо алдсан тул зөрчлөө дахин давтах, хууль тогтоомжийг санаатай зөрчих явдал таслан зогсоогдохгүй байна. Ийм учраас ЗХТХ болон АСТТХ тогтоомжид зарим зөрчлийн хор уршиг, шинж чанараас хамаарч зөрчилд хүлээлгэх хариуцлагыг чангатгах шаардлагатай байна. Тухайлбал:

-Цагийн хувиар зөрчиж шөнийн цагаар архи согтууруулах ундаагаар үйлчилсэн, худалдсан

-21 насанд хүрээгүй хүнд архи согтууруулах ундаагаар үйлчилсэн, түүгээр үйлчлэх ажилд авч ажилуулсан

-Архи согтууруулах ундаа хэрэглэсэн хүнд, архи согтууруулах ундаагаар үйлчилсэн болон худалдсан

Зэрэг зөрчилд хүлээгэх хариуцлагыг чангатган архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлыг цуцлах хүртэл хариуцлага оногдуулхаар хуульчлах. Дээрх зөрчлүүд нь дахин давтан үйлдэгддэг, хор уршиг дагуулдаг, тархмал нийтлэг шинжтэй өргөн хүрээтэй, зөрчлийн дийлэнх хувийг эзэлдэг, гэмт хэрэг захиргааны зөрчил үйлдэгдэх нөхцлийг бүрдүүлдэг зэрэг шинжтэй байдаг.

Дээрхи зөрчлүүд таслан зогсоогдохгүй байгаа шалтгаан нь: Энэ зөрчлийг үйлдэгчидын хувь хүний ёс суртахуун, эрх зүйн ухамсар дорой, хууль тогтоомжийг биелүүлдэггүй, үйлдсэн зөрчилд хүлээлгэх хариуцлага сул, оногдуулж буй торгуулийн хэмжээ бага, хяналт шалгалт сул байдаг нь дээрх зөрчлүүдийг таслан зогсооход сөргөөр нөлөөлж байна гэж үзэж байна.

Иймд дээрх зөрчлүүдийг таслан зогсоохийн тулд АСТТХ-д тусгай зөвшөөрөлыг нь цуцлах шийтгэлийг үндсэн шийтгэл болгон түлхүү хуульчлах.

Мөн зөрчил гаргаж архи согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлөө цуцлуулсан цэг салбар, аж ахуйн нэгж байгууллагуудад дахин тусгай зөвшөөрөл олгохгүй байхаар хуульчилж хатуу чанга баримтлах шаардлагатай байна.

Түүнчлэн архи согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлөө цуцлуулсан байгууллага аж ахуйн нэгж, цэг салбарууд нь тусгай зөвшөөрөлөө цуцлуулах үед ажиллаж байсан аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн нэрээ өөрчлөн дахин архи согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл авч байгаа явдлыг таслан зогсоох шаардлагатай байна. Жишээлбэл ХУД-н 2-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Б” нэртэй баарны архи согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл цуцлагдсан боловч аж ахуйн нэгжийн нэрээ өөрчлөн “НБ” гэж нэрээ өөрчлөн дахин тусгай зөвшөөрөл авсан, мөн тус дүүргийн 9-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “БН” нэртэй хүнсний дэлгүүрийн тусгай зөвшөөрөл цуцлагдсан боловч ЭБТС гэж нэрээ өөрчлөн дахин зөвшөөрөл авч урьд өмнө нь гаргаж байсан зөрчлөө дахин давтан гаргасаар байна. Энэ мэт аж ахуйн нэгжүүдэд дахин тусгай зөвшөөрөл олгохгүйгээр хуульчлах нь зүйтэй гэж үзэж байна.

Мөн баар ресторан, кафе, супер маркет, хүнсний дэлгүүрүүд нь өөрийн тусгай зөвшөөрөлөө бусдад түрээслүүлдэг явдал түгээмэл байгаа нь бидний ажилд сөргөөр нөлөөлж байна.

Түрээсээ төлөх гэсэн түрээслэгчид цагийн хуваарь хэтрүүлэн ажиллах, архи согтууруулах ундаа хэрэглэсэн хүнд архи согтууруулах ундаагаар үйлчлэх, насанд хүрээгүй хүнд архи согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах зэрэг нийтлэг зөрчлийг гаргаж байна.

Иймд АСТТХ-н 5.4 дэхь хэсгийг өөрчлөн найруулж Архи согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллага, архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх эрхтэй баар ресторан, супер маркет, хүнсний

дэлгүүрүүд нь уул зөвшөөрөлийг бусдад түрээслүүлэх, барьцаалах, байршилыг өөрчлөхийг хориглоно гэж өөрчлөн найруулах¹²⁰.

Сүүлийн үед архидан согтуурах явдал нь их дээд, дунд сургуулийн сурагч оюутуудын дунд ихсэж улмаар гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдэх, гэмт хэрэг зөрчлийн хохирогч болох явдлын шалтгаан нөхцөл болж байна. Оюутан сурагчидын нийтийн байр, бүх шатны сургууль, цэцэрлэг, эмнэлэг, сувилалын газарт архи согтууруулах ундаа хэрэглэх, түүгээр үйлчлэхийг хориглосон хуулийн заалт хэрэгжихгүй байгаа нь оюутан сурагч, ард иргэдийн амар тайван амьдрах хүсэл эрмэлзлэлийг хясан боогдуулж хүүхэд залуусийн хөгжилд сөргөөр нөлөөлж улс нийгэмдээ хэрэгтэй сайн хүн болж төлөвшихөд архидалт сөргөөр нөлөөлж байгаа талаар ард иргэдийн зүгээс санал хүсэлт, гомдол ирдэг нь санаадгүй хэрэг огт биш юм. Тиймээс АСТТХ-н 7-р зүйлийн 7.1.4-д Оюутан сурагчидын нийтийн болон хичээлийн байр гэснийг өөрчлөн найруулж “Оюутан сурагчидын нийтийн болон хичээлийн байр түүний ойр орчим 400 метрээс дотогш зайд” гэж өөрчлөн найруулах мөн хуулийн 7.1.7-д Галт тэрэг бүх төрлийн тээврийн хэрэгсэл, усан болон нисэх онгоцны буудлын зөвшөөрөгдсөн цэгээс бусад газар гэснийг өөрчлөн найруулж “Галт тэрэг, бүх төрлийн тээврийн хэрэгсэл, усан болон нисэх онгоцон дотор, галт тэрэг бүх төрлийн тээврийн хэрэгсэл, усан болон нисэх онгоцны буудлын зөвшөөрөгдсөн цэгээс бусад газар” гэж өөрчлөн найруулах¹²¹.

Архи согтууруулах ундааг хэрэглэх, худалдан борлуулах талаар хэвлэл мэдээлэлийн хэрэгслээр сурталчилгаа хийхийг хориглосон зөрчсөн үйлдэл сүүлийн үед ихээр гарах болсон нь энэхүү зөрчлийг арилгуулах, түүнд харицлага тооцох ажлыг тууштай хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

АСТТХ-ийн 9-р зүйлийн 9.2-д заасан Согтууруулах ундаа худалдан борлуулах, хэрэглэх талаар хэвлэл мэдээлэлийн хэрэгслээр сурталчилахыг хориглоно гэсэн заалтыг УДШ-н 2000 оны 151-р тогтоолоор тайлбарласан байдаг ч үүнийг улам боловсронгуй болгон “Бүх төрлийн сонин сэтгүүл, ФМ, радио, телевизээр болон зурагт хуудас самбараар, архи согтууруулах ундааг илт магтсан, хонжворт болон амталгаат, урамшуулалт худалдаа, үйлдвэрлэсэн хуулийн этгээдийн нэрийг бүтээгдэхүүндээ өгөхгүй байх, эсвэл хүний биед тустай металл, химийн элемент, амьтны гаралтай гэх мэтээр сурталчихыг ойлгож гэж өөрчлөн тайлбарлах.

АСТТХ-н 7.8-р зүйлд Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй газарт 00-06 цагийн хооронд цагийн хооронд архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно гэсэн заалтийг өөрчлөн найруулж “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй худалдаа үйлчилгээний газрын зэрэглэл, байршил, хүн амын нягтрал, тухайн нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг харгалзан ялгавартайгаар тогтоох ба 22 цагаас 12 цагийн хооронд архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно гэж” өөрчлөн найруулах. Түүнчлэн санал асуулгад оролцогчидын 15% нь архи согтууруулах ундааг худалдан борлуулах цэг салбарыг цөөлөх, архины үйлдвэрлэл экспортоор оруулж ирэх архи согтууруулах ундааны хэмжээг багасгах гэсэн дүгнэлттэй уялдуулан үйлдвэр худалдааны яамны сайдын 2008 оны 05-р тушаалыг хүчингүй болгон АСТТХ-н 4-р зүйлд “хоёр мянган хүн ам тутамд архи согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх нэг цэг байна” гэж хуульчлан хатуу мөрдлөгө болгох¹²².

Мөн нэг жилд архины хордлогоор нас барсан хүний тоо 1000 хол давсан нь архины хэрэглээ ихэссэн, үйлдвэрлэгч, худалдан борлуулагч нар нь чанарын шаардлага хангахгүй архи согтууруулах ундааг худалдан борлуулсантай холбоотой юм. Үүний эх

¹²⁰ Г.Бямбадорж, Архидан согтуурах явдалтай тэмцэх үйл ажиллагаа, УБ., 2011., 167-р тал

¹²¹ Г.Бямбадорж, Архидан согтуурах явдалтай тэмцэх үйл ажиллагаа, УБ., 2011., 168-р тал

¹²² Хэсгийн байцаагч эрдэм шинжилгээний бага хуралын эмхтгэл, УБ., 2011, 6-р тал

сурвалжийг олохын тулд мөрдөн байцаах алба, эрүүгийн цагдаагийн алба, хэв журмын алба хамтран үр дүнтэй ажиллах шаардлагатай байна.

Ямар нэгэн архидалтай холбоотой хэрэг бүрийн шалтгаан нөхцлийг бүрэн тогтоож хэргийг шалгах явцдаа нас барсан хүн хаана хэзээ хэнтэй архи согтууруулах ундаа хэрэглэсэн, ямар цэг салбараас авсан, цаашлаад уг цэг салбар нь ямар үйлдвэрээс авдаг болохыг тогтоон үйлдвэрлэсэн архи согтууруулах ундаа нь чанарын шаардлага хангаж байгаа эсэхийг мэргэжилийн байгууллагатай хамтран шалгаж тогтоох зэрэг ажлыг хийж хэвших нь зүйтэй гэж бид үзэж байна. Энэхүү ажлыг хийж хэвшүүлэхийн тулд ЭБШХ-д нэмэлт өөрчлөлт оруулж болох юм гэсэн саналуудыг дэвшүүлж байна.

ОЙ ХЭЭРИЙН ТҮЙМРИЙН ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГ ХИЙХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Жамъянсүрэнгийн Ганбаатар
ДХИС-ийн Онцгой байдлын тэнхимийн
ахлах багш, докторант, хурандаа

Монгол Улсын хэмжээнд гарч байгаа ой хээрийн гал түймрийн нөхцөл байдал, шалтгаан нөхцлийг тогтоох, хэргийн газрын үзлэгийг хийхэд анхаарах зарим асуудал, шинжээчид тавих асуултын талаар асуудал хөндсөн сэдэв болно.

НҮБ-ын дэргэдэх галын статистикийн төвөөс ХХI зууны эхний 10 жилд улс орнуудад гарсан гал түймрийн нөхцөл байдалд хийсэн дүгнэлтээс үзэхэд дэлхийн байгаль цаг уурын дулаарал, техник технологийн хөгжил хүн амын өсөлтөөс шалтгаалан ой хээрийн гал түймрийн тоо хохирол жил тутам харьцангуй өсөж байгааг тэмдэглэсэн байна.

Монгол оронд гарч байгаа ой хээрийн гал түймрийн нөхцөл байдал

Гал түймэртэй тэмцэх замаар Үндсэн хуулиар тогтоосон хүмүүнлэг ардчилсан нийгэмд бүх иргэн амьд явах, аюулгүй орчинд амьдрах бололцоог хангах, байгаль экологийн тэнцвэртэй байдлыг хадгалах, төр, аж ахуй нэгж, байгууллагын галын аюулгүй байдлыг ханган улс орны нийгэм эдийн засгийн хөгжлийг тогтворжуулахад гол анхаарлаа хандуулах нь Гал Түймэртэй Тэмцэх Байгууллагын эрхэм зорилго болж байна.

2000–2010 онуудад Монгол улсын хэмжээнд гарсан гал түймрийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд жилд дунджаар 2200 гал түймрийн хэрэг зөрчил гарч, гал түймрийн улмаас 52 хүн нас барж төр байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн өмчинд 5,7 тэрбум төгрөгний хохирол учирсан байна.

2009 онд улсын хэмжээнд ой, хээрийн түймэр 15 аймгийн 67 суманд нийт 120 удаа гарч, түймрийн улмаас 160749,8 га ойн талбай, 244283,3 га бэлчээрийн талбай, нийт 405035,1 га талбай түймэрт өртөн шатаж түймрийг унтраахад 69.3 сая төгрөг, байгаль экологид 533.8 сая төгрөгийн, эд материалын болон бусад зардалд 2.1 сая төгрөгийн нийт 605.2 сая төгрөгийн хохирол учирсан бол өнгөрсөн онд 13 аймгийн 52 суманд нийт 104 удаа ой хээрийн түймэр гарч, нийт 1 сая га талбай шатаж, урьдчилсан байдлаар 938.0 сая төгрөгийн хохирол учирсан бөгөөд түймрийг унтраахад 54,5 сая төгрөг зарцуулаад байна.

2009 онд улсын хэмжээнд гарсан түймрийг аймгаар нь авч үзвэл Архангай 6, Баянхонгор 2, Баян-Өлгий 1, Булган 19, Дархан-Уул 11, Дорнод 7, Завхан 2, Сүхбаатар 3, Сэлэнгэ 37, Төв 7, Увс 2, Улаанбаатар 4, Ховд 5, Хөвсгөл 12, Хэнтий 2 удаа тус тус гарч, гарч байгаа түймрийн шалтгаан нөхцлийг авч үзэхэд тамхи шүдэнзний галаас 13, отогны галаас 10, хил давж орж ирсэн галаас 6, машин тракторын яндангийн очноос 2, аянганаас 2, ил задгай гал үнс нурамнаас 20, айлын гэрийн яндангийн очноос болон айлын гэр шатснаас 2, цахилгаан шугам тасарснаас 1, бусад шалтгаанаар 23 удаа тус тус шалтгаалан түймэр гарснаас 79 түймрийн эзэн холбогдогч шалтгааныг Цагдаагийн байгууллага шалгаж тогтоосон байна.

ХХI зууны эхний 10 жилд манай улсад 1928 хүн тутамд нэг гал, 43 мянган хүн тутамд 1 хүн нас барж байгаа нь дэлхийн 54 оронд сүүлийн 90 жилийн хугацаанд явуулсан гал түймрийн статистик судалгааг үндэслэн НҮБ-ын дэргэдэх Олон улсын галын статистикийн төвөөс 2005 онд гаргасан үзүүлэлттэй харьцуулахад 1000 хүнд ноогдох галын тоогоор 2 дахин бага 100 000 хүнд ноогдох галд нас барсан хүний тоогоор 56.5 хувиар өндөр байна.

Дэлхий дээр энэ байгууллагаас гаргасан судалгаагаар жилд дунджаар 7 000 000, хоногт 19178 гал түймэр гарч, жил бүр 70 гаруй мянган хүн (100000 хүн тутамд 2.7 хүн) гал түймрийн улмаас нас барж байна.

Жил бүр улсын хэмжээнд гарч байгаа гал түймрийн шалтгаан нөхцөлийг нутаг дэвсгэрийн онцлог байдал, байгаль экологи, цаг агаарын нөхцөл, гал гарч байгаа

зонхилох шалтгаанаар үнэлгээ дүгнэлт өгч, гал түймрийн шалтгаан нөхцлийг улирал, сар, өдөр, цаг, гарагаар судлахад дараах үзүүлэлт гарсан юм.

Ой хээрийн түймрийн гаралтын давтамжийг сараар тодорхойлбол 8,9,4,5 дугаар саруудад нийт гал түймрийн 55-70 хувь гардаг нь хавар, намрын хуурайшилттай улирал эхэлж салхины хүч ихсэх, түүнчлэн сүүлийн жилүүдэд дэлхийн цаг агаарын уур амьсгалын эрс өөрчлөлтөөс шалтгаалан зуны улиралд хэт халалт үүсэж байгаагаас шалтгаалан гардагтай холбож үзэх үндэслэлтэй юм. Түүнчлэн түймрийн 65,5 хувь нь 12-16 цагийн хооронд гарч байна.

Гал түймрийн тоог 7 хоногийн гаригууд болон цагаар харьцуулсан үзүүлэлтээс дүгнэлт хийхэд Даваа, Пүрэв /нийт галын 31 хувь/ хамгийн бага гарсан Лхагва гараг /12 хувь/ , цагийн байдлаар 06-12, 16-18 цагуудад нийт гал түймрийн 33.5 хувь нь гарсан байна. /2000-2009 онуудад гал түймрийн нөхцөл байдалд хийсэн судалгаанаас/

Зөвхөн 2007 онд улсын хэмжээнд 2873 удаагийн объектын болон ой, хээрийн түймэр гарч төр байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн өмчинд 199.2 тэрбум төгрөгний хохирол учирсаныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гал түймрийн тоо 14.9 хувиар, хохирол 17.7 дахин өсчээ. Үүнээс зөвхөн ой хээрийн түймрийн хохиролыг авч үзэхэд 2007 онд нийт 228 удаа ой хээрийн түймэр гарч 195.9 тэрбум төгрөгний хохирол учирсаныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гал түймрийн тоо 28 хувиар, хохирол 117.8 дахин тус тус өссөн байна. Гал түймрийн улмаас 83 хүн амь насаа алдаж, 34 хүн түлэгдэж гэмтсэн байна.

2004-2008 онуудад мэргэжлийн байгууллагыг татан буулган үйл ажиллагаа нь доголдсоноос НҮБ-ын галын статистикийн төвийн гал түймрийн тоо хохиролын талаархи өсөлтийн дундаж үзүүлэлт Монгол улсад 3 оронтой тоогоор дахин өссөн нь олон улсын хэмжээнд мэргэжилтнүүдийн анхаарлыг зүй ёсоор татсан юм. Нөгөө талаар дэлхийн байгаль экологийн өөрчлөлт цаг уурын хэт дулаарал, хүний зохисгүй үйл ажиллагаанаас улбаатай Монгол орны ойн бүсэд гарч байгаа түймрийг унтраах үйл ажиллагаа удирдлага зохион байгуулалт, техник зэвсэглэмжийн хангалтгүй байдлаас шалтгаалан ихээхэн хэмжээний талбайг эзлэн экологийн хохиролыг өсгөх нөхцлийг бүрдүүлж байна.

Ой хээрийн түймрийн эзэн шалтгааны тогтооход Улсын Мөрдөн байцаах газрын Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс шинээр байгуулагдан тус хэлтэстэй хуурайшилтын улиралд 7 хоног бүр эзэн шалтгааны талаар мэдээ мэдээлэл солилцож , холбогдогчид авсан арга хэмжээний талаар бүртгэл судалгаа хийж ажиллаж байгаа нь зохих үр дүнгээ өгч байна.

2010 онд ОБЕГ-аас гаргасан мэдээгээр Цагдаагийн байгууллага ой, хээрийн түймрийн хэрэг зөрчлийн нийт 10 хэргийн холбогдогчид 445 000 төгрөгийн захиргааны арга хэмжээ авч, 9 түймрийн хохирол болох 18 628 000 төгрөгийг нөхөн төлүүлж, 8 түймрийн хэрэгт эрүү үүсгэн шалгасан байна.

Ой хээрийн түймрийн үзлэг хийхэд анхаарах зарим асуудал

Ой хээрийн гал түймрийн эзэн шалтгаан нөхцлийг хөдлөшгүй нотлох баримтаар илрүүлэхэд ЭБШ ажиллагааны нэг төрөл болох галын хэргийн газрын үзлэгийг үндэслэл журмын дагуу хууль зүйн хүрээнд зохион явуулах нь хэрэг бүртгэх, мөрдөн шалгах чиглэлийг тодорхойлж тухайн гэмт хэргийг хуулийн хүрээнд шийдвэрлэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

Криминалистикийн шинжлэх ухаанд үзлэг хийх шаардлагатай ойн болон хээрийн түймэр газар эсвэл гэмт хэрэг үйлдэгдсэн хэмээн тооцож буй газрыг ой хээрийн түймрийн хэргийн газар гэж ойлгодог.

Хэргийн газрын үзлэг гэдэг нь гэмт хэрэг учрал болсон газраас хэргийн бодит үнэнийг тогтооход ач холбогдолтой төрөл бүрийн материаллаг объект, түүн дээрх ул мөр, түүний шинж тэмдэг, шинж байдал, өөр хоорондын байрлалыг судлах, дүгнэлт хийх, илрүүлэх, бэхжүүлэхээр хийж буй байцаан шийтгэх ажиллагаа юм.

Ой хээрийн түймрийн гэмт хэргийг халуун мөрөөр авч хэрэгжүүлэх хойшуулашгүй арга хэмжээ нь хэргийн газрын үзлэгээр эхэлдэг. Ой хээрийн түймрийн хэрэг гарсан газар нь

ихээхэн хэмжээний талбай эзэлсэн,түүнчлэн хүмүүс тухайн орчинд тэр бүр байдаггүй, түймэр дээр шатлагын болон гал унтраах явцад гэмт хэрэг гарсан газар дээр ул мөр үгүй болох 2 удаагийн нөхцөл байдал үүсдэг нь түймрийн эзэн шалтгааныг тогтооход зарим нэг хүндрэл учруулдаг.

Ой хээрийн түймрийн хэргийн газрын үзлэгийн тэмдэглэлд түймэрт өртсөн нутаг дэвсгэрийн талбай, шатсан ойн төрөл,бэлчээрийн ургамал шаталтын нөлөөгөөр ямар өөрчлөлтөд орсоныг тодорхой тусгаж бичих шаардлагатай. Ялангуяа хаана анхны түймрийн голомт байсныг тогтоох нь нэн чухал байдаг. Энэ нь цаашид галын хэргийг илрүүлэх, гал гарсан шалтгаан тогтооход үнэлж баршгүй ач холбогдолтой юм. Гал түймрийн хэргийн газрын гол цөм нь гал үүсэн гарсныг тогтоосон эсвэл урьдчилан таамаглаж байгаа гал үүсэн гарсан голомт юм. Зарим тохиолдолд үзлэгийг өндөр температурын үйлчлэлд аль болох бага өртсөн газраас эхлэх нь ашигтай байдаг

Ой хээрийн түймрийн голомтыг тогтоох талаар Б.Е.Мегорскийн онолыг өргөн хэрэглэдэг бөгөөд энэ арга нь түймэр гарсан нутаг дэвсгэрийн хэмжээг тодорхой тасралтгүй үргэлжлүүлэн нүдний баримжаагаар үзэж шалгахыг хэлнэ. Үзлэгийн явцад түймрийн тархалтын чиглэл / цаг агаарын нөхцөл,салхины чиглэл,хурд / , түймэр үүсэн гарсан голомтыг заасан шинж тэмдгүүд, гал гарсан шалтгаантай холбоотой эд мөрийн баримтыг илрүүлнэ. Галын голомтыг тогтооход шатлагын процессын тархалтын хуулиудын талаарх сайн мэдлэг туслана. Хэргийн газарт цаг хугацаа алдахгүй түргэн шуурхай очих /хэргийн газрын ул мөрийг бэхжүүлснээр гал анх үүссэн голомтыг тогтоох/ ,аймаг орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэс болон мэргэжлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах,хэргийн газрын үзлэг хийхэд цаг агаарын нөхцөл байдлыг сайтар тусгасан байх зэрэг асуудал ихээхэн ач холбогдолтой байдаг.

Монгол улсын ой хээрийн бүсэд гарч байгаа гал түймрийн шалтгаан нөхцөл,байршил, шатлагын талбайг тогтоох ажилд зайнаас тандан судлал, газарзүйн мэдээллийн системийн шинжлэх ухааныг ашиглах явдал ихээхэн ач холбогдолтой байдаг.

Ой хээрийн түймрийн хэрэг гарсан байдал, нөхцөл шалтгааныг тогтоохын тулд хийлгэх шинжилгээний үндсэн зорилт нь ой хээрийн түймэр гарсан шалтгаан, гал үүссэн голомт, цаг хугацаа, тархсан чиглэл ,түймэр үүссэн нөхцөл байдал ,цаг агаар, салхины чиглэл ,санаатай үйлдэл бол түймэр тавьсан арга, тухайн орон нутгийн онцлог, ой модны бүтэц / хар мод, хуш, улиас,хус,нарс гэх мэт/ тал хээрийн өвс ургамлын байдал тэдгээрийн түймэрт нөлөөлөгдөх байдал, тухайн бүс нутгийн түймрээс хамгаалагдсан байдал, унтраах ажиллагаанд оролцсон онцгой байдлын албаны болон бусад ажилтаны үйл ажиллагаанд үнэлэлт өгөхөд оршино.

Шинжилгээ хийлгэхийн тулд тухайн нийслэл аймгийн онцгой байдлын газар хэлтсийн холбогдох албан тушаалтанаас тухайн нутаг дэвсгэрт түймрээс урьдчилан сэргийлэх талаар газар нутгийг шалгаж үзээд галын аюулгүй байдлын талаар авах арга хэмжээний тухай бичсэн бичиг баримт , түймэр гарсан газарт хийсэн үзлэгийн тэмдэглэл, үзлэг, туршилтын ажиллагааны үед авсан гэрэл зураг, зурмал схем, тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдөх галын аюулгүй байдлын дүрэм журам зэргийг шинжээчид танилцуулах шаардлагатай.

Шинжээчид тавьж болох асуултууд нь

1. Ойн / хээрийн / түймэр гарсан шалтгаан юу вэ?
2. Түймэр гарахад хүргэсэн ямар нөхцөл байна вэ?
3. Ойн / хээрийн / түймэр нь аянга цахилгаан болон цаг агаарын нөлөө зэргийн аль нэгээс үүсэн гарсан байж болох эсэх?
4. Ойн / хээрийн / түймэр хүчтэй салхинд мод, ургамлын үрэлтээс шалтаалан түймэр гарсан байж болох уу?
5. Ойн / хээрийн / түймэр хөрсөн доорхи хүлэр, ургамлын үндэс болон бусад органик нэгдэл бодисын ялзрал, халалт зэрэг аажим исэлдэлтийн процессын явцад түймэр гарсан байж болох уу?

6. Тодорхой эд юмс нь /нэр заагдсан / хөндлөнгийн ямар нэгэн зүйлээс шалтгаалан шатаж болох уу? /жишээ нь : галт тэрэг, трактор, машины яндангаас гарсан оч, дөлнөөс, машин механизмын эд ангийн хэт халалт болон үрэлтээс, нарны гэрлийн туяанаас, асаасан шүдэнз хаяснаас унтраагүй тамхины ишнээс, үлдэгдэл халуун нурам, цогноос гэх мэт /
7. Түймрийн шатлагын талбай ихсэхэд байгаль цаг агаарын хүчин зүйл нөлөөлсөн үү?
8. Ойд ил задгай гал түлээд үнс нурмаа бүрэн унтраалгүй орхисоноос түймэр гарсан байж болох уу?
9. Тракторын яндангаас гарсан оч нь унтрахгүйгээр ямар нэгэн тодорхой хэмжээний газарт бууж чадах уу? /хэдэн метрийн зайтай газарт бууж болох вэ гэх мэт /
10. Нэр заагдсан тодорхой эд юмс нь тухайн ямар нэгэн нөхцөл нөлөөнөөс өөрөө авалцан шатаж болох уу? /Жишээ нь: амьтны буюу ургамалын гаралтай тос шингэсэн хог, үртэс, хөвөн, даавуу,олс зэрэг нь өөрөө авалцан шатах уу?/
11. Ямар нэг хүн зориуд гал тавьсан шинж тэмдэг байна уу? Байгаа бол чухам ямар аргаар шатаасан ба энэ нь ямар шинж тэмдгээр илэрч байна бэ?
12. Ой хээрийн түймэр чухам хаанаас эхлэн гарч ямар замаар тархсан бэ?
13. Нэр заагдсан тодорхой ямар нэг газар нь гал эхлэн гарсан цэг, голомт мөн үү?
14. Түймрийн байдлаас үзвэл шаталт хэдий хэр удаан хугацаанд үргэлжилсэн бэ?
15. Тухайн нутаг дэвсгэрийг ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажил хэр хийгдсэн бэ ?
16. Уг түймрийн шинж байдлаас үзэхэд анх гал ноцож эхэлсэнээс хойш барагцаалбал ямар хугацаа өнгөрсний дараа хүчтэй түймэр болон их хэмжээний талбайг хамрах бэ?
17. Шаталтаас үлдсэн зүйл нь /нурам, үнс, нүүрс,/ ямар эд материалын /мод, цаас, арьс, даавуу, хөвөн, эсгий, гэх мэт / үлдэгдэл бэ?
18. Нэр заагдсан тодорхой хэмжээний эд юмс нь бүрмөсөн шатаж дуусахад хэдий хэмжээний хугацаа шаардагдах бэ?
19. Түймэр гарсан бүсэд шатах шингэн байсан уу? Байсан бол чухам ямар шингэн байсан бэ?
20. Түймэр унтраах ажиллагаанд оролцсон нэр бүхий хүмүүсийн үйл ажиллагаа нь ой хээрийн түймэр унтраах дүрмийн шаардлагатай тохирч байна уу?
21. Тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалах чиг үүрэг бүхий албан тушаалтан нь түймрээс урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээ хангаж байх үүрэгтэй байх бэ?
22. Тухайн нутаг дэвсгэрийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүрэг бүхий албан тушаалтан нь энэ талаар хийвэл зохих бүх үүргээ гүйцэтгэж зайлшгүй авах арга хэмжээнүүдийг бүрэн авсан байна уу? Хэрэв үүргээ биелүүлээгүй бол ямар ажлуудыг хийсэнгүй бэ?
23. Түймэр унтраах ажиллагаанд оролцсон мэргэжлийн онцгой байдлын албаны алба хаагчдын үйл ажиллагаанд тактикийн алдаа байсан эсэх / Хугацаа алдсан, техник хэрэгсэлийг бүрэн гүйцэд ашиглаагүй, шийдвэрлэх чиглэлийг буруу тогтоосон бол ямар алдаа гаргасан бэ?
24. Түймэр гарах үед явагдаж байсан тодорхой ажлын үед галын аюулгүй байдлыг хангасан бүх арга хэмжээ бүрэн авагдсан байсан уу? Хэрэв дутуу бол ямар арга хэмжээг авах байсаныг аваагүй бэ?
25. Цаашид тухайн нутаг дэвсгэрт түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ямар арга хэмжээ авч, ямар ажил зохиох шаардлагатай байна бэ? Гэх мэт асуултуудыг тухайн хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан тавьж болох юм.

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС ИРГЭД ГАЛТ ЗЭВСЭГ, СУМ ХЭРЭГСЭЛ
ҮЙЛДВЭРЛЭХ, ЗАХИАЛАХ, ХУДАЛДАХ, ТЭЭВЭРЛЭХ, ЭЗЭМШИХ ЖУРМЫН
БИЕЛЭЛТЭНД ТАВИХ ХЯНАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ
БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ**

Сэнгээгийн Гантулга

ДХИС-ийн Эрүүгийн эрх зүйн тэнхмийн багш,
хууль зүйн магистр, цагдаагийн ахлах дэслэгч

Хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэхийг зорьж буй өнөө үед Монгол улсын Цагдаагийн байгууллага хуулиар хүлээсэн үүргээ нийгмийн шинэ харилцаатай уялдуулан биелүүлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах, тэдэнд учирсан эдийн ба эдийн бус хохирлыг гэм буруутай этгээдүүдээр нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх, иргэд галт зэвсэг, сум хэрэгсэл үйлдвэрлэх, захиалах, худалдах, тээвэрлэх, эзэмших үйл ажиллагаанд хяналт тавих, галт зэвсэг ашиглан үйлдсэн гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчилд зохих хууль зүйн хариуцлагыг хүлээлгэх нь цагдаагийн байгууллагын нэн түрүүнд шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлуудын нэг болоод байна.

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 20.4-т “Иргэд галт зэвсэг, сум хэрэгсэл үйлдвэрлэх, захиалах, худалдах, тээвэрлэх, эзэмших үйл ажиллагаанд хяналт тавих”¹²³ үүргийг цагдаагийн байгууллагаас гүйцэтгэх захиргааны үүргийн хүрээнд хамааруулсан зохицуулалт байдаг.

Цагдаагийн байгууллага хуулиар хүлээсэн энэ үүргээ биелүүлэн хяналт тавих явцад иргэд, аж ахуйн нэгжээс захиргааны зөрчил гаргах тохиолдол өсөх хандлагатай байгааг статистик мэдээнээс үзэж болно. Үүнд: Захиргааны хариуцлагын тухай хуулийн 23-р зүйл “Галт зэвсэг болон амьсгал боогдуулах, нулимас асгаруулах бодис хууль бусаар олж авах, авч явах, хадгалах”¹²⁴ зөрчил 2003 онд нийслэлд 11 бүртгэгдэж байсан бол 2010 онд 172 болж, даруй 161 зөрчлөөр буюу 15 дахин өсч, хураасан галт зэвсэг 2003 онд 65 байсан бол 2010 онд 115 болж, даруй 50 галт зэвсгээр буюу 43.4% өссөн үзүүлэлттэй байна. Харин торгуулийн хэмжээ жил дараалан өсч, 2003 онд 63.000 төгрөг байсан бол 2010 онд 704.000 болж өсчээ.¹²⁵

Галт зэвсгийн тухай Монгол улсын хуулийн 6-р зүйлд “Галт зэвсгийн хэв загварыг өөрчлөх, үйлдвэрийн бус аргаар хийж бэлтгэх, ийм галт зэвсгийг өмчлөх, ашиглахыг хориглосон”¹²⁶ байдаг бөгөөд галт зэвсгийг өмчилж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Галт зэвсгийн тухай хуульд зааснаар галт зэвсгийг аюулгүй хадгалах, зарласан хугацаанд бүртгүүлэх, гэрчилгээтэй хэрэглэх үүргийг цагдаагийн байгууллагын өмнө хүлээдэг. Хэрэв галт зэвсгийн тухай хууль зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Галт зэвсгийн тухай хуулийн 21-р зүйлд зааснаар захиргааны арга хэмжээ авдаг. Мөн хуулийн 21-р зүйлээр захиргааны арга хэмжээ авагдсан байдлыг авч үзвэл: 2003 онд 38, 2004 онд 69, 2005 онд 143 зөрчил гэх мэтчилэн жил дараалан өсч, улмаар 2009 онд 158 болж, 2003 онтой харьцуулахад 120 зөрчлөөр буюу 61.2%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Мөн тодорхой журмуудаар цагдаагийн байгууллагаас галт зэвсэг, сум хэрэгсэл үйлдвэрлэх, захиалах, худалдах, тээвэрлэх, эзэмших үйл ажиллагаанд тавих хяналтыг зохицуулсан байдаг. Тухайлбал:

1. Хууль зүйн болон Эрүүл мэндийн сайдын 2003 оны 1-р сарын 15-ны өдрийн 1/112 тушаалаар “Галт зэвсэг ашиглахад харшлах өвчин, бие эрхтний байдлын жагсаалт”-ыг гаргасан. Үүнд: Хоёр гарын эрхий, долоовор хуруугүй, доод

¹Терийн мэдээлэл.УБ.,1993.,№1

¹²⁴ Терийн мэдээлэл.УБ.,1992.,№2

¹²⁵ НЦГ-ын Хэв журмын хэлтсийн тайлан судалгаа.УБ.,2010

¹²⁶ Терийн мэдээлэл.УБ.,2002.,№4

эрүүний протезтой, паркинсоны өчинтэй, шизофрени, эпилепси, оюуны хомсдол, тархины эмгэгшлийн үе дэх ой сулралтай, хоёр нүд нь сохор, тархины цус харвалтаас үүссэн саажилтын хомсдолтой этгээдийг урт буу, гар буу ашиглах боломжгүй харш болохыг заасан. Эдгээр этгээдүүдийг галт зэвсэг ашиглахыг хориглосон заалтыг хэрэгжүүлэх, захиргааны хяналт тавих үүргийг цагдаагийн байгууллага биелүүлдэг. Энэ журмын хувьд дээр дурьдсан галт зэвсэг ашиглахад харшлах зарим өвчнийг нэмж тайлбарласан бол оновчтой гэж бид үзэж байна.

2. ЦЕГ-ын дарга, ГЕГ-ын даргын хамтарсан 2002.01.24-ны өдрийн 36/34 тушаалаар “Галт зэвсгийг улсын хилээр оруулах, зөвшөөрөл олгох, хяналт тавих журам” батлагдаж, энэ журмын 2-р зүйлд “Хуулиар хориглоогүй галт зэвсгийг улсын хилээр оруулах бол ЦЕГ-ын Хэв журмын албанаас галт зэвсгийг улсын хилээр оруулах зөвшөөрөл авах, улсын хилээр оруулах зөвшөөрөл авахын тулд иргэний цагдаагийн байгууллагад бүрдүүлэх материалын жагсаалтыг зааж өгсөн.
3. ЦЕГ-ын даргын 2010.09.29-ны 503 дугаартай тушаалаар Галт зэвсгийг бүртгэх, гэрчилгээ олгох журмыг¹²⁷ баталсан. Энэ журамд цагдаагийн байгууллагаас галт зэвсгийг бүртгэх, гэрчилгээ олгох, Галт зэвсгийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих захиргааны үүргийг гүйцэтгэх дэг горимыг тогтоож өгсөн. Иргэн, хуулийн этгээдийн галт зэвсгийг бүртгэх, гэрчилгээ олгоход тавигдах шаардлага, хориглох зүйл, гэрчилгээ олгох, хамтран эзэмшигчийг бүртгэх, бүртгэлээс хасах, шилжүүлэг хийх, галт зэвсгийг өмчлөх үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг цагдаагийн байгууллага гүйцэтгэхээр заасан.

Энэ нь цагдаагийн байгууллага иргэдийн хариуцлага, үүрэгтэй уялдуулж үйл ажиллагаагаа явуулж, олон нийтийн эрүүл, аюулгүй байдлыг хамгаалах боломж бүрдүүлж байна.

ЦЕГ-ын дарга, ГЕГ-ын даргын хамтарсан 2002.01.24-ны өдрийн 36/34 тоот тушаалд заасны дагуу Монгол улсад галт зэвсэг, сум хэрэгслийн худалдаа эрхлэх зөвшөөрөл бүхий “Их ав” ХХК, түүний охин компаниуд болох Хорсмен клуб ХХК, Асетрэвэл ХХК-ууд тус бүр 2006 онд Хорсмен клуб ХХК 255 галт зэвсэг, 84.000 ангийн, 110.000 спортын зориулалтын сум, Асетрэвэл ХХК 978 галт зэвсэг, 165.000 ангийн, 320.000 спортын зориулалтын сум хэрэгсэл Монгол улсын хилээр оруулж ирэхээр зөвшөөрөл авсан байна.¹²⁸ Харин эдгээр ХХК-иудын 2007 онд Хорсмен клуб ХХК 468 галт зэвсэг, 100.000 ангийн, 5 сая спортын зориулалтын сум, Асетрэвэл ХХК 1400 галт зэвсэг, 260.000 ангийн, 4.5 сая спортын зориулалтын сум хэрэгсэл Монгол улсын хилээр оруулахаар зөвшөөрлийг цагдаагийн байгууллагаас авсан¹²⁹ байгаа нь 635 галт зэвсгээр буюу 20.4%-иар, ангийн зориулалттай сум 111.000-аар буюу 18%-иар, спортын зориулалтын сум хэрэгсэл 9 сая 70.000-аар тус тус өссөн үзүүлэлтэй байна.

Харин 2006 онд энэ хоёр ХХК-ны худалдаалсан галт зэвсэг нийт 728 байсан бол 2007 онд 1240 болж, даруй 512-иор буюу 41.2%-иар өсчээ.

ЦЕГ-ын даргын 2010.09.29-ны 503 дугаартай тушаалаар “Галт зэвсгийг бүртгэх, гэрчилгээ олгох журам” болон Галт зэвсгийн тухай хуульд заасны дагуу иргэн, хуулийн этгээд нь галт зэвсгээ цагдаагийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй бөгөөд 2006 онд 537 иргэн, хуулийн этгээд, харин 2007 онд 1160 иргэн, хуулийн этгээд шинээр авсан галт зэвсгээ цагдаагийн байгууллагад бүртгүүлэн, гэрчилгээ авч, галт зэвсгийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлжээ.¹³⁰

2006-2007 онд Монгол улсын хилээр орж ирж худалдаалагдсан болон мөн онуудад цагдаагийн байгууллагад бүтгүүлэн, гэрчилгээ авсан галт зэвсгүүдийн тоог

¹²⁷ Монгол улсын Цагдаагийн байгууллагын йл ажиллагааны журам.УБ.,2011, 375-р тал

¹²⁸ НЦГ-ын Хэв журмын хэлтсийн тайлан судалгаа.УБ.,2010.02.29

¹²⁹ НЦГ-ын Хэв журмын хэлтсийн тайлан судалгаа.УБ.,2010.02.29

¹³⁰ НЦГ-ын Хэв журмын хэлтсийн тайлан судалгаа.УБ.,2010.02.29

харьцуулан үзвэл: 2006 онд 681 галт зэвсгийг Монгол улсын хилээр Хорсмен клуб ХХК, Асестрэвэл ХХК-ууд оруулж ирснээс /энэхүү тоон үзүүлэлтэнд иргэд хувийн журмаар гадаад орнуудаас Монгол улсын хилээр оруулж ирсэн болон гадаадын жуулчид спортын болон ангийн зориулалтаар оруулж ирсэн галт зэвсгийн тоо ороогүй болно¹³¹/728 галт зэвсэг худалдан борлуулсан байна. Харин 2006 онд 537 иргэн, хуулийн этгээдэд хуульд заасны дагуу цагдаагийн байгууллагад худалдан авсан галт зэвсгээ бүртгүүлж, гэрчилгээ авсан бөгөөд 191 галт зэвсэг цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй. 2007 онд дээрх ХХК-ууд 1240 галт зэвсэг худалдан борлуулснаас 1160 иргэн, хуулийн этгээдэд худалдан авсан галт зэвсгээ цагдаагийн байгууллагад бүртгүүлж, гэрчилгээ авсан байгаа нь 80 галт зэвсэг бүртгэлгүй байгааг илтгэж байна. Энэ бол цагдаагийн байгууллагын иргэн, хуулийн этгээдийн галт зэвсэг, сум хэрэгсэл үйлдвэрлэх, захиалах, худалдах, тээвэрлэх, эзэмших журмын биелэлтэнд тавих хяналт хангалтгүй байгааг илтгэх нэг үзүүлэлт юм.

Галт зэвсэг ашиглан үйлдэгдсэн гэмт хэрэг цагдаагийн байгууллагад 2008 онд 71, 2009 онд 49, 2010 онд 27 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22 нэгж буюу 44.9 хувиар буурсан байгаа хэдий ч галт зэвсэг ашиглан бусдыг санаатай алсан гэмт хэрэг дийлэнх хувийг эзэлж, үүний улмаас сүүлийн 3 жилд 87 хүн амь насаа алдсан байна.¹³² Тухайлбал: 2006.05.03-нд Өмнөговь аймгийн Хилийн цэргийн 0131-р ангид а/ч Тэгшсайхан х/ч Батжаргалыг буудаж амь насыг нь хохироосон, ХБНГУ-ын иргэн болсон 47 настай Л.Чинбатыг нүүрэн тус газар нь буудаж амь насыг нь хохироосон гэх мэт онц хүнд гэмт хэргүүд үйлдэгдсэн байна. Эдгээр галт зэвсэг ашиглан үйлдэгдсэн гэмт хэргүүдээс нэг ТТ маркийн буу нь улсын бүртгэлд бүртгэгдээгүй буу байсан байна.

2008 онд Төв аймгийн Эрдэнэ сумын харьяат Б.Нэргүй, эхнэр Ж.Эрдэнэцэцэг, төрсөн ах С.Батбаяр, Б.Ганбаатар нарын хамтаар 5 дарвик, 1 калибрь буугаар зэвсэглэн Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Төв аймгийн нутгаар явж, иргэдэд буу тулган сүрдүүлж, бурхан, үнэт зүйлс, Delica маркийн автомашин дээрэмдэн, хэсгийн төлөөлөгчийн өөдөөс буудаж, зугтаасан онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдэн иргэдийг цочирдуулсан. Мөн Улаанбаатар хотод 2008.06.14-нд Баянгол дүүргийн 8-р хороо 4-р хорооллын байранд ангийн зориулалттай буугаар иргэн Б-г буудаж амь насыг нь хохироосон, Хан уул дүүрэгт хөршүүд муудалцаж, улмаар нэгийгээ калибрь маркийн буугаар буудаж, биед нь хүнд гэмтэл учруулсан, Нийслэлийн хөдөлгөөнт эргүүлийн газрын алба хаагч хариуцсан чиглэлдээ үүрэг гүйцэтгэж байхдаа Accent маркийн автомашиныг зогсоож шалгатал улсын бүртгэлгүй байлдааны зориулалттай 3 буу авч явцгаасан, 2008.07.01-ны өдөр үүссэн нийгмийн эмх замбараагүй байдлын үеэр 5 хүн галт зэвсгээр буудагдан амь насаа алдсан, 2011.09.07-нд МУИС-ийн харьяа Эдийн засгийн сургуулийн замын эсрэг талд байрлах РС тоглоомын газарт иргэн С иргэн Ц-г буудаж хөнөөгөөд өөрийн амиа хорлосон гэх мэт жишээ энд олныг дурдаж болохоор байна.

Алдагдсан галт зэвсэг, сумны тоо 2006 онд 11 байсан бол 2007 онд 8 галт зэвсэг алдагдсан байна. Үүнд байлдааны АКМ буу 1ш алдагдсан байгаа нь иргэдэд түгшүүр төрүүлж байна.¹³³ Мөн байлдааны зориулалттай Вепрь, АКМ, Скиз, Винтов зэрэг галт зэвсгийг ангийн зориулалтаар хэрэглэх тохиолдлууд цөөнгүй байна. Сүүлийн хэдхэн сарын байдлаар улсын хилээр байлдааныг болон ангийн зориулалттай сум, галт зэвсэг хууль бусаар оруулахаар завдсан тохиолдол ихсэх хандлагатай байна. Сэлэнгэ аймгийн Алтанбулагийн боомтоор ОХУ болон Монгол улсын иргэд байлдааны зориулалтын олон тооны сум хэрэгсэл оруулахыг завдсан, 2008 оны 10 сард Монгол улсын иргэн н.Амараа

¹³¹ 2006 онд Монгол улсын тамирчид 21 галт зэвсэг, Монгол улсын иргэд 60, гадаадын анчид 408 галт зэвсэг Монгол улсын хилээр оруулж ирсэн байна. Харин 2007 онд Монгол улсын тамирчид 42 галт зэвсэг, Монгол улсын иргэд 79, гадаадын анчид 366 галт зэвсэг Монгол улсын хилээр оруулж ирсэн байна. НЦГ-ын Хэв журмын хэлтсийн тайлан, судалгаа.УБ., 2006-2007

¹³² ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төвийн тайлан мэдээ.2008-2010

¹³³ НЦГ-ын Хэв журмын хэлтсийн тайлан, судалгаа.УБ.,2007.10.01 /Шуурхай удирдлагын төвийн хоногийн мэдээнээс тивэрлэсэн/

гэгч АНУ-аас 98.500 ширхэг байлдааны болон ангийн зориулалттай сумыг гаальд худал мэдүүлэн оруулж ирснийг тагнуул, цагдаагийн байгууллагынхан илрүүлэн тус тус шалгаж байна.

Иймд судалгааны үр дүнд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Монгол улсын хилээр оруулж ирэн худалдаалагдаж буй галт зэвсгүүдэд тавих хяналтыг сайжруулах, худалдаалагдаж буй галт зэвсэг тус бүрийг бүрэн гэрчилгээжүүлэх, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх зорилгоор “Их ав” ХХК-тай хамтарч тус ХХК-аас галт зэвсэг, сум хэрэгсэл худалдан авах гэж буй иргэдэд Хууль сайд болон Эрүүл мэндийн сайдын 2003.01.15-ны өдрийн 1/112 тоот тушаалын дагуу “Галт зэвсэг ашиглахад харшлах, өвчин, бие эрхтний байдлын жагсаалт”-д хамаарах эсэх, мөн урьд нь ял шийтгэгдэж байсан эсэхийг шалгуулан харшлах шалтгаангүй бол худалдаалахыг зөвшөөрч, иргэн, хуулийн этгээд галт зэвсэг худалдан авсан тохиолдолд тухайн галт зэвсгийг гэрчилгээжүүлэн, улсын нэгдсэн санд бүртгэх. Ингэхийн тулд цагдаагийн байгууллагаас алба хаагч тус галт зэвсэг худалдаалах төв дээр сууж ажилласнаар, тухайн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахын зэрэгцээ, галт зэвсгийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн байдлыг газар дээр нь шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг цаг тухай бүр нь арилгуулах, худалдаалагдаж буй галт зэвсэг, сум хэрэгсэл нэг бүрийг бүртгэлд авч гэрчилгээжүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой юм. Мөн ийнхүү нэг цэгийн үйлчилгээг бий болгосноороо албан тушаалтнуудын хүнд суртал, шат дамжлагыг үгүй болгох, цагдаагийн байгууллага, иргэдийн харилцаа шинэ шатанд гарах нөхцөл бүрдэх юм. Цаашилбал: Галт зэвсэг, сум хэрэгсэл нэг бүрийг нэгдсэн бүртгэлд авснаар гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчлөөс урьдчилан сэргийлэх, галт зэвсэг ашиглан үйлдэгдэж буй гэмт хэргийг цагийн тухай бүр нь түргэн шуурхай илрүүлэх боломж илүү их бүрдэж өгөх юм.
2. Монгол улсын хилээр Монгол улсын тамирчид, Монгол улсын иргэд, гадаадын анчдын оруулж ирж буй галт зэвсэг, сум хэрэгсэлд тавих хяналтын сайжруулах, үүний тулд нэгдсэн бүртгэлийн дата-санг нэн даруй бий болгох
3. Хил хамгаалах байгууллага, гааль, тагнуул, цагдаагийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, техник технологийн шинэчлэлийн нэн даруй хийх
4. Галт зэвсэг, сум хэрэгсэл худалдаалах төвүүдийн харуул хамгаалалтыг сайжруулах
5. Галт зэвсэг, сум, хэрэгсэл хууль бусаар худалдаалж буй иргэд /ченж/ нарт тавих хяналтыг чангатгах

ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТОГТОЛЦООНД КРИМИНАЛИСТИКИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Батхишигийн Лхагвасүрэн
ДХИС-ийн Шүүхийн шинжилгээний тэнхимийн
багш, докторант, цагдаагийн ахмад

1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн Хуулийн Хоёрдугаар бүлэгт хүний эрх, эрх чөлөөг тунхагласан байдаг ба хүний эрх, эрх чөлөө нь Үндсэн хуулийн эрх зүйн томоохон институт билээ.

Өнөөдөр Монгол Улсад хүний эрхийг бүрэн хамгаалж чадаж байна уу?

Хүний эрхийг хамгаалах олон арга байдаг. Гэвч бид нэг аргын талаар хаана, хаанаа ярихгүй байна. Энэ бол криминалистик юм. Криминалистик нь хүний халдашгүй эрхийг хамгаалахаас гадна бусад олон эрхийг хангах боломжтой.

Аливаа этгээдийг гэмт хэрэгт холбогдуулан мөрдөн шалгах, шүүн таслах, ял шийтгэл оногдуулах ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх нь тухайн улс орны хүний эрхийн төлөв байдлыг харуулах нэг чухал үзүүлэлт байдаг.

Хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах нь Монгол Улсын Үндсэн Хуульд заасан төрийн үүрэг юм.¹³⁴

Эмнести интернэшнл байгууллагаас гаргасан Эрүү шүүлтээс сэргийлэх 12 заалтад хөтөлбөрийн удиртгал хэсэгт “эрүү шүүлт нь бидний дунд оршсоор, дэлхий даяар түүнийг хэрэглэсээр байна. Үүнд Олон улсын хүний эрхийн Эмнести Интернэшнл байгууллагын арга туршлага, хууль эрх зүйн хамгаалалт ч дутах байна”¹³⁵ гэжээ.

1990 оноос хойш хүний эрх, эрх чөлөөний батлагааг эрх зүйн хэм хэмжээгээр хангах, баталгаажуулах талаар олон талт ажлыг хийж байгаа хэдий ч ЭБША-ны явцад хүний эрх зөрчигдөж байгаа асуудал яригдсаар л байна. Тухайлбал: 2008 оны 06 дугаар сарын 25-ны өдөр болсон “Эрүү шүүлттэй тэмцэх нь” зөвлөлдөх уулзалтанд ХЭҮК-ийн гишүүн, доктор П.Оюунчимэг “Эрүү шүүлтийн бүхий л арга хэрэгсэл өнөөдрийг хүртэл амь бөхтэй дэлхий дахинаа оршсоор байна”¹³⁶ гэж, доктор, профессор Ж.Бямбаа “мөрдөн байцаалтыг дан ганц байцаалт хэмээн үзэх, шүүхийн өмнөх шатанд бүхий л нотлох ажиллагааг дан ганц байцаалтаар хэрэгжүүлэхээр туйлшрах явдал нийтлэг шинжтэй байна. Янз бүрийн бохир аргуудыг мөрдөн байцаалтын уламжлагдсан жишиглэл мэтээр яс махандаа шингээсэн цагдаагийн ажилтан төдийгүй, прокурор, шүүгч манайд цөөнгүй байна”¹³⁷ гэж, УЕП-ын МБА-ны дэд дарга Ц.Батболд “2002 оны 9 сараас хойш УЕП-ын МБА нь эрүүдэн шүүхтэй холбоотой нийт 38 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна”¹³⁸ гэж, прокурор Е.Сагсай “ЭБША-ны явцад сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорихыг урьтал болгодог, удаан хугацаагаар хорьж байцаадаг, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэг хүлээлгэх арга хэрэгсэл болгох хандлага оршсоор байгаа”¹³⁹ гэж, ЦА-ийн ЭБШЭЗК-ийн тэнхимийн эрхлэгч, цагдаагийн хошууч Б.Эрдэнэбилэг “.....нотлох баримт цуглуулахдаа байцаалтыг хэт шүтэх..... баривчлах эсхүл цагдан хорьж хэрэг хүлээлгэх арга өнөөг хүртэл амь бөхтэй оршиж байна,”¹⁴⁰ гэж өгүүлсэн байна.

Мөн Хүний эрхийн үндэсний комиссоос гаргасан Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаархи 2009 оны илтгэлд “ер нь хэрэг гарсан эсэх, хэрэв гарсан бол уг хэрэгт энэ хүн холбоотой эсэх нь огт тодорхойгүй байхад сэжигтнээр тооцож,

¹³⁴ Монгол Улсын Үндсэн Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.

¹³⁵ Эмнести интернэшнл байгууллагаас гаргасан Эрүү шүүлтээс сэргийлэх 12 заалтад хөтөлбөрөөс.

¹³⁶ “Эрүү шүүлттэй тэмцэх нь” зөвлөлдөх уулзалтын эмхтгэл., УБ., 2008., 61 дэх тал.

¹³⁷ Мөн тэнд., 74 дэх тал.

¹³⁸ Мөн тэнд., 88 дахь тал.

¹³⁹ Мөн тэнд., 94 дэх тал.

¹⁴⁰ Мөн тэнд., 102 дахь тал.

улмаар цагдан хорих гэж махран хөөцөлдөж, хорьж байгаа явдал нь сэтгэл санаа, улмаар бие махбодийн шаналал, дарамтын дор хэрэг хүлээлгэж мэдүүлэг авах сонирхол, оролдогой холбоотой”¹⁴¹, “Манайд хорих, цагдах явдал хэт хавтгайрсан, хэрэг хүлээлгэх гол хэрэгсэл болсон ба энэ нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын «Хэргийг нь шүүхээр таслан шийдвэрлэх хүнийг цагдан хорих явдал нийтлэг журам байх ёсгүй» гэсэн заалтыг шууд, илтээр зөрчиж байгаа харуулж байна”¹⁴² “Манай улсын өнөөгийн практикт тухайн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай баримт цуглуулахгүйгээр сэжигтнийг яаран баривчилж, цагдан хорьж, өөрийг нь байцааж хэргийг нь хүлээлгэдэг хуучирсан арга барил бүрэн арилаагүй байна”¹⁴³ гэж дурьджээ.

Түүнчлэн 2010 оны 11 сарын 02-ны өдөр Швейцарын Женев хотод болсон НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн ээлжит 9 дүгээр хуралдаанд Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаархи үндэсний илтгэл, ХЭҮК болон Монголын ТББ-уудын форумын мэдээллүүдийг хэлэлцүүлэх үеэр¹⁴⁴ Их Британий төлөөлөгч “Монгол Улс Олон Улсын гэрээ, конвенийн заалтыг дотоодын хууль тогтоомжиндоо ягштал тусгаснаар эүү шүүлттэй бүрэн төгс тэмцэж чадахгүй. Бодит ажил зохиож хэрэгжүүлэх шаардлагатай” гэж, АНУ-ын төлөөлөгч “Монгол Улс хүний эрхийг хамгаалах механизмыг хууль тогтоомжиндоо ойлгомжтой байдлаар тусгах шаардлагатай” гэж, Швейцарь улсын төлөөлөгч “Эрүү шүүлттэй тэмцэх хуулийн заалт ойлгомжтой, тодорхой баймаар байна” гэж, Шинэ Зеландын төлөөлөгч “Монгол Улсын цагдаа нар эрүү шүүлтийг хүч хэрэглэх замаар хэрэгжүүлж байгаад санаа зовж байна” гэж, Гана улсын төлөөлөгч “Монгол Улс эрүү шүүлтийг тодорхойлохдоо Олон улсын стандартыг баримтлаагүй байна” гэж тус тус хэлжээ.

2010 оны эхний хагас жилийн байдлаар ХЭҮК хүлээн авсан 94 гомдол, 8 хүсэлтийн 64 нь буюу 62.7 хувь нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаатай холбоотой гомдол байна. Эдгээрийг агуулгаар нь задлавал:

- Хилс хэрэгт шийтгэгдсэн тухай-31,
- ЭБША-г явуулж буй субъектын үйл ажиллагаатай холбоотой-22,
- Эрүүдэн шүүгдсэн талаар-2,
- Өмгөөлөх эрхээр хангуулах, эрх зүйн туслалцаа хүссэн-9 байна¹⁴⁵.

Дээр дурьдсан судлаачдын хэлсэн үг, зарим судлагааны үр дүнгээс үзвэл Монгол Улсад хүний эрхийг зөрчиж буй явдалтай дан ганц эрх зүйн хэм хэмжээг баримталж тэмцэх нь хангалтгүй, түүнчлэн “Мэдүүлэг бол нотлох баримтын хаан” гэсэн Вышинскийн онол хүчтэй хэвээр байсаар байна гэдгийг харуулж байна. Гэтэл дэлхийн орнуудын мөрдөх байгууллага энэ онолоос татгалзаад нилээд хугацаа өнгөрчээ. Учир нь мэдүүлэгт сэжигтэн, гэрч, хохирогчийн ашиг сонирхол, эсвэл сэтгэл зүйн дарамт, сэтгэхүй нөлөөлдөг буюу субъектив нөлөө их байдаг тул ярьсан зүйл нь бодит үнэнд бүрэн төгс нийцэж чаддаггүйг амьдрал өөрөө баталсан байна.

Хуульч бид криминалистик гэдгийг зөвхөн “криминалистикийн шинжилгээ” мэтээр дутуу төсөөлдөг нь криминалистикийн онолын болоод практик ач холбогдлыг бууруулж байна.

Криминалистикийн тухай олон тодорхойлолт байдаг ч товчилбол: «Гэмт явдалд холбоотой бүх үзэгдлийн зүй тогтлыг судлаж, түүнд үндэслэн гэмт хэргийг “мөрдөж нотлох” аргачлалыг боловсруулдаг шинжлэх ухаан» гэж болно.¹⁴⁶ Шүүгч, прокурор, гүйцэтгэх тагнуулын ажилтан, мөрдөгч нарын зайлшгүй эзэмшсэн байх ёстой мэдлэгийн нэгэнд криминалистик зүй ёсоор орно. Өөрөөр хэлбэл, криминалистикийн

¹⁴¹ МУХЭҮК., Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаархи илтгэл-2009., УБ., 125 дахь тал.

¹⁴² Мөн тэнд 130 дахь тал.

¹⁴³ Мөн тэнд 137 дахь тал.

¹⁴⁴ United Nations Webcast: www.un.org/webcast.

¹⁴⁵ Хүний эрхийн үндэсний комисс., Мэдээлэл., 2010 оны 2 \26\., 4 дэх тал.

¹⁴⁶ Б.Лхагвасүрэн., Криминалистикийн шинжилгээ судлал., УБ., 2010., 16 дахь тал.

боловсруулсан зөвлөмж, аргачлалыг ашиглахгүйгээр гэмт хэргийг мөрдөж нотлох гэсэн ойлголт байхгүй.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн гэмт хэргээр яллаулж буй хүн бүр гэм буруутай болох нь хуулийн дагуу нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдох эрхтэй”¹⁴⁷ гэж, мөн Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэхь хэсэгт “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор шүүгч нь хэргийн байдлыг **тал бүрээс нь бүрэн бодитойгоор нотлох** хуульд заасан бүх арга хэмжээг авч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг яллах ба цагаатгах, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх ба хөнгөрүүлэх байдлыг бүрэн тогтоох үүрэгтэй” гэж, тус хуулийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсэгт “Сэжигтэн оргон зугтахыг завдсан, эсхүл онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдэх **хангалттай баримт** байгаа бол түүнийг баривчилна”¹⁴⁸ гэж тус тус заажээ. Дээр дурьдсан “тал бүрээс нь бүрэн бодитойгоор нотлох”, “хангалттай баримт” гэдэг ойлголт нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийг гэмт үйлдлийн мөрөөр нь нотлох, баривчлах гэсэн санаа гэж ойлгож болно.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах албан тушаалтнаас хүний нилээд эрх, эрх чөлөөг хөндсөн олон шийдвэрийг гаргадаг. Эдгээр шийдвэр нь бодит нотлогоонд үндэслэсэн бол тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор гаргаж буй хүний эрхийг хуулийн дагуу хязгаарлаж байгаа зүй ёсны явдал. Харин шийдвэр нь бодит нотлогоонд үндэслээгүй бол хүний эрх, эрх чөлөөг хууль бусаар зөрчиж буй хэрэг болно. Иймд хууль зүйн практикт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа хууль ёсны байхын тулд мөрдөгч, прокурор, шүүгч нарын гаргаж байгаа шийдвэр криминалистикийн буй болгосон бодит нотлогоонд үндэслэсэн байхыг шаардаж байна. Өөрөөр хэлбэл криминалистикийн онолын үндэс нь байгаль, техник, нийгмийн бодит зүй тогтолд суурилсан байдаг тул криминалистик бодит нотлогоо гаргадаг.

Криминалистик хүний эрхтэй нягт холбоотой ба криминалистикийн аргаар хүний эрхийг хангах нь гэмт хэргийг шинжлэх ухааны үүднээс нотлож буй ажиллагаа юм.

Хүний эрх, эрх чөлөөг дээдлэсэн өнөөгийн ардчилсан нийгэмд гэмт бүх явдлыг зөвхөн байцаах, залхаах аргаар сэжигтэн, яллагдагчийг айдаст автуулан, хэрэг хүлээх аргагүй байдалд оруулж хэргийг шийдэх биш харин гэмтний хэргийн газарт үлдээсэн мөрөөр нь буюу шинжлэх ухааны үүднээс “мөрдөж нотлох” ёстой.

Монгол Улсад хүний эрхийг хангах механизмд криминалистикийн эзлэх байр суурь, гүйцэтгэх үүргийн чухлыг мэдрэхгүй байна. Криминалистик хүний эрхийг бодитойгоор хангахын тулд амьдралын шаардлагаар үүссэн шинжлэх ухаан юм. Иймд хүний эрхийг хангахад криминалистикийн гүйцэтгэх үүргийг суртчилан таниулах, цаашлаад шүүх, прокурор, өмгөөллийн байгууллагын үйл ажиллагаанд илүүтэйгээр нэвтрүүлэх шаардлага тулгарч байна. Сүүлийн үед Дотоод хэргийн их сургууль, МУИС-ийн Хууль зүйн сургуулиас бусад “эрх зүйч” бэлтгэдэг сургуулиудад криминалистикийн чиглэлийн хичээл, сургалт явуулахгүй байгаа нь залуу шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгч нар гэмт хэргийг нотлох, хүний эрхийг хангахад криминалистикийн гүйцэтгэх үүргийн чухлыг төдийлөн сайн ойлгохгүй байгаа байдал анзаарагддаг.

Криминалистикийн шинжилгээний ерөнхий зарчмын нэгд “хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хангах” зарчим хамаарна. Хүний халдашгүй эрхийг бодитойгоор хангахын тулд өөрийн орны криминалистикийг дэлхийн орчин үеийн хөгжлийн түвшинд хүргэх зайлшгүй шаардлага тулгарч байна. Ингэхийн тулд хэргийн газрын үзлэгийн чанарыг ахиулан, гэмт үйлдлийн мөрийг заавал илрүүлж, бэхжүүлэх, гэмт үйлдлийн мөрөнд хийх шинжилгээний аргачлалыг боловсронгуй болгох явдал юм.

Тухайлбал наад зах нь хэргийн газрын үзлэг, криминалистикийн шинжилгээ хийхэд хэрэглэдэг хэмжих хэрэгслийг Стандарт, хэмжил зүйн газраар баталгаажуулах

¹⁴⁷ НҮБ., Олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн эмхтэл., УБ., 1992., 14 дэх тал.

¹⁴⁸ Төрийн мэдээлэл., 2002., №5.

Жишээ нь: хэргийн газарт мөрийг хэмжихүйн гэрэл зургийн аргаар бэхжүүлэхэд ашигласан хэмжих хэрэгсэл, дараа нь уг гэрэл зурагт хийх шинжилгээнд ашиглаж буй хэмжих хэрэгслийн нэгж 10см-т 1-2мм-ээр зөрөх\, хэргийн газрын үзлэг болон ЭБШ бусад ажиллагаанд дижитал технологийг нэвтрүүлэх, хэргийн газраас заавал гэмт үйлдлийн мөр илрүүлэх, үзлэгийн тэмдэглэлд мөр бүрийг зөв тодорхойлон бичиж бэхжүүлэх, криминалистикийн нэршилийг зөв ашиглах жишээ нь: хэргийн газрын үзлэгийн тэмдэглэлд бичихдээ: -“хэргийн газраас илрүүлсэн гарын мөр 2 ш” гээд мөр бэхжүүлэх ажиллагааны тогтсон аргачлалыг баримтлахгүй байна. Мөн “хэргийн газраас илрүүлсэн гарын дардас” гэж бичдэг. Хэргийн газраас гарын дардас илрэх магадлал маш бага юм\, байцаалтын тактикийг зөв хэрэгжүүлэх, жишээ нь: цагдан хорино, дулаан хувцас бэлд гэхчилэн айлгах, мэдүүлэг авахдаа хуурч мэхлэх, дарамтлах, мөн Та болсон явдлын талаар ярина уу? гэж тэмдэглэлд бичсэн хэдий ч бодит байдал дээр“-үйлдсэн хэргээ хүлээ” гэж тулгаж асуудаг. Мөр үүссэн хугацааг зөв тогтоох, мөр үүсэх зүй тогтлыг шийдвэр гаргахдаа баримтлах зэрэг нь хүний эрхийг хангах арга болно.

Өмгөөлөгч нар мөрдөн байцаагч, сэжигтэн, хохирогч нарын хооронд зуучлагч хийж байгаа нь нууц биш. Өмгөөлөгч криминалистикийн талаар нилээд мэдлэгтэй байдаг байсан бол хууль зүйн туслалцааг жинхэнэ утгаар нь үзүүлнэ. Хүний эрхийг дээдлэсэн орнуудад криминалистикийн өмгөөлөл өндөр хөгжсөн байдаг. Тухайлбал криминалистикийн шинжилгээний үйлчилгээ үзүүлдэг хууль зүйн товчоодыг хуулиар зөвшөөрсөн байна.

Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэдгийг тогтоохын тулд гэмтний үлдээсэн мөрөөр нотлох нь ялыг шударгаар оногдуулах, эсвэл гэм буруугүй этгээдийг хилсээр шийтгэхээс урьдчилан сэргийлж чадна. Хэргийн газарт гэмт үйлдлийн мөр үүсэх нь зайлшгүй гэдгийг хүний эрхийг дээдэлдэг олон орны криминалистууд хүлээн зөвшөөрсөн байдаг тул хэргийн газраас гэмт үйлдлийн мөр илрүүлэх ажиллагаанд ихээхэн ач холбогдол өгдөг ба хэргийн газраас сэжигтэн этгээдийн гэмт үйлдлийн мөр илрээгүй бол Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактад заасан үзэл баримтлалын дагуу түүнд ял оногдуулахгүй байх зарчим үйлчилдэг байна.

Эцэст нь дүгнэж хэлбэл хүний олон эрхийг бүдүүлгээр зөрчдөг эрүү шүүлтийн үндсэн хэлбэр болох “байцааж нотлох” гэсэн ойлголтыг мөрдөгч нарын сэтгэхүйгээс арчиж, гэмт хэргийг зөвхөн “криминалистикийн аргаар мөрдөж нотлох” ёстой гэсэн үзэл баримтлалыг ЭБША-г хэрэгжүүлэгчдэд төлөвшүүлэх шаардлага өнөөгийн хууль зүйн практикт бий болжээ. Криминалистик нь гэмт хэргийг тал бүрээс нь бүрэн бодитойгоор нотлох хангалттай баримтыг бий болгодог тул ЭБША-нд хүний эрхийг хангахад нэн чухал үүргийг гүйцэтгэдэг шинжлэх ухаан юм.

Ингээд судлаачийн зүгээс дараахь саналыг дэвшүүлж байна.

1. Монгол Улсад эрх зүйч бэлтгэдэг бүх их, дээд сургуулиудад криминалистикийн хичээлийг зохих түвшинд заах.

2. Мөрдөн байцаагч криминалистикийг хангалттай сайн мэддэг бол Монгол Улсын Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг үйлдэхгүй байх боломжтой.

3. Эрүүдэн шүүх явдалтай тэмцэхийн тулд эрх зүйн орчинг сайн бүрдүүлэхээс гадна мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, өмгөөлөгч, эрүүгийн төлөөлөгч нарыг криминалистикийн техник, тактикаар мэргэшүүлэх, энэ чиглэлээр дорвитой ажлыг зохион байгуулах..

4. Хүний эрхийн баталгааг хангахад криминалистикийн гүйцэтгэх үүргийн чухлыг нийтэд суртчилах.

5. Хэргийн газраас гэмт үйлдлийн мөр илрүүлэх ажиллагааг сайжруулах.

6. Криминалистикийн шинжилгээгээр шийдэх асуудлыг нэмэгдүүлэх.

7. “Өмгөөлөх криминалистик”-ийг Монголд бий болгох.

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ БА ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН НИЙГМИЙН АСУУДАЛ

Төмөрбатын Мөнхдалай

ДХИС-ийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн
багш, докторант, цагдаагийн дэд хурандаа

Нийтлэлийн зорилго:

Цагдаагийн албан хаагч, түүний гэр бүлийн гишүүдийн нийгмийн асуудлыг дээшлүүлэхэд зарим хууль тогтоомжийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх нь тэдний эрх зүйн хамгаалалт, нийгмийн баталгааны нэг хэсэг болохын тухайд үр ашгаа өгөх боломжийг нээн харуулахыг эрмэлзсэн болно.

Цагдаагийн алба нь төр ард түмнийхээ өмнө цагдаагийн тангараг өргөж гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах хүндтэй бөгөөд амаргүй ажил албанд нэгэн амьдралаа эгнэгт буцалтгүй зориулсан шилдэг эрчүүдээс бүрддэг билээ.

Цагдаагийн алба хаагчдын эрх зүй, нийгмийн хамгаалалт баталгааг төр хамгаалдаг гэх боловч үнэн хэрэг дээрээ хамгаалж чадаж байна уу үгүй юу гэдэгт бид бүгд анхаарал хандуулах цаг нэгэнт болжээ.

Цагдаагийн алба хаагч нь “Монгол Улсын төрийн албаны хууль”-д заасанчилан төрийн тусгай албан хаагчид хамаарагдахын хувьд төрийн улс төрийн, төр захиргааны, төрийн үйлчилгээний алба хаагчийн нэг адил албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцлийн, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн, эрдмийн зэргийн нэмэгдэл зэрэг цалин хөлс авч ажилладаг ч гэлээ ард иргэд баярлаж, амарч байхад ар гэр амьдрал ахуйгаа огоорсон мэт өдөр шөнөгүй, амралт чөлөөгүй, нойр хоолгүй зүтгэн 25 жилээс дээш хугацаагаар цагдаагийн байгууллагад ажиллах бололцоогүй болтлоо эрүүл мэндээр хохирч явдаг нь хэн ч маргахгүй бодит үнэн юм.

Цагдаагийн албанд орж ажиллаж буй алба хаагчид нь цалингаас өөр орлогогүй, цалингаас цалингийн хооронд өрийн сүлжээнд орж үр хүүхдэдээ боловсрол эзэмшүүлэх, тэдэндээ өвлүүлэх өмч хөрөнгөгүй, дийлэнх нь амьжиргааны хувьд дундаас доогуур орлоготой байдаг ч гэсэн өргөсөн тангарагтаа үнэнч, ажил албандаа чин шударгаар зүтгэж явдаг, эгэл жирийн, даруухан мөртлөө цагдаагаа гэсэн сэтгэл, зүтгэлтэй гавьяатай хүмүүс байдаг юм.

Цагдаагийн алба хаагч нь ардчилсан нийгэмд иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэхийн тулд Монгол Улсын үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг нэг мөр, зөв шударгаар хэрэгжүүлэхэд анхааран, хууль ёсыг чанд сахин ажилладаг хэдий ч Монгол Улсын хөдөлмөрийн тухай хуулийн зарим нэг заалтыг бүрэн хэрэгжүүлдэггүйгээс алба хаагчдын цаг наргүй, амралт чөлөөгүй ажилладаг гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг сахиулахад чиглэсэн хүнд хөдөлмөр нь зохих ёсоор үнэлэгддэггүй бөгөөд бид бүгд нэгэнт тангараг өргөсөн бол хийх л ёстой хэмээн ойлгож дээр дооргүй, нойр хоолгүй, хичээн зүтгэж, ажил албаа залгуулан, тангарагтаа үнэнчээр албан үүргээ гүйцэтгэж явна.

Монгол улсын ”Төрийн албаны хууль¹⁴⁹”, ”Шүүхийн тухай хууль¹⁵⁰”, ”Прокурорын байгууллагын тухай хууль¹⁵¹”-д алба хаагч, ажилтан “...өргөсөн тангарагаасаа няцвал хуульд заасан хариуцлага хүлээнэ...” хэмээн заасанг цагдаагийн

¹⁴⁹ Монгол Улсын Төрийн албаны тухай хууль. 2002 он. 3 дугаар бүлэг. 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. “Төрийн захиргааны алба хаагчийн тангараг”.

¹⁵⁰ Монгол Улсын Шүүхийн тухай хууль. 2002 он. 4 дүгээр бүлэг. 43 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. ”Шүүгчийн тангараг”

¹⁵¹ Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хууль. 2002 он. 5 дугаар бүлэг. 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. “Прокурорын тангараг”

алба хаагч “шаардлага гарвал амь насаа үл хайрлахаа батлан тангараглая¹⁵²” хэмээн тангараг өргөсөнтэй хэрхэн адилтгаж болох юм бэ.

Цагдаа юуны тулд амь насаараа дэнчин тавьж ард түмэн, төрийнхөө эрх ашиг сонирхлыг хамгаалахын төлөө хүчин зүтгэж байгаагийн учир холбогдол, үнэ цэнэ нь “амь насаа үл хайрлахаа батлан тангарагласан энэ үгнээс л хэн бүхэнд тов тодорхой байдаг юм.

Цагдаагийн алба хаагчийн хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, хөдөлмөр эрхлэлт, эрх зүй, нийгэм, эдийн засгийн баталгаа нь Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудаар хамгаалагдан зохицуулагдаж байдаг бөгөөд цагдаагийн хөдөлмөрийг үнэлэхэд “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн заалтыг хэн нэг дарга, албан тушаалтан өөрийн шийдвэрээр, дураар өөрчлөх эрх үгүй.

“Нийгмийн харилцааг бүхэлд нь буюу түүний алив нэг төрлийг нь зохицуулдаг эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогцыг хууль тогтоомж /англ-legislaton, опос-законодательство/ гэх бөгөөд энэхүү ухагдахуунд үндсэн хууль, хуулиуд, Улсын их хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол хамаарна”¹⁵³ гэж академич С.Нарангэрэл өөрийн бүтээлдээ дурьджээ.

Төрийн албаны тухай хуульд “Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн хуулиар зохицуулна¹⁵⁴” гэж заасан бөгөөд дээрхи хуулийн заалт болон тодорхойлолтоос харахад цагдаагийн алба хаагчийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг гагцхүү хуулиар зохицуулна.

Дарга захирагчийн өгсөн тушаал шийдвэр нь хуультай зөрчилдвөл тушаал захирамжийг биш хуулийн заалтыг баримтлах, хууль нь үндсэн хуулийн заалттай зөрчилдвөл үндсэн хуулиа баримтлах нь хуулийг дээдлэх ёсны гол шалгуур, үзэл баримтлал болдог.

Хэн нэгэн дарга захирагчийн өгсөн үүрэг¹⁵⁵ даалгавар¹⁵⁶, тушаал¹⁵⁷ захирамж¹⁵⁸ нь ерөнхий болон шууд утгаараа хууль зөрчөөгүй байх нь чухал бөгөөд тодорхой ажил алба гүйцэтгүүлэхдээ “Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй”¹⁵⁹ гэсэн хуулийн заалтыг анхаарч үзэх шаардлагатай.

Хөдөлмөрийн тухай хуульд заасан хууль ёсоор албадан хөдөлмөрлүүлэх асуудал нь:

1. Гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь шүүхээр тогтоогдон шүүхийн таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолоор 100-500 цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх ял шийтгүүлсэн этгээдийн хөдөлмөр

2. Хуулиар болон хөдөлмөрийн гэрээнд зааснаар дарга захирагчийн өгсөн үүрэг даалгавар, тушаал захирамж биелүүлэн ажиллаж буй алба хаагчийн үйл ажиллагаагаар тус тус хэрэгжих бөгөөд бусад нөхцөлд хууль бусаар албадан хөдөлмөрлүүлсэн гэж үзэх үндэслэл болно.

Цагдаагийн алба хаагчийг хууль болон хөдөлмөрийн гэрээнд заагаагүй нөхцөлөөр илүү цагаар ажиллуулсан, түүнд олгох цалин хөлс болон тэдгээртэй холбогдох асуудлыг хөндөж үзэхэд маргаантай зүйл нилээдгүй байдаг.

Төр засгаас цагдаагийн хөдөлмөрийг үнэлэх, олгох цалин хөлсний хэмжээг тогтоож байгаа асуудалд онцгой анхаарч түүнийг алба хаагч нарын ажил алба,

¹⁵² Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль. 1993 он. 4 дүгээр бүлэг. 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. “Цагдаагийн тангараг”

¹⁵³ С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ. 2007 он. 556 дах тал

¹⁵⁴ Монгол Улсын Төрийн албаны тухай хууль. 2002 он. 3 дугаар бүлэг. 11 дүгээр зүйлийн 6 дах хэсэг.

¹⁵⁵ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 1966 он. 424 дэх тал “биедээн дааж авсан хариуцан гүйцэтгэх зүйл”

¹⁵⁶ Мөн бүтээлийн 174 дэх тал “гүйцэтгүүлэхээр өгсөн үүрэг”

¹⁵⁷ Мөн бүтээлийн 562 дах тал “албаар тогтоож заасан заавар”

¹⁵⁸ Мөн бүтээлийн 271 дэх тал “тушаалын нэг хэлбэр”

¹⁵⁹ Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль. 1999 он. 1 дүгээр бүлэг. 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

амьдралын хэрэгцээ /хэрэглэгдэхүүн/¹⁶⁰, хэрэглээ /хэрэглэхүүн/¹⁶¹-ний зохистой түвшинд хүргэхэд цагдаагийн төв байгууллага, удирдлагын зүгээс шаардлагатай алхамыг шат дараалуулан хийж, хэрэгжүүлэх нь алба хаагчдын амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ болох юм.

Өнөөдөр цагдаагийн алба хаагч, тэдний гэр бүлийн гишүүдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд төр, засгаас тусгайлж онцгойлон цогц арга хэмжээ авах төдийлөн шаардлагагүй бөгөөд гагцхүү хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтыг төрийн байгууллагын аль ч шатанд зөв, бүрэн хэрэгжүүлэх ажлыг сайтар зохион байгуулан үр дүнг тооцож ажиллахад л цагдаа хүчтэй, чадвартай болох боломж бага ч гэсэн нэмэгдэнэ.

Үүний гаргалгаа маш энгийн бөгөөд амархан. Тухайлбал: Цагдаагийн байгууллагад 5 жил ажиллаж байгаа цагдаагийн ахлагчийн сарын үндсэн цалин 260.000 төгрөг, цолны нэмэгдэл 22% буюу 57.200 төгрөг, тусгай албаны нэмэгдэл 10% буюу 26.000 төгрөг, түүний сард авах нийт цалин /НӨТ ороогүй/ 343.200 төгрөг бөгөөд уг цагдаагийн ахлагчийн жилд авах цалингийн хэмжээ $343.200 \times 12 \text{ сар} = 4.118.400$ төгрөг болно.

Цагдаагийн алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ баяр, амралтын өдрүүдэд илүү цагаар ажиллах шаардлага зайлшгүй гардаг.

Монгол Улсад албан ёсоор тэмдэглэн өнгөрүүлж бүх нийтээр амардаг баярын өдөр жилд дунджаар 11 өдөр, амралтын өдөр 7 хоногт 2, сард 8, жилд дундаар 88 удаа тохиох ба үүнд Хөдөлмөрийн тухай хуулийн 52-р зүйлд “Нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтныг **нөхөн амруулаагүй бол** дундаж цалин хөлсийг **2.0 дахин нэмэгдүүлж...**”, мөн хуулийн 53-р зүйлд “Илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг **нөхөн амруулаагүй бол** түүнд **1.5 дахин** түүнээс дээш хэмжээгээр **нэмэгдүүлсэн цалин** олгох”-оор тус тус заасанг баримтлан хэрэгжүүлж ажиллахад хөдөлмөрийн тухай хуулиар баярын болон амралтын өдөр илүү цагаар ажилласан дээрхи алба хаагчийн өдөрт болон сар, жилд авах цалингийн хэмжээг тооцож үзье.

Цагдаагийн ахлагчийн ердийн нэг өдөрт авах цалин 15600 төгрөг /сарын цалин 343.200 төгрөг : ажлын 22 өдөр = 15600 төгрөг/ байх ба ажил үүрэг гүйцэтгэсэн баярын нэг өдөр 15600 төгрөг $\times 2 = 31200$ төгрөгний, амралтын нэг өдөр 15600 төгрөг $\times 1.5 = 23400$ төгрөгний цалинг авах болно. Ингээд уг алба хаагчийн жилд авах цалинг дунджаар тооцоолоход жилд тохиох баярын 11 өдөр $\times 31200$ төгрөг = 343.200 төгрөг, жилд дундажаар 88 амралтын өдөр байна гэж үзэхэд 88 өдөр $\times 23400$ төгрөг = 2.059.200 төгрөг, жилд авах цалингийн хэмжээ болох 4.118.400 төгрөг дээр өмнөх нэмэгдлийг нэмж тооцоход жилд дунджаар 6.520.800 төгрөгний, сард дунджаар 543.400 төгрөгний цалин авах боломжтой болно. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлснээр цагдаагийн ахлагчийн цалин сард 200.200 төгрөгөөр буюу 58.3%-иар нэмэгдэж байна. Энэ нь цагдаагийн алба хаагчдад илүү цагаар ажиллах эдийн засгийн сонирхолыг бий болгож үүнтэй уялдан ажлын үр бүтээл, чанар дээшлэн тэдний ар гэр, ахуй амьдралд жаахан ч гэсэн тус дэм өгөхийг үгүйсгэхгүй. Зах зээлийн харилцааны өнөөгийн нөхцөлд цалин, ахуй хангамж сайн байх тутам мэдлэг боловсролтой чадварлаг боловсон хүчнээр Цагдаагийн байгууллагын эгнээ өргөжиж, алба хаагчдын ажлын үр нөлөө, чанар дээшлэхийн зэрэгцээ байгууллагын үйл ажиллагаанд ахиц дэвшил бий болох нөхцөл болно.

¹⁶⁰ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 1966 он. 765 дах тал. “ аливаа юмыг хийж үйлдэхэд хэрэглэгдэх юмс” юмс”

Аливаа үзэгдэл, үйл явц нь эерэг болон сөрөг талтай байх ба сайн тал нь цагдаагийн алба хаагч илүү цагаар үр бүтээлтэй ажиллан цалингаа нэмэгдүүлэх, нийгмийн асуудлаа тодорхой хэмжээгээр шийдвэрлэх сонирхол байхад, муу тал нь хяналт, тооцоо сулыг далимдуулан бусдын хөдөлмөрийг ашиглах явдал гарч болохыг үгүйсгэх аргагүй юм.

Цагдаагийн албан хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах үүргээ хэрэгжүүлэн, иргэдийн амар амгалан амьдралын баталгааг хангаж ажиллахад тэдэнд эрүүл байх, эрүүл мэндийн асуудал туйлаас чухал бөгөөд эрүүл байж гэмээ нь ажил үүргээ хэвийн гүйцэтгэх боломж нөхцөл бүрдэнэ. Эрүүл байхын үндэс нь амралт¹⁶² бөгөөд өндөр ачаалалтай ажилласан, тодорхой хугацаанд ажил үүрэг гүйцэтгэсний дараа амралт хамгаас чухал байдаг ч цагдаагийн албан хаагч нь ямар ч нөхцөлд ажил үүргээ туйлын чадварлаг, сайн гүйцэтгэхчээд дараа нь амарч бие сэтгэлийн алжаалаа тайлж чаддаггүй.

Ард иргэд, зарим нэг удирдах ажилтны дунд цагдаагийн алба хаагчийг хүн биш робот¹⁶³ мэтээр төсөөлөх явдал байсаар л байна. Роботод засвар үйлчилгээ, тохиргоог цаг хугацаанд нь хийхгүй бол эвдэрч, гацна, хэвийн ажиллах боломжгүй болно. Цагдаа бол автомат биш бие махбодиос бүрдсэн, сэтгэл зүй, оюун ухаантай хүн. Тийм болохоор түүнд тодорхой хугацааны амралт хэрэгтэй.

Төв орон нутгийн Цагдаагийн газар хэлтсийн 530 алба хаагч нараас авсан судалгаагаар “Та баяр ёслол болон амралтын өдөр ажлаад үүнийгээ дараа нь тооцуулдаг эсэх?” гэсэн асуулгад ажил үүрэг тул тооцуулах шаардлагагүй гэж 210 буюу 39.6%, дараа нь нөхөн тооцуулдаг гэж 50 буюу 9.4%, огт тооцдоггүй гэж 270 буюу 50.9% нь хариулснаас үзэхэд нийт 480 албан хаагч буюу 90.5% нь баяр ёслол болон амралтын өдөр ажлаад амралтаа тооцуулаагүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт.1

Асуулт	Хариулсан тоо	Хувь
Ажил үүрэг тул баяр ёслол, амралтын өдөр ажиллаад дараа нь тооцуулах шаардлагагүй гэж үздэг	210	39.6
Дараа нь нөхөн тооцуулдаг	50	9.4
Огт тооцдоггүй	270	50.9

“Та илүү цагаар ажилласныхаа цалин хөлсийг хэрхэн тооцуулдаг вэ?” гэсэн асуулгад судалгаанд оролцогчдын 438 буюу 82.6% нь огт тооцдоггүй гэж, 92 буюу 17.3% нь тодорхой хэмжээгээр урамшуулал хэлбэрээр тооцуулдаг гэж, 0 буюу 0% нь хөдөлмөрийн тухай хуульд зааснаар тооцож авдаг гэж тус тус хариулсан нь илүү цагийн цалин хөлсийг тооцож олгодоггүйг харуулж байна. Хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт. 2

Асуулт	Хариулсан тоо	Хувь
Огт тооцдоггүй	438	82.6
Тодорхой хэмжээгээр урамшуулал хэлбэрээр тооцуулдаг	92	17.3
Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар тооцож авдаг	0	0

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн “Долоо хоногийн ажлын цаг нь 40 хүртэл байна¹⁶⁴. Ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 хүртэл цаг байна¹⁶⁵. Ажлын

¹⁶² Мөн бүтээлийн 39 дэх тал. “биений хүчийг сэргээхээр албач ажил хийхгүй сул байх үе”

¹⁶³ Д.Алтангэрэл. Англи Монгол толь. УБ. 2002 он. 428 дах тал. ”robottroub t-робот-автомат”

¹⁶⁴ Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль. 1999 он. 5 дугаар бүлэг. 70 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

¹⁶⁵ Мөн хуулийн 70 дугаар зүйлийн 2 дах хэсэг.

дараалсан 2 өдрийн хоорондох тасралтгүй амралт нь 12 цаг ба түүнээс дээш хугацаатай байна¹⁶⁶” гэсэн заалтыг удирдлага болгон алба хаагч нарын амрах эрхийг эдлүүлэх нь тэдний хөдөлмөрийн чадвар алдалтыг багасгах, өндөр бүтээмжтэй ажиллах бололцоо нөхцөлийг бий болгож байдаг.

Амралт нь дараахи хэлбэрүүдтэй байж болно. Үүнд:

- Нэгээс доошгүй цагийн хугацаатай үргэлжлэх ажлын өдрийн завсарлага
- 12 цагаас доошгүй хугацаатай үргэлжлэх ажлын хоёр өдрийн хоорондын завсарлага
- 48 цагаас доошгүй хугацаатай үргэлжлэх долоо хоног бүрийн амралт
- Ажлын 15 өдрөөс доошгүй хугацаагаар үргэлжлэх ээлжийн үндсэн болон нэмэлт амралт
- 3,7,10,14 хоногийн хугацаатай үргэлжлэх нөхөн сэргээх амралт
- Баяр ёслолын өдрүүдийн амралт зэрэг хэлбэртэй байна.

Цагдаагийн алба хаагч нь дээрхи хэлбэрийн амралтаа хууль ёсоор эдлэснээр хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх, чадвар алдалтыг багасгах, стрессээс гарах, сурч боловсрох, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх, үр хүүхдийнхээ сурлага, хүмүүжилд болон эрүүл мэнддээ анхаарал хандуулах, эмчлүүлж сувилуулах, ар гэрийнхээ ахуй амьдралд туслах, амьдарч буй орчныхоо ая, тав тухтай байдлыг бий болгох зэргээр нийгмийн асуудлаа шийдвэрлэх нөхцөл боломж бүрддэг.

Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай боловсон хүчин бэлтгэх, тэдгээрийг ажил албандаа зөв шударгаар хөдөлмөрлүүлэх, алба хаагчийг урамшуулан тэтгэж үр бүтээлтэй ажиллах нөхцөл бололцоо, ажил амьдралын баталгааг бүрдүүлэх нь хүндээ чиглэсэн юу юунаас ч чухал зорилт болох юм.

Цагдаагийн байгууллагын тухай хуульд алба хаагчийн ээлжийн амралтын нэмэгдэл хоногийг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий алба хаагчид алба хаасан 2 жил тутамд ажлын 3 өдрийн, цагдаагийн бусад алба хаагчид алба хаасан 5 жил тутамд ажлын 3 өдрийн нэмэгдэл амралт олгоно гэсэн заалт нь алба хаагчдын ажлын нөхцөл, ачаалал, сэтгэл зүйн сөрөг нөлөөллийг багасгах зорилготой, зөв зүйтэй асуудал болсон боловч алба хаагчдаас тэр бүр ээлжийн амралтаа бүрэн эдлэх боломж бололцоо байхгүй байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байна.

Судалгаанд оролцогчдоос “Цагдаагийн байгууллагын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор олгогдсон амралтаа бүрэн эдлэдэг эсэх?” асуултанд 56 буюу 10.5% нь бүрэн эдэлдэг гэж, 266 буюу 50.1% нь бүрэн эдлэж чаддаггүй гэж, 138 буюу 26% нь ажлын шаардлагаар дуудагдаж ажилдаа ордог гэж, 60 буюу 11.3% нь өөрийн хүсэлтээр амралт дуусахаас өмнө ажилдаа ордог гэж, 10 буюу 1.8% нь дутуу амарсан ч ондоо багтаан гүйцээж амардаг гэж тус тус хариулсан байна.

Хүснэгт. 3

Асуулт	Хариулсан тоо	Хувь
Бүрэн эдэлдэг	56	10.5
Бүрэн эдлэж чаддаггүй	266	50.1
Ажлын шаардлагаар дуудагдаж ажилдаа ордог	138	26
Өөрийн хүсэлтээр амралт дуусахаас өмнө ажилдаа ордог	60	11.3
Дутуу амарсан ч ондоо багтаан гүйцээж амардаг	10	1.8

¹⁶⁶ Мөн хуулийн 70 дугаар зүйлийн 3 дах хэсэг.

Дээрхи үзүүлэлтээс үзэхэд судалгаанд хамрагдсан алба хаагч нарын 464 буюу 87.5% нь ээлжийн амралтаа бүрэн эдлэж чаддаггүй нь судалгааны дүнгээс харагдаж байна.

Энэ нь нэг талаар цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны онцлогтой уялдан ажлын шаардлагаар офицер бүрэлдэхүүн цагдаа бүрэлдэхүүнээс бага цөөн хоног амарсан. Нөгөө талаар алба хаагч нарын удаан хугацааны амралт нь тэдгээрийн ар гэр, амьдрал ахуйд эдийн засгийн хувьд хүндрэлтэй байсан зэргээс шалтгаалан өөрсдийн санаачлагаар ажилдаа орсноор ээлжийн амралтаа бүрэн эдлэж чадаагүй зэрэг байдлаар илэрдэг байна.

Иймд алба хаагч нарын ээлжийн амралтыг амралт үргэлжлэх хугацааны байдал, ажлын шаардлагыг харгалзан Монгол Улсын хөдөлмөрийн тухай хуулийн 79.4-р зүйлд заасан “ өөрийн хүсэлтээр ээлжийн амралтыг тухайн жилдээ хэсэгчлэн эдлэж болно” гэсэн заалтыг удирдлага болгон хэрэгжүүлж ажиллах нь алба хаагч нарынхаа ая тухтай амрах, ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд тус дөхөм болох биз ээ.

Мөн түүнчлэн төв орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг бодиттой, үнэн зөв үнэлж дүгнэх нь нэг цагдаагийн алба хаагчид оногдох ажлын ачааллыг тооцон бүтэц, орон тоог нэмэгдүүлэхэд түлхэц болох ба ингэснээр нэг алба хаагчид оногдох ачаалал багасаж хуулиар олгогдсон амрах эрхээ бүрэн эдлэх боломж бүрдэнэ.

Амрах эрхээ зохих ёсоор бүрэн эдлэж , биеийн хүчээ нөхөн сэргээж чадаагүй алба хаагч нар албан үүргээ гүйцэтгэж яваад алдаа эндэгдэл гаргах явдал цөөнгүй тохиолддог. Цагдаагийн албан хаагч үүргээ гүйцэтгэж яваад алдаа гаргахад нөлөөлсөн шалтгаан нөхцөл, хүчин зүйл, нөхцөл байдал зэргийг тал бүрээс нь сайтар судлан тогтоож тэднийг албанаас халж цааш нь түлхэх бус, тангарагтаа үнэнч явсан шилдэг цагдаа гэдгээр нь хамгаалж өмгөөлж явцгаая.

Цагдаагийн хүнд , хэцүү албыг цагдаагаас өөр хэн ч хийж гүйцэтгэхгүй. Цагдааг цагдаагаас өөр хэн ч хайрлаж, хамгаалж өмгөөлөхгүй. Энэ бүгдээс дараахи дүгнэлтийг хийж байна.

Дүгнэлт.

1. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажилласнаар цагдаагийн алба хаагч болон тэдний гэр бүлийн нийгмийн асуудал тодорхой хэмжээгээр сайжрах, дээшлэх боломжтой болно.

2. Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах үүргээ хэрэгжүүлэхдээ тодорхой хугацаагаар баяр, амралтын өдрүүдэд илүү цагаар ажилласан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарч, төсөвд тодотгол хийх замаар санхүүжүүлэх ажлыг зохион байгуулах.

3. Ямар ч нөхцөлд цагдаагийн алба хаагчийн ээлжийн амралтыг биечлэн бүрэн эдлүүлдэг байх боломж нөхцлийг бий болгох.

4. Цагдаагийн алба хаагч нарын эрх зүй, нийгэм, эдийн засгийн баталгааг бүрэн хангасан цогц хуулийг шинэчлэн батлан хэрэгжүүлэх зэрэг ажлыг удирдлага зохион байгуулалтын хувьд хийх нь цагдаагийн албан хаагчийн эрх зүй, нийгмийн хамгаалалтыг боловсронгуй болгоход бага ч гэсэн тус дөхөм болох буй заа.

ОЛОН ХҮНД НӨЛӨӨЛӨХ ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ АСУУДЛЫГ ХӨНДСӨН НЬ

Ширэндэвийн Чулуун

ДХИС-ийн Цагдагийн эрх зүйн тэнхимийн
багш, хууль зүйн магистр, цагдаагийн хошууч

Цагдаагийн байгууллагын нэг зорилт бол нийгмийн хэв журам сахиулах, цагдаагийн байгууллагад хуулиар олгогдсон эрх мэдлийг хуулийн хүрээнд үр дүнтэй хэрэгжүүлэх явдал юм.

Цагдаагийн албан хаагч ажил үүргээ биелүүлэх явцад өөрийн болон бусад хүмүүсийн амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хор уршиг учруулах аюултай тулгарч байдаг. Ийм үед цагдаагийн албан хаагч хуулиар хүлээсэн албан үүргээ гүйцэтгэхдээ цагдаагийн тусгай хэрэгсэл хэрэглэх зайлшгүй шаардлага гардаг.

Тусгай хэрэгсэл хэрэглэхэд цагдаагийн алба хаагч нь “Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Үндсэн хууль” зэрэг баримт бичгүүдэд тунхагласан хүний эрхийн талаар тодорхой мэдлэгтэй байх нь зайлшгүй шаардлагатай билээ.

Монгол Улс НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг доромжилон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн гишүүн бөгөөд энэ конвенцид эрүү шүүлт болон бусад зүй бус харьцааг ямар ч нөхцөлд хориглосон.

Монгол Улсын цагдаагийн байгууллага нийгмийн хэв журмыг сахиулах болон нийтийн эмх замбараагүй байдлын үеэр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гэмт хэрэг үйлдэгчийг зохих ёсны хариуцлагад татах үүрэгтэй. Гэвч эдгээр үйл ажиллагаа нь хүч хэрэглэх тухай олон улсын хүний эрхийн стандартад нийцэх ёстой. Эдгээр дүрмийг бодит байдал дээр хэрэгжүүлэх талаар НҮБ-аас олон төрлийн стандартыг боловсруулжээ. Тухайлбал: НҮБ-с 1990 онд баталсан “хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд” хэмээх эрх зүйн баримт бичиг юм.

Энэхүү эрх зүйн баримт бичигт тусгай хэрэгсэл гэдгийг:

Хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн хүн, амьтанд нөлөөлөх, хүний бие болон зэвсэг, техник хэрэгслийг чадамжгүй болгох зорилгоор бүтээгдсэн хэрэгслын цогц юм. гэж тодорхойлжээ.

Мөн “Хууль хэрэгжүүлэгч албан тушаалтнуудын зан үйлийн тухай” НҮБ-ын баримт бичгийн 3 дугаар зүйлд зааснаар “Хууль сахиулагчид нь зөвхөн онцгой тохиолдолд л өөрийн ажил үүргийг хэрэгжүүлэх хэмжээнд хүч хэрэглэж болно.

НҮБ-ын Үндсэн зарчмуудын 9-д “...албан хаагчид галт зэвсгийг зөвхөн өөрийгөө хамгаалах, эсвэл амь насаа алдах, эсвэл хүнд гэмтэл бэртэл авах эрсдэлд байгаа хүмүүсийг аврахаас бусад тохиолдолд хэрэглэж болохгүй” гээд “хүмүүсийн амь насанд шууд аюул учруулж буй онц хүнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ийм гэмт хэрэгтнийг баривчлахад”, “ийм үр дүнд хүрэхэд өөр аюулгүй арга хэмжээ үр дүнгүй байгаа тохиолдолд “ галт зэвсэг хэрэглэнэ гэж заажээ.

Дээрхи байдлуудаас үзвэл цагдаагийн алба хаагч нь цагдаагийн тусгай хэрэгслийг шаардлагатай цаг үед, шаардлагатай нөхцөлд хэрэглэх явдал нь хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн нь харагдаж байна.

Ийм учраас Монгол улсын цагдаагийн байгууллагыг нийгмийн хэв журам сахиулах, нийтийн аюулгүй байдлыг хангах, олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон үед түүнийг албадан тараах болон хууль бусаар зохион явуулж байгаа жагсаал цуглааныг албадан тараах үед хэрэглэх цагдаагийн зэвсэг тусгай хэрэгсэл түүн дотороо олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх эрхийг олон улсын жишигт нийтцүүлэн, цагдаагийн алба хаагч галт зэвсэг тусгай хэрэгсэл хэрэглэх эрх, хэрэглэх үнлэслэл журам, зэргийг цагдаагийн байгууллагын тухай хууль, жагсаал цуглаан хийх

журмын тухай хууль зэрэг хууль тогтоомжид зааж өгөх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Нийгмийн хэв журам зөрчигч, цагдаагийн албан хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцэгчийн идэвхтэй болон идэвхгүй байдлаар илэрхийлэх үйлдлийг хяналтандаа авах, саад хийх, таслан зогсоох зорилгоор хуулиар зөвшөөрсөн тусгай хэрэгсэл болон бусад хэрэгсэл ашиглан явуулж байгаа үйл ажиллагааг олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг намжаах, /албадан тараах/ үйл ажиллагаа гэнэ.

Цагдаагийн зэвсэг тусгай хэрэгсэл хэрэглэх явдал нь хүний төрөлхөөс зайгдсан нэр төртэй байх, амьд явах, аюул заналхийллээс ангид, эрх чөлөөтэй байх эрхийг хөндөж байдаг. Тиймээс хүн бүр өөрийн эрхээ хуулиар хамгаалуулах эрхтэйг санаж хүний эрх, эрх чөлөөг үргэлж хамгаалах, хүндэтгэх, хөхүүлэн дэмжих зарчмыг баримтлах нь зүйтэй.

Цагдаагийн алба хаагч нь тусгай хэрэгсэл хэрэглэхдээ хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, дотоодын Үндсэн хууль зэрэг баримт бичгүүдэд тунхагласан хүний эрхийн талаар тодорхой мэдлэгтэй байх нь зайлшгүй шаардлагатай.

Тиймээс тусгай хэрэгслийг хэрэглэх үндэслэл журмыг нарийн боловсруулж баталсан хууль тогтоомж, журам, заавар, удирдамжийн дагуу хэрэглэх ёстой.¹⁶⁷

Тусгай хэрэгслийн үйлдвэрлэгчээс гаргасан заавар нь гадаад хэл дээр бол хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан орчуулагчаар албан ёсны орчуулгыг хийлгэнэ.¹⁶⁸

Түүнчлэн тусгай хэрэгсэл хэрэглэхийн өмнө болон хэрэглэсний дараа нарийн бүртгэл хөтөлж хууль бусаар буюу хяналтгүйгээр, өөр зорилгоор ашиглах явдлаас зайлсхийх хэрэгтэй. Тиймээс Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5 дугаар бүлгийн 41.1 дэх хэсэг, 42 дугаар зүйлд Цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр албаны зэвсэглэмжид хүлээн авч бүртгэсэн галт зэвсэг, тусгай хэрэгсэл, сумыг хэрэглэнэ гэж заасан байдаг.

“Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл” гэж нийгэмд үүссэн сөрөг нөхцөл байдлыг хяналтанд авах боломжтой хоёр ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг хэрэглэх боломжтой хэрэгсэл юм.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэхийн өмнө тусгай хэрэгсэл хэрэглэх үндэслэл байгаа эсэхийг заавал тодорхойлно. Үндэслэлтэй шаардлага байгаа тохиолдолд тусгай хэрэгслийн төрөл, тоо, хэмжээ, хэрэглэх хүрээ, дэс дараа, тактикийг сонгож, олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэх талаар прокурорын байгууллагад урьдчилан мэдэгдэнэ.¹⁶⁹

Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар 4 төрлийн олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг тодорхойлсон байна. Үүнд:

1/ Олон хүнд нэг зэрэг нөлөөлөх нулимс асгаруулагч

Хоёр ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг нөлөөлөх хамрын самсаа болон нулимсны булчирхайг цочроож нулимс ихээр гоожуулах хий, шингэн төлөв байдалтай бодис /гар бөмбөг, сум, утаа, шүршүүр хэлбэртэй байж болно/;

2/ Олон хүнд нэг зэрэг нөлөөлөх амьсгал боогдуулагч

Хоёр ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг нөлөөлөх амьсгалын замын эрхтнээр дамжин уушгинд хүрч ханиалгах, амьсгал, хоолой боох үйлчлэл үзүүлэх зориулалт бүхий шингэн болон хийн төлөв байдалтай бодис;

¹⁶⁷ НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он., 1 дүгээр зүйл

¹⁶⁸ Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5 дугаар бүлгийн 41.1 дэх хэсэг, 42 дугаар зүйл. Цагдаагийн байгууллагын

үйл ажиллагааны журмын 2010 оны 04 дүгээр сарын 02 –ны өдрийн 173 тоот тушаалын 1-р хавсралтын 233.3.4 дэх

заалт

¹⁶⁹ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 2010 оны 04 дүгээр сарын 02 –ны өдрийн 173 тоот тушаалын 1-р

хавсралтын 236.4.3 Б заалт

3/ Усан хөөрөг

Усыг өндөр даралтаар хүчтэй цацах төхөөрөмж

Усан хөөрөгт машиныг нийгмийн хэв журам хамгаалах албаны даргын тушаалаар томилогдсон дараах 5 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллуулна.

- Багийн ахлагч: Шуурхай удирдлагын штабын даргын шийдвэр, тусгай хэрэгсэл хэрэглэх бүлгийн даргын удирдлагад ажиллаж, багийн үйл ажиллагааг удирдана.
- Усан хөөрөгч: усан хөөргийн төхөөрөмжийн бэлэн байдал, ашиглалтыг хариуцна.
- Оператор: дуу, дүрс бичлэгийн төхөөрөмжийн бэлэн байдал, ашиглалтыг хариуцна.
- Техникч: нулимс асгаруулагч, будагч бодис, усаар цэнэглэх, усны хоолойг холбох, салгах болон нөөц жолоочийн үүрэг гүйцэтгэнэ.
- Механик-жолооч: машины техникийн аюулгүй ажиллагааг ханган ажиллана¹⁷⁰.

4/ Утаан хөшиг үүсгэгч

Үзэгдэх орчныг хязгаарлах зорилгоор утаан хөшиг үүсгэх бодис /гар бөмбөг, сум, утаа, шүршүүр хэлбэртэй байж болно.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх тохиолдлууд

Олон улсын эрх зүйн зохицуулалт

- Хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд бодит хохирол учрах аюул
- Өөр арга, хэрэгсэл хэрэглэх нь үр дүнгүй буюу зайлшгүй нөхцөлд
- Хүч буюу тусгай хэрэгсэл хэрэглэх нь хуулийн биелэлтийг хангахад чиглэсэн байх¹⁷¹

Дотоодын зохицуулалт:

- Нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох;
- Нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгааг таслан зогсоох;
- Байгууллага, иргэдийн мэдэлд байгаа барилга байгууламж, орон байрыг эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх;
- Хориглон эсэргүүцэж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг баривчлах;
- Цагдаагийн алба хаагч болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон;
- Цагдаагийн болон дотоодын цэргийн хамгаалалтад байгаа объект руу нууцаар нэвтрэн орсон, эсхүл зэвсэг хэрэглэн буюу бүлэглэн довтолсон;
- Хүнийг барьцаанд авсан;
- Ялтан,цагдан хоригдогч оргосон, хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээд зугатсан;
- Галт зэвсэг, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох бусад зүйлээр зэвсэглэсэн этгээд зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлэн эсэргүүцсэн;
- Хуяглан хүргэж яваа этгээдийг суллахаар зэвсэг хэрэглэн, эсхүл бүлэглэн довтолсон;
- Хорих, цагдан хорих, баривчлах байранд нийтийн эмх замбараагүй байдал гарч, хүний амь нас, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах бодитой нөхцөл байдал бий болсон¹⁷². гэсэн үндэслэлүүдийг хуульчилан зааж өгсөн боловч түүнийг хэрхэн

¹⁷⁰ Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5 дугаар бүлгийн 41.1 дэх хэсэг, 42 дугаар зүйл. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 2010

оны 04 дүгээр сарын 02 –ны өдрийн 173 тоот тушаалын 1-р хавсралтын 236.7.1 дэх заалт

¹⁷¹ НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он., 4, 9 дүгээр зүйл

¹⁷² Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5 дугаар бүлгийн 41.1 дэх хэсэг, 42 дугаар зүйл. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 2010

оны 04 дүгээр сарын 02 –ны өдрийн 173 тоот тушаалын 1-р хавсралтын 236.4.1 дэх заалт

аяж хэрэглэх хуулийн заалтыг улам боловсронгуй болгож өгөх шаардлагатай байна:

Тухайлбал: Цагдаагийн эрх бүхий албан тушаалтан тодорхой нөхцөл байдалд тусгай хэрэгсэл хэрэглэхдээ урьдчилан болон анхааруулах боломжгүй үед тохиолдолд бие даан шийдвэр гаргаж хэрэглэх эрхийг цагдаагийн байгууллагын тухай хуульд зааж өгөх.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 236-д тусгай хэрэгсэл хэрэглэх талаар олон шинэ заалт оруулсан боловч энэ нь цагдаагийн байгууллагын тухай хуулинд тусгагдаагүй учир алба хаагчидад хуулиа мөрдөж ажиллах уу журамаа баримтлаж ажиллах уу гэсэн эргэлзээг төрүүлсээр байна. Өөрөөр хэлбэл хуулийн хүчин чадлаас илүү эрхийг журмаар зохицуулж байгаа нь онолын хувьд алдаатай боловсруулжээ гэж бид үзэж байна.

Нийтийн хамарсан эмх замбараагүй байдлын үед олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх нь:

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал гэж: Олныг хамарсан үймээн самуун, эвдэн бусниулах, галдан шатаах, эд хөрөнгө устгах, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэх буюу төрийн төлөөлөгчийг зэвсэглэн эсэргүүцэх үйл ажиллагаа нөхцөл байдлыг ойлгоно.¹⁷³

Цагдаагийн албан хаагч албан үүргээ биелүүлэх үед нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэх, эвдэн бусниулах, галдан шатаах, эд хөрөнгө устгах, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэх буюу төрийн төлөөлөгчийг зэвсэглэн эсэргүүцэх зэргээр бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх, ийм үйлдлийг таслан зогсоох үүднээс хүч хэрэглэхээс бусад хэлбэрээр эсэргүйцлийг зогсоох боломжгүй тохиолдолд хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг зохих журмын дагуу тухайн нөхцөл байдалд ялгамжтай хэрэглэнэ.

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэхийн өмнө нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагын үнэлгээ хийж бодит үндэслэл байгаа эсэхийг нарийн тодорхойлно. Мөн түүнчлэн хүрээлэн байгаа орчин, эрсдэл, хэрэглэсний дараа гарч болох үр дагаварыг тооцоолон төлөвлөгөө гарган ажиллана.

Жагсаал цуглааныг албадан тараах, нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын үед цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр байгуулсан шуурхай удирдлагын штаб (цаашид “Удирдлагын штаб” гэнэ)-ын даргын зөвшөөрөлгүй галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглоно.

Олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед ажиллахдаа дараахи зарчмуудыг баримтлана.

Түгээмэл зарчмууд

- Тайван замаар буюу хүч хэрэглэхгүйгээр асуудлыг шийдвэрлэх зарчим

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь жагсаал, цуглааны үед ажиллахдаа жагсагчдын эсрэг аль болох хүч хэрэглэхгүй байх, асуудлыг эв зүйгээр зохицуулах зорилготой байгаагаа үйл ажиллагаагаараа илэрхийлж байх хэрэгтэй. Цагдаагийн байгууллага, алба хаагч нь бололцоотой бүх тохиолдолд галт зэвсэг, олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх тухайгаа урьдчилан сануулах ба тухайн нөхцөл байдалд хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэнэ¹⁷⁴. Энэ нь жагсаал, цуглааныг зохион

¹⁷³ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 2010 оны 04 дүгээр сарын 02 –ны өдрийн 173 тоот тушаалын 2-р

хавсралтын 414.2 дэх заалт

¹⁷⁴ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 2010 оны 04 дүгээр сарын 02 –ны өдрийн 173 тоот тушаалын 1-р

хавсралтын 233.6.1 дэх заалт.

байгуулагч, эсхүл тэдний төлөөлөгчтэй гэрээ хэлэлцээр хийх, сануулга бичиг тараах, чанга яригчаар анхааруулах гэх мэт хэлбэртэй байна.

➤ Хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн хүч хэрэглэх зарчим

Хуулиар зөвшөөрөгдсөн хүч, хэрэгсэл гэдэг нь гагцхүү хуулиар баталж хүлээн зөвшөөрсөн тусгай хэрэгслийг үндэслэл бүхий нөхцөлд хэрэглэнэ. Өөрөөр хэлбэл алба хаагч нь дотоодын хууль тогтоомж, тушаал, заавруудыг сайтар судалсан байх ба хуулиар зөвшөөрөгдөөгүй тусгай хэрэгсэл ашиглаж болохгүй юм¹⁷⁵. Жишээ нь хуулинд тодорхой заасан нулимс асгаруулагчаас өөр төрлийн химийн бодис бусад олон хүнд нөлөөлөх бодис хэрэглэхийг хориглоно.

➤ Бусад арга, хэлбэрээр эсэргүйцлийг таслан зогсоох боломжгүй тохиолдолд хүч хэрэглэх зарчим

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал нь энгийн арга хэрэгсэлээр зогсоох боломжгүй болсон буюу тайван замаар тараах боломжгүй, үр дүнгүй болох нь тодорхой болсон үед тухайн нөхцөл байдал, эсэргүйцэлд тохирсон тусгай хэрэгсэл хэрэглэнэ. Түүнчлэн цагдаагийн байгууллага хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд ноцтой хохирол учирхаар байвал тусгай хэрэгслийг хэрэглэж болно.

➤ Тусгай хэрэгслийг ялгамжтай хэрэглэх

Тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэр гаргаж байгаа эрх бүхий албан тушаалтан нь шийдвэр гаргахдаа жагсаал, цуглаанд оролцогчдын зорилго, нас, хүйс, ямар хүмүүс байгаа зэргээс хамаарч тусгай хэрэгслийг ялгамжтай байдлаар хэрэглэнэ. Энэ нь мөн тухай этгээдийн гаргаж байгаа үйлдэлд тохирсон түүнд чиглэсэн байхыг хэлнэ. Цагдаагийн алба хаагч болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар болон галт зэвсэг хэрэглэж довтолсон, эсэргүүцсэн, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон, бүлэглэн довтолсон хүмүүсийг дотор нь ялгах боломжгүйгээс бусад тохиолдолд өндөр настай, илэрхий насанд хүрээгүй, жирэмсэн, тахир дутуу болох нь мэдэгдэж байгаа хүмүүст тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглох ба шаардлагатай үед мэх хэрэглэж болно¹⁷⁶.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэхээс өмнө:

○ Анхааруулга өгөх

Нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгааг таслан зогсоох, жагсаал, цуглааныг албадан тараах шийдвэрийг биелүүлэх, байгууллага, иргэдийн мэдэлд байгаа барилга байгууламж, орон байрыг эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх тохиолдолд олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэхийн өмнө урьдчилан анхааруулна.

Урьдчилан анхааруулахдаа тодорхой хугацаа зааж, чанга яригчаар зарлах зэрэг боломжтой аргыг хэрэглэнэ.

Урьдчилан анхааруулснаас хойш заасан хугацаанд үйлдлээ зогсоогоогүй бол тусгай хэрэгсэл хэрэглэнэ.

Гэхдээ тухайн ажиллагаа, бүлгийг удирдаж байгаа албан тушаалтны шийдвэрээр урьдчилан анхааруулахгүй хэрэглэж болно¹⁷⁷.

○ Эсэргүйцлээ зогсоох хугацаа өгөх

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь анхааруулга өгсөний дараа тэдэнд сайн дураараа тарж явах бололцоо олгоно. Энэ нь уг жагсаалыг сонирхогч иргэд, хөндлөнгийн хүмүүс тусгай хэрэгсэлийн нөлөөнд өртөхөөс сэргийлнэ. Цагдаагийн байгууллага, алба хаагч нь олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэхдээ анхааруулга өгөхөөс гадна тэдгээр жагсаалд оролцогчид, сонирхогчдыг чөлөөтэй тарж явах бололцоог олгож гарах, явах гарцыг нээсэн байна.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх үед:

¹⁷⁵ НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он., 2 дугаар зүйл

¹⁷⁶ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 2010 оны 04 дүгээр сарын 02 –ны өдрийн 173 тоот тушаалын 1-р хавсралтын 233.7.1 дэх заалт

¹⁷⁷ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 2010 оны 04 дүгээр сарын 02 –ны өдрийн 173 тоот тушаалын 1-р хавсралтын 236.4.6 дах заалт

- Хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэх

Тусгай хэрэгсэл хэрэглэж байгаа зорилго нь тухайн эсэргүйцлийг няцаах, хяналтандаа авах, таслан зогсооход чиглэгдсэн байдаг тул аль болох бага хор уршиг учруулах. Эсэргүүцэл зогссон үед дахин хэрэглэхгүй байх

- Хүний амь нас, нэр хүндэд хүндэтгэлтэй хандаж илүү их хохирол учруулахгүй байх¹⁷⁸

Хэдийгээр тухайн эсэргүүцэгч этгээд чулуу, мод, шил, төмөр шидсэн бусдын амь нас эрүүл мэнд, эд хөрөнгөнд халдсан ч гэсэн түүнийг барисан тохиолдолд иргэдийн урд гаргасан үйлдэлд өширхөх маягаар зодох, дэглэх үйлдэл хийж болохгүй. Түүнчлэн эмх замбараагүй байдалд оролцоогүй энгийн буюу хөндлөнгийн хүмүүсийн аюулгүй байдлыг хангаж ажиллах хэрэгтэй. Шүүхээр гэм буруутай нь тогтоогдоогүй үед хэнийг ч гэм буруутайд тооцож болохгүй гэсэн зарчмыг баримтлах.

- Онцгой байдал болон бусад шаардлагатай байгууллагуудтай ажиллах арга хэмжээ авах

Энэ нь нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед гарч болох эрсдэлүүдийг тооцож Засаг дарга Онцгой байдал, Тагнуул, Эмнэлэг, Шүүхийн шийдвэр биелүүлэх, Прокурор, Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах талаар төлөвлөгөөтэй, урьдчилан дадлага сургууль хийсэн байхыг хэлнэ.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсний дараа:

Эмнэлгийн тусалцааг гэмтэж бэртсэн хүн бүрт яаралтай үзүүлж шаардлагатай арга хэмжээ авах /өмнө үйлдсэн үйлдэлээс үл хамааран/

Тухайн этгээдийн жагсаал, цуглаан дээр гаргасан авир байдлыг үл харгалзах ба хохирсон хэнд ч болов туслах /цагдаа, үймээн гаргагч, жагсагч, жирийн иргэн, сонирхогч г.м/. Тусламж шаардлагатай хүнд газар дээр нь анхны тусламж үзүүлж, эмнэлэгийн байгууллагад хүргэх арга хэмжээг цаг алдалгүй авах, хордсон хүн амьтан гал түймэр гарах эх үүсвэр байгаа эсэхийг шалгаж холбогдох арга хэмжээ авах, иргэдэд зөвлөгөө өгөх¹⁷⁹

- Дээд буюу удирдах албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх

Тусгай хэрэгсэл хэрэглэсэн талаар өгөгдсөн үүргийг хэрхэн биелүүлсэн талаар шуурхай удирдлагын штабт илтгэнэ.

- Бэртэж гэмтсэн хүнийн ар гэрийхэн болон ойр дотны хүмүүст нэн даруй мэдэгдэх¹⁸⁰

Жагсаал, цуглаанд оролцогчид болон иргэд нь хэдийгээр хууль бус үйлдэл хийж хэрцгий авирласан байлаа тусгай хэрэгсэлийн нөлөөлөлд өртөж гэмтэж бэртсэн бол цагдаагийн байгууллагаас уг этгээдийн хэн болохыг тогтооож, ар гэрийнхнийх нь хаяг, утасны дугаарыг тодруулан түүний ар гэр, хамаатан садан, найз нөхдийн аль нэгэнд яаралтай мэдэгдэх арга хэмжээ авна. Уг хүний талаар ямар шийдвэр гарч хаана байгааг нь мөн дуулгана.

- Илтгэх хуудас бэлдэж удирдлагад танилцуулах

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсэн үндэслэл, нөхцөл байдал, арга ажиллагаа, үр дүнгийн тухай эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэнэ. Өөрөөр хэлбэл цагдаагийн төв байгууллагын даргад шуурхай танилцуулж энэ тухай илтгэх хуудас бичих.¹⁸¹

Анхны тусламж үзүүлэх, бие хамгаалах хэрэгслийг ашиглах алба хаагч нь тусгай хэрэгсэл ашиглах, олон нийттэй харилцах, зөрчилдөөн шийдвэрлэх, сэтгэлийн хөдөлгөөнөө дарж сурах чадвараа сайжруулах сургалтанд хамрагдсан байх, бамбай

¹⁷⁸ НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он., 5 /6/ дугаар зүйл

¹⁷⁹ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 2010 оны 04 дүгээр сарын 02 –ны өдрийн 173 тоот тушаалын 1-р хавсралтын 236.4.7-ийн А, Б заалт

¹⁸⁰ НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он., 5 дугаар зүйл

¹⁸¹ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 2010 оны 04 дүгээр сарын 02 –ны өдрийн 173 тоот тушаалын 1-р хавсралтын 236.4.7-ийн В заалт

хамгаалалтын хантааз, хамгаалалтын малгай, шууд үхэлд хүргэдэггүй зэвсэг хэрэглэж, эзэмшиж сурах. Өөрийн мэдэлд байх тусгай хэрэгсэлийг аюулгүй болгоомжтой авч явах.

Бүх төрлийн тусгай хэрэгслийн ашиглалтын албаны бэлэн байдалд цагдаагийн төв байгууллагын нийгмийн хэв журам хамгаалах алба хяналт тавьж цагдаагийн байгууллагын дарга тус байгууллагад байгаа бүх төрлийн тусгай хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын бэлэн байдлыг хариуцах алба хаагчийг томилж, үйл ажиллагаанд нь хяналт тавина.

Бэртгэж гэмтэгсэдэд тусламж үзүүлэх:

Цагдаагийн байгууллагын алба хаагч албан үүрэг гүйцэтгэх явцдаа галт зэвсэг, тусгай хэрэгслийг бусдад хүч хэрэглэсэн тохиолдолд наад захын эмнэлгийн анхны тусламж үзүүлэх шаардлагатай. Ер нь ямар ч осол аюул тохиолдсон үед анхны тусламжийг зөв, тодорхой дэс дараалалтайгаар үзүүлэх явдал нь цагдаагийн ажилтны мэдлэг, чадварын нэг үзүүлэлт мөн.

Анхны тусламж гэдэг нь: Аливаа осол гэмтэл, гэнэтийн биеийн хямрал, өвчин эмгэгийн үед эмнэлгийн тусламж иртэл, гарын доорх материалыг ашиглан, өөртөө болон нөхөртөө үзүүлэх тусламжийг хэлдэг. Өөрөөр хэлбэл эмнэлгийн мэргэжлийн бус жирийн ард иргэдийн өөртөө болон нөхөртөө үзүүлж байгаа тусламжийг анхны тусламж гэж нэрлэх ба үүнийг эмнэлгийн мэргэжлийн түвшинд үзүүлж байгаа анхны тусламжаас ялгаж ойлгох хэрэгтэй.

Анхны тусламжийг зөв үзүүлснээр:

- Амь насыг аврах
- Осол гэмтлээс шалтгаалсан бусад хүндрэлүүдээс сэргийлэх
- Эдгэрэлтийг түргэсгэх
- Эмчилгээний зардлыг бууулах
- Хөдөлмөрийн чадвар алдалтын хугацааг богиносгох зэрэг эерэг үр дагаврыг бий болгоно.

Цагдаагийн нэгж байгууллага нь ямар ч үед албаны бэлэн байдалд байж шаардлагатай үед үүрэг гүйцэтгэх дадлага туршлагатай байх нь цагдаагийн байгууллагын нэн тэргүүний зорилт юм.

**НИЙГМИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХАД МОРЫТ ЭРГҮҮЛИЙГ АШИГЛАЖ
БАЙГАА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ**

Банзрагчийн Батхуяг

ДХИС-ийн Мэргэжлийн сургалтын төвийн сургалтын
ахлах мэргэжилтэн, магистрант, цагдаагийн дэд хурандаа

Монгол улсын Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үндсэн чиг үүргийг биелүүлэх үндсэн нэгж нь нийгмийн хэв журам хамгаалах алба бөгөөд түүний бүрэлдэхүүнд эргүүл нь чухал үүрэгтэй.

“Цагдаагийн байгууллагын тухай хууль”-ийн 11-р зүйлд зааснаар “Цагдаагийн байгууллага нь гудамж талбай үйлчилгээний газар, нийтийн тээврийн буудал, орон сууц зэрэг олон нийтийн газар хууль тогтоомжоор болон төрийн эрх бүхий бусад байгууллагаас тогтоосон нийтээр дагаж мөрдөх журмыг сахин биелүүлж хүн амын амгалан тайван байдлыг хамгаална” гэсэн үндсэн үүргийг цагдаагийн байгууллагын бүх албад өөр өөрсдийн чиг үүргийн хүрээнд биелүүлэхээс гадна эргүүлийн нь тус үүргийг хэрэгжүүлэгч үндсэн субъект болж байдаг.

Монгол Улсад өнөөгийн байдлаар хэв журмын албаны эргүүлийг ашиглаж буй техник хэрэгслийн байдлаас шалтгаалж автомашинт, мотоцикльт, морьт болон ердийн хөсөгт, явган эргүүл гэж ангилж, үүрэг гүйцэтгэх орон зай, тактик, үйл ажиллагааг нь тодорхойлж болох юм.

Үүрэг гүйцэтгэх орон зайны хувьд явган эргүүлийн үүрэг гүйцэтгэх замын хэмжээг 1-1,5 км, мотоцикльтой эргүүл 3-5 км, автомашинт эргүүл 6-8 км-ийн орон зайд үүрэг гүйцэтгэх бөгөөд нутаг дэвсгэрийн болон хэв журмын нөхцөл байдлыг харгалзан маршрутын хэмжээг тухайн үед өөрчилдөг байна.

Сүүлийн жилүүдэд цагдаагийн байгууллага нийгмийн хэв журам хамгаалах бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааныхаа эрх зүйн байдалд өөрчлөлт хийж, үйл ажиллагаагаа иргэдэд ойртуулах, үйлчилгээг шуурхай хүртээмжтэй хүргэх, гарч буй гэмт хэрэг, зөрчлийн тухай цагдаад хандсан иргэдийн гомдол мэдээллийг бүртгэх, түүний мөрөөр авах арга хэмжээг нэг цэгт хянан зохицуулж, дуудлагаар хамгийн богино хугацаанд хүрэлцэн очих, гудамж талбай, эмзэг цэгүүдийг байнгын хөдөлгөөнт эргүүлийн /24 цагийн/ хяналтанд авч, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх ажлыг сайжруулан иргэдийнхээ тайван ажиллаж амьдрах нөхцөл бүрдүүлэхийг нэн түрүүний зорилгоо болгоод байна.

Урьд нь Цагдаагийн байгууллага гэмт хэрэг, зөрчлийн дуудлаганд хугацаа алдан очдог байсан бол хөдөлгөөнт эргүүл ажиллаж эхэлснээс хойш энэ хугацаа 5-6 дахин багасаж 1-10 минутанд очиж үүргээ гүйцэтгэдэг болсон байна.

Нийгмийн хэв журам хамгаалах алба нь гудамж, талбай, олон нийтийн бусад газруудад гарч болох гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоож түүнээс урьдчилан сэргийлэх гол зорилгыг өөртөө хүлээхээс гадна иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах, амгалан тайван байдлыг сахиулах, бусдын өмчлөх эрхийг хамгаалах, баривчлагдсан ба албадан саатуулагдсан этгээдүүдийг харгалзан хамгаалах, хуяглан хүргэх, тээврийн хэрэгсэл ба явган хүний хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавих үүргүүдийг биелүүлж байна.

Мөн нийтийг хамарсан арга хэмжээ, онцгой нөхцөл байдлын үед шаардлагатай бол цагдаагийн бүх хүч хэрэгслийг оролцуулсан эргүүлийн үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж, гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэгдэж байгаа талаархи мэдээ, мэдээллийг тухайн цаг үед олж авахын тулд олон нийттэй байнга холбоотой ажиллахаас гадна гэмт хэрэг, зөрчил үйлдэгч ба гэмт этгээдийг баривчлах, хэргийн газрыг хамгаалах, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ялангуяа түүнийг таслан зогсоох асуудалд бие дааж идэвхитэй арга хэмжээ авах чадвартай байх шаардлагыг ханган биелүүлсээр байна.

Хот суурин газрын ойролцоох зуслан, амралтын газар, алслагдсан суурин, төмөр замын буудал зэрэг төвөөс алслагдмал газарт эргүүлийн үүрэг гүйцэтгэх нь ажиллагаа шаардсан ажил бөгөөд эргүүлийн алба хаагч нарын бие даан үүрэг гүйцэтгэх чадвар, иргэд, олон нийтийн тусалцаа дэмжлэг авах ажлын арга барилаас ажлын үр дүн ихээхэн шалтгаалдаг. Өөрөөр хэлбэл эргүүл нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэхдээ дан ганц өөрийн бололцоонд тулгуурлах бус тухайн дэвсгэр нутаг дахь төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн тусалцаа дэмжлэгт түшиглэн үйл ажиллагааг хэрэгжүүлвэл илүү үр дүнтэй байна.

Эргүүлийн үйл ажиллагааны нэг онцлог нь зам тээврийн салбарт хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тусгайлсан үүргийг хэрэгжүүлэн биелүүлэх явдал байдаг.

Замын цагдаагийн эргүүлийн онцлог нь тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөнд хяналт тавих, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангадаг бол нийгмийн хэв журам хамгаалах эргүүл нь олон нийт, иргэдтэй харьцаагаараа ялгаатай.

Монгол Улсын цагдаагийн байгууллагаас сүүлийн жилүүдэд явуулж байгаа шинэчлэлт өөрчлөлтийн нэг бол 2010 оноос олон нийтийн хэв журмыг хамгаалах үйл ажиллагаанд морьт эргүүлийг ашиглаж Нийслэлийн хөдөлгөөнт эргүүлийн газрын харьяанд хэсэг байгуулан ажиллаж байна.

Тус хэсгийг Нийслэлийн Засаг Дарга, ИХТ-ын хөрөнгө оруулалтаар ОХУ-аас томсог үүлдрийн 20 мориор хангасан байна.

Морьт эргүүл Улаанбаатар хотын төв гудамж, талбай орчимд эргүүлийн нэгдсэн байршилтын дагуу 8 чиглэлд нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр хэв журам сахиулах эргүүл хийж, олон нийтийг хамарсан урлаг, спорт, нэгдсэн арга хэмжээний хүрээнд хамгаалалт, эргүүлийн үүрэг гүйцэтгэж эхэлсэн.

Үүний зэрэгцээ Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт адууны зүчээ, тэжээлийн агуулах, өвсний хашаа, малчин цэргийн байр, гүний худаг зэргийг барьж байгуулсан ба өвөлд нь Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт оторлуулж байна.

Шинэхэн байгуулагдсан морьт эргүүлийн бүтэц, зохион байгуулалт, орон тооны хувьд тус газрын орон тоонд тохируулан машинт болон явган эргүүлийн алба хаагчдаас дотооддоо зохион байгуулж морь унадаг 15 алба хаагчийг сонгон шалгаруулж, морьт эргүүлийн үүрэг гүйцэтгэх алба хаагчаар томилон, морин спортын сургалтын төвд дадлага хийлгэн ажиллуулж байна.

Морьт эргүүл байгуулагдсанаас хойш “Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-д “Морьт эргүүл хийх журам”-ыг Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар 2010 оны 10 дугаар сарын 14-ны өдөр 539 код батлан гаргасан байна.

Харин “Албаны морьдыг жүчээнд байршуулах, сургах, маллах, тэдгээрийг бүртгэх, мал эмнэлэг, эрүүл ахуйн үйлчилгээ үзүүлэх, жүчээнд ажиллах заавар” батлагдаагүй байна.

Цаашид морьт эргүүлийн үйл ажиллагааг сайжруулахад алба хаагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор бүтэц, орон тоог батлан зориулалтын өвөл, зуны улирлын тусгай зориулалтын дүрэмт хувцасаар хангаж /хромон гутал, кальпитай өмд, бүрх малгай, тусгай хэрэгсэл зүүх тоноглолтой бүс, гар станц, хамгаалалтын хантааз, дуулга/, хүн, морийг жинхэнэ ёсоор албаны чиглэлээр үүрэг гүйцэтгэх дадал чадвар сургах, морьдыг зөөж тээвэрлэх тусгай зориулалттай автомашин, чиргүүлийг тоноглох, морьдыг маллах, арчлах, байрлуулах нөхцөлийг улам сайжруулах зэрэг нь одоогоор тулгамдаж буй асуудлын нэгээхэн хэсэг болж байна.

Дээрх тулгамдаж буй асуудлыг онцолсны учир орчин үеийн Монголын Цагдаагийн байгууллагын толь нь болсон нийгмийн хэв журам хамгаалах албаны эргүүлийн цагдаагийн нэгэн хэсэг болсон морьт эргүүлийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдол ихээхэн чухал болохыг тодруулах үүднээс гадаадын өндөр хөгжилтэй орны цагдаагийн газрын морьт эргүүлийн үйл ажиллагааны талаар товч мэдээлэлийг хүргэж байна.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Ханновер хотын цагдаагийн газар нь 20,0 мянган ажилтантай, Цагдаагийн удирдах газар нь мужийнхаа 6 хотын цагдаагийн газрыг удирддаг, бие даасан сургуультай, эргүүлийн албаны үйл ажиллагаандаа усан завь болон нисдэг тэрэг, морь, нохойг ашигладаг.

Үүнээс морьт цагдаагийн нэгжийн хувьд 1920 оноос эхэлж дэлхийн II дугаар дайны үед завсардаж дайны дараа буюу 1946 оноос үргэлжлүүлэн явуулж ирсэн. Нэгж нь 32 морьтой, 36 алба хаагчтай, 51 хувь нь эмэгтэй алба хаагч эзэлдэг бөгөөд хотын төвд байрлалтай тул хотын аль ч цэгт хурдан очих, олон цагаар ажилласан тохиолдолд байрандаа ирж морио түр амрааж, хангалт хийх боломжтой гэж үздэг юм байна.

Морьдыг сонгон авахад хямдхан боловч аль болох том биетэйг нь сонгон авдаг, сүүлийн үед морин уралдаанд оролцож байсан морьдоос авч байгаа бөгөөд 7 хүртэл насалж, 850 кг жинтэй болдог үүлдрийн морьдийг сонгодог байна.

Алба хаагчдыг сонгохдоо эмээл, хэрэглэлээ засаж сэлбэх чадвартай, малын эмч, морь сургах талаар мэргэжлийн эсвэл тийм чадвартай, амьтанд хайртай хүн байхыг чухалчилдаг юм байна.

Морьдыг энгийнээс хүндрүүлэх замаар үүрэг гүйцэтгэхэд учирч болох бүх саад бэрхшээл, сааданд сургаж, зоригжуулан дараа нь тойргоор давхиулж тайвшруулдаг, хөгшин туршлагатай морьдыг бусад залуу морьдоор дагуулан багаар сургалтыг өдөр бүр тодорхой хугацаагаар явуулдаг юм байна.

Ер нь морьдыг сургахад их яаралгүй хөнгөнөөс нь хүндийг хүртэл элдэв дуу чимээ, хөдөлгөөнд ажирахгүй, үргэхгүй болтол нь сургаж бэлтгэдэг.

Морьт цагдаа нь жагсаал, цуглааны үеийн болон цагдаагийн хамгаалалт, олон нийтийг хамарсан арга хэмжээ, эргүүл, самналт баривчлах үйл ажиллагааны үед хүчирхэг, өндөр нуруутай, сургагдсан морьтойгоо тэдэнтэй тулж хүчийг сааруулж зогсоох, тойрог үүсгэх, бүслэх, сэтлэх, жагсагчдыг чиглэл хөдөлгөөнөө өөрчилсөн тохиолдолд дагаж хяналт тавьдаг зэргээр нэг морьтой цагдаа нь 10 явган цагдаагийн алба хаагчтай тэнцэхүйц хэмжээний үүргийг гүйцэтгэдэг ба төдий хэмжээний хөрөнгө хэмнэдэг гэсэн үзэл баримтлалтай юм байна.

Энэ үзэл баримтлалыг 20-иод жилийн өмнөөс боловсруулан гаргасан ба үүний тод жишээ нь 2009 онд зэргэлдээх мужид болсон жагсаал, цуглааны үеэр 10 морьтон цагдаа, 30 явган цагдаагийн алба хаагчид 6000 хүнтэй жагсагчдыг зогсоож чадсан явдлаар тайлбарлахад хангалттай юм.

Морьт цагдаагийн нэгжийн алба хаагчид тайван цагт эргүүлийн үйл ажиллагаанд оролцож, дэг журам сахиулахын зэрэгцээ эрэн сурвалжлах ажиллагаанд оролцож ажилладаг.

Мөн байгаль орчин, морь, амьтан хамгаалах, хүүхэд олон нийтийн үйл ажиллагаанд сайн дураараа оролцож байгууллага, үйл ажиллагаагаа сурталчилж, **“өөрсдийгөө бусдад харуулж, өөрсдөө сайн хянах”** гэсэн зарчмаар ажилладаг байна.

Сүүлийн үед морьтой цагдаагийн алба хаагчийн дуулганд теле хяналтын камер байрлуулж удирдлагын төвөөс хянах бодлого баримталж байгаа ба морьдыг хуяглахыг больж зөвхөн ой модонд явах үед нь хамгаалалт хэрэглэж байгаа юм байна.

Эцэст нь дүгнэхэд Монголын цагдаагийн байгууллагад орчин үеийн морьт эргүүлийн нэгжийг багагүй хөрөнгө хүчээр байгуулан өндөр үнээр гадны морь авч ашиглаж байгаатай зарим хүмүүс санал нийлдэггүй хэдий ч цаг хугацаа өнгөрөх тусам Монголын цагдаагийн морьт нэгж өргөжин монгол морьдоор бүлээ нэмж, үүрэг чиглэлээ өргөжүүлэн, улам мэргэшиж өндөр хөгжилтэй гадаадын орны жишигт хүрч “Монголын морьт цагдаа”-гийн имидж дэлхийд дуурсагдах болно гэдэгт итгэлтэй байна.

**ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ХУУЛЬ ЁСНЫ ШААРДЛАГЫГ ҮЛ БИЕЛҮҮЛЭХ,
ЗАНАЛХИЙЛЭХ ЗӨРЧЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
ТҮҮНД ХИЙСЭН СУДАЛГААНЫ ДҮН**

Намсрайн Буянхүү

Багануур дүүргийн ЦХ-ийн бичиг хэргийн
эрхлэгч, магистрант, цагдаагийн ахлагч

1992 онд “Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хууль” батлагдсан нь захиргааны зөрчил ба хариуцлагын талаарх нийтлэг үндэслэл, журам, захиргааны шийтгэлийн төрөл хэмжээг тогтоон, захиргааны зөрчилтэй хэрэгт хянан шийдвэрлэх ажлыг боловсронгуй болгон журамлаж, захиргааны эрх зүйн олон акт үйлчилж байсныг нэгтгэн Монгол Улсын Үндсэн хуулинд нийцүүлсэн байна.

Уг хуулийн 30² дугаар зүйлд “Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх, цагдаагийн байгууллагад худал мэдээлэл өгөх” зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлагын талаар хуульчилсан¹⁸² байна.

Цагдаагийн байгууллагын бүрэлдэхүүнд орж, түүний нэг эд эс болж ажиллаж амьдарч байгаа миний бие төрийн нэрийн өмнөөс ажил үүргээ гүйцэтгэж буй цагдаагийн алба хаагчийн эрх ашиг зөрчигдөх, улмаар тэдний нэр хүндийг бууруулах, хууль ёсны албан шаардлагыг эсэргүүцэх зэрэг нийгмийн сөрөг үзэгдлийн өнөөгийн түвшинг тодорхойлох зорилгоор судалгаа, шинжилгээний ажил хийхээр зорьж, цагдаагийн байгууллагад 2008-2011 онд бүртгэгдсэн захиргааны зөрчил, цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх заналхийлэх зөрчлийн үзүүлэлтэнд дүн шинжилгээ хийсэн.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн нийт захиргааны зөрчлийн шийдвэрлэлтийн байдлыг 30² дугаар зүйлтэй харьцуулж, сүүлийн 4 жилийн байдлаар судалж үзэхэд¹⁸³:

Мөн Дархан-Уул аймгийн цагдаагийн газар, Төмөр замын цагдаагийн хэлтэс, Нийслэлийн дүүргүүдээс жагсаал цуглаан ихээр зохион байгуулагддаг

д/д	Он	Захиргааны хариуцлагын тухай хуулиар	Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30 ²	Торгосон хүн		Баривчилсан хүн	
				ЗХТХ-иар нийт	30 ² -р зүйлээр	ЗХТХ-иар нийт	30 ² -р зүйлээр
1	2008	129036	6096	30221,5	1216259,0	6147	377
2	2009	215981	6217	25406,0	2663758	6159	501
3	2010	80076	1808	18460,5	2811463	10709	535
4	2011	106310	1885	24074,7	3602157	12380	336

Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтэс, ачаалал ихтэй Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтэс, алслагдсан дүүрэг болох Багануур дүүргийн цагдаагийн хэлтсийн нийт 367 алба хаагчаас “Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх, цагдаагийн байгууллагад худал мэдээлэл өгөх” зөрчлийн талаарх тэдний ойлголт, тухайн зөрчил ямар хэлбэрээр ихэвчлэн илэрдэг, одоогийн үйлчилж буй хууль

¹⁸² “Төрийн мэдээлэл” сэтгүүл 1992 он №3-4

¹⁸³ Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл судалгааны төвийн 2008,2009,2010,2011 оны статистик мэдээнээс авсан тоо баримт

эрх зүй орчин албан үүрэг гүйцэтгэхэд хир нийцэж байгаа болон боловсронгуй болгох талаар санал асуулгын хуудсаар авсан саналыг нэгтгэн дүн шинжилгээ хийлээ.

Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн, заналхийлсэн, зөрчлийг шийдвэрлэж байгаа байдалд дүгнэлт хийж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилгоор Нийслэлийн хөдөлгөөнт эргүүлийн газар, Баянзүрх, Сүхбаатар, Багануур дүүргийн цагдаагийн хэлтэс, Төмөр замын цагдаагийн хэлтэс, Дархан-Уул аймгийн цагдаагийн газрын 367 алба хаагчаас санал асуулгын хуудсаар авсан саналыг нэгтгэхэд:

-Санал асуулгад оролцсон алба хаагчдын 41 буюу 11.2 хувь нь мөрдөн байцаагч, 34 буюу 9.3 хувь эрүүгийн төлөөлөгч, 17 буюу 4.6 хувь нь хэрэг бүртгэгч, 76 буюу 20.7 хувь нь хэсгийн байцаагч, 54 буюу 14.7 хувь нь хүүхдийн болон хэв журмын байцаагч, 145 буюу 39.5 хувь нь ахлагч бүрэлдэхүүн байна.

Насны ангиллын хувьд 197 буюу 53.7 хувь нь 20-30 насны, 133 буюу 36.2 хувь нь 31-40 насны, 36 буюу 9.8 хувь нь 41-50 насны алба хаагч эзэлж байна.

Боловсролын тухайд 272 буюу 74.1 хувь нь дээд, 95 буюу 25.9 хувь нь бүрэн дунд боловсролтой байна.

Цагдаагийн байгууллагын зорилт, чиг үүрэг болон хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд иргэд олон нийтийн зүгээс таны эсрэг сөрөг хандлага гардаг уу гэсэн асуултанд 158 буюу 43.1 хувь нь “Тийм”, 17 буюу 4.6 хувь нь “Үгүй”, 192 буюу 52.3 хувь нь “Заримдаа” гэж тус тус хариулсан байна.

Таны ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотойгоор иргэд олон нийтэд тавьсан хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх зөрчил гарч байсан бол ямар хэлбэрээр илэрдэг вэ? гэсэн асуултанд давхардсан тоогоор 284 буюу 77.4 хувь нь хэл амаар доромжлох, 136 буюу 37.1 хувь нь заналхийлэх, 149 буюу 40.6 хувь нь гүтгэх гэж, 66 буюу 18.0 хувь нь хүч хэрэглэх, 84 буюу 22.9 хувь нь биед халдах, 96 буюу 26.2 хувь нь дүрэмт хувцас урах гэж тус тус хариулсан байна.

Тухайн үед зөрчил гаргасан иргэнд эрүүгийн болон захиргааны ямар хариуцлага хүлээлгэсэн бэ? гэсэн асуултанд 25 буюу 6.8 хувь нь эрүүгийн хариуцлагад татсан, 65 буюу 17.7 хувь 7-14 хоног баривчилсан, 162 буюу 44.1 хувь торгуулийн арга хэмжээ авсан, 29 буюу 7.9 хувь нь хоорондоо эвлэрч зохицсон, 133 буюу 36.2 хувь хариуцлага хүлээлгээгүй гэж тус тус хариулсан байна.

Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэхэд хууль эрх зүйн орчин хэр нийцэж байна вэ? гэсэн асуултанд 52 буюу 14.2 хувь нь “Нийцэж байна”, 86 буюу 23.4 хувь “Сайн мэдэхгүй байна”, 229 буюу 62.4 хувь нь “Нийцэхгүй байна” гэж тус тус хариулсан байна.

Та хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлага бий юу? гэсэн асуултанд 316 буюу 86.1 хувь нь “Шаардлагатай”, 17 буюу 4.6 хувь нь “Шаардлагагүй”, 34 буюу 9.3 хувь нь “Сайн мэдэхгүй байна” гэж тус тус хариулсан байна.

Санал асуулгад оролцсон 350 алба хаагч буюу 95.3 хувь нь албан үүргээ гүйцэтгэх явцдаа ямар нэгэн байдлаар сөрөг хандлагатай тулгарсан байна. Тухайлбал: алба хаагчдын дийлэнх буюу 73.8 хувь нь доромжлуулах, заналхийлэх, гүтгэх халдлагын хохирогч болж, 26.2 хувь нь дүрэмт хувцсаа уруулсан байна. Халдлагад өртсөн алба хаагчдын 53.7 хувь нь 20-30 насны, 74.1 хувь нь дээд боловсролтой алба хаагч байна.

Албан үүрэг гүйцэтгэхэд хууль, эрх зүйн орчин нийцэхгүй байна гэж алба хаагчдын 62.4 хувь нь, эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай гэж 86.1 хувь нь санал өгсөн байна.

Цагдаагийн байгууллагын эрх зүйг орчинг боловсронгуй болгох талаар алба хаагчид дараах саналыг гаргасан байна. Үүнд:

Цагдаагийн байгууллагыг иргэд “Үйлчилгээний байгууллага” гэж үздэг учраас цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, эсэргүүцэх

байдал гаргаж, улмаар доромжлох, заналхийлэх, гүтгэж, эрх чөлөөнд нь халдаж байна. Ялангуяа сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна.

-Цагдаагийн байгууллагын тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Эрүүгийн хууль болон бусад хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, боловсронгуй болгох, сайжруулах,

-Захиргааны зөрчил болон эрүүгийн хариуцлагын ялгааг тодорхой болгох, хариуцлага хүлээлгэх санкцыг боловсронгуй болгох, торгуулийн хэмжээг нэмэх, мэргэшсэн алба хаагч ажиллуулах.

- Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30.2 дугаар зүйлд заасан ойлголтын талаар хуулийн тайлбар гаргах.

-Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан “Цагдаагийн байгууллага, түүний алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа”-г хангаж хэрэгжүүлэх ажлыг сайжруулах

-Иргэдэд хэл амаар доромжлуулж, гүтгүүлсэн тохиолдолд түүнийг нотлох баримт, техник хэрэгсэл байдаггүй тул энэ талаар тодорхой арга хэмжээ авах.

-Цагдаагийн алба хаагчийн эрх ашгийг хамгаалсан байгууллага, эвлэл, холбоо байгуулах шаардлагатай байна гэжээ.

Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4-ийн 1-д “Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн”¹⁸⁴ гэж хуульчилсан.

Цагдаагийн алба хаагч нь хуульд заасан чиг үүргийн дагуу зөрчил гаргагч болон гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч зарим тохиолдолд гэрч, хохирогч зэрэг бусад оролцогчдод албадлага хэрэглэх замаар хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах зорилгоор төрийн албадлага хэрэглэдэг нь цагдаа хүчний байгууллага болохыг тодорхойлдог.

Цагдаагийн байгууллагыг хүчний эсхүл үйлчилгээний гэсэн тодотгол дагах болоод нилээдгүй хугацаа өнгөрч байна. Нийгмийн сэтгэл зүй цагдааг үйлчилгээний байгууллага байхыг хүсч байдаг. Цагдаагийн байгууллага нийгэмд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг сахин хамгаалахад үндсэн чиг үүргээ хандуулж, иргэний нийгэм, олон түмний хүч дэмжлэгт тулгуурлан үйл ажиллагаа явуулах нь цагдаа үйлчилгээний байгууллага байхын гол шинж юм.

Олон нийт цагдаагийн хамтын ажиллагааг өргөжүүлж, иргэншсэн үйл ажиллагаа явуулахад алба хаагчдын ёс зүйн төлөвшил, ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилт чухал байр суурь эзэлнэ.

Дээрхи байдлыг үндэслэн дараах санал дэвшүүлж байна:

1. Цагдаагийн алба хаагчийн сонгон судалж хүний нөөц бүрдүүлэхдээ тэдний харьцааны ур чадвар, сэтгэл зүйн бэлтгэлийг өндөр түвшинд тавих.
2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн дэмжлэг туслалцааг авч, олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон нийтийн санаа бодол, зөвлөгөөг сонсож, судлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх
3. Алба хаагчдын ажил, үүргээ шаардлагын хэмжээнд гүйцэтгэхэд нөлөөлөх гол хүчин зүйл болох цаг үеийн нөхцөл байдлыг зөв үнэлэхэд чиглэсэн дадлага эзэмшүүлж, мэргэжил, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх,
4. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, эрх зүй, актуудыг улам боловсронгуй болгох нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байна.

ХЭСГИЙН БАЙЦААГЧИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ

Раднаабазарын Гантулга

Дархан уул аймгийн цагдаагийн газрын Эрүүлүүлэх
баривчлах байрны дарга, магистрант, цагдаагийн хошууч

УИХ, Засгийн газраас энэ бүхэнд дүгнэлт хийж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ихээхэн анхаарал тавьж, хэд хэдэн хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал: Монгол Улсын Засгийн газраас “Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх” /2002 он/, “Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр” /1999 он/, “Хар тамхи, мансууралтай тэмцэх” /2000 он/, “Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” /2000 он/ зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байжээ.

Мөн УИХ-аас “Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр” /2003 он/, Монгол Улсын Засгийн газраас “Архидан согтуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол /1994 он/, “Архидан согтуурахтай тэмцэх тухай” /2000 он/, “Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай” /2003 он/ Монгол Улсын хуулиудыг батлан гаргаж мөрдүүлсэн нь улс орны хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ихээхэн нөлөө үзүүлсэн байна.

Ялангуяа УИХ-аас 1997 онд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” Монгол Улсын бие даасан хуулийг батлан, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд нийтийн тэмцлийг өрнүүлж, багагүй ажил хийжээ.

Энэ чиглэлээр зохицуулах бүх шатны зөвлөлүүд тодорхой үүрэг гүйцэтгэж байлаа. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улам идэвхижүүлж, ялангуяа цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх албаны бүтэц, үйл ажиллагааг боловсронгуй болгоход ихээхэн анхаарсан байна.

Үүний үндсэнд цагдаагийн байгууллагад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс, төв орон нутагт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилтны орон тоог баталж, зарим аймаг, хотод гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасгийг байгуулж, эрх зүйн орчинг бүрдүүлж өгсөн.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн туслалцааг авч ажиллах, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Хэв журам хамгаалах газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийг өөрчлөн “Олон нийттэй харилцах хэлтэс” болгон өөрчилж, ажлын чиг үүргийг тодорхойлж өгсөн.

Цагдаагийн байгууллага Монголын нээлттэй нийгэм хүрээлэн /Соросын сан/-тэй хамтран “Цагдаа-олон нийтийн хамтын ажиллагаа” төслийг хэрэгжүүлж байна.

Энэ нь Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг өөрчлөн шинэчилж, эрх зүйн харилцааг боловсронгуй болгох, цагдаа-олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах, цагдаагийн үйл ажиллагааг иргэншүүлэх, цагдааг олон түмний дотор үйлчилдэг, үйлчилгээний байгууллага болгон төлөвшүүлэх эхлэл тавьж байгаа юм.

1997 онд Монгол Улсад гарч буй гэмт хэрэг, түүний дотор хулгайлах гэмт хэргийн гаралтыг судлан дүгнэлт хийж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөрийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанд оруулж батлуулсан. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд цагдаагийн байгууллага түлхүү анхаарч ажилласнаар хулгайлах гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажилд нэлээд ахиц, өөрчлөлт гарсан билээ.

2001 онд хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийг Эрүүгийн цагдаагийн газрын бүтцээс гаргаж, хэв журмын албаны бүтцэд оруулан, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архидан согтууралтай тэмцэх, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасгуудтайгаар шинээр байгуулж, улсын хэмжээнд үйл ажиллагааг нь явуулж байна.

Засгийн газраас батлан гаргасан Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Хар тамхи, мансууралтай тэмцэххөтөлбөрүүдийг санаачлагч нь цагдаагийн байгууллага байсны дээр 2005 онд дуустал хэрэгжих хугацаанд цагдаагийн мэргэжлийн албадын хүч, анхаарлыг төвлөрүүлж ажиллаж байсан байна.

Нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, цагдаагийн байгууллагын анхаарлын төвд байлгаж, төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх бодлогыг тодорхой төрлийн гэмт хэрэгт чиглүүлэн хөрөнгө мөнгө, хүн хүч, техник хэрэгслээр хангуулахад анхаарч асуудлыг холбогдох хурал, төрийн төв байгууллагад оруулснаар тодорхой шийдвэрийг гаргуулан, хөрөнгө мөнгөний асуудлыг шийдвэрлүүлэн ард иргэдийн санаа сэтгэлийг зовоон бухимдал төрүүлж буй зарим төрлийн гэмт хэргүүдтэй шийдвэртэй тэмцэж эхэлсэн байна. Тухайлбал: Улсын Их Хурлаар малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргийгшинжлэх ухааны үндэстэй нотлох, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, шинэ төрлийн гэмт хэргүүдтэй тэмцэх талаар тогтоол шийдвэрүүд гаргуулсан нь цаг үе, нөхцөл байдалд дүгнэлт хийж, тодорхой зарим хэргүүдэд цохилт өгөхүйц арга хэмжээ авч буй нь зохих үр дүнгээ өгч байна.

Цагдаагийн алба хаагчийн мэдлэг чадвар, ажлын хариуцлага, сахилгыг сайжруулах, ёс зүйг төлөвшүүлэх, бүх шатны дарга нараас алба хаагч нартай ажиллах ажлын арга барилыг дээшлүүлэхийн тулд зорилго чиглэл, үе шаттай олон арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Анх 1975 онд хэсгийн байцаагч хэмээх албан тушаалыг бий болгосон үеэс эхлэн өнөөг хүртэл хэсгийн байцаагч нь хариуцсан нутаг дэвсгэртээ гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлж, оршин суугчид, иргэдийн амгалан тайван байдлыг хангаж, амьдрах таатай орчныг бүрдүүлэх үүргийг амжилттай хэрэгжүүлж ирсэн байна.

Хэсгийн байцаагч нь хариуцсан нутаг дэвсгэртээ цагдаагийн байгууллагын бүх чиг үүргийг хэрэгжүүлэхдээ гэмт хэрэг, захиргааны зөрчилтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах ажлыг бие даан зохион байгуулагч гол хүч юм.

Хэсгийн байцаагч нар гэмт хэрэг илрүүлэх, хэрэг бүртгэлт хийх, хүний өргөдөл гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэх, эрх зүйн зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж цагдаагийн бусад албан тушаалтнуудтай харьцуулбалхууль хамгаалах бүх хүрээг хамарч цагдаагийн байгууллагыг төлөөлөн ажилладаг өргөн эрх хэмжээтэй орон нутгийн цагдаагийн үндсэн нэгж юм.

Хэсгийн байцаагч нь байгууллагынхаа өвөрмөц олон талын үйл ажиллагааг ийнхүү бие даан явуулахдаа төвөөсөө алсагдмал, холбоо мэдээллийн хувьд дутагдалтай, ажлын хүнд нөхцөлд үүрэг гүйцэтгэдэг цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааны гол цөмийг бүрдүүлдэг албан тушаалтан юм.

Энэ бүхнээс дүгнэн үзэхэд цагдаагийн хэсэг “хэсгийн байцаагч” нь цагдаагийн эрх зүйн бие даасан субъект болж, Цагдаагийн орон нутгийн байгууллагын зорилт, чиг үүрэг, үндсэн үүрэг, эрхийг хэрэгжүүлдэг нь тодорхой байна.

Зөвхөн нийгмийн хэв журам хамгаалах салбарт л гэхэд хэсгийн байцаагч нь энэ чиглэлээр гарсан хууль тогтоомж, эрх зүйн актыг иргэн, албан тушаалтнаас хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, түүнийг тайлбарлан ойлгуулах, гэмт хэрэг, нийгмийн хэв журмыг газар дээр нь илрүүлэн таслан зогсоох, захиргааны зөрчилд хариуцлага хүлээлгэх, согтуурах, танхайрах, хутга мэс, бусад зүйлийг хууль бусаар биедээ авч явах зэрэг эрх зүйн зөрчилтэй өдөр тутам тэмцэл явуулах, гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийн улмаас хохирсон иргэнийг эрхийг сэргээн хангах, олон нийтийн газар биеэ авч явах чадваргүй хүнд хойшлуулшгүй тусалцаа үзүүлэх, нийтийг хамарсан арга хэмжээний үед хэв журам сахиулах гэх мэт үүрэг гүйцэтгэж, цагдаагийн байгууллагын өмнө тавигдсан зорилт, чиг үүргийг ханган биелүүлж байна.

Үүний зэрэгцээ гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг бие даан болон захиргаа, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран зохиох, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, шүүхээс даалгасан хүнийг эрэн

сурвалжлах, алдагдсан эд зүйлийг олж тогтоох, байгалийн гамшиг, хүн малын халдварт өвчин гарсан, бусад онцгой нөхцлийн үед хариуцсан нутаг дэвсгэрийн Засаг даргын ажилд тусалж авран хамгаалах, хүн хүч, тээврийн хэрэгсэл дайчлах, хорио цээрийн дэглэм тогтооход оролцох, эрх зүйд харш үйлдлээс хамгаалах арга хэмжээг холбогдох албан тушаалтнуудтай хамтран зохион байгуулж хэрэгжүүлдэг байна.

Цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын амжилтанд хүрэх нөхцөл нь хариуцсан хэсгийнхээ өөрчлөгдөж буй нөхцөл байдлаа өдөр тутам мэдэрч үнэлэх, өдөр тутмын ажлын төлөвлөж, ажлын цагаа үр ашигтай зарцуулах, үйл ажиллагаандаа илүү тохиромжтой тактикийн арга барилыг сонгож хэрэглэх, нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх ажлын туршлага, шинжлэх ухаан, техникийн ололтыг өргөнөөр нэвтрүүлэх, хамтран ажиллах зүй зохистой орчинг бүрдүүлэхэд оршдог.

Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, үйлчлэх нутаг дэвсгэрийн хэмжээ, оршин суух хүн амын тоо, ажлын ачаалал зэрэг хүчин зүйлээс хамаарч цагдаагийн тухайн хэсэгт хэдэн байцаагч, хичнээн цагдаа ажлуулахаа орон нутгийн цагдаагийн байгууллага, харьяалагдах нутаг дэвсгэрийн Засаг дарга тохиролцон орон тоогоо тогтооно.

Цагдаагийн хэсгийн төлөөлөгч, байцаагчийг орон нутгийн цагдаагийн байгууллагаас тухайн нутаг дэвсгэрийн Засаг даргатай зөвшилцөн ирүүлсэн санал хүсэлтийг үндэслэн цагдаагийн төв байгууллага, цагдааг орон нутгийн цагдаагийн байгууллага нь тус тус тогтоогдсон журмын дагуу томилно.

Тухайн орон нутагт ажиллаж байгаа хэсгийн байцаагч нь өөрийн үйл ажиллагааг тухайн нутаг дэвсгэрийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын өмнө ажлаа хариуцан тайлагнаж, оршин суугаа газрынхаа хүн амд ажлын үр дүнгийн талаар тайланга тавина.

Сүүлийн хэдэн жилд нийгмийн сэтгэхүй, хүмүүсийн бодол санаанд өөрчлөлт гарч эхэлсэн нь ажиглагдаж эхэлсэн. Өнөөдөр нийгэм гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах үйл ажиллагаанд иргэд, олон нийт найдаж, итгэж болох илтгэлцлийг хүсч байна. Нөгөө талаас цагдаагийн байгууллагын явуулж буй үйл ажиллагааг ард иргэд талархан хүлээж авах тийм нийгмийн сэтгэхүйг хүсэж байна.

Гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхэд ажлын өөр арга барил, ард иргэдтэй өөр харьцаатай байх хэрэгтэй гэдгийг зөв совингоороо мэдэрч төр эрх зүйн зохицуулалтыг нь хийж өгөх ёстой.

Энэ хүрээнд Засгийн газар болон Цагдаагийн Ерөнхий газраас тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж иржээ. Тухайлбал Монгол Улсын Засгийн газрын 1992, 2000 оны “Цагдаагийн байгууллагын сум, хорооны хэсгийн төлөөлөгч, байцаагч нарыг албан ажлаа явуулахад нь шаардагдах ажлын байр, тээврийн хэрэгсэл, холбоогоор хангах, цахилгаан, дулааны зардлыг төсвөөс санхүүжүүлэх, хойшлуулшгүй ажилд хэрэглэх шатахууны лимиттогтоох, хариуцсан нутаг дэвсгэрт нь байр орон сууцаар хангах, сум хорооны цагдаагийн алба хаагчийн эхнэр, нөхрийг ажлын шаардлагаар цагдаагийн туслах ажилтнаар хуульд нийцүүлэн томилж, 50 хувиар цалинжуулах арга хэмжээг жил бүрийн төсөвд тусгаж хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт даалгасан 43, 94 тоот тогтоол, 1999 онд Цагдаагийн Ерөнхий Газраас хэсгийн байцаагч, төлөөлөгч нарын тогтвортой ажиллах нөхцлийг хангах, тэднээс үүргээ биелүүлэх боломж, баталгааг бүрэн хангах, тэдний үйл ажиллагааг иргэдэд ойртуулах, мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх зорилтын хүрээнд “Цагдаагийн байгууллагын хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарын тогтвортой үйл ажиллагааг хангах дэд хөтөлбөр”-ийг 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр баталж ажилласан байна.

Мөн гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулахад хэсгийн байцаагчийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор 2003 оны Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 229 тоот тушаалаар “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ыг баталж, Цагдаагийн байгууллагын хэсгийн байцаагчийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн боломж бүрдсэн байна.

Монголын цагдаагийн байгууллагын нэг бүрэлдхүүн хэсэг болох хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны төлөв байдлыг нээн харуулах, хэсгийн байцаагчдын ажлын нөхцөл байдалд үнэлгээ өгөх, тэднээс чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч буй саад бэрхшээлийг ил тод болгон түүнийг даван туулах арга замыг эрэлхийлэх шаардлага зүй ёсоор гарч ирж байна.

Дархан-Уул аймгийн хүн амын нягтрал өдрөөс өдөрт нэмэгдэж байгаатай холбоотойгоор хот зохион байгуулалт оновчтой бус хэлбэрээр хийгдэж, иргэдийн шилжин суурьших явдал ихэссэнтэй холбоотойгоор зарим өрх айлын байршил, хаяг тодорхойгүй байдлыг ихээр үүсгэж байгаа нь хэсгийн байцаагчдын үйл ажиллагааны хэвийн нөхцлийг алдагдуулах нэг шалтгаан болж байна.

Тиймээс миний хийсэн судалгаанд оролцсон хэсгийн байцаагчдын ажиллаж буй нтаг дэвсгэрийн онцлогийг тодруулан үнэлэх зорилгоор явуулсан санал асуулгад давхцсан тоогоор нийт нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжийн 30 орчим хувь нь гэр хороолол ихтэй гэж үнэлсэн байхад үлдсэн хэсэг нь шилжин суурьшигчид ихтэй зэргээр үнэлжээ. Энэ нь хэсгийн байцаагчийн ажлын ачаалал ихсэх, үйл ажиллагааны үр нөлөө буурах шалтгаан болж байна.

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 33-38-р зүйлд заасан алба хаагчийн нийгмийн баталгаа хэрхэн хэрэгжиж буйг үнэлэх үүднээс хэсгийн байцаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар төр, засгийн хэрхэн анхаарал тавьж байгаа талаарх асуулга явуулахад судалгаанд хамрагсдын 61 нь буюу 62.8 хувь нь хангалтгүй буюу огт хангалтгүй хэмээн хариулсан байхад 36 нь 37.1 хувь нь зарим талаараа асуудлыг шийдвэрлэдэг хэмээн үнэлжээ.

Хэсгийн байцаагчаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдлыг нэрлэнэ үү гэсэн асуулгад давхардсан тоогоор судалгаанд хамрагсдын 50 нь буюу 51.5 хувь нь байнга илүү цагаар ажилладаг /7 хоногт дунджаар 60-аас дээш цаг ажилладаг гэж 86 хувь нь хариулжээ/ гэж хариулсан байхад 60 нь буюу 61.8 хувь нь унаа машин болон холбооны хэрэгсэл байхгүй гэж хариулжээ. Мөн 20 нь тусгай хэрэгслийн хангалт муу, 40 нь хүн ам, нутаг дэвсгэрийн хэмжээ их, 37 нь ажлын байрны нөхцөл муу, 50 нь хэт олон төрлийн ажиллагаа явуулдаг, ажлын ачаалал хэт их хэмээн үнэлжээ. Мөн та ажлынхаа ихэнхи цагийг ямар ажилд зарцуулдаг вэ гэсэн асуултанд давхцсан тоогоор 56 нь өргөдөл, гомдол, эрүүгийн хэрэг шалгахад 72 нь зөрчил гаргасан хүнийг шүүхээр баривчлуулахад 22 нь байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхөөр орж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил явуулахад 6 нь эргүүлд гарахад гэж хариулсан бөгөөд айл өрхөөр явахад иргэд илт дургүйцдэг, гэртээ оруулдаггүй, нохой нь сул байдаг, өдрийн цагаар хүнгүй байдаг гэсэн хүндрэлүүдийг дурьджээ.

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС ХАРАА ХЯНАЛТГҮЙ ХҮҮХЭДЭД ҮЗҮҮЛЖ БҮЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БАЙГАА АСУУДАЛ ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

Дашнямын Гандолгор

Дотоод хэргийн их сургуулийн магистрант

Нийслэлийн цагдаагийн газрын харьяа хүүхэд хамгаалал халамжийн төв нь амьдралын хүнд нөхцлийн улмаас гэр орон, эцэг эхтэйгээ хамт амьдрах боломжгүй болж гэр орноосоо дайжин нийслэл хотын гудамж талбай, олон нийтийн газраар тодорхой зорилгогүй хараа хяналтгүй тэнүүчлэн орц хонгил, дулааны траншейгаар хоног төөрүүлэн амьдарч байгаа эцэг эхдээ хайхрагдахаа байсан хаягдмал, тэнэмэл, эмзэг бүлгийн, асран хамгаалагчгүй болон төөрсөн хүүхдүүдийг цуглуулж тэднээс анкет тодорхойлолт, тэмдэглэл, гарын хээний дардас, фото зураг авч хувийн хэрэг нээн баримтжуулан байрлуулж, тэдний эцэг эх, асран хамгаалагчийн оршин суугаа хаягийг олж тогтоон хүүхдийг нь эцэг эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч хүүхдийн эдэлж чадахгүй байгаа алдагдсан эрхийг нь сэргээлгэх үүрэгтэй¹⁸⁵.

Цагдаагийн байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хүүхдийн эрх ашгийг хамгаалах, хүүхэд гэмт хэрэг үйлдэх, гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх бодлогыг, Нийгмийн хэв журам хамгаалах газар, аймаг, нийслэл, дүүргийн цагдаагийн газар, хэлтсийн хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан 70 гаруй алба хаагчтайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. НЦГ-ын дэргэдэх хүүхдийн халамж үйлчилгээний төв нь Цагдаагийн төрөл, мэргэжлийн албадад чиглэл, зөвлөмж хүргүүлэх зэргээр дотоод ажлуудыг байнга зохион байгуулдаг. Цагдаагийн байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах үүднээс “Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт”-д нийцүүлэн НЦГ-ын харьяа Хүүхдийн халамж үйлчилгээний төвийг 2010 онд “Хүүхэд хамгаалал, хаяг тогтоох төв” болгон өөрчилсөн.

Өнөөдөр хүүхэд гэмт хэрэг үйлдэх, аливаа хүчирхийлэл, ялангуяа гэмт хэргийн халдлагад өртөж, амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаа, эд хөрөнгөөрөө хохирох явдал тогтвортой буурахгүй байгаа байдал ажиглагдаж байна.

Сүүлийн 4 жилд (2007-2010 он) насанд хүрээгүй хүмүүсээс 2874 гэмт хэрэг үйлдэж, 4367 хүүхэд холбогдсон, 4342 хүүхэд гэмт хэргийн халдлагад өртөж хохирсоны 434 буюу 10.0 хувь нь нас барсан, 2473 буюу 57.0 хувь нь хөнгөн, хүндэвтэр, хүнд хэлбэрээр гэмтэл авсан байна¹⁸⁶.

Манай улсын хүн амын 33.0 хувь нь хүүхэд буюу 18 насанд хүрээгүй хүмүүс¹⁸⁷ байгаа юм. Хүүхэд гэмт хэргийн халдлагад өртсөн эрсдлийг тооцож үзэхэд 10000 хүүхэд тутамд хохирсон 11.78 хувь, нас барсан 0.95 хувь, гэмтсэн 6.28 хувь байна. Үүнээс дүгнэн үзэхэд хүүхдийн эрх ашиг хохирох, амь насаа алдах, эрүүл мэндээрээ хохирох эрсдэл өндөртэй байна гэж үзэж болно.

2010 онд Гэмт хэргийн халдлагад 1066 хүүхэд өртөж хохирсоны 86 буюу 8.1 хувь нь нас барж, 568 буюу 53.3 хувь нь гэмтсэн байна. Нас барсан 86 хүүхдийн 48 нь 7 хүртэлх насны, 25 нь 8-13 насны, 13 нь 14-17 насны хүүхдүүд байгаа ба өртсөн гэмт хэргийн төрлөөр авч үзвэл бусдыг амиа хорлоход хүргэх хэрэгт 43, зам тээврийн осол, хэрэгт 29, бусдыг болгоомжгүй алах хэрэгт 7, хүнийг санаатай алах хэрэгт 2, өвчтөнд тусламж үзүүлэхгүй байх хэрэгт 1, хүчиндэх хэрэгт 1, бусад хэрэгт 3 өртөж нас баржээ¹⁸⁸.

¹⁸⁵ Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хууль., УБ 2000 он., www.legalinfo.mn

¹⁸⁶ Цагдаа олон нийтийн хамтын ажиллагааны TSONHA.MN сайтаас

¹⁸⁷ Улсын бүртгэлийн ерөнхий газраас гаргасан статистик

¹⁸⁸ Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэж буй гэмт хэргийн шалтгаан нөхцөл ЦЕГ-аас гаргасан статистик дээр хийсэн судалгаа. Tsonha.mn сайтаас. 2011 он

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэргийн халдлагад өртөж хохирсон 28 хүүхэд байна. Үүний 12 нь төрсөн, 1 нь үрчилж авсан, 15 нь дагавар хүүхэд байгаа юм. Хүчингийн гэмт хэргийн хохирогч нь бага насны, сургуулийн өсвөр насны хүүхдүүд олонтаа байна. 17 нас хүртэлх 152 хүүхэд хүчингийн гэмт хэрэгт өртөж, бие махбодь, сэтгэл санааны хувьд хохирсон байна. Насаар нь ангилвал 7 хүртэлх насны 13, 8-13 насны 46, 14-17 насны 93, хүүхэд хохирсон байна. Эдгээр хүүхдүүдийн 118 нь сургуулийн сурагч, 7 нь сургууль завсардсан охидууд байна¹⁸⁹.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдсэн ч, тэдний эрүүл мэнд, амь насанд аюул занал тулгараагүй л бол мэдээлэгддэггүй, бүртгэгддэггүй, далд нууц үлддэг асуудал хэвээр оршин байна.

2011 онд Насанд хүрээгүй хүмүүсээс 245 гэмт хэрэг үйлдэгдэж, 92 хэргээр буюу 60.1 хувиар өсч, 517 хүүхэд холбогдон шалгагдсан байна. Гэмт хэргийн халдлагад 457 хүүхэд өртөж хохирсоны 65 нь 7 хүртэлх, 126 нь 8-13 насны, 266 нь 14-17 насны хүмүүс байна. *Үүний дотор хүчиндэх гэмт хэрэгт 69 хүүхэд хохирсоны 6 нь 7 хүртэлх, 20 нь 8-13 насны, 43 нь 14-17 насны хүмүүс байгаа ба бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах хэрэгт 7 хүүхэд хохирчээ*¹⁹⁰.

Эцэг, эхчүүдийн хүүхдүүдээ тавих анхаарал халамж сул, хаана юу хийж цагийг өнгөрөөж байгааг мэддэггүй, сургууль завсардалт, гэр бүлийн таагүй орчин, хүчирхийлэл, таагүй уур амьсгал, гэр бүлийн салалт, насанд хүрэгчдийн үлгэргүй байдлаас шалтгаалан хүүхэд залуучууд бусдад уруу татагдаж, гэмт хэрэгт холбогдох, хууль эрхийн мэдлэг дутмаг, санамсар болгоомжгүйгээсээ гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргийн хохирогч болж, амь нас эрүүл мэндээрээ хохирох явдал их гарч байна. Иймд хүүхдийн эрхийг хамгаалж, хангах асуудал өнөөдөр чухлаар тавигдаж байгааг дээрх судалгаанаас харж болох ба цаашид хүүхдийн эрхийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Хүүхдийн эрх, хүүхдийг гэмт хэргийн хохирогч болон оролцогч болохоос урьдчилан сэргийлэхэд цагдаагийн байгууллагаас гүйцэтгэж буй үүрэг үлэмж их юм.

Судлаачийн зүгээс тус өгүүллээрээ цагдаагийн байгууллагаас хүүхдийн эрхийн талаар явуулж тодорхой үйл ажиллагаанд анхаарлаа хандуулж статистик тоо баримтанд үндэслэн дүн шинжилгээ хийж өнөөгийн байдал, цаашид боловсронгуй болгох асуудлын талаар өөрийн байр суурийг илэрхийлэхийг хичээсэн юм. Ингээд эхлээд цагдаагийн байгууллагаас хараа хяналтгүй хүүхдэд үзүүлж буй үйлчилгээний өнөөгийн байдлын талаар авч үзье.

Цагдаагийн байгууллагаас хараа хяналтгүй хүүхдийн талаарх үйл ажиллагаа явуулахдаа дараахь хууль тогтоомжид тулгуурлан хуулиар олгогдсон үүргээ хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль,
2. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль,
3. Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хууль,
4. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-р заалт,
5. Монгол улсын Засгийн газрын 2002 оны 245 дугаар тогтоолоор батлагдсан Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр батлах тухай,
6. Засгийн газрын 2005 оны 234 дүгээр тогтоолоор батлагдсан Хүн худалдаалах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр,
7. Монгол улсын Засгийн газрын 1994 оны 91-р тогтоолын 2-р хавсралтаар батлагдсан Хараа хяналтгүй хүүхдийг саатуулах байрны дэглэм журам, Улсын нийгмийн хамгаалал,


¹⁸⁹ Насанд хүрээгүй хүмүүсээс бэлгийн хүчирхийлэлд өртөж буй өнөөгийн байдал, тулгамдсан асуудал илтгэлээс. Хүүхэд хамгаалал, хаяг тогтоох төвийн нийгмийн ажилтан, цагдаагийн ахмад Ц.Нарантуяа. УБ хот. 2011 он.

¹⁹⁰ Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэж буй гэмт хэргийн шалтгаан нөхцөл ЦЕГ-аас гаргасан статистик дээр хийсэн судалгаа. tsonha.mn сайт. 2011 он

8. Хөдөлмөрийн сайдын 2005 оны 29 тоот тушаалаар батлагдсан
9. Хүүхдийн асрамж халамжийн байгууллагуудын мөрдөх үлгэрчилсэн дүрэм,
10. Хүүхэд асрамж, халамж хамгааллын үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад тавих нийтлэг шаардлага стандарт зэрэг хууль эрхийн актууд болно.

Цагдаагийн байгууллага дээрх хууль эрхийн актыг чанд даган мөрдөж хүүхдийг гэмт хэрэг, осол зөрчилд орохоос урьдчилан сэргийлж хараа хяналтгүй тэнэмэл хүүхдийг цуглуулах нэгдсэн үйл ажиллагааг өнгөрсөн онд 42 удаа зохион явуулж гудамж талбай, олон нийтийн газар хараа хяналтгүй хэсүүлэн явсан 475 хүүхдийг авч ирж анкет, тодорхойлолт, гарын хээний дардас авч хувийн хэрэг нээн гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлж, ухуулга яриа хийж, ар гэр, асран хамгаалагчид 726 хүүхдийг хүлээлгэн өгч, үр хүүхдээ тэнүүлчүүлэн гуйлга гуйлгуулсан иргэдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар санамж бичиг өгсөн зэрэг олон талт ажиллагаа явуулж буй ч хэдий боловч үр дүнгийн хувьд төдийлөн хагалтгүй байна. Тус төв нь 1996 оноос хойш хүлээн авсан хараа хяналтгүй хүүхдийн тоон статистикийг графикаар авч үзвэл:

Хүүхэд хамгаалал, хаяг тогтоох төвд ирсэн нийт хүүхдүүдийн график судалгаа



Дээрх статистикаас харахад хараа хяналтгүй хүүхэд ихсэх шалтгаан нь нийгмийн байдлаас ихээхэн хамааралтай болох нь ажиглагдаж байна. Тухайлбал 1996-1999 оны хооронд хараа хяналтгүй хүүхдийн тоо хэт өссөн нь тухайн үед эдийн засаг сул дорой байсантай ч шууд уялдаа холбоотой юм.

Харин сүүлийн жилүүдэд хараа хяналтгүй хүүхдийн тоо жилээс жилд буурч байгааг¹⁹¹ бид НЦГ-ын дэргэдэх хүүхдийн халамж үйлчилгээний төвөөс гаргасан дараахь тоон судалгаанаас харж болно. Энэ нь хэдийгээр сайшаалтай боловч 1995-1999 он хүртэлх их хэмжээгээр гудамжинд хараа хяналтгүй хүүхдүүд насанд хүрсэн, нөгөө талаар эдийн засаг, нийгмийн бага боловч таатай өөрчлөлтийн үр дүнгээс шууд хамааралтай болов уу. Түүнчлэн 2010 онд гэхэд л НЦГ-ын дэргэдэх хүүхдийн халамж үйлчилгээний төвд байрлаж байгаад насанд хүрсэн 30 иргэнийг бүртгэн гаргаж Хүүхдийн төлөө газарт хүргүүлсэн байна.

¹⁹¹ НЦГ-ын дэргэдэх хүүхдийн халамж үйлчилгээний төвөөс гаргасан статистик 2010 оны байдлаар

Хүүхдийн халамж үйлчилгээний төв болон асрамжийн газраар хүмүүжээд гардаг хэдий ч насанд хүрээд эдгээр иргэд орох орон, амьдрах байр орон, эрхлэх ажил байхгүй зэрэг амьдралын наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй байдалд ордог. Амьдралын хүнд нөхцөлөөс болон дахин гудамж, талбай, орц хонгил, траншейгаар тэнүүчлэн, архи дан согтуурах, хулгай, дээрэм хийх зэргээр гэмт хэрэг үйлдэх зэргээр амьдарахад хүргээд байгаа юм.

ЦЕГ-ын даргын 2006 оны 150 тоот тушаалаар батлагдсан цагдаагийн хийж гүйцэтгэх үйл ажиллагааны тактикийг хэрэгжүүлэх аргачлалыг батлах тухай ЦЕГ-ын даргын 2009 оны 403 тоот тушаалаар батлагдсан үйлчилгээний стандарт ЦЕГ-ын даргын 2008 оны 08 тоот тушаалаар батлагдсан цагдаагийн албан хаагчийн ёс зүйн дүрэм зэргийг бие бүрэлдэхүүнээр судлуулж мөрдөж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Иргэдэд хүүхдийг нь хүлээлгэн өгөхдөө төвийн албан хаагчдийн харилцааны байдал ёс зүйн талаархи үнэлгээ дүгнэлт авч, ажлыг дүгнэх үзүүлэлтэнд шалгуур үзүүлэлт болгон оруулж дэвшүүлэн ажиллаж байна. Тус төвөөс хүүхдээ хүлээн авсан 728 эцэг эх, асран хамгаалагчдаас албан хаагчдийн зан харицаа үйлчилгээний талаар үнэлгээ өгүүлэв. Нийт 691 үнэлгээ өгөдсөний 95% нь онц сайн гэсэн дүн өгсөн нь тус төв нь албан сургалтыг чанаржуулж, алба хаагчдийн мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд онцгой анхаарч ажилладаг болохыг харуулсан тоон үзүүлэлт юм.

Нийслэл хотын гудамж, талбай олон нийтийн газараар тодорхой зорилгогүй, сэлгүүцсэн тэнэмэл байдлаар амьдарч байгаа хүүхдүүдийг гэмт хэрэгт орохоос урьдчилан сэргийлэх, сэрэмжлэн нэгдсэн үйл ажиллагааг 42 удаа зохиож 475 хүүхдийг тус төвд авчирч, анкет тодорхойлолт, гарын хээний арчдас авч хувийн хэрэг нээж байрлуулан халамж үйлчилгээнд хамруулсан нь хүн ам цөөн манай орны хувьд хараа хяналтгүй хүүхэд нэлээд их байгаа нь сэтгэл эмзэглэм асуудал болоод байна.

Иймээс хараа хяналтгүй хүүхдийг хамгаалах үйл ажилагааг өргөтгөх, халамж асрамжийн үйлчилгээ эрхэлж буй байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах талаар арга хэмжээ авах, хүүхэд хамгааллыг эрх зүйн зохицуулалтын хувьд ч боловсронгуй болгох шаардлага үүдэн буй болж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хууль, цагдаагийн байгууллагын тухай хуулийн 20.3 МУ-ын Засгийн газрын 2002 оны 245 тоот тогтоолоор батлагдсан хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр батлах тухай, Засгийн газрын 2005 оны 34 тоот тогтоолоор батлагдсан хүн худалдаалах ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр, МУ-ын Засгийн газрын 1994 оны 91 тоот тогтоолын 2-р хавсралтаар батлагдсан хараа хяналтгүй хүүхдийг саатуулах байрны дэглэм журам, улсын нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 29 тоот тушаалаар батлагдсан хүүхдийн халамжийн байгууллагуудын мөрдөх үлгэрчилсэн дүрэм, хүүхэд асрамж халамж, хамгааллын үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад тавих нийтлэг шаардлага, стандарт зэргийг хэрэгжүүлж хүүхдийг гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж хараа хяналтгүй тэнэмэл хүүхдийг цуглуулах нэгдсэн үйл ажиллагааг 42 удаа зохион байгуулж олон нийтийн газар хараа хяналтгүй тэнүүчлэн явсан 475 хүүхдийг авчирч, анкет тодорхойлолт, гарын хээний дардас авч хувийн хэрэг нээн гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлж 728 хүүхдийг хүлээлгэн өгч, үр хүүхдээ тэнүүчлүүлэн гуйлга гуйлгуулсан иргэдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар санамж бичиг өгчээ.

Сүүлийн 4 жилд (2007-2010 он) насанд хүрээгүй хүмүүсээс 2874 гэмт хэрэг үйлдэж, 4367 хүүхэд холбогдсон, 4342 хүүхэд гэмт хэргийн халдлагад өртөж хохирсоны 434 буюу 10.0 хувь нь нас барсан, 2473 буюу 57.0 хувь нь хөнгөн, хүндэвтэр, хүнд хэлбэрээр гэмтэл авсан байна. Хүүхдийг гэмт хэрэг эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэднийг гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлж буй ажиллагаа дутмаг, нэгдсэн бодлого дутагдалтай байгааг харуулсан хэрэг юм. 2007 онд НЦГ-ын ХХҮТөвд ирсэн 1159 хүүхдийн 200 нь 633 удаа 2008 онд ирсэн 902 хүүхдийн 155 нь 504 удаа

2009 онд ирсэн 879 хүүхдийн 143 нь 627 удаа дахин давтан ирснийг анхаарахгүй байж болохгүй.


Манай улсын хүн амын 33.0 хувь¹⁹² нь хүүхэд буюу 18 насанд хүрээгүй хүмүүс байгаа юм. Хүүхэд гэмт хэргийн халдлагад өртсөн эрсдлийг тооцож үзэхэд 10000 хүүхэд тутамд хохирсон 11.78 хувь, нас барсан 0.95 хувь, гэмтсэн 6.28 хувь байна. Үүнээс дүгнэн үзэхэд хүүхдийн эрх ашиг хохирох, амь насаа алдах, эрүүл мэндээрээ хохирох эрсдэл өндөртэй байна гэж үзэж болно.

2010 онд гэмт хэргийн халдлагад 1066 хүүхэд өртөж хохирсоны 86 буюу 8.1 хувь нь нас барж, 568 буюу 53.3 хувь нь гэмтсэн байна. Нас барсан 86 хүүхдийн 48 нь 7 хүртэлх насны, 25 нь 8-13 насны, 13 нь 14-17 насны хүүхдүүд байгаа ба өртсөн гэмт хэргийн төрлөөр авч үзвэл бусдыг амиа хорлоход хүргэх хэрэгт 43, зам тээврийн осол, хэрэгт 29, бусдыг болгоомжгүй алах хэрэгт 7, хүнийг санаатай алах хэрэгт 2, өвчтөнд тусламж үзүүлэхгүй байх хэрэгт 1, хүчиндэх хэрэгт 1, бусад хэрэгт 3 өртөж нас баржээ.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэргийн халдлагад өртөж хохирсон 28 хүүхэд байна. Үүний 12 нь төрсөн, 1 нь үрчилж авсан, 15 нь дагавар хүүхэд байгаа юм. Хүчингийн гэмт хэргийн хохирогч нь бага насны, сургуулийн өсвөр насны хүүхдүүд олонтаа байна. 17 нас хүртэлх 152 хүүхэд хүчингийн гэмт хэрэгт өртөж, бие махбодь, сэтгэл санааны хувьд хохирсон байна. Насаар нь ангилвал 7 хүртэлх насны 13, 8-13 насны 46, 14-17 насны 93, хүүхэд хохирсон байна. Эдгээр хүүхдүүдийн 118 нь сургуулийн сурагч, 7 нь сургууль завсардсан охидууд байна. Дээрх нөхцөл байдлууд нь хүүхэд хууль болон олон улсын гэрээнд заасан эрхээ хэрэгжүүлж чадахгүй байгаагийн томоохон илрэл юм.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдсэн ч, тэдний эрүүл мэнд, амь насанд аюул занал тулгараагүй л бол мэдээлэгддэггүй, бүртгэгддэггүй, далд нууц үлддэг асуудал хэвээр оршин байна.


2010 онд давхардсан тоогоор 865 хүүхэд хүлээн авсны 173 эмэгтэй, 692 эрэгтэй хүүхэд байна.




Энэ нь хараа хяналтгүй гэр бүлээсээ дайжин гарч буй хүүхдүүдийн ихэнх хувийг эрэгтэй хүүхэд эзэлж байгаа нь нэлээн анхаарал татсан хэрэг төдийгүй судлан, шинжлэж түүний шалтгааныг толруулах шаардлага буйг харуулсан хэрэг юм. Анх удаа ирсэн 194, давтан ирсэн 654, төөрсөн 26 хүүхдүүдийг хүлээн авч карт, тодорхойлолт, гар хурууны хээний дардас авч, хувийн хэрэг нээн materiaжуулжээ. Эцэг, эхийн хараа хяналтгүйн улмаас төөрсөн хүүхдийн тоо нэлээд байгаа ч хүүхэддээ хайхрамжгүй хандсан эцэг, эхчүүдэд хүлээлгэх хариуцлагын механизм байхгүй байгааг дурьдах хэрэгтэй.

Давхардсан тоогоор нийт 728 хүүхэд хүлээлгэн өгснөөс эцэг эхэд, ар гэрт нь 545, бусад төвд 116, хүүхдийн байцаагчид 67 тус тус хүлээлгэж өгсөн байна.

¹⁹² Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвөөс гаргасан статистикаас



Эцэг, эх, ар гэрт нь хүлээлгэн өгч байгаа нь сайшаалтай хэдий ч тэдгээрийг гэр бүлдээ хэрхэн амьдарч буй болон гэр бүл нь сурч боловсрох, амьдрах эрхийг нь хангаж чадахуйц талаарх нарийвчилсан судалгаа болон хүүхэд гэр бүлдээ хэрхэн амьдарч буй талаар тавьж буй хараа хяналт сул байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Түүнчлэн хүүхдийн үйл ажиллагаа, болон түүнтэй холбогдох эрх зүйн зөрчлийн талаарх мэдээллийг авч үзвэл¹⁹³:



Дээрх тайлангаас үзвэл хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртөх, бүр амь насаа алдах, бусдад хулгайлагдсан байж болзошгүй зэрэг мэдээлэл ихсэж буй нь сэтгэл эмзэглүүлж байна. Дээрх зөрчлүүдээс хамгийн ихээр үйлдэгдэж буй нь хүүхэд бэлгийн хүчирхийлэлд ихээр өртөж буй нь сэтгэл эмзэглүүлэм мэдээ юм. Түүнчлэн хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртөж буйг дахин нотолсон нэгэн баримт бол нийслэлийн эрүүл мэндийн газраас гаргасан тайлангаас бид бэлхнээ харж болно. Үүнд дурьдсанаар 13 хүүхдийг ДОХ буюу бэлгийн замын халдварт илрүүлэх шинжилгээнд хамруулж бэлгийн замын өвчинтэй 10 хүүхдийг илрүүлж эмчилсэн¹⁹⁴ тухай дурьдсан байна.

Энэ нь насанд хүрээгүй хараа хяналтгүй хүүхдүүдийн дунд бэлгийн хүчирхийлэл, биеэ үнэлэх явдал ямар түвшинд байгаа болон түүнд холбогдох эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулсан хэрэг юм. Тухайлбал арван найман насанд хүрээгүй хүнтэй бэлгийн хурьцал үйлдэх, БЗХӨ халдаах гэх мэт эрүүгийн хуулинд заасан зүйлүүдийн хэрэгжилт, эрүүгийн эрх зүйн шинжийг тодорхойлох шаардлагатайг харуулсан хэрэг гэж үзэж байна. Тиймээс төрөөс хүүхдийн эрх зүйн зөрчил, гэмт хэргийн золиос болгохгүй байх талаар бодлогын хэмжээнд авч үзэх шаардлагатай байна.

2010 онд хүүхэд халамж үйлчилгээний төв нь “Хүүхэд хамгаалал аян”-ны хүрээнд хүйтний улирал эхэлж байгаатай холбогдуулан нийслэл хотоор хараа хяналтгүй, гудамжны орц хонгил, оллон нийтийн газраар тэнэж хэсүүчлэн амьдарч байгаа хүүхдүүдийг даарч осгох, өвчинд нэрвэгдэх, гэмт хэрэг зөрчилд өртөх болон аливаа

¹⁹³ НЦГ-ын дэргэдэх халамж үйлчилгээний төвийн тайлан мэдээнээс

¹⁹⁴ Нийслэлийн эрүүл мэндийн газраас гаргасан тайлан мэдээн дээр хийсэн статистик

эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилго бүхий ажлын төлөвлөгөө гарган, бие бүрэлдэхүүнд танилцуулан хэрэгжүүлэх дараахь ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Гудамж, орц хонгил, олон нийтийн газраар хэсүүчлэн яваа хүүхдүүдийг олж илрүүлэн тэднийг төвийн байранд байрлуулан халамж үйлчилгээнд хамруулах нэгдсэн арга хэмжээ зохиох алба хаагчдын ажиллах хуваарь гарган ажиллав.

2. Нийт 6 удаа нэгдсэн арга хэмжээг зохиож 56 хүүхдийг төвд байрлуулж, хүүхэд тус бүрд хувийн хэрэг нээж, нөхцөл байдлын үнэлгээ хийж, ажиллах төлөвлөгөө боловсруулж, асуудлыг шийдвэрлэв. Нийслэлийн хөдөлгөөнт эргүүлийн газар, Баянгол дүүргийн цагдаагийн хэлтэс, нийслэлийн хүүхдийн төлөө газартай хамтран ажилласан. Нийт 80 хүүхэд хүлээлгэн өгснөөс эцэг эхэд нь 34, хотын дотор хаягаар хүлээлгэж өгсөн 24, хөгжим хүүхдийн хөгжилд 4, насанд хүрсэн тодорхой хаягтай 1, хүүхдийн байцаагчид 17 хүүхдийг тус тус хүлээлгэж өгсөн байна.

3. 81 хүүхдэд эрүүл мэндийн түвшин тогтоох үзлэг хийж өвчтэй 46 хүүхдийг оншилж эмчлүүлэв.

4. Төвд ирсэн хүүхдийн талаар нийслэлийн цагдаагийн газрын өглөөний рапортанд мэдээлж харьяа дүүргийн байцаагч нар хүрэлцэн ирж асуудлыг шийдвэрлэдэг болно.

5. Төвд байрласан хүүхдүүдийн нэгдсэн бүртгэлийг компьютерийн сүлжээнд бүртгэж, цахим бүртгэлд хамааруулж ажиллах.

6. Хүүхдүүдийн хувийн ариун цэврийг сахиулж дотуур хувцас, ариун цэврийн хэрэгсэл, ОО, сойз, саван, шампунь, үсчний үйлчилгээнд хамааруулах.

7. ДОХ-ын эсрэг дэлхий нийтийн өдрийг тохиолдуулан 33 хүүхдэд ДОХ-оос урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгч санамж гарын авлага өгч сэрэмжлүүлэх.

8. Нийт 71 хүүхдийг хүн ам орон сууцны улсын тооллогод бүртгүүлэх

9. Улаанбаатар хотын гудамж талбай олон нийтийн газраар тодорхой зорилгогүй сэлгүүцэн орц хонгилоор хоноглон хоног төөрүүлж байгаа хүүхдүүдийг гэмт хэрэг зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх улмаар хараа хяналтгүй хүүхдүүдэд өөрийн авьяас чадвараа нээн хөгжүүлэн нийгмийн амьдралд идэвхитэй оролцон муу зуршил, үзэл бодлоосоо хөндийрөн нийгмийн идэвхтэй гишүүн болон төлөвшиж хүмүүжин нийгэмшүүлэх зорилгоор Нийгэм хамгаалал хөдөлмөрийн яамны санаачлагаар “Хөгжим- Хүүхдийн хөгжилд” төслийг хэрэгжүүлж эхлээд байна.

10. Нийслэлийн цагдаагын газрын хүүхэд хамгаалал, хаяг тогтоох төвөөр удаа дараа ирдэг 2-10 жил тэнэмэл байдлаар амьдарч ирсэн 50 хүүхдийг сонгон нийслэлийн засаг даргын тамгын газрын хүүхэд сургалт хүмүүжлийн тусгай төвд байршуулан хичээл сургалтын ажлыг төлөвлөгөөний дагуу явуулж байсан бөгөөд үйл ажиллагааны талаа UBS телевизээр долоо хоног бүрийн бямба, ням гарагуудын 19.00 цагаас “Гэртээ харих зам” зорилгот цуврал нэвтрүүлэг хийж олон түмэнд хандан тэдний анхаарлыг хараа хяналтгүй хүүхдийн асуудлыг шийдвэрлэхэд хандуулж байна.

11. 2010 оны 12-р сарын 01-нд уг төсөлд 3 хүүхдийг \Эрдэнэбаатарын Төмөрсүх 16 нас, Цогтын Баттулга 16 нас, Баттулгын Өлзий-орших 15 нас\ шинээр нэмж орууллаа.

12. Нийслэлийн цагдаагийн газрын хүүхэд хамгаалал, хаяг тогтоох төв нь дээрхи төсөлд хамруулан давхардсан тоогоор 61 хүүхэд хүргүүлсэн боловч зарим нэн нь оргон нийслэл хотоор үргэлжлүүлэн тэнүүлэх зэргээр зугтан өнөөдрийн байдлаар 35 хүүхэд төсөлд амжилттай хамрагдан нийгэмшүүлэх зорилго, шаардлагын дагуу тус төвд нь БГД-ийн 6-р хорооны нутаг дэвсгэрт байрлах 52-ын 1-р байранд шилжин ирж, үйл ажиллагаагаа явуулж байна. ХУД-ийн 11-р хороонд байрлах төвийн байранд батлагдсан хуваарийн дагуу 24 цагийн жижүүр томилогдон ажилласан болно. Дотуур байранд байршин “Хөгжим хүүхдийн хөгжилд” хөтөлбөрт хамрагдаж байгаа хүүхдүүдийн тогтолтыг Ерөнхий сайд болон засгийн газрын гишүүдэд, НХХяамны салбарын хамт олонд, ЦЕГ-ын зөвлөлийн гишүүдэд, НЦГ, Дүүргүүдийн ЦХ-үүдийн удирдах бүрэлдэхүүнд, Батлан Хамгаалах Яамны удирдах болон Батлан Хамгаалах Яамны дэргэдэх Тэмүүжин сургуулийн сонсогч нарт, Орчлон дунд сургуулийн сурагчдад Дархан-уул аймаг, Сэлэнгэ аймаг, Орхон аймгуудад зохион байгуулав.

13. Дотуур байранд байрлаж буй хүүхдүүдэд ХХХТТ-өөс бие бялдарын сургалт 123 удаа, 123 цаг, Эрх зүйн сургалт 14 удаа 14 цаг, монгол хэлний сургалт 26 удаа 26 цаг, Унших бичиг 9 удаа 9 цаг, Оёдол 9удаа 23 цаг, Зургийн хичээл 5 удаа 6 цаг, Эрүүл Мэндийн сургалт 5 удаа 9 цаг, ДЗОУБ-аас дуу хөгжим 11 удаа 18 цаг, Зохион бүтээх сургалт 1 удаа 2 цаг, сэтгэл зүйн сургалт 9 удаа 6 цаг, Швед Монголын нийгэмлэгээс 3 удаа 7 цаг,

14. Хүний наймаанаас урьдчилан сэргийлэх сургалт 1 удаа 2 цаг, Монгол хэлний цагаан толгой, Англи хэлний хар яриа сургалт 5 цаг, англи хэлний сургалт Том ном унших арга зүй 2 цаг, Шүрэн урлалын сургалт 2 цаг, хүүхэд өөрийгөө тодорхойлох зан төлөвийн тоглоом 3 цаг, хүний эрхийн тухай ойлголт 2 цаг, Циркийн сургалт 7 цаг, Хүн худалдаалах ялангуяа хүүхэд эмэгтэйчүүд бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх сэдвийн сургалт 1 цаг,

15. Архи тамхины хор уршиг сэдэвт сургалт 3 цаг, насанд хүрээгүй хүмүүс гэмт хэргийн хохирогч болох нь сургалт 2 цаг 30 минут, хүний эрхийн тухай ойлголт 2цаг, Стресс тайлах арга зам сургалт 1 цаг, ДОХ-ын тухай сургалт 1 цаг, Ёс суртахууны соёл, эх оронч үзэл сургалт 1 цаг, хөгжим хүүхдийн хөгжимд төсөлд хамрагдаж буй хүүхдүүдэд албан бус монгол хэл, математик, зураг, англи хэлний хичээлийг өдөр бүр 4 цаг, морин хуур, найрал дууны хичээлийг өдөр бүр 4 цаг, тамхины хор хөнөөл сэдвээр 2 цаг, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх сэдвээр 2 цагаар тус тус зохион явуулсан¹⁹⁵ байна.

Цагдаагийн байгууллагаас хараа хяналтгүй хүүхдэд үзүүлж буй үйлчилгээний хувьд гагцхүү Улаанбаатар хотод бус аж үйлдвэр хөгжсөн томоохон хотууд руу чиглэх болсон нь сайшаалтай хэрэг юм. Энэхүү ажиллагааг улам өргөжүүлэн хөдөө орон нутаг руу чиглүүлэх шаардлагатай байна. Учир нь цагдаагийн байгууллагаас үзүүлж буй энэхүү үйл ажиллагааны тайлан, мэдээнээс үзэхэд хөдөө орон нутгийн хүүхдүүдийн талаар огт дурьдагдаагүй байгаа нь анхаарал татсан асуудал юм.

Энэ байдлаар үзвэл хараа хяналтгүй хүүхэд гагцхүү хотжилтоос улбаатай нийгмийн үзэгдэл болж таараад байна. Харин хүүхэд хараа хяналтгүй болж буй шалтгаан нь гэр бүл салалт, эцэг эхийн харьцаа, нийгэм эдийн засгийн тогтворгүй байдал, найз нөхдийн хүрээлэл болон орчин тойрны насанд хүрсэн хүмүүсийн буруу үлгэр дуриалал, хүчирхийлэл, дарамт шахалт, өөрийнх нь хүсэл зориг зэрэг олон хүчин зүйлээс хамаарсан байдаг. Тиймээс хөдөө орон нутагт гэр бүлийн харьцаа маш сайн байдаг уу гэвэл бас л худал зүйл юм. Хөдөө орон нутаг дахь цагдаагийн байгууллагын хажууд хараа хяналтгүй хүүхдийн талаарх асуудал эрхэлсэн байцаагчийг томилон ажиллалуулах саналтай байна. Харин хүүхдийг боловсрол эзэмшүүлэх талаар сургалт, хичээл гэх төдийхнөөс өөр хэрэгжүүлсэн арга хэмжээ хомс байгаа нь хүүхдийн сурч боловсрох эрх төдийлөн хангаж чадахгүй байгааг харуулсан хэрэг. Түүгээр зогсохгүй тус төвд байрлаж буй хараа хяналтгүй хүүхдээс түүвэрчилсэн судалгааны дүнгээс үзэхэд 14-16 насны хүүхдийг хамруулсан. Эдгээр хүүхдүүд бичиг үсэг тайлагдаагүй нь бичгийн хэв болон монгол хэлний зөв бичих дүрэм мэдэхгүй байгаа нь харамсалтай.

Тус тайлан мэдээнээс үзэхэд хүүхдийг бичиг баримтжуулах /иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, эрүүл мэндийн даатгалын дэвтэр зэрэг болно/ ажиллагааг тогтмол зохион байгуулж тэднийг нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, эдлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа дутмаг байна. Тухайлбал хүний хөгжил сангаас олгож буй мөнгөн тэтгэмж авах эрх үүссэн нэг ч хүүхдийн тухай дурьдаагүй байна.

2010 онд “Хувь заяа” төслийн хүрээнд хийсэн ажлын ажлын тайланг авч үзвэл:

- 1996-2009 онуудад тус төвд байрлаж байсан хүүхдүүдийг олж цуглуулах, тэлнийг үйл ажиллагаанд оролцуулах зорилгоор мэдээлэл цуглуулж, маршрутын чиглэлээр нийт 5 удаа арга хэмжээ зохиож, 15 хүүхдийг .
- 1996-2009 онуудад тус төвд ажиллаж байсан ахмад ажилтнуудад урилга хүргүүлж, 5 ахмад ажилтантай уулзах.

¹⁹⁵ НЦГ-ын дэргэдэх хүүхдийн халамж үйлчилгээний төвийн 2010 оны тайлангаас

- Төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчдийг урьж 8 ажилтныг уулзалтанд оролцуулах зэрэг ажлуудыг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Тус уулзалтын үр дүнгийн талаар авч үзвэл:

Уулзалтыг 2010 оны 05 дугаар сарын 18-ны өдөр 10.00-21.00 цагт “Намуун” зочид буудлын рестораны танхимд зохион явуулав. Уулзалтанд: хүүхдүүдийг төлөөлж 15, ахмад ажилтнуудыг төлөөлж 5, “Нeрp” төвийн 2, Хүүхэд сургалт хүмүүжлийн тусгай төвийн 2, “Хөгжлийн баянбүрд” төвийн 2, Хүүхдийн халамж үйлчилгээний төвийн 20, Нийслэлийн хүүхдийн төлөө газрын 2, нийт 50 хүн оролцуулан нэлээд өргөн хүрээтэй ажиллагаа зохион байгуулсан байна.

- Хүүхдийн халамж үйлчилгээний төвийн 15 алба хаагч 1996-2009 онд тус төвд давхардсан тоогоор 20094 хүүхдийн бүртгэл судалгаандаа хамруулсан байна. Дээрх тоон үзүүлэлт нь хүн ам цөөн манай орны хувьд нийт хүн амын нэг хувийг эзлэх болсон нь төр засгийн бодлогыг анхааран чиглүүлэх шаардлага зүй ёсоор урган гарч байгааг илтгэн харуулсан хэрэг юм.
- Тодруулгаас: Бүртгэлд хамрагдсан 20094 хүүхдийн 630 хүүхдийн одоогийн нөхцөл байдал тогтоогдсон ба энэ нь нийт хүүхдийн 3.1%-ийг эзэлж байна. Нас барсан 15, ял эдэлж байгаа 21, биеэ үнэлэгч 10, ор сураггүй 5, архаг архичин 10, хог түүгч 13 иргэн тогтоогдов. Тухайн үед охидын судалгаанд хамрагдсан 149 охидоос 34 буюу 22.8% нь тогтоогдсон болно. Эдгээр 34 охидын 15 нь буюу 44.1 % нь биеэ үнэлэгч болсон нь тогтоогдсон байна. Хүүхдийн халамж үйлчилгээний төвөөр дамжин хүмүүжсэн хүүхдийн нэлээдгүй хувь нь нийгэмд архичин, биеэ үнэлэгч, зүй бусаар нас барсан, сураггүй алга болсон зэрэг сэтгэл эмзэглэм судалгаа гарсан нь энэ төвийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, үйл ажиллагааг нь өргөтгөх бодит хэрэгцээ, шаардлага тулгараад байгаад харуулсан баримт юм.

Халамж үйлчилгээний төвийн үйл ажиллагааны тайлангаас харахад хүүхдийг нийгэмшүүлэх, сурч боловсрох эрхийг хангах талаар багагүй арга хэмжээ зохиодог хэдий ч төдийлөн үр дүнд хүрч чадахгүй байгаа нь дээрх судалгаанаас харагдаж байна. Иймээс эдгээр хүүхдүүд нь насанд хүрч халамж үйлчилгээний төвөөс гараад орох оронгүй, очих ах, дүү, аав, ээж, хамаатан садангүй учир дахин гудамжинд траншайнд амьдрах, тогтвортой ажлын байр байхгүй учир хог түүх, гэмт хэрэг үйлдэх замаар мөнгө олж хоногийн хоолоо залгуулах, бусдад уруу татагдан архи, тамхинд донтох зэрэг эмгэнэлт байдал нэгэнт газар авчээ. Энэ байдлыг таслан зогсоож иргэдийнхээ эрх, эрх чөлөөг эдлэх боломжийг олгох нь ардчилсан төрийн үндсэн хуулиараа тунхагласан үүрэг мөн. Дээрх үүргийнхээ хэрэгжилтийг бага боловч хангахын тулд хараа хяналтгүй хүүхдийн эрхийг хамгаалах нь нэн тэргүүний тулгамдсан асуудлуудын нэг болжээ.

Тиймээс хүүхдийн халамж үйлчилгээний төвийн хүүхдийн нийгэмшилт хийгээд насанд хүрч халамж үйлчилгээний төвөөс гарахад нь ажлын байр, түр хугацаагаар боловч амьдрах орон байр болон амьдралын зайлшгүй хэрэгцээт наад захын эд зүйл зэргээр нэг удаа хангаж байх талаар анхаарах нь зүйтэй. Амьдралынхаа наад захын нэн чухал хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаагийн улмаас нийгэмд орон гэргүй, тэнэмэл, архичин, биеэ үнэлэгчид, гэмт хэрэгтэнүүд бий болсоор байгааг анхаарах нь зүйн хэрэг биз ээ.

Харин НЦГ-ын дэргэдэх хүүхдийн халамж үйлчилгээний төвийн алба хаагчдаас авсан бидний судалгаагаар дээрх байдлыг шийдвэрлэх арга замын талаар нэгдсэн саналтай байсан. Тус судалгаанд хамрагдсан алба хаагчид хараа хяналтгүй хүүхдийг цэргийн зохион байгуулалттай сургууль нээх замаар тэднийг нийгэмшүүлэх, цаашлаад насанд хүрсэн хойно нь ч мөн ажлын байраар ч хангах боломжтой юм гэсэн санал дэвшүүлсэн нь цаашид нарийвчлан судлах шаардлагатай.

**МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН ЗАХИРГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТ, ОНОЛ-ПРАКТИКИЙН
ЗАРИМ АСУУДАЛ**

Ганболдын Нансал

ЦЕГ-ын Бодлого зохицуулалт, үнэлгээний хэлтсийн
ахлах мэргэжилтэн, магистрант, цагдаагийн ахмад

Монгол Улсад хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг дээдэлж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэж хүмүүнлэг, ардчилсан иргэний, нийгмийг төлөвшүүлэх зорилготой өнөө үед нийтийн хэв журмыг хэлбэрэлтгүй бэхжүүлэх, эрх зүйн зөрчилтэй тууштай тэмцэх явдал нийгмийн хөгжлийн бодит чухал зорилт болсон билээ.

Цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөө, нэр төр, хууль ёсны ашиг сонирхол хөндөгддөг учир түүнийг хамгаалах, албадлагыг аль болох хязгаарлах, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг үнэмшүүлэн ойлгуулах, хүмүүжил, олон нийтийн нөлөөлөл үзүүлэх, аргын хүрээг өргөтгөх зэрэг ажилд Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан зарчмын дагуу “ардчилал, ил тод, байдлыг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, хүнлэг шударга ёсыг эрхэмлэн дээдлэх” үзэл санааг баримталж ажиллах нь цагдаагийн албан хаагчийн нэр хүнд, үйл ажиллагааг сайжруулах нь дамжиггүй юм.

Нийгмийн хөгжлийн бодит зүй тогтол, төрийн удирдлага, захиргааны үйл ажиллагааны үндсэн шинжийг тусгасан цагдаагийн захиргааны албанд удирдлага болгож байгаа үзэл баримтлал, үндэслэлийг Цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааны зарчим гэж ойлгоно.¹⁹⁶

Монгол Улсын Үндсэн хуулийн 1.2 дах хэсэгт “Ардчилсан ёс, шудрага ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”¹⁹⁷ гэсэн үндсэн тулгуур зарчим дээр тулгуурлан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны зарчим нь боловсрогдсон билээ.

Зарчмын агуулга нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны мөн чанар, түүний тогтвортой шинжийг илүү бодиттойгоор илэрхийлдэг бол эрх зүйн хэлбэрээр тодорхойлогдсон зарчим нь цагдаагийн захиргааны үйл ажиллагааг төлөвшиж хэрэгжих үндсэн нөхцөл болж өгдөг.

“Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хууль”¹⁹⁸-ийн 3.1-т “Хуулийг дээдлэх, шударга ёс, тэгш байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” хэмээн үйл ажиллагааны тулгуур зарчмыг тодорхойлж өгсөн бол 3.2-т “Нэгдмэл төвлөрсөн удирдлагыг нутаг дэвсгэрийн удирдлагатай хослуулах нь цагдаагийн байгууллагын удирдлагын зарчим мөн” гэсэн удирдлагын зарчмаа давхар тодорхойлж өгчээ.

Цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа дээрх хоёр зарчмыг мөрдлөгө болгосноор гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага, алба, салбар, ангиуд зохион байгуулалтын бүтцийн илүү оновчтой хувилбарыг сонгон авах, тэдгээрийн эрх хэмжээг зөв тогтоох, чиг үүргээ хэрэгжүүлэхэд эрх зүйн давхардал гаргахгүй байх боломжийг бий болгосноор цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, материал, санхүүгийн аль болох бага зардал гарган, оновчтой зохион байгуулалтын хэлбэрт шилжиж, өмнөө тавигдсан зорилтоо биелүүлэх нөхцлийг бүрдүүлэх ач холбогдолтой болно.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны зарчмууд нь нийгмийн хөгжлийн хурдацтай зэрэгцэн хууль тогтоомжийн шинэчлэлт, цагдаагийн байгууллагын өмнө тавигдсан зорилт, тулгамдаж буй асуудлуудтай уялдан шинээр зарчим боловсрогдон

¹⁹⁶ Ж. Долгорсүрэн Монгол Улсын цагдаагийн эрх зүй, УБ хот 2003 он, 44 дэх тал

¹⁹⁷ Монгол Улсын Үндсэн хууль” 1-р зүйл www.mongolianlaws.com

¹⁹⁸ Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хууль”-ийн 3-р бүлэг. www.legalinfo.mn

мөрдөгдөх, зарим зарчим улам боловсронгуй болох зэргээр үргэлж хөдөлгөөнд байх нь зайлшгүй юм. Өөрөөр хэлбэл цагдаагийн байгууллага үйл ажиллагааныхаа хүрээ, хязгаар, эрх зүйн зохицуулалтыг байнга сайжруулах, өмнөө тавигдсан үүрэг, зорилтоо амжилттай хэрэгжүүлэх үндэслэл нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны зарчмыг байнга боловсронгуй болгох явдал юм.

Ийнхүү зарчим нь практик дээр төлөвшиж хэрэгжсэнээр цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагаа сайжирч, иргэдийн цагдаагийн байгууллагад хандах хандлага дээшилж, тэдгээрийн хоороондын харилцаа улам бат бэхжих боломжтой юм.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны зарчмыг шинэчлэх, түүнийг илүү өгөөжтэй боловсронгуй болгоход анхаарах зүйл бол цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны зарчим нь маш өргөн хүрээг агуулж байдаг учир үйл ажиллагааны зарчмыг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны салбар чиглэл бүрээр гаргах шаардлага зүй ёсоор гарч ирж байна. Тухайлбал: “Олон нийтийн газар хэв журам сахиулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах” гэх мэт үйл ажиллагааных нь онцлогоос хамаарч тус бүрд нь нарийвчлан томъёолж хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй өгөөжтэй байх болов уу гэж бодож байна.

Цагдаагийн байгууллага өөрийн үндсэн зорилт, чиг үүргээ хэрхэн гүйцэтгэж байгаа нь цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааны зарчим тодорхойлогддог байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах ажилд цагдаагийн байгууллага үйл ажиллагааны зарчмаа хэрхэн баримтлаж байгааг “Максима” төвийн иргэдээс авсан судалгааны үр дүнгээс харж болох юм. Энэхүү судалгааны зорилго нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, менежментийн үр нөлөөг сайжруулах, иргэд олон нийт болон цагдаагийн байгууллагын харилцааг сайжруулах талаар олон нийт ямар санал бодолтой байгаа талаар мэдээлэл авах, хийсэн судалгаандаа үндэслэн санал зөвлөмж боловсруулах зорилгыг агуулсан байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны зарчим нь цагдаагийн байгууллагын өмнө тавигдсан зорилттой салшгүй холбоотой бөгөөд зорилт нь үйл ажиллагааны үр дүнг урьдчилан илэрхийлдэг бол зарчим нь тэр үйл ажиллагаа чухам ямар үндэслэлээр хэрэгжвэл илүү өгөөжтэйг тодорхойлдог байна.

Зарчим нь ийм маягаар захиргааны үйл ажиллагааны хэлбэр, арга, албаны зохион байгуулалтын бүтэц, боловсон хүчинд нөлөө үзүүлнэ. Учир нь цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааны стратеги, тактик, арга барил болон үүрэг, зорилтоо гүйцэтгэн биелүүлэх албаны бүтэц, ажлын зохион байгуулалтад тавигдах үндсэн шаардлага зарчимд тусгагддаг. Өөрөөр хэлбэл зарчим нь цагдаагийн үйл ажиллагааны эхлэл, түүний хэрэгжих ерөнхий шинж төлөв, хэмжээ хязгаар, цаашилбал үйлчилж буй зүй тогтлын шууд тусгал, үр дүн юм.¹⁹⁹

Тэгэхлээр зарчим нь цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааны бүхий л үндсийг тодорхойлж өгөх бөгөөд зарчим дээр тулгуурлаж захиргааны үйл ажиллагаа хэлбэрээ олж явагдах учиртай.

Цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа зарчмууд нь хоорондоо харилцан уялдаа холбоо бүхий хамааралтай байх бөгөөд зарчим тус бүрээрээ тодорхой ажиллагаанд мөрдөгдөж болох бөгөөд зарим тохиолдолд гүйцэтгэх үүргийн онцлогоос шалтгаалан зарчмыг нийтэд нь эсхүл заримыг нь хослон хэрэглэх, үгүй бол нэгийг нь сонгон авч хэрэглэснээр үйл ажиллагаа илүү үр дүнд хүрнэ.

Бидны үзэж байгаагаар цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааны зарчмыг үйл ажиллагааны онцлог, хамрах хүрээнээс хамааран үндсэн 2 хэсэгт хуваан зарчмыг тодорхойлж өгвөл илүү үр дүнтэй байх болов уу гэж бодож байна.

Өөрөөр хэлбэл цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааг явуулж буй үйл ажиллагааны онцлогоос хамааран гадагшаа болон дотогшоо чиглэсэн гэж хувааж үздэг.

¹⁹⁹ Ж. Долгорсүрэн “Монгол Улсын цагдаагийн эрх зүй” УБ. 2004. 81 дэх тал

Тэгвэл дотогшоо чиглэсэн үйл ажиллагаанд удирдлага, зохион байгуулалтын зарчмыг, гадагшаа чиглэсэн үйл ажиллагаанд тактикийн зарчмуудыг тус тус баримтлах бөгөөд захиргааны үйл ажиллагаа бүхэлдээ социал-эрх зүйн зарчмуудыг үйл ажиллагаандаа удирдлага болгох нь зүйтэй юм.

Цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааны социал-эрх зүйн зарчим нь цагдаагийн байгууллага, алба хаагчдын албан тушаал, цолны зэрэглэл, үйл ажиллагааны онцлогоос үл хамаарах бөгөөд цагдаагийн бие бүрэлдэхүүн нийтээрээ баримтлах нийтлэг шинжтэй үзэл баримтлалуудыг хамааруулан ойлгоно. Үүнд:

- Хүнлэг ёсны зарчим;
- Ард түмний итгэл хүлээж, тэдний тус дэмжлэгт түшиглэх зарчим;
- Шинжлэх ухаанлаг хандах зарчим;
- Тэгш байдал, шудрага ёсны зарчим;
- Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчим тус тус хамаардаг байна.

Тэгвэл удирдлага, зохион байгуулалтын зарчим нь цагдаагийн төв байгууллага, түүний харьяа алба, газар, хэлтэс, тасаг, хэсгийн зохион байгуулалтын бусад бүтцийг тогтоох, тэдгээрээс үйл ажиллагаагаа явуулах, мэргэжлийн удирдлагаар хангахад дагаж мөрдөх үзэл баримтлал юм. Үүнд:

- Салбарын зарчим
- Шугаман бүтцийн зарчим
- Чиг үүргийн зарчим
- Нутаг дэвсгэрийн зарчим
- Нутаг дэвсгэрийн удирдлагыг төвлөрсөн удирдлагатай хослуулах
- Эрх хэмжээг зөв хувиарлах
- Ажлын үр дагаврыг хариуцах
- Хамтын ба ганцаар захирах зарчмыг хослуулах

Тактикийн зарчим нь цагдаагийн байгууллагаас өөрийн үндсэн зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай хүч хэрэгсэл, ажлын зохион байгуулалт, ажлаа хэрэгжүүлэх арга барил, үйл ажиллагаагаа оновчтой зөв тактикаар явуулахад мэргэжлийн удирдлагаар хангахад баримтлах үзэл баримтлалуудыг хамааруулан ойлгоно. Үүнд:

- Цагдаагийн байгууллагын тактикийн зарчим
- Шаардлагатай газарт шийдвэрлэх үед хүч хэрэгслийг төвлөрүүлэх
- Хүч хэрэгслээ иж бүрэн ашиглах, тэдний үр нөлөөтэй хамтын ажиллагааг хангах
- Нийгмийн хэв журам сахиулах ажиллагаа тасралтгүй, уян хатан зохиогдох
- Үйл ажиллагаа байнга идэвхитэй явагдах
- Нөөцтэй байх зэрэг зарчмууд хамаарч байна.

Өнөөдөр Монгол Улс хөгжлийн шинэ тогтолцоонд шилжээд тодорхой хугацаа өнгөрсөн бөгөөд хуучин тогтолцоонд хэрэглэгдэж байсан эрх зүйн зарчим шинэчлэгдэх зайлшгүй шаардлага бий болсон юм.

Энэ удаа цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааны тактикийн зарчмын хэрэгжилтийн талаар товчхон санаагаа хэлэх гэсэн юм. Учир юу гэвээс өнөөдөр цагдаагийн байгууллага зарчмаа зөв тодорхойлж, үйл ажиллагаандаа мөрдлөгө болгож чадна, тэр хэрээр гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үйл ажиллагаандаа ахиц дэвшил гаргаж, ард иргэдийнхээ дунд албаныхаа нэр хүндээ дээшлүүлэх нөхцөл боломж бүрдэх юм.

“Америкийн Нэгдсэн Улсын Азийн сангийн захиалгаар Максима судалгааны төвийн явуулсан судалгаагаар цагдаагийн байгууллагад эрс шинэчлэл хийхийг олон нийт, цагдаагийн нийт бие бүрэлдэхүүн дээд, дунд, доод бүх шатанд хүссэн байна. Иймд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулж, бүтэц зохион байгуулалтыг бэхжүүлэх талаар судалгаанд оролцогчид 20 гаруй санал дэвшүүлснийг анхаарч үзэх

шаардлагатай. Судалгаанд хамрагдсан иргэд цагдаа дахь сөрөг үзэгдэл нь “алаг үзэх” явдал болсон гэж үзсэн байна.²⁰⁰

Цагдаагийн байгууллагын ажилтнууд төрийн тусгай алба хаагчийн хувьд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах үүрэгтээ үлгэр жишээ, хуулийг биелүүлэгч, сахигч байх ёстой билээ.

Саяхан Монгол Улсын Засгийн Газраас баталсан “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийн хүрээнд явагдсан “Аюулгүй, амар тайван орчин” 1 сарын аяны явцад иргэд, олон нийтийн санал асуулга явуулж дүнгээ нэгтгэжээ.

Энэхүү санал асуулга нь “хаалттай” болон “нээлттэй” 9 асуултаас бүрдсэн ба иргэдээс өөрсдийн оршин суух нутаг дэвсгэрийн гэмт хэргийн болон хэв журмын нөхцөл ямар түвшинд байгаа, цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үндсэн үүргээ хэрхэн гүйцэтгэдэг, хууль сахиулах үйл ажиллагаанд иргэд хэрхэн оролцдог, иргэдийн оролцоог дээшлүүлэх талаар авах арга хэмжээ, цагдаагийн алба хаагчийн харьцаа хандлага, цаашид цагдаагийн байгууллагаас хийвэл зохих үйл ажиллагаа зэргийг тодруулах зорилгыг агуулсан байна.

Санал асуулгад 20 аймаг, нийслэлийн 9 дүүргийн нийт 8674 иргэн хамрагдсан байна. Энэхүү судалгаанаас захиргааны үйл ажиллагааны тактикийн зарчимд хамаарах зарим асуулт, хариултыг түүвэрлэн авч дүгнэлт хийхийг чармайлаа.

- Цагдаагийн байгууллага танд шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлж чаддаг уу? гэсэн асуултанд 8674 иргэн хариулт өгөхөөс 8213 иргэн сонголт хийсэн байна. Иргэдийн хийсэн сонголтыг харуулбал:
 - Бүрэн чаддаг гэж – 2906 иргэн буюу 35.3%
 - Зарим тохиолдолд чаддаг гэж – 4392 иргэн буюу 53.4%
 - Огт чаддаггүй – 915 иргэн буюу 11.2% .
- Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах үйл ажиллагааг хэрхэн дүгнэж байна вэ? гэсэн асуултад 8674 иргэн хариулт өгөхөөс 8387 иргэн хариултын хувилбараас сонголт хийсэн. Үүнд,
 - Хангалттай сайн гэж -3277 иргэн буюу 40%
 - Дунд зэрэг гэж – 4364 иргэн буюу 52%
 - Огт хангалтгүй гэж – 746 иргэн буюу 8.8%
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаар хаанаас мэдээлэл авдаг вэ? гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан 8674 иргэнээс 8389 иргэн хариулсан байна. Үүнд:
 - Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гэж – 64 хувь буюу 5369 иргэн
 - Бусдын ярианаас гэж – 25 хувь буюу 2098 иргэн
 - Огт мэдээлэл авч байгаагүй гэж- 10.3 хувь буюу 871 иргэн тус бүр хариултын хувилбарыг сонгон хариулсан байна.²⁰¹

Иргэдийн дунд явуулсан санал асуулгад иргэд харилцан адилгүй хариулт өгсөн хэдий ч цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагаа, цаашдын үйл ажиллагааны зарчимд анхаарах асуудлууд тодорхой хэмжээгээр илрэн гарсан гэж үзсэн байна.

Санал асуулгад хамрагдсан иргэдийн 62.7 хувь нь оршин суугаа нутаг дэвсгэрийн эрүү болон хэв журмын нөхцөл байдлыг дунд зэрэг байдаг гэж дүгнэсэн ба энэхүү нөхцөл байдалд цагдаагийн байгууллага шаардлагатай тусламж үйлчилгээг 53,4 хувьтай дунд түвшинд ханган ажилладаг хэмээн илэрхийлсэн нь цагдаагийн байгууллага захиргааны үйл ажиллагаандаа нийгмийн хэв журам сахиулах ажиллагаа тасралтгүй, уян хатан зохиогдох болон үйл ажиллагаа байнга идэвхитэй явагдах гэсэн зарчмуудыг бүрэн дүүрэн баримталж чадаж байна уу гэсэн дүгнэлт эндээс урган гарч байна.

Харин цагдаагийн алба хаагчийн зан харьцааны талаар асуусан асуултанд дийлэнх нь буюу 3775 иргэн зөв боловсон, хуулийн дагуу харьцдаг гэж дүгнэсэн нь сайшаалтай юм.

²⁰⁰ “Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний илтгэл” 2010 он www.upr-mongolia.mn

²⁰¹ www.khevjuram.com

Цагдаагийн байгууллагын гол зөрчил нь нэг талаас нийгэм өөрчлөгдөж хөгжлийн чиг хандлагатай уялдан хүмүүсийн сэтгэхүй ухамсар өөрчлөгдсөн байхад нөгөө талд цагдаагийн байгууллага хуучирсан ажлын арга барил, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтаар явж байгаа нь харагдаж байна. Энэ байдлыг зоригтой өөрчлөх цаг нь хэдийнээ болжээ.

Өнөөдөр цагдаагийн байгууллага үйл ажиллагааныхаа зарчмыг нийгмийнхээ зүй тогтолтой уялдуулан шинэчилж, шинэчлэгдсэн цогц бодлого боловсруулан зохион байгуулалтын дорвитой өөрчлөлт, шинэчлэлт хийхгүй бол нийгмийн хөгжилтэй мөр зэрэгцэн алхаж чадахгүй болоод байна.

Цагдаагийн байгууллага болон алба хаагчид маань өөрөө мэргэжлийн хувьд, бие хүний хувьд бас өөрчлөгдөх хэрэгтэй байна. Нийгэмд цоо шинэ нарийн үзэгдлүүд бий болж шинэ гэмт хэргүүд гарч байхад хуучинсаг цагдаа хариу үйлдэл хийж чадахгүй байна.

Нөгөө талаар цагдаагийн байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэр зэрэг захиргааны үйл ажиллагааны тасралтгүй, байнгын тогтвортой явуулах зарчмыг баримтлан зохион байгуулж явуулж байна уу гэдэг нь гэмт хэрэг, эрх зүйн зөрчилд хийсэн дүн шинжилгээнээс ихээхэн хамаарах болно.

**ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧААС НОГДУУЛАХ ЗАХИРГААНЫ
ШИЙТГЭЛИЙН ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ
ЗАРИМ АСУУДАЛ**

Алтанхуягын Насанжаргал
СБД-н ЦХ-н Мэдээлэл хүлээн авагч цагдаа,
магистрант, цагдаагийн ахлагч

Монгол улсад жилд гэмт хэргээс хэд дахин илүү тоогоор үйлддэгддэг захиргааны зөрчилд захиргааны хариуцлага хүлээлгэх эрх бүхий субъектүүдийн дотор цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан голлох байр суурийг эзэлдэг Захиргааны зөрчил нь “ялимгүй гэмт хэрэг”-т тооцогдон бусдад учруулсан хор, уршгаараа гэмт хэргээс ялган зүйлчлэгдэх тохиолдлууд цөөнгүй байна.

Захиргааны зөрчил гаргагчид ногдуулж байгаа захиргааны шийтгэлийн тогтолцоонд цагдаагийн алба хаагчийн ногдуулдаг захиргааны шийтгэл тодорхой байр суурийг эзэлдэг бөгөөд үр нөлөөг дээшлүүлэх нь захиргааны шийтгэлийн зорилгыг хангахад ихээхэн ач холбогдолтой юм.

Захиргааны шийтгэл ногдуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг тойрсон тулгамдсан асуудлууд цөөнгүй байгаа боловч уг асуудлыг тусгайлан судалсан эрдмийн бүтээл харьцангуй цөөн байна.

Цагдаагийн алба хаагчаас ногдуулах захиргааны шийтгэлийн төрөл, хэмжээ, хугацаа, захиргааны хариуцлага хүлээлгэхтэй холбогдох харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчилдөөнийг арилгах асуудлыг хөндөх, захиргааны шийтгэл ногдуулах үндэслэл, журмыг борловсронгуй болгох гэх зэрэг захиргааны шийтгэлийг тойрсон тулгамдсан асуудлууд нь энэхүү сэдвийг сонгон судалгаа, шинжилгээний ажил хийх хэрэгцээ, шаардлагатайг харуулж байгаа тул миний бие “Цагдаагийн алба хаагчийн ногдуулах захиргааны шийтгэлийг үр нөлөөг дээшлүүлэх зарим асуудал “сэдвээр судалж байгаа юм.

Цагдаагийн алба хаагчаас ногдуулах захиргааны шийтгэлийн тухай асуудлыг Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа төрөлжсөн хуулиудын хэмжээнд судалгааг нилээд бодитой хийж, захиргааны шийтгэл ногдуулах бодит үндэслэл, захиргааны шийтгэл хүлээлгэх үндэслэл байгаа эсэхийг шалгах ажиллагааны эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, түүнийг боловсонгуй болгох, хуулиудын давхардал, хийдэл, зөрчилдөөнийг арилгах асуудалд тухайлан анхаарал хандуулж, нилээд өргөн хүрээнд авч үзлээ.

Захиргааны шийтгэлийн онцлогийг Эрүүгийн болон Иргэний эрх зүй, сахилгын зөрчил, хариуцлагатай харьцуулж адил болон ялгаатай талыг тодотгон харуулахыг эрмэлзэв.

Захиргааны хариуцлагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг хөндсөн “Захиргааны хариуцлагын тухай хууль”-ийн шинэчлэн найруулсан төслийг нийгмийн харилцаа, бодит хүчин зүйлүүдтэй уялдаа холбоотойгоор судалж, зөвхөн цагдаагийн алба хаагчаас захиргааны шийтгэл ногдуулах асуудлыг төдийгүй захиргааны хариуцлага хүлээлгэх хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлыг хөндсөн нь судалгааны ажлын цар хүрээ, ач холбогдлыг үнэлэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлөх болов уу.

Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал

1.1.Захиргааны хариуцлагын тухай төрөлжсөн хуулийг батлан гаргах асуудал нэн тэргүүнд тавигдана. Төрөлжсөн хуулийг баталснаар хуулиудын давхардал, хийдэл арилж, цагдаагийн алба хаагчаас захиргааны хариуцлагын тухай хуулийг хэрэглэхэд дөхөмтэй болно.

Захиргааны хариуцлага хүлээлгэх хууль тогтоомжууд хэт олон байгаагаас цагдаагийн алба хаагч тэр бүр судалж хэрэглэх боломжгүй байдлыг үүсгэдэг сөрөг үр дагавартай бөгөөд энэ нь хуулийн хэрэгжилтэд төдийгүй захиргааны шийтгэлийн зорилгыг хангахад сөргөөр нөлөөлөх байдлуудыг бий болгож байгаа юм. Цагдаагийн алба хаагчдаас авсан санал асуулгаар захиргааны хариуцлага хүлээлгэх хууль тогтоомжийг өөрсдийн үйл ажиллагааны хүрээнд хэрэглэгддэг, Захиргааны хариуцлагын тухай хууль Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай хууль, Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, Галт зэвсгийн тухай хууль гэх зэргээр хязгаарлан ойлгох явдал байгаа нь харагдаж байлаа.

Хэрэв Захиргааны хариуцлагын тухай төрөлжсөн хууль батлагдвал захиргааны хариуцлага хүлээлгэх олон хуулиуд цэгцлэгдэж, хуулиудын давхардал, хийдэл, зөрчил арилах төдийгүй хууль хэрэглэгчдийн ажлын үр дүн дээшлэх, зөрчил гаргагч шийтгэлийг завших зэрэг сөрөг нөхцөл байдлуудыг засах боломжтой болно.

Захиргааны хариуцлагын тухай төрөлжсөн хууль нь ерөнхий, тусгай анги гэсэн бүтэцтэйгээр боловсруулж батлах нь зүйтэй байна. Хуулийн **ерөнхий ангид** захиргааны зөрчил, хариуцлагын тухай ойлголтыг томъёолон хуульчилж нэг мөр ойлголт өгөх, захиргааны шийтгэлийн төрөл, хэмжээ, оногдуулах хэлбэр, захиргааны хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, журам, захиргааны хариуцлагыг хөнгөрүүлж, хүндрүүлж үзэх нөхцөл байдлууд, захиргааны хариуцлага хүлээлгэхдээ баримтлах зарчмуудыг тусгах, хуулийн **тусгай ангид** захиргааны зөрчлийг халдсан болон журам тогтоосон хэм хэмжээгээр хамгаалагдсан харилцааг шалгуур болгон бүлэг, зүйл хэсгийг тогтоон төрөлжүүлэх тухайлбал, эдийн засгийн харилцааны эсрэг захиргааны зөрчил, байгаль хамгаалах журмын эсрэг захиргааны зөрчил, нийгмийн хэв журамд халдсан захиргааны зөрчил, нийтийн аюулгүй байдлын эсрэг захиргааны зөрчил гэх зэрэг.

Захиргааны хариуцлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг судлаач миний дэмжиж байгаа санаагаар боловсруулсан бөгөөд энэ хууль батлагдвал олон эерэг үр дүн өгнө гэдэгт найдаж байна.

2.Одоогийн даган мөрдөж байгаа Захиргааны хариуцлага хүлээлгэх хууль тогтоомжуудад Захиргааны хариуцлагын тухай хуулиас хүлээлгэх хариуцлагыг иш татсан буюу хийдэлтэй гэж үзэхээр хууль 55 байгаа нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн 28 хувийг эзэлж байна. Эдгээр хуулиудын 14-д нь “Хууль тогтоомжинд зааснаар хариуцлага хүлээлгэнэ” гэсэн ерөнхий заалттай, 41 хуульд Захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар хариуцлага хүлээлгэнэ гэсэн иш татсан зохицуулалттай байна. Эдгээр иш татсан зохицуулалттай зөрчлүүдэд бүгдэд нь захиргааны торгууль ногдуулахаар заасан байгаа болно. Эдгээрээс цагдаагийн алба хаагч хариуцлага хүлээлгэх эрхтэй байгаа хуулиуд цөөнгүй байна.

Тухайлбал: Эдгээр нь гол төлөв Захиргааны хариуцлагын тухай хуулийн зарим зөрчилд хүлээлгэх захиргааны хариуцлага гэсэн II бүлэгт заасан зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлагыг иш татсан байдлаар тусган хуульчлах байдлаар хариуцлага хүлээлгэх асуудлыг зохицуулсан байгаа юм. Хуулийн хийдэл гаргахгүйн тул захиргааны хариуцлага хүлээлгэх хууль тогтоомжид иш татсан зохицуулалтыг багасгах, хүлээлгэх хариуцлагыг тухайн хуульд тодорхой заах нь зүйтэй байна.

3.Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-д иргэнд ногдуулах торгох шийтгэл 100-50000, албан тушаалтанд 1000-60000, байгууллага, аж ахуйн нэгжид 50000-250000 төгрөгийн торгууль ногдуулахаар торгуулийн нийтлэг хэмжээг заасан.

Мөн зүйлд Захиргааны хариуцлагын тухай хуулийн 28, 28.1 дэх заалтад заасан зөрчлөөс бусад зөрчилд энэ хэмжээ хамаарахаар заасан байна. Энэ нь дурдсан заалтад зааснаас бусад зөрчилд ногдуулах торгуулийн хэмжээ Захиргааны хариуцлагын тухай хуулийн 4.3-д заасан торгуулийн нийтлэг хэмжээтэй нийцэж байх үндэслэл, шаардлагыг тогтоосон хэрэг юм.

Гэтэл энэ хэмжээг зөрчиж торгуулийн хэмжээг тогтоосон хуулиуд цөөнгүй байгаа нь захиргааны торгуулийн нийтлэг хэмжээг зөрчсөн бөгөөд энэ нь хуулиудын хоорондын үл нийцэх, зөрчилдөөнийг бий болгож байна.

Хуулиудын энэхүү зөрчилтэй заалтууд нь цагдаагийн алба хаагч шийтгэлийг сонгон хэрэглэхэд ихээхэн түвэгтэй байдлыг бий болгодог бөгөөд Захиргааны хариуцлагын тухай хуулийн торгох шийтгэлийн ерөнхий хэмжээг тогтоосон дээрх заалтад захиргааны хариуцлага хүлээлгэх бусад хууль тогтоомжийг нийцүүлэх асуудлыг орхигдуулсантай холбоотой юм.

Хэрэв торгуулийн хэмжээг нэмэх шаардлагатай гэж үзвэл Захиргааны хариуцлагын тухай хуулийн нийтлэг хэмжээг өөрчлөх асуудлыг зэрэгцүүлэн шийдвэрлэх нь зүйтэй юм. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа 196 хуулиас иргэнийг торгох шийтгэлийн ерөнхий хэмжээнээс хэтэрсэн 9, албан тушаалтныг торгох шийтгэл хэмжээнээс хэтэрсэн 13, аж ахуйн нэгжийг торгох шийтгэл хэмжээнээс хэтэрсэн 11 хууль, дахин нэмэгдүүлсэнтэй тэмцэх хэмжээгээр торгох шийтгэл хэмжээнээс хэтэрсэн 11 хууль байгаа судалгаа гарсан байна.²⁰²

Энэ нь Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа хуулийн давхардал, хийдэл, зөрчилдөөнийг засах нэгдсэн арга хэмжээний хүрээнд зайлшгүй шийдвэрлэх асуудлын нэг юм.

Цагдаагийн алба хаагчийн хэрэглэдэг захиргааны хариуцлага хүлээлгэх хуулиудын дотор захиргааны торгуулийг 2 хуульд давхардуулан заасан, эдгээр нь хэмжээ болон шийтгэл ногдуулах, шийтгэл хүлээх субъект нь хоорондоо зөрчилдөөнтэй зохицуулалт цөөнгүй байна. Тухайлбал, 1998 онд батлагдсан Садар самуун явдалтай тэмцэх тухай Монгол Улсын хуулийн 13.2.3-д садар самууныг сурталчилсан бол олсон орлогыг нь хурааж гэм буруутай албан тушаалтныг 40000-60000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж байгууллагыг 10000-150000 хүртэл төгрөгөөр торгох, энэ зөрчлийг нэг жилийн дотор давтан гаргасан бол хэвлэл, мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг зогсоох²⁰³ гэжээ.

Гэтэл Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хуулийн Садар самууныг сурталчлах, өнгөний өвчнийг эмчлүүлэхээс зайлсхийх гэсэн 41 дүгээр зүйлд Садар самууныг сурталчилсан бол 10000 төгрөг хүртэл торгохоор²⁰⁴ заажээ.

Хуулийн дээрх 2 заалтыг үзэхэд торгуулийн хэмжээ зөрүүтэйн зэрэгцээ Захиргааны хариуцлагын тухай хуульд шийтгэл хүлээх субъект тодорхой бус байгаа нь харагдаж байна. Энэ мэт зүйл, заалтууд цөөнгүй байгаа тул цэгцэлж, давхардлыг арилгах шаардлагатай байгаа нь ажиглагдаж байна. Энэ нь цагдаагийн алба хаагч торгууль ногдуулахдаа чухам ямар хуулийг хэрэглэх нь ойлгомжгүй байх, түвэгтэй асуудлыг үүсгэж байгаа юм. Торгуулийн хэмжээ зөрүүтэйгээс зөрчил гаргагч ялгавартай хариуцлага хүлээж шударга бус байдал бий болох, цагдаагийн алба хаагч үзэмжээрээ хандаж торгуулийн хэмжээг сонгон ялгаварлах боломжийг бүрдүүлэх гэх зэрэг олон сөрөг үр дагаврыг бий болгох боломжтой юм.

Захиргааны торгуулийг ногдуулахад цөөнгүй тохиолдох хүндрэлтэй асуудал нь Захиргааны хариуцлагын тухай хууль болон Эрүүгийн хуулийн давхардлын асуудал юм. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг нь Захиргааны хариуцлага хүлээлгэх хууль тогтоомжинд заасан захиргааны зөрчилтэй ихэнх шинжээрээ адил боловч зөвхөн учруулсан хор уршгийн хэмжээгээрээ ялган зүйлчлэгдэх тохиолдол цөөнгүй байна. 2000 оны эхээр зарим эрдэмтэн, судлаачид захиргааны зөрчлийг ялимгүй гэмт хэрэгт тооцож Эрүүгийн хуульд багтаан хуульчлах саналыг гаргаж нилээдгүй шүүмжлэлийг дагуулж байсан билээ.

Зохион байгуулалт үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар

²⁰² УИХ-ын захиалгаар ХЗҮХ –ээс явуулсан судалгааны тайлангаас. УБ, 2010.

²⁰³ Терийн мэдээлэл 1998, №3

²⁰⁴ Терийн мэдээлэл 1992, №4-5

Цагдаагийн алба хаагчаас ногдуулах захиргааны шийтгэлийн үр нөлөөг судлах судлах, хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага хэрэгцээг тодорхойлоход захиргааны зөрчлийн улсын нэгдсэн тоо бүртгэлтэй болох асуудал нэн чухал юм.

Одоогийн байдлаар улсын хэмжээнд үйлдэгдэж байгаа захиргааны зөрчлийн нэгдсэн тоо бүртгэл байхгүй бөгөөд энэ нь захиргааны торгох шийтгэл ногдуулалтын байдал, зөрчлийн өсөлт, бууралтыг судлах, зөрчил гаргагчдын тухай мэдээллийг төвлөрүүлэн дахин зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, хариуцлагыг хүндрүүлж, хөнгөрүүлж үзэх нөхцөл байдлыг тодорхойлох, гэмт хэргээс эртлэн сэргийлэх арга замыг тодорхойлох, бодлого, чиглэлийг боловсруулж хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байгаа юм.

Судалгааны ажлын явцад Цагдаагийн Ерөнхий Газар, Гаалийн Ерөнхий Газар, Үндэсний Татварын Ерөнхий Газрын захиргааны зөрчлийн тоо бүртгэлийн байдлыг танилцан судлав. Цагдаагийн Ерөнхий Газрын Мэдээлэл, судалгааны төв нь захиргааны зөрчлийн тоо бүртгэлийг нэгтгэн төвлөрүүлэхээс гадна зөрчлийн гаралт, хандлага, ногдуулсан шийтгэл, түүний өсөлт, бууралт, зөрчил гаргагчдын мэдээлэл, нийгмийн харилцаанд хандсан байдлыг ямар хууль тогтоомжоор хариуцлага хүлээлгэсэнтэй нь уялдуулан нилээд бодитой авч үзэн дүгнэлт хийдэг байдал ажиглагдаж байв

Шийтгэлийн хэлбэр, хэмжээ, зөрчил гаргагч, зөрчлийг хянан шийдвэрлэсэн эрх бүхий албан тушаалтны мэдээлэл

Зөрчил гаргасан 308677 иргэн буюу 87.0 хувийг торгуулийн хуудсаар 1293.4 сая төгрөгөөр, 46100 буюу 13.0 хувийг шийтгэврээр, үүний дотор 26246 иргэн, 19 албан тушаалтан, 379 байгууллага, аж ахуйн нэгжийг 519.5 сая төгрөгөөр тус тус торгож, 12674 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, 6782 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан байна. Зөрчил гаргасан байгууллагыг төрөл, өмчийн хэлбэрээр нь авч үзвэл: Төрийн байгууллага 1, төрийн бус 4, хувийн хэвшлийн 374, төрийн өмчийн 3, орон нутгийн өмчийн 3, хувийн өмчийн 373 байгууллага байна.

Шийтгэл ногдуулсан эрх бүхий албан тушаалтнаар нь авч үзвэл: 39094 буюу 84.8 хувьд цагдаагийн эрх бүхий алба хаагч, 6761 буюу 14.7 хувьд шүүгч, 245 буюу 0.5 хувьд Засаг дарга тус тус шийтгэл ногдуулжээ.

Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан зөрчлийн төрлөөр авч үзсэн судалгаа

Улсын хэмжээнд 44993 зөрчил бүртгэгдсэний дотор хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих 31107, танхайрах 9986, согтуурах 1320, цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх, цагдаагийн байгууллагад худал мэдээлэл өгөх 1240, бусдын эд хөрөнгийг бага хэмжээгээр ашиглан шамшигдуулах 680, худалдаа, үйлчилгээний журам зөрчих 437, бусдын эд хөрөнгийг шунахай зорилгоор хувьдаа ашиглах 54, төрийн төлөөлөгчийн хууль ёсны шийдвэрийг биелүүлэхгүй байх, эсэргүүцэх 70, гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол улсад оршин суух, дамжин өнгөрөх, зорчих журам зөрчих 29, нийтийн эзэмшлийн эд хөрөнгө эвдэх, гэмтээх 11, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих 29, галт зэвсэг болон амьсгал боогдуулах, нулимс асгаруулах бодис хууль бусаар олж авах, авч явах, хадгалах 5, төрийн байгууллагын ажилтны нэр барих 6, хүйтэн зэвсэг авч явах 4, энгийн харуул, манааны журам зөрчих 1, бусад төрлийн 14 зөрчил тус тус бүртгэгджээ.

Хохирогчтой холбогдох судалгаа .

Зөрчлийн улмаас 4279 иргэнд 314268.1 мян төгрөгийн хохирол учирсны 71.5 хувийг нөхөн төлүүлжээ.

Хохирсон иргэдийг насны байдлаар нь авч 547, 45-49 насны 650, 60-64 насны 25, 65-69 насны 14, 70 ба түүнээс дээш насны 13;

Хохирсон иргэдийг нийгмийн байдлаар нь авч үзвэл: Төрийн алба хаагч 119, хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч 442, төрийн бус байгууллагын ажилтан 81,

хувиараа хөдөлмөр эрхлэгч 428, ажилчин, малчин 570, оюутан 145, сурагч 27, сургууль завсардсан хүүхэд 1, тэнэмэл 6, ажилгүй 2383, бусад 77 иргэн бүртгэгджээ.

Хохирсон иргэдийн 290 буюу 6.8 хувь нь согтуугийн улмаас, 224 буюу 5.2 хувь нь өөрийн буруутай үйлдэл, 866 буюу 20.2 хувь нь гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирчээ.

Гаалийн Ерөнхий Газрын захиргааны зөрчлийн тоо бүртгэл нь хугацаагаар буюу сар, жилээр, гаалийн хууль тогтоомжийн зүйл, заалтад заасан журам, түүнийг зөрчсөн байдлыг гол үзүүлэлт болгон гаргадаг байна. Гаалийн байцаагч нарын ногдуулдаг шийтгэлийн төрөл нь торгох, хууль бусаар олсон орлого, эд зүйлийг хураах шийтгэл байдаг тул ногдуулсан торгуулийн хэмжээ, зөрчигдсөн хуулийн зүйл, заалт гэсэн 2 гол үзүүлэлтээр л бүртгэлээ гаргадаг, зөрчлийн тоо бүртгэлийг хариуцсан ажилтантай боловч зөрчлийн судалгааг хийж дүгнэлт, саналыг боловсруулах ажил учир дутагдалтай байдал ажиглагдаж байв. Гаалийн Ерөнхий Газрын захиргааны зөрчлийн тоо бүртгэлийн нэгдсэн мэдээг авч үзвэл дараахь байдалтай байна.

Захиргааны зөрчлийн тоо, ногдуулсан торгуулийн хэмжээ, зөрчил гаргагчийн талаар мэдээлэл авах боломжийг судлан үзэхэд цагдаагийн байгууллагаас гаргадаг захиргааны зөрчлийн тоо бүртгэл нь үзүүлэлтийн хувьд боломжтой, зөрчлийн ангилалт, гаралт, хандлагыг нилээд бодитой авч үзсэн байв. Улсын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газар, Гаалын ерөнхий газраас гаргадаг захиргааны зөрчлийн тоо бүртгэлийн үзүүлэлтүүд учир дутагдалтай сайжруулах шаардлагатай нь харагдаж байлаа.

Цаашид захиргааны зөрчлийн нэгдсэн тоо бүртгэлийг хариуцах байгууллага, түүний эрх зүйн байдлыг нь тогтоох, уг ажиллагааг явуулах бүтцийг бий болгох, эрх зүйн орчныг нь бүрдүүлэх шаардлагатай байгаа юм. Энэ нь захиргааны зөрчлийн гаралт, хандлага түүнд нөлөөлсөн бодит хүчин зүйлүүдийг судлан тодорхойлох, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах боломжийг бүрдүүлэх бөгөөд цаашлаад гэмт хэргээс эртлэн сэргийлэх ажлыг зохион байгуулах нөхцлийг бүрдүүлэх юм.

2.2. Торгуулийг төлөх хэлбэрийг боловсронгуй болгож төлбөр төлөлтийг бэлэн бусаар хийдэг олон улсын жишигт шилжих нь ач холбогдолтой байгаа бөгөөд торгуулийг ногдуулсан цагдаагийн алба хаагч бэлэн мөнгийг шууд авах, түүнийгээ тодорхой хугацаагаар ашиглах, мөн торгуулийн хуудас бичихгүйгээр мөнгийг бэлнээр авах боломжтой болсноос хэрэг, зөрчилд холбогдох замыг хаах, зөрчил гаргагч болон цагдаагийн алба хаагчийн хоорондын торгуултай холбогсон сөргөлдөөнийг арилгах зэрэг олон чухал ач холбогдолтой арга хэмжээ болох юм.

Зөвхөн 2011 онд нийслэлийн цагдаагийн газрын хэмжээнд 222011 ширхэг торгуулийн хуудас цагдаагийн алба хаагчдын гар дээр очиж 539,8 сая төгрөгийн торгууль бэлнээр тооцогдон төлөгдсөн байгаа нь багна бус үзүүлэлт юм. Энэ тоог нийт цагдаагийн алба хаагчдаар тооцож үзвэл ямархуу үзүүлэлт гарах нь ойлгомжтой байна.

2010 онд Цагдаагийн байгууллагын хэмжээнд 550210 захиргааны зөрчлийг захиргааны эрх зүйн зөрчлийг бүртгэж, зөрчил гаргасан 51909 иргэн, 29 албан тушаалтан, 880 аж ахуйн нэгж, байгууллагад 2, 811,463 , 4 мянган төгрөгийн торгууль ногдуулж, 19498 иргэний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан бол **2011 онд** 653619 зөрчил бүртгэгдэж, 616345 иргэн, 1271 аж ахуйн нэгж, байгууллага, 41 албан тушаалтанд 3,6 тэрбум төгрөгийн торгох шийтгэл ногдуулж, 23582 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан байна ²⁰⁵

Иймд нэг талаас цагдаагийн алба хаагчдын эрх ашгийг хамгаалах нөгөө талаас зөрчил гаргагчдын эрх, түүнчлэн торгох шийтгэл ногдуулах үйл ажиллагааг орчин үеийн олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагыг ч хангах юм.

Гэхдээ энэ тогтолцоонд шилжихэд төлбөр тооцоо бэлэн бус хэлбэрт шилжих эрх зүйн болон техникийн орчин бүрэн шийдэгдсэн байх шаардлагатай бөгөөд энэхүү орчныг бүрдүүлэх ажил боломжтой хэмжээнд явагдаж байгааг дэмжих, мөн Засгийн

²⁰⁵ 2010, 2011 онд ЦБ-аас шийдвэрлэсэн захиргааны зөрчлийн нэгдсэн мэдээнээс авлаа.

газраас хэрэгжүүлж байгаа “Цахим монгол” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад анхаарах нь зүйтэй юм. Торгуулийг бэлэн бусаар төлөхтэй холбогдох эрх зүйн харилцааг журамласан эрх зүйн хэм хэмжээний төслийг боловсруулах шаардлага үүсч байгаа юм.

2.3.Цагдаагийн Ерөнхий газрын Мэдээлэл, судалгааны төвд Криминологи судалгааны хэлтсийг байгуулсан нь гэмт хэрэг болон захиргааны зөрчлийн шалтгаан нөхцөл, гаралт, хандлага, захиргааны шийтгэлийн үр нөлөөг судлах судалгааны ажлын үр дүнг дээшлүүлэхэд чиглэгдсэн чухал алхам боловч судалгааны байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, чиг үүргийг тодорхой болгох, судалгааны ажлын үр дүнг дээшлүүлэхийн тулд Гэмт явдал судлалын хүрээлэнг байгуулж судалгааны ажлыг хариуцуулах нь зүйтэй гэж үзэж байна.

**КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
ТУЛГАМДСАН АСУУДАЛ**

Мөнхбаярын Нямжаргал
ШШҮХ-ийн Лабораторийн мэргэжилтэн
магистрант, цагдаагийн дэд ахлагч

Шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагаа, үзлэг шинжилгээний чанар үр дүнг ахиулах нь тус байгууллагын нэн тэргүүний зорилт бөгөөд үүн дотроо криминалистикийн албаны ажлын үзүүлэлтийг ахиулах нэг хөшүүрэг нь тус албаны ажилд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээ гэж үзээд энэ сэдвийг сонгон судаллаа.

Криминалистикийн шинжилгээний алба нь 60 гаруй жил цагдаагийн байгууллагын бүтцэд багтан үүрэг гүйцэтгэж байсан бөгөөд 2002 - 2004 онуудад Цагдаагийн ерөнхий газрын даргын 2003 оны 472 дугаар тушаалаар баталсан журмаар үйл ажиллагаандаа хяналт- шинжилгээ хийж үнэлгээ өгч цаашдын бодлого зорилтоо тодорхойлон ажиллаж байв.

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 63 дугаар тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Шүүхийн шинжилгээний үндэсний төвийг байгуулсан юм.

Тус төвд Эрүүл мэндийн яамны харьяа Шүүх эмнэлгийн магадлах төв, Сангийн сайдын дэргэдэх Шүүх нягтлан бодох бүртгэлийн магадлах товчоо, Цагдаагийн ерөнхий газрын Шинжилгээний хүрээлэнг нэгтгэн үйл ажиллагаа явуулах болжээ

Өнөөгийн байдлаар Шүүхийн шинжилгээний байгууллагаас жил бүр Засгийн газрын 2006 оны 51 дүгээр тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан 2007 оны 207 дугаар тушаал, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан 2010 оны 222 дугаар тушаалд нийцүүлэн гаргасан Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захиралын 2009 оны 170 дугаар тушаалаар батлагдсан “Шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөх журам”-ыг мөрдлөгө болгон хэлтэс, албадын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ хийж, дүнг жил бүр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөлийн хуралдаанд оруулан холбогдох шийдвэрийг гаргуулж байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээг хийхдээ Төсвийн ерөнхий захирагчаас ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны талаарх хэрэглэгчдийн үнэлгээг Хууль зүй, дотоод хэргийн сайдын хуралдаанаар хэлэлцүүлсэн үнэлгээний дүнгээр, Төсвийн ерөнхий захирагчаас ерөнхий менежертэй байгуулсан гэрээний биелэлт, Засгийн газрын үйл ажиллагааны болон үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, байгууллагын зорилтыг хэрэгжүүлсэн байдал, бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөөний биелэлт, үндсэн ажил алба хаагчдын сахилга хариуцлага, соён гэгээрүүлэх ажил, байгууллага орчноо тохижуулах талаар авсан арга хэмжээ, санхүүгийн үйл ажиллагаа болон төсөв захиран зарцуулсан талаар авсан арга хэмжээ, байгууллагын үйл ажиллагааны талаар хэрэглэгчдээс авсан санал, асуулгын үнэлгээг өөрсдийн хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээр тус тус тооцож байна.

Дээрх бодлогын зорилт, баримт бичиг, үйл ажиллагааны үр дүнг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Тамгын хэлтэс, холбогдох хэлтсийн саналд тулгуурлан үнэлж дүгнэдэг бөгөөд тус байгууллагын үйл ажиллагааны хамрах хүрээ нь :

- Хууль, тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэр, хөтөлбөрийн биелэлтэд хяналт шинжилгээ хийж, үр дүнд нь үнэлгээ өгөх замаар хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг дээшлүүлэхэд бодлогын зөвлөгөө өгөх, удирдлагыг мэдээллээр хангах

- Үйл ажиллагааны гүйцэтгэлийн мэдээллээр үйлчлүүлэгч, хэрэглэгчдийг хангах

- Шүүхийн шинжилгээний төв байгууллага, аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний албадын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, үр дүн, үр нөлөөг дээшлүүлэхэд санал, зөвлөмж боловсруулан хүргүүлдэг.

Байгууллагын үйл ажиллагаанд дахь хяналт- шинжилгээ /мониторинг/, үнэлгээ нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийж, үр дүнд нь үнэлгээ өгч, тэргүүний арга туршлагыг бусад албад, газар, хэлтсүүдэд түгээх замаар ололт амжилтыг бататгах, доголдол гажуудал түүний шалтгааныг илрүүлж засах арга замыг тодорхойлж байна.

Өөрөөр хэлбэл, энэ нь шүүхийн шинжилгээний байгууллагын бодлого, зорилтоо бүрэн хэрэгжүүлэх удирдлагын үндсэн арга болж байна гэж үзэж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллага нь төв, орон нутгийн түвшинд үзлэг, шинжилгээний ажил, үйлчилгээ иргэдэд хэрхэн хүрч байгаа, үйлчилгээний хүртээмж чанар, үр дүнгийн талаарх судалгааг улсын хэмжээнд жил болгон явуулж, холбогдох арга хэмжээг авч, чиглэл өгөн төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай чанартай хүргэхээр ажиллаж байна.

Мөн хяналт- шинжилгээ, үнэлгээний ажлыг сайжруулах зорилгоор төв, аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний алба болох 28 нэгжийн ажлын ололт, амжилт, дутагдал бүрийг шинжилж судлан үнэлэлт өгч, дутагдал заагдсан арга хэмжээнүүдийг эрчимжүүлэх, сайжруулах зорилгоор санал, зөвлөмжийг боловсруулан хүрээлэнгийн захирлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж, холбогдох нэгжүүдэд хүргүүлж, үр дүнг тооцож байна.

Хяналт- шинжилгээ үнэлгээний ажил эрхэлж буй алба хаагчдыг мэргэшүүлэх зорилгоор жил бүрийн эхний улиралд “Удирдах ажилтны сургалт, зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, түүнд албаны дарга нар, нэгж дээрээ хяналт- шинжилгээ, үнэлгээний ажил эрхэлж буй дэд дарга нарыг хамруулан ажлын үр дүнг нэгж нэг бүрээр хэлэлцэн, хяналт- шинжилгээ, үнэлгээний аргачлал, журмын талаар сургалт явуулдаг байна.

Харъяа нэгжийн үйл ажиллагааг тодорхой шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд тодорхой аргачлалаар тооцож, үр дүнг үнэлэх болсноор удирдах бүрэлдэхүүнээс ажлын үр дүнг үнэлэх явцад танил тал татах, өөрийн дотоод итгэлээр бодитой бус үнэлэх явдал хумигдах болсон нь ач холбогдлоо өгч байна.

Гэсэн хэдий ч хяналт- шинжилгээ, үнэлгээний аргачлалд зааснаар тоогоор илэрхийлэн үнэлэх боломжгүй зорилт, арга хэмжээний оноо, хувийг тодорхойлоход нэгж, байгууллагуудаас зорилт, арга хэмжээний хэрэгжилт, биелэлтийг гаргаж ирүүлэхдээ бодитой бус хандах, хийгдээгүй ажил, арга хэмжээг хийгдсэн, биелэгдсэн мэтээр тайландаа тусгаж ирүүлэх зөрчил дутагдал гарах болсон байна.

Цаашдаа хэлтэс, алба бүр дээр нарийвчилсан, хэсэгчилсэн, сонгосон үзүүлэлт, хугацаагаар хяналт-шинжилгээ үнэлгээ хийх механизмыг бүрдүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага бий болж байгаа юм.

Миний судалгааны ажлын гол агуулга бол Шүүхийн шинжилгээний байгууллагын голлох салбар нэгж болох Криминалистикийн шинжилгээний хэлтэс болон аймаг, нийслэлийн криминалистикийн шинжээчдийн ажлын үзүүлэлт, үр дүнг бодитой үнэлэх, ажлын чанар, үр дүнг ахиулах, түүнд чиглэсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх арга аргачлалыг бий болгоход чиглэж байгаа юм.

Шүүхийн шинжилгээний байгууллагын үндсэн чиг үүргийн үйл ажиллагаанд голлох асуудал болох Криминалистикийн шинжээчдийн ажлыг дүгнэхдээ хийсэн үзлэг шинжилгээний тоог харгалзахаас гадна шинжилгээ хийж дүгнэлт гаргасан хугацаа, ажлын чанар, давтан шинжилгээ хийгдсэн эсэх, хэргийн газрын үзлэгт оролцсон байдал, хэргийг илрүүлэн нотлон тогтооход шаардлагатай ул мөр, эд мөрийн баримтыг олж

илрүүлж, бэхжүүлсэн байдал, тэдгээр нь шинжилгээний шаардлага хангаж буй эсэх, түүнчлэн дүгнэлт гаргах явцад мэргэжлийн алдаа гаргасан, бусдын нөлөөнд автсан зэрэг үйл ажиллагаатай нь холбоотой гомдол мэдээлэл гарсан эсэх нь харгалзан үзвэл зохих нь гол асуудлын нэг болоод байна гэж үзэж байна.

Криминалистикийн шинжээчид нь ШШҮТ-ийн захирлын 2007 оны 118-р тушаалын хавсралтын дагуу үндсэн үйл ажиллагааныхаа мэдээг улирал, хагас, бүтэн жилийн өссөн дүнгээр, дэлгэрэнгүй тайлангийн хамтаар Тамгын хэлтэст ирүүлснээр өөрсдийн хийсэн ажил, ажлын чанар үр дүнг үнэлүүлж байгааг судалгаа хийх явцдаа олж мэдсэн юм.

Мөн криминалистикийн шинжээчдийн үйл ажиллагааны үндсэн шалгуур үзүүлэлт нь тус хүрээлэнгийн захирлын 2010 оны а/343-р тушаалын хавсралтаар батласан “Шүүхийн шинжилгээний ажлын чанарын үндсэн шалгуур үзүүлэлт”-ийг мөрдөж ажиллах бөгөөд хүрээлэнгийн мэргэжлийн чиг үүрэг хэрэгжүүлэгч хэлтэс, алба шинжээч, мэргэжилтний ажлыг дүгнэх, үйл ажиллагааны явц үр дүнд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөхдөө энэхүү шалгуур үзүүлэлтийг хангасан үндэслэл” болгоно гэж заасан байгаа.

Шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тодорхойлсон байна.

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт
1	Хэргийн газрын үзлэгт оролцож ул мөр, эд мөрийн баримт илрүүлж, бэхжүүлэх	Криминалистикийн шинжээч мэргэжилтэн нар нь гэмт хэргийн газрын үзлэгт оролцож, хэргийг илрүүлэх нотлон тогтооход шаардлагатай ул мөр, эд мөрийн баримтыг олж илрүүлэх, гэрэл зураг, дүрс бичлэгээр болон бусад материал ашиглан бэхжүүлж үзлэгийн тэмдэглэлд тусгуулсан байна.
2	Криминалистикийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах	Шинжээч нь криминалистикийн уламжлалт гарын мөр, мөр судлал, галт зэвсэг, гар бичмэл, гарын үсгийн болон баримт бичгийн зэрэг шинжилгээг “Криминалистикийн шинжилгээ хийх журам”-ыг мөрдлөг болгон шинжлэх ухааны үндэслэлтэй хийж, хэрэг илрүүлж, нотлоход ач холбогдол бүхий дүгнэлтийг гаргана.
3	Мэдээллийн сан бүрдүүлж ашиглах	Улсын хэмжээний шүүхийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн болон төрөлжсөн сан ашиглах журмуудыг мөрдлөгө болгон “Илрээгүй гэмт хэргийн”, “Галт зэвсгийн хонгио ба хошууны”, “Гарын хээний” гэх мэт санг бүрдүүлж, шинжилгээ, судалгаанд ашиглах, шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагын хүсэлтийн дагуу лавлагаа мэдээлэл гаргаж өгнө.
4	Мөрдөн байцаалтын туршилт, задлан шинжилгээ, эксгумацид оролцоход хэрэгжүүлсэн байх үйл ажиллагаа	Криминалистикийн шинжээч мэргэжилтэн нь мөрдөн байцаалтын туршилт, задлан шинжилгээ, эксгумацид оролцохдоо гэрэл зураг болон дүрс бичлэгийн камер ашиглаж ул мөр, эд мөрийн баримтыг бэхжүүлэх арга хэмжээ авсан байна. Задлан шинжилгээний үед цогцосны гарын хээний дардас, арчдасыг бэхжүүлж авахаас гадна шаардлагатай биологийн гаралтай бичил ул мөрийг /үс, хумс, шүлс, үрийн шингэн г.м/ бэхжүүлсэн байна.

Эдгээр шалгуур үзүүлэлтийг үндэслэн өнөөгийн практикт ШШҮТ-ийн захирлын 2007 оны 118-р тушаалын хавсралтаар баталсан статистик, мэдээний үзүүлэлтийн дагуу “Криминалистикийн шинжилгээний албаны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж байна.

Шүүхийн шинжилгээний ажлын шалгуур үзүүлэлт, статистик мэдээ гаргаж буй үзүүлэлтийг тодорхой нарийвчлан, дутуу орхигдсоныг нэмж, давхардсан заалтуудыг арилган ойлгомжтой болгон цэгцлэх нь хяналт шинжилгээг бодитой хийхэд чухал түлхэц өгнө гэж үзэж байна.

Улирал бүр тоон үзүүлэлтээр мэдээ гаргадаг боловч криминалистикийн шинжээчдийн дунд эдгээр тоон үзүүлэлтийн зарим нь тохиромжгүй үг хэллэгтэй байгаагаас шалтгаалан шинжээч бүр өөрсдийн ойлголт, үзэмжээр энэхүү статистик мэдээг өгдөг нь хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөхөд бодит бус байдал үүсгэж байгаа юм.

Энэ нөхцөл байдлаас гарах зорилгоор нийт албан хаагчдаас санал судалгаа авч нэгтгэн үзлэг, шинжилгээний статистик үзүүлэлтийг нэг мөр болгон цэгцлэх үүднээс Криминалистикийн шинжээчдээс 2011 оны 12 сард судалгаа авсан юм.

Судалгааны санал асуулгад Криминалистикийн шинжилгээний хэлтсийн 24 шинжээч, Нийслэлийн шүүхийн шинжилгээний албаны 32 нийт 56 шинжээч хамрагдсан байна.

Статистик, мэдээний үзүүлэлтэд хэрхэн ач холбогдолтой ханддаг вэ? асуултанд ач холбогдолтой гэж үзэж үнэн зөв мэдээ өгдөг гэсэн хариулалтыг нийт алба хаагчдын 35,7% буюу 20 алба хаагч нь, 64,3 % буюу 36 алба хаагч нь статистик, мэдээ нь ажил дүгнэх үзүүлэлтэд нөлөөлдөггүй учир ач холбогдол өгдөггүй гэсэн хариулт өгсөн байна. Статистик, мэдээний хүснэгтийг өөрчлөх зайлшгүй шаардлагатай, тохиромжгүй үг хэллэг ихтэй учир мэдээгээ өгөхөд хүндрэл гардаг гэдэгт нийт алба хаагчдын 64,3 % нь Тийм гэсэн хариулт байна.

Тус байгууллагын 2012 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд асуудал тусгагдсаны дагуу ажлын хэсэг байгуулж ажиллуулсан бөгөөд үүнд өөрийн судалгааг үндэслэн саналаа өгч тусгуулсан. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын 2012 оны а/17 дугаар тушаалаар “ Ажил дүгнэх үзүүлэлт” шинэчлэн батласан. Энэ тушаалын нэгдүгээр хавсралтаар Криминалистикийн шинжилгээний ажил дүгнэх үзүүлэлтийг баталсан нь судлаач миний судалгааны ажлын явцын үр дүн юм.

Үүнийг хэрэгжүүлсэнээр криминалистикийн нэгж бүр дээр нарийвчилсан хяналт-шинжилгээ үнэлгээ хийх механизмыг бүрдүүлэх бололцоо бүрдэж байна.

Хэдийгээр шүүхийн шинжилгээний байгууллагад хийгдэж байгаа хяналт- шинжилгээ, үнэлгээний зэрэгцээ дотоодын хяналт шалгалтын ажлын хүрээнд, жил бүр гүйцэтгэлийн, ээлжит, ээлжит бус, хэсэгчилсэн, санхүүгийн болон иргэдийн гомдол, санал, мэдээллийг үндэслэн холбогдох шалгалтуудыг хийж байгаа боловч эдгээр шалгалтууд нь зөрчил, дутагдлыг арилгах, шалган туслах удирдамжийн дагуу хийгддэг учир хяналт- шинжилгээний ажлын хүрээнд бус, харин хяналт, шинжилгээний хүрээний ажлыг дайвар байдлаар авч хэрэгжүүлж байгаа нь энэ чиглэлийн ажилд зарим тохиолдолд мэргэжлийн биш, бодитой бус хандаж байгаагаас энэхүү ажлын үр дүнг бууруулж, эцсийн үр дүнд нь сөргөөр нөлөөлж байгаа юм.

Түүнчлэн аймгийн шүүхийн шинжилгээний албадын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж буй алба хаагчдад ажлын үр дүнг газар дээр нь очиж танилцаж, судлах томилолтын зардал, төсөв байхгүй, энэ талаар холбогдох журам, эрх зүйн актуудад тодорхой тусгаж, зааж өгөөгүйгээс хяналт, шинжилгээ үнэлгээний ажил бүрэн хэрэгжиж чадахгүй байна.

Мөн хяналт- шинжилгээ, үнэлгээний ажлыг салбар нэгж дээр эрхлэн явуулж байгаа алба хаагчдыг эрхэлж буй ажилд нь мэргэшүүлэх зорилгоор байнгын сургалтад хамруулах арга хэмжээ авагдахгүй байсан нь энэ ажилд ахиц гаргахад хүндрэл учруулж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагаас хяналт- шинжилгээ, үнэлгээний ажлыг шаардлагатай хэмжээнд хүртэл хэрэгжүүлэх, боловсронгуй болгох зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг эрхлэн явуулдаг нэгжийг бий болгох шаардлагатай байна.

Ингэснээр хяналт шинжилгээний ажил шаардлагын хэмжээнд хүртэл бүрэн, чанартай хийгдэх нэг нөхцөл бүрдэнэ гэж үзэж байгаа юм.

Түүнчлэн шүүхийн шинжилгээний байгууллагад хяналт- шинжилгээ, үнэлгээний ажлыг эрхлэн явуулах мэргэжлийн боловсон хүчин дутмаг, уг ажлыг нэгжүүд дээр хариуцсан алба хаагчдыг мэргэшүүлэх сургалт, арга хэмжээнд бага хамруулж байгаа нь энэ чиглэлийн ажлыг онолын үндэслэл тааруу, учир дутагдалтай гүйцэтгэх, эрх зүйн баримт бичгүүдэд заасан арга, аргачлалыг шаардлагын хэмжээнд бүрэн дүүрэн ашиглах явдал дутмаг байх нь дамжиггүй юм.

Өнөөдөр тус байгууллага нь тодорхой шалгууруудын дагуу төв, аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний албаны ажил, үйлчилгээг жилдээ 1 удаа дүгнэж байгаа, шаардлагатай ажил, арга хэмжээг газар дээр нь очиж танилцаж санал, зөвлөмж өгч, биелэлтийг хангуулах ажил төсөв мөнгөнөөс шалтгаалж хийгдэхгүй байгаа нь удаашралтай, хэрэгжихгүй тасраад байгаа, цаасан дээр хийсвэр байдлаар тайлагнаж ирээд байгаа арга хэмжээг цаг хугацаанд нь илрүүлж гаргаж ирэх, тухайн ажлыг эрчимжүүлэх талаар хийгдэж байгаа арга хэмжээ хэлбэрийн төдий явагдаж байгаа байдал ажиглагдаж байна.

Ингэхдээ харъяа төв, орон нутгийн нэгжүүдийн жилийн үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ хийж, үнэлгээ өгөхөд ашиглаж байгаа шалгуур үзүүлэлтүүдийг хэт ерөнхий байдалтай тогтоосон нь жил ирэх тусам хяналт- шинжилгээ хийж, бодитой үнэлэлт өгөхөд хүндрэл учруулах байдал гарч байгаа нь шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тогтоож, шинэчлэх зайлшгүй шаардлагатайг харуулж байгаа юм.

Хэдийгээр шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагаан дахь хяналт шинжилгээ, үнэлгээг боловсронгуй болгох талаар шаардлагатай арга хэмжээг авч, тодорхой алхмуудыг хийж байгаа боловч дээд шатны байгууллагаас гаргаж байгаа эх сурвалж болох эрх зүйн актуудыг боловсронгуй болгохгүйгээр төгс шийдвэрлэх аргагүй юм.

Нөгөө талаар шүүхийн шинжилгээний байгууллагаас өөрийн үйл ажиллагаандаа хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг боловсронгуй болгох талаар тодорхой арга хэмжээнүүдийг авч байгаа ч төсөв, хөрөнгө уг ажлыг гүйцэтгэхэд шаардагдах ажил, арга хэмжээг шийдвэрлэх боломжгүй байна.

Тухайлбал, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтуудад хамруулах зардал, тайлан болон биелэлт тооцох баримт бичгүүдэд хэрэгжилтийг тооцож ирүүлсэн ажил, арга хэмжээний бодит байдалтай газар дээр нь очиж танилцаж, үр дүнг үнэлэх алба хаагч, шинжилгээ, судалгааны багийн ажиллах томилолтын зардал, тус байгууллагаас өөрийн үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ хийж, үнэлгээ өгөхөөс гадна хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгэж, бодит байдалд дүн шинжилгээ хийх зардал гэх мэт.

Улмаар шүүхийн шинжилгээний байгууллагаас хяналт- шинжилгээ, үнэлгээний явцад гарсан алдаа дутагдал, гажуудлыг арилгах, тухайн ажлын үр дүнг бодитой байгаа эсэхийг тогтоох, тус байгууллага өөрөө өөрийнхөө үйл ажиллагаанд үнэлгээ өгөх бус хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлж, дүгнүүлэх зорилгоор 2010 онд “Удирдлагын академийн мэргэшсэн баг”-аар судалгааны ажил хийлгэн, үнэлэлт, дүгнэлт өгсөн тайлантай танилцахад хэрэглэгчийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэн авч, өөрсдийн үйл ажиллагааг дүгнэсэн дүнтэй харьцуулах, түүнээс өөрсдийн хийсэн үнэлгээ хир бодит байдалд нийцэж байгаа, цаашид анхаарах, эрчимжүүлэх, боловсронгуй болгох талаар авч хэрэгжүүлэх ямар шаардлага, арга хэмжээ байгаа талаар бодитой мэдээлэлтэй болж байгаагаараа ач холбогдолтой арга хэмжээ болжээ.

Цаашид шүүхийн шинжилгээний байгууллагаас өөрийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөхдөө баримтлах шалгуур үзүүлэлтийг менежерийн, алба хаагчдын, байгууллагын гэсэн 3 түвшингийн хүрээнд нарийвчлан шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн боловсруулах нь чухал ач холбогдолтой алхам болохоор байна.

Дүгнэлт

Шүүхийн шинжилгээний байгууллагын хэмжээнд хийгдэж байгаа энэ чиглэлийн ажлын өнөөгийн байдлыг судлан цаашид үйл ажиллагааг нь илүү үр дүнтэй, үр ашигтай, боловсронгуй болгох асуудлыг бага боловч амьдралд ойрхон оновчтой тодорхойлон гаргаж ирэхийг зорьсон юм.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ойлголт, түүнд тавигдах шаардлага, арга зүйг судлан, хэрхэн хэрэгжүүлдгийг олсон онолын мэдлэгтээ түшиглэн харууллаа. Төрийн албаны өөрчлөлт шинэчлэлтийн явцад энэхүү сэдвээр гадаадын болон дотоодын төсөл хөтөлбөр, их дээд сургууль, мэргэжил дээшлүүлэх чиглэлээр төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалт семинарууд зохиогдож сургалтын гарын авлагууд бүтээл болон гарсан байна.

Харин гадаадын бусад орны хяналт, шинжилгээний чиглэлээр бодитой судалсан судалгааны материал харьцангуй ховор байна.

Мөн Шүүхийн шинжилгээний байгууллагад энэ сэдвээр судалгааг анх удаа хийж байгаа нь байгууллагын үндсэн чиг үүргийн үйл ажиллагааны чанар, үр дүнг боловсронгуй болгоход зохих хувь нэмэр оруулна гэж үзэж энэ сэдвийг судлах сонирхол бий болгосон юм.

Ийнхүү судлан үзэхэд цаашид гүйцэтгэлийн шалгуурт, үр дагаварт чиглэсэн арга барилаар явах нь зүйтэй юм гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Хэдийгээр байгууллага хэвийн түвшинд ажил үүргээ явуулж байгаа хэдий ч цаашид үйл ажиллагаагаа эрчимтэй явуулахад дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Бодлогын баримт бичгийн зорилт хүрэх үр дүн, түүний шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тогтоож, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлж амжилт ололтоо бататгах, алдаа гажуудлыг засах замаар дэвшүүлсэн зорилтоо бүрэн хэрэгжүүлж бодит үр дүнд хүрэх

- Хяналт-шинжилгээ, үнэлгээг хөндлөнгийн нөлөөнөөс үл хамааралтай байх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс бие даасан тогтолцоо болгон хөгжүүлэх

- Шүүхийн шинжилгээний байгууллагад энэ чиглэлээр ажиллаж байгаа алба хаагчдад зориулсан "Хяналт-шинжилгээ, үнэлгээний чадавх бий болгох" сургалтыг дотоод, гадаадад тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулах, хяналт шинжилгээний чадавхыг тасралтгүй хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх

- Хяналт-шинжилгээ, үнэлгээг бүрэн дүүрэн бодитой хийхийн тулд шаардагдах хөрөнгө, төсвийн асуудлыг холбогдох шатны байгууллагуудаар шийдвэрлүүлэх

- Шүүхийн шинжилгээний байгууллагын хяналт- шинжилгээ, үнэлгээнд олон нийт, иргэдийн санаа бодол, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн байдлыг харгалзан үзэхийн тулд хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ, судалгааны ажлыг гүйцэтгүүлэн үр дүнд харьцуулалт, анализ хийж цаашдын бодлого боловсруулалтанд үр дүнг ашиглах тогтолцоог бий болгох

Дээрх санал, зөвлөмжүүдийг тасралтгүй, түргэн шуурхай, цаг алдалгүй авч хэрэгжүүлж, хэвшүүлж чадвал Шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагаан дахь хяналт, шинжилгээний үр нөлөө, гүйцэтгэлийн удирдлагын үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжих болохоор байгаа юм.

Шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагаан дахь хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг сайжруулах талаар гаргах санал

Цаашид байгууллагын үйл ажиллагаан дахь хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын эхлэл, явц байдлаас үндэслэн түүнийг хэрхэн сайжруулж, боловсронгуй болгох талаар өнөөгийн тулгамдаж байгаа байдлуудыг судалсанаар дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

1. Байгууллагын хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр дагнан ажиллуулах зорилгоор хяналт- шинжилгээ, үнэлгээний мэргэшсэн баг, нэгжийг шинээр зохион байгуулж, бүтэц орон тоог бүрдүүлэх, шаардлагатай боловсон хүчнийг сонгон шалгаруулж авах, тэдгээртэй холбоотой бий болох зардал, мөнгөн хөрөнгийн асуудлыг улсын төсөвт суулган, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна. Ингэснээр тус байгууллагын хэмжээнд дээрх чиглэлийн үйл ажиллагааг дайвар байдлаар хандах хандлага арилж, авч хэрэгжүүлж байгаа бодлого, түүний хэрэгжилтийг тооцох, биелэлтийг үнэлж, дүгнэх ажил тасралтгүй байнгын үйл ажиллагаагаар хангагдах,

цаашид авч хэрэгжүүлэх, эрчимжүүлэх шаардлагатай байгаа ажил, арга хэмжээний талаар удирдлагыг цаг тухайн үед нь мэдээллээр хангах боломжтой болох юм.

3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтнүүдийг хөндлөнгөөс хараат бус байдлаар ажиллах нөхцөлийг, эрх зүйн орчинг бүрдүүлэх нь нэгэнт бий болсон баг бүрэлдэхүүний албан тушаалын шатлалыг удирдах алба хаагчдын хэмжээнд хүрэхээр шатлалын түвшинд хүргэж ахиулах, удирдах албан тушаалтнуудаас дарамт шахалт, бусад нөлөөлөл үзүүлэхгүй байх нөхцөлөөр хангах, хэлтэс, албадуудад хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгийн талаар Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын зөвлөлийн хуралдаанд танилцуулж шийдвэр гаргуулах хүртэл нууцлалыг задруулахгүй байх, албандаа хүндэтгэлтэй, ёс зүйтэй хандаж ажиллах талаар шаардлагатай дүрэм, журмыг боловсруулж мөрдүүлэх, баг, бүрэлдэхүүнийг бусдаас хараат бус байдлаар бүрэн ажиллах техник хэрэгслээр хангах нь чухал байна.

4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг эрхлэн явуулах мэргэжилтнүүдийг зохих сургалтад байнга хамруулж, мэргэшүүлэх арга хэмжээ авах шаардлагын хүрээнд энэ ажлын чиглэлээр явагдаж байгаа гадаад, дотоодын бүхий л шатны сургалтуудад нэн түрүүнд төв байгууллагын нэгж дэх алба хаагчдыг бүрэн хамруулах, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр ажиллаж байгаа багш, мэргэжилтэн, судлаачдыг урьж хичээл заалгах тасралтгүй суралцах нөхцөлийг зохион байгуулах, бусад агентлагууд, байгууллагуудаас явуулж байгаа мониторингийн чиглэлээр хийгдэж байгаа ажлын арга туршлагаас өөрийн байгууллагад нэвтрүүлэх, арга туршлага солилцох арга хэмжээнүүдийг байнга зохион байгуулах нь ач холбогдолтой юм.

5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний онол, арга зүйг ашиглан хяналт-шинжилгээ хийж, үнэлгээг өгөх шалгуур үзүүлэлтүүдийг боловсронгуй болгох /байгууллагын оршин байгаа нутаг дэвсгэр, эрүүгийн нөхцөл, байдлын онцлог, алба хаагчдын тоо, ажил, мэргэжлийн түвшинг харгалзан менежер, алба хаагч, байгууллагын түвшинд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх шалгуур үзүүлэлтийг боловсруулах/

УТАСЛАГ ЭДЛЭЛД ХИЙХ МЕХАНОСКОПИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Түмэнжаргалын Оюунжаргал

ШШҮХ-ийн Криминалистикийн шинжилгээний хэлтсийн
шинжээч, магистрант, цагдаагийн дэслэгч

Монгол улсын Үндсэн хуульд заасан “Монгол улсад хууль ёсоор суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, “Гэм буруутай нь шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно” гэсэн заалтуудыг хангахын тулд гэмт хэрэг илрүүлэх арга зүйг байнга боловсронгуй болгож, түүнийг хуулийн байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлэх нь чухал. Үүнд Криминалистикийн²⁰⁶ шинжлэх ухаан, түүн дундаа Мөр судлалын шинжлэх ухаан нэн чухал үүрэгтэй.

Хүн төрөлхтөн үүссэн үеэс эхлэн хөгжиж дэвшихийн хэрээр нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт хэрэг мөн адил хурдацтайгаар өсөж, гэмт этгээдүүдийн арга заль, үйлдэл, улам нарийсч байна. Сүүлийн жилүүдэд жил тутам 20 мянга гаруй гэмт хэрэг бүртгэгдэж байгаа нь хүн амтайгаа харьцуулахад манай улсад гэмт хэргийн гаралт асар өндөр хурдацтай өсөж байгааг харуулж байна. Ардчилал, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдэлсэн өнөөгийн нийгэмд аливаа гэмт хэргийг хуулийн хүрээнд, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр, гэмт үйлдлийн улмаас бий болсон ул мөр, эд мөрийн баримтанд тулгуурлан нотлон тогтоох явдал чухал юм.

Түүхийн хуудсыг сөхөхөд 1957 онд Төв аймгийн Шаамар тосгонд гарсан дээрмийн хэрэгт автомашины дугуйны хээ, гутлын мөрний шинжилгээг хийж уг хэргийг үйлдсэн гэмт этгээдийг нотлон тогтоож байсан нь мөр судлалын анхны шинжилгээ байв.²⁰⁷ Харин утаслаг эдлэлд хийх механоскопийн анхны шинжилгээг 1958 онд Москва хотноо Цагдан сэргийлэхийн тусгай дунд сургууль төгссөн криминалист шинжээч Төрийн Мою 1960 - 1961 онд Чононборис хүн хутгалсан хэрэгт хохирогчийн хувцасанд шинжилгээ хийж үүссэн гэмтлүүд нь хурц иртэй зүйлийн үйлчлэлээр үүсгэгдсэн болохыг нотлон тогтоож байжээ.

ЦЕГ-ын даргын 1998 оны 04-р сарын 23-ны өдрийн А/23 тоот тушаалаар Криминалистикийн Шинжилгээний Төвийн бүтцийг лабораторийн системд шилжүүлэн шинжээч нарыг мэргэжлээр нь дагнуулах болсонтой холбогдуулан “Мөр судлалын лаборатори” хэмээн бие даан ажиллах болсон байна²⁰⁸.

Шүүхийн Шинжилгээний Үндэсний хүрээлэнгийн Криминалистикийн шинжилгээний хэлтсийн Мөр судлалын лаборатори нь хэргийн газраас хураан авсан болон хэрэгт ач холбогдол бүхий:

- Утаслаг эдлэлд хийх шинжилгээ
- Хүний мөр /Гарын мөрнөөс бусад хөлийн, шүдний, биеийн бусад хэсгийн мөр гэх мэт /
- Эвдлэгч багаж, хэрэгслийн мөр
- Тээврийн хэрэгсэлийн мөр болон түүний механизмд хийх шинжилгээ
- Цоож түгжих механизмд үүссэн мөр
- Мал амьтны мөр
- Бусад төрлийн өөрчлөлт болох боолт, зангилаа, цоож, түгжих механизмын

бүтэц, ажиллах зарчим, хэсгээр бүхлийг тогтоох, үнэт эдлэлийн хийц зэрэгт адилтгалын болон онош зүйн шинжилгээ хийж дүгнэлт гаргах үндсэн үүрэг бүхий нэгж юм.

Утаслаг, ширхэглэг материалаар хийсэн эдлэл нь хүний амьдралын бүхий л нөхцөл байдалд хэрэглэгддэг байнгын хэрэглээний бүтээгдэхүүн билээ. Үүний тод илрэл нь

²⁰⁶ Криминалистик нь crimen – гэмт хэрэг, criminalis – гэмт явдлын гэсэн утгатай латин үг

²⁰⁷ Ч.Алтанхишиг, “Нэгэн жаран”, 2004он., 76 дах тал

²⁰⁸ Ч.Алтанхишиг, “Нэгэн жаран”, 2004он., 76 дах тал

бидний өдөр тутамдаа хэрэглэдэг хувцас, ахуйн зориулалттай эд зүйл /ор, хөнжлийн даавуу, нүүр гарын алчуур, суудлын бүрээс г.м/ юм.

2011 онд хийгдсэн мөр судлалын 505 шинжилгээг шинжилгээний төрлөөр нь авч үзвэл: 4.9 хувийг гутлын мөрөнд хийх шинжилгээ, 12.0 хувийг тээврийн хэрэгсэлтэй холбогдох шинжилгээ, 2.1 хувийг хэсгээр бүхлийг тогтоох шинжилгээ, 2.5 хувийг цоож, түгжих механизмд хийх шинжилгээ, 1.5 хувийг үнэт эдлэлтэй холбогдох шинжилгээ, 6 хувийг мөр судлалын бусад шинжилгээ, 71.0 хувийг утаслаг эдлэлд хийх механоскопийн шинжилгээ тус тус эзэлж байна.

Иймд шинжилгээний дийлэнх хувийг эзэлж буй утаслаг эдлэлд хийх механоскопийн шинжилгээний зарим нэр томъёог нэг мөр ойлгох үүднээс практик ажиллагаан дээр болон оёдол эсгүүрийн мастеруудтай уулзан судалгаа хийж монгол хэл зүйн үүднээс харьцуулан судлав. Хувцас, эдлэлд үүссэн мөр гэсэн ойлголт нь нийтлэг хэллэг бөгөөд энэ утгаараа хувцас, эдлэл дээр үүссэн цусан мөр, шороон мөр, тээврийн хэрэгсэлийн мөр, гутлын мөр, бусад хүчин зүйлийн улмаас үүссэн ул мөр гэх мэт өргөн ойлголтыг хамардаг. Иймээс хувцас, эдлэлд үүссэн урагдалт, цооролт, ханзралт, зүсэгдэлтүүдийг хувцас, эдлэлд үүссэн мөр гэсэн нийтлэг ойлголтоос салгаж дангаар нь хувцас, эдлэлд үүссэн гэмтэл гэж нэрлэх нь зүйтэй байна. Утгын хувьд гэмтэл гэдэг нь тухайн объектод гадны ямар нэгэн хүч үйлчилсэнээс бүрэн бүтэн байдлаа алдах, дүр байдлаа өөрчлөх гэсэн ойлголтыг агуулж байна.²⁰⁹ Хүний хэрэгцээ шаардлага болсон хувцас²¹⁰, эдлэл²¹¹-үүдийг утаслаг ширхэглэгээс гарган авдаг тул “утаслаг эдлэлд хийх механоскопийн шинжилгээ” хэмээн нэрлэх нь оновчтой гэж судлаач бид үзэж байна.

Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын хэмжээнд 2007-2011 онуудад хийгдсэн утаслаг эдлэлд хийх механоскопийн шинжилгээний дүгнэлтүүдэд судалгаа хийн шинжээчийн дүгнэлт, томилсон тогтоол, захирамж, түүнд тавигдсан асуулт нэг бүрийг уншиж тэмдэглэл хөтөлж танилцахад дараах нөхцөл байдлууд ажиглагдлаа.

Судалгаанд хамрагдсан онуудад буюу нийт 5 жилийн хугацаанд Шүүхийн шинжилгээний байгууллагад хийгдсэн криминалистикийн мөр судлалын 2267 шинжилгээ хийгдсэний 1616 буюу 71.2 хувийг утаслаг эдлэлд хийх механоскопийн шинжилгээ эзэлж байна. Үүнийг он тус бүрээр нь авч үзвэл: 2007 онд 55.2 хувь буюу 211, 2008 онд 67.1 хувь буюу 303, 2009 онд 78.1 хувь буюу 351, 2010 онд 81.4 хувь буюу 392, 2011 онд 71.0 хувь буюу 359 шинжилгээ эзэлж байна/Хүснэгт-1, График 1, 2/. Мөр судлалын шинжилгээнд утаслаг эдлэлд хийх механоскопийн шинжилгээний эзлэх хувийн жин их байгаа нь 2011 онд улсын хэмжээнд нийт 19197 гэмт хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 922 хүн амиа алдаж, 8100 хүн биедээ гэмтэл бэртэл авч, бусдын бие махбодид гэмтэл учруулсан гэмт хэрэг 0,3 хувиар, танхай 11,7 хувиар, дээрэмдэх 3,1 хувиар, хүчиндэх 7,3 хувиар, хүнийг санаатай алах 13,9 хувиар, бусдыг болгоомжгүй алах гэмт хэрэг 40 хувиар тус тус өссөн²¹² статистик тоо баримттай шууд хамааралтай байна.

2007-2011 онд хийгдсэн утаслаг эдлэлд хийх механоскопийн шинжилгээ,
түүний эзлэх хувь

Хүснэгт – 1

Он	Нийт хийгдсэн криминалистик-ийн шинжилгээ	Мөр судлалын шинжилгээ	Утаслаг эдлэлд хийх механоскопийн шинжилгээ	Мөр судлалын шинжилгээнд эзлэх хувь
----	---	------------------------	---	-------------------------------------

²⁰⁹ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь 1966 он 169, 865-р талууд

²¹⁰ Хувцас – хүний биеийг бүрхсэн, гадны элдэв нөлөөллөөс хамгаалах чадвартай, биеийн хэвийн байдлыг хадгалах эдлэлийн бүрдлийг хэлнэ.

²¹¹ Эдлэл – гэдэг нь нэхмэл, сїлжмэл эдийг эсгэж, оёсон, шууд хэрэглээнд зориулагдсан бїтээгдэхїйн юм.

²¹² www.news.gogo.mn

2007	5661	381	211	55.3 %
2008	5660	451	303	67.1 %
2009	4172	449	351	78.1 %
2010	4637	481	392	81.4 %
2011	3876	505	359	71.0 %


Үүнийг графикаар харуулбал :

График – 1



Утаслаг эдлэлд хийх механоскопийн шинжилгээний тоон үзүүлэлт, эзлэх хувь 2007 -2011 он

График – 2



2010 онд хийгдсэн 392 шинжилгээг хийсэн хугацаагаар нь авч үзвэл 1-5 хоногт 276, 5-10 хоногт хийсэн 104, 10-аас дээш хоногт хийсэн 12 шинжилгээ байна. Энэ төрлийн шинжилгээний хугацаа хэтэрсэн явдал нь дараах хүчин зүйлээс үүдэлтэй. Үүнд:

- Эрх бүхий албан тушаалтан нь шинжээч томилсон тогтоолыг үйлдэж шинжилгээний зүйлийг шинжилгээний байгууллагад хүргэх хооронд хугацаа алдах
- Гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш хэдэн сарын дараа хугацаа алдаж шинжилгээг томилох явдал практикт цөөнгүй гарчээ.

Шинжээчид шинжилгээ хийлгэх тогтоолыг хэзээ хүлээн авч ямар хугацаанд шинжилгээ хийсэн талаараа шинжээчийн дүгнэлтийн удиртгал хэсэгт бичилт хийхгүй байгаа тохиолдол цөөнгүй ажиглагдлаа.

2010 онд утаслаг эдлэлд хийгдсэн 392 шинжилгээг томилсон байгууллага, субъектээр нь авч үзвэл Нийслэлийн дүүргүүдийн цагдаагийн хэлтсийн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч- 288, Хөдөө, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн мөрдөн байцаагч -60, Улсын мөрдөн байцаах газрын Онц хүнд зохион байгуулалттай гэмт хэргийг мөрдөх хэлтсийн мөрдөн байцаагч-25, Замын цагдаагийн газрын Эрүүгийн хэргийг бүртгэх, мөрдөн байцаах хэлтсийн мөрдөн байцаагч-14, Улсын ерөнхий прокурорын дэргэдэх

Мөрдөн байцаах албаны мөрдөн байцаагч-1, Нийслэлийн цагдаагийн газрын Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх тасаг-1, Төмөр замын цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаагч-2, Нийслэлийн дүүргийн шүүхийн шүүгч -1 тус тус томилсон байна.

Судалгаанд хамрагдсан шинжилгээнүүдийг хэргийн өнгөөр нь авч үзвэл: 88.5% нь Хүний амь нас эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 6.1% хүчингийн гэмт хэрэг, 3.0% танхайн гэмт хэрэг, 1.7% хулгай, дээрмийн гэмт хэрэг, үлдсэн 0.7%-г бусад гэмт хэрэг эзэлж байна. ы

Шинжилгээнд ирүүлж буй объектийн тухайд: Дийлэнхи хувийг утаслаг, ширхэглэг материал буюу хохирогч, сэжигтэн нарын гэмт хэрэг үйлдэгдэх үед өмсөж явсан хувцас эзэлж байгаа бөгөөд тэдгээрийг битүүмжлэн ирүүлж байгаа байдал туйлын учир дутагдалтай байна. Шинжилгээнд ирүүлсэн объектуудыг битүүмжлэлийн хувьд авч үзвэл:

- Гялгар уут болон шуудайнд хийж ирүүлсэн – 338 шинжилгээ буюу 86.2%
- Хувцасанд нь боож задгай байдлаар ирүүлсэн – 17 шинжилгээ буюу 4.3%
- Цаасан хайрцаганд хийж ирүүлсэн – 37 шинжилгээ буюу 9.4%-г эзэлж байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.

Дээрх 392 шинжилгээний 31 нь уг хувцас эд зүйлд үүссэн гэмтэл нь харьцуулах шинжилгээнд хүргүүлсэн хутга, заазуур, хайчаар үүсгэгдсэн эсэхийг тогтоох асуулт тавьж ирүүлсэнээс:

- Багаж хэрэгслийн /хутга, хайч, чинжаал г.м/ ажлын хэсгийг цаасаар ороож, скочдон ирүүлсэн – 23
- Хувцас, эд зүйлтэй хамт сул хийж ирүүлсэн-8 шинжилгээ байна.

Хувцас, эдлэлд үүссэн гэмтэл нь уг хутга, хайчаар үүсгэгдсэн эсэхийг тогтоохдоо түүнд өсгөгч багаж ашиглан үзлэг хийж утаслаг ширхэглэг материал илрүүлэн, тухайн хувцас эдлэлд өөр хутга, хайчаар туршилтын мөр үүсгээд илэрсэн утаслаг ширхэглэг материалуудыг өөр хооронд нь харьцуулан шинжилдэг.

Гэтэл практикт хутгыг зөв битүүмжлээгүйн улмаас утаслаг ширхэглэг материал устаж үгүй болсон, эсвэл хувцас эд зүйлтэй хамт сул хийж нэмэлт мөр гарсан гэх зэргээр гэмтэл учруулсан багаж зэвсгийг тухайлан тогтоож дүгнэлт гаргах боломжгүй болгож байна. Гэмтлийн хэлбэр, хэмжээ, хутга хайчны ажлын хэсгийн дундаж өргөн, угийн өргөн, хэлбэр зэргээс үндэслээд үүсгэгдсэн байж болно гэсэн агуулгатай дүгнэлт гарч байна.

Үүнээс гадна цусаар бохирлогдсон хувцас, эд зүйлсийг хатаахгүйгээр, нэг хэргийн сэжигтэн, хохирогч нарын хувцас, эд зүйлсийг хамтад нь битүүмжилж ирүүлдэг. Энэ нь хохирогч, сэжигтэн нарын хувцас, эд зүйл дэх цус, биологийн гаралтай бусад бодисууд бие биенийхээ хувцасанд нэвчих, ялзарч муудах улмаар шинжилгээ хийх боломжгүй болох, буруу дүгнэлт гарах сөрөг талыг дагуулж байдаг. Тиймээс нотолгооны ач холбогдлыг хангах, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор шинжилгээнд ирүүлж байгаа объектуудыг ЭБШХ-д заасан журмын дагуу зөв битүүмжлэх шаардлагатай.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн зүгээс шинжээчид тавьж буй асуултууд зарим талаар учир дутагдалтай байна гэж үзэж байна. Ихэнхи тохиолдолд зөвхөн тэдгээрт үүссэн механик үйлчлэлийн мөрөнд буюу урагдалт, цооролт зэрэгт шинжилгээ хийгддэг ба амархан устаж үгүй болох тоосон мөр, бичил объектуудад тэр бүр шинжилгээ хийгддэггүй. Энэ нь нэг талаар хэргийн газрын үзлэг хийж буй мэргэжилтэн-шинжээч, мөрдөн байцаагч нар цогцос болон утаслаг ширхэглэг материал бүхий объектыг зөөвөрлөх, түүнийг шинжилгээнд хүргүүлэхдээ тэдгээрт үүссэн тоосон мөр болох “гутлын мөр, тээврийн хэрэгслийн явагч хэсгийн мөр”, бичил объект зэрэг амархан устаж үгүй болох магадлалтай ул мөр байгаад тэр бүр анхаарал хандуулахгүй байгаатай холбоотой байж болно.

Гэмт хэргийн газрын үзлэгийг хийхэд бохир заваан орчин, газар орчны эвгүй байрлал, техник хангамж дутуу, хүн хүчний хомсдол, цаг агаарын тааламжгүй нөхцөл,

ажлын ачаалал гээд олон олон хүндрэлүүд гарч болохыг үгүйсгэхгүй. Гэхдээ хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргүүд болон бусад төрлийн гэмт хэргүүдийн механизмд энэ төрлийн объектуудаас жишээлбэл: зодолдсон, ноцолдсон, хохирогч эсэргүүцэл үзүүлсэн тохиолдолд тэдгээрийн хувцсанд гутлын тоосон мөр илэрсэн үед адилтгалын ба онош зүйн шинжилгээ хийх, цогцсыг зөөвөрлөсөн тохиолдолд гэмт хэрэг анх үйлдэгдсэн газрын хөрсний үлдэгдэл, наалдац илрэх, түүгээр физикийн шинжилгээ хийлгэх, мөн хохирогчийн хувцсан дээр сэжигтэн этгээдийн хувцасны утаслаг ширхэглэг материал гогдогдон үлдэх болон тухайн гэмт хэргийн механизмд хамааралтай бусад төрлийн бичил объектууд илэрч болохыг анхаарах хэрэгтэй юм.

Нөгөө талаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар шинжилгээнд хүргүүлсэн хувцсанд зөвхөн урагдалт, цооролт байгаа эсэх, хэрэв байгаа бол ямар хүчин зүйлийн үйлчлэлээр үүсгэгдсэн эсэх гэсэн асуултуудаар шинжилгээний хүрээг хязгаарлаж байна. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 162.3-дахь хэсэгт “Шинжилгээ хийж байх үед шинжээч уг хэрэгт ач холбогдол бүхий бусад зүйлийг олж тогтоосон бол энэ талаар асуулт тавигдаагүй байсан ч өөрийнхөө дүгнэлтэнд заах үүрэгтэй” гэж заасан байдаг. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн тавьсан оновчтой асуултуудаас маш их нөхцөл байдал хамаардаг тус асуултаа тодорхой, оновчтой тавьж байх нь чухал.

Хувцасанд хийгдэх шинжилгээний үе шатаас хамааран үзлэгийн үед тогтоогдож буй урагдалт, зүсэгдэлт, цооролт гэх мэт өөрчлөлтүүдийг гэмтэл гэж нэрлэн цаашид шинжилгээний үед тухайн тогтоогдсон гэмтлүүдийг нарийн багаж тоног төхөөрөмж ашиглан шинжилсэний үндсэн дээр шинж тэмдгүүдийг тогтоож тухайн гэмтэл нь чухам ямар төрлийнх /урагдалт, цооролт, зүсэгдэлт, ханзралт г.м/ болохыг тодорхойлж байх нь зүйтэй гэж үзэж байна.

Хувцасанд хийгдсэн шинжилгээний дүгнэлтүүдийг уншиж, судлаж байх явцад шинж тэмдгүүдээс хамааран гэмтлүүдийг урагдалт, цооролт, зүсэгдэлт, ханзралт гэсэн 4 төрөлд ангилан нэршиж тогтсон байгаа нь ажиглагдлаа. Дээрх 4 төрлийн нэршил нь монгол хэлзүйн болон утгын хувьд ойлгомжтой, монгол хэлний товч тайлбар толинд тусгагдсан, практик ажиллагаанд хэрэглэж хэвшсэн, хэллэг байх тул үүгээр нь нэрлэж тогтох нь зөв юм байна гэсэн дүгнэлтэнд хүрч байна.

Шинжээчид тавьсан дараах асуултуудад хариулах боломжгүй байна гэсэн байна. Үүнд:

- Уг гэмтэл нь /урагдалт, ханзралт, цооролт, зүсэгдэлт/ хэзээ үүссэн болохыг цаг хугацааны хувьд нарийвчилж тухайлбал: 2011 оны 05 сарын 11-ний өдөр үүсэх боломжтой эсэх ? гэсэн асуултанд хариулах боломжгүй. Харин гэмтлийн шинэ, хуучин эсэхийг тогтоож болно.

- Уг гэмтэл нь ямар хүчээр үүссэн бэ, шинжилгээнд хүргүүлсэн хувцаснууд нь ямар материалаар хийгдсэн болох, материалын эсэргүүцэх чадварыг тогтоох? Мөр судлалын лабораторид тасралын хүч хэмжих багаж, материал судлалын “нэгдсэн сан” байхгүй тул эдгээр асуултуудад хариулах боломжгүй байна.

- Хутга /хайч, заазуур гэх мэт/ нь хэдий хэмжээний, ямар хүчээр уг хувцас, эд зүйлсийг нэвтэрч хүний биед гэмтэл үүсгэх боломжтой эсэх гэсэн асуултуудад хариулах боломжгүй байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 79.2-дахь хэсэгт “Хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт сэлт, мэдээлэл нь гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, эд мөрийн баримт, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны тэмдэглэл болон бусад баримтаар тогтоогдоно.”²¹³ хэмээн зааж, шинжээчийн дүгнэлтийг нотлох баримт болгон хуульчилсан байна. Мөн тус хуулийн 156-р зүйлд “Шинжилгээ заавал хийлгэх” гэсэн заалтыг ч оруулсан байна. Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-дахь хэсэгт “Шинжээчийн дүгнэлт гэж шинжээч өөрийн тусгай мэдлэгийн хүрээнд хийсэн шинжилгээний явц үр дүнг тусгасан нотлох баримтын эх сурвалж болох баримт

²¹³ Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль

бичиг”²¹⁴ хэмээн тодорхойлсон байдаг. Ийнхүү шинжээчийн дүгнэлт нь гэмт хэргийг нотлох чухал ач холбогдол бүхий нотлох баримт боловч тухайн шинжилгээний үр дүн хэргийн хувь заяанд хэрхэн нөлөөлсөн, бидний ажлын үр дүн хэр зэрэг байгаа талаархи мэдээлэл, судалгаа байх ёстой. Энэ нь нэг талаар шинжээч нарын ажиллах эрч хүч, урам зоригийг сэргээх, хийж байгаа ажлаасаа таашаал авах, нөгөө талаар залуу шинжээч бидний гэмт хэрэг илрүүлэх сэтгэлгээг хөгжүүлэх, хөхүүлэн дэмжих зэрэг олон талын ач холбогдолтой юм. Иймд шинжээчийн дүгнэлт тухайн хэргийг шийдвэрлэхэд хэрхэн нөлөөлсөн талаар эргэж мэдээлэх тогтолцоог сайжруулах шаардлагатай байна гэж үзэж байна.

Дүгнэлт санал

Монгол улсад үйлдэгдэж байгаа гэмт хэргийн дийлэнх хувийг хүч хэрэглэсэн гэмт хэрэг буюу бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах, хулгай, дээрэм, танхай, хүчингийн гэмт хэрэг эзэлж байна. Үүнийг дагаад утаслаг эдлэлд хийх механоскопийн шинжилгээний тоо жил ирэх тусам өсөн нэмэгдэж байна. Шинжилгээний объектуудыг ЭБШХ-д заасан журмын дагуу шинжилгээнд зөв савлаж, хаяглан, лацдаж битүүмжилж ирүүлэх нь түүнд шинжилгээ хийх нөхцөл боломжийг хангаад зогсохгүй, цаашид шинжээчийн дүгнэлт үнэн зөв гарахад ач холбогдолтой.

Дээрх сэдвийн хүрээнд хийгдсэн судалгаа, дүгнэлтээ үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна.

- Шинжилгээнд ирүүлж буй объект, хутга, хайч зэрэг багаж зэвсгийг заавар, журмын дагуу, стандартын сав, хайрцаг, баглаа боодолд хийн хаяглаж, лацдан, нэг хэргийн сэжигтэн, хохирогч нарын хувцас эд зүйлсийг тус тусад нь битүүмжилж ирүүлэх
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шинжээч, мэргэжилтэн болон байцаан шийтгэх ажиллагааны бусад оролцогчдод хэргийн газрын үзлэг, ул мөр эд мөрийн баримтыг хуульд заасан үндэслэл журмын дагуу илрүүлж бэхжүүлэх, хураан авч битүүмжлэх, тэдгээрийг шинжилгээнд хүргүүлэхэд шаардлагатай мэдлэг олгох сургалт, давтан сургалтыг тогтмол зохион байгуулах
- Шинжээчийн дүгнэлт тухайн хэргийг шийдвэрлэхэд хэрхэн нөлөөлсөн талаар эргэж мэдээлэх тогтолцоог сайжруулах
- Бусад улс орнууд утаслаг эдлэлийн шинжилгээг хийхдээ ямар арга аргачлал, техник хэрэгсэл ашиглаж байгаа талаар судалж, өөрийн орны практикт нэвтрүүлэх
- Утаслаг эдлэлд хийх механоскопийн шинжилгээний дагнасан, мэргэшүүлэх болон давтан сургалтыг практик байгууллагын алба хаагчидын дунд зохион байгуулах
- Төрөл бүрийн материал дээр туршилт судалгаа /зүсэх, хайчлах, татаж чангаах, шатаах, тодорхой зайнаас тодорхой өнцгөөр буудах, хатуу мохоо ирмэгтэй зүйлээр үйлчлэх гэх мэт/ хийж материал судлалын “нэгдсэн сан” бүрдүүлж ашиглах

²¹⁴ Шүүхийн шинжилгээний тухай хууль

**ХОРИХ ЯЛ ЭДЛЭЭД СУЛЛАГДСАН ИРГЭДЭД ЦАГДААГИЙН
БАЙГУУЛЛАГААС ТАВИХ ЗАХИРГААНЫ ХЯНАЛТЫН
ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ**

Отгоны Түмэнбаяр

НЦГ-н Хэв журмын хэлтсийн ахлах байцаагч,
магистрант, цагдаагийн ахмад

Хяналт бол нийгмийн амьдралын талаар үнэн бодит мэдээллийг авч болох, үйл ажиллагаа тогтвортой явуулах гол чухал механизм юм. Түүний тусламжтайгаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж, эрх зүйн хэм хэмжээг ямар түвшинд сахиж, мөрдөж байгааг харж болох бөгөөд энэ нь нийгэмд сахилга, хууль ёсыг сахиулах, эмх замбараагүй байдал үүсгэхгүй, эсвэл түүнийг даамжруулахгүй байх чухал хэрэгсэл юм.

Өнөө үед нийгмийн үнэт зүйлийн талаархи ойлголт эрс өөрчлөгдөж төрийн удирдан захирах чиг үүрэг нь тэргүүлэх ач холбогдол нь багасаж байгаа бөгөөд харин төрөөс нийгмийн амьдралыг зохицуулах, хянах чиг үүргийн ач холбогдол улам өсөх хандлагатай байна.

Аливаа хяналтын мөн чанар нь хяналтын объект болох аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүний үйл ажиллагаанд хууль тогтоомж, эрх зүйн бусад акт, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, удирдамж хэрхэн биелэгдэж байгаад эрх бүхий байгууллага, ажилтнаас тавих байнгын ажиглалт болоход оршино.

Захиргааны хяналт нь төрийн хяналт шалгалт, хяналтын бие даасан томоохон төрөл хэсэг бөгөөд түүний зорилт нь эдийн засаг, аж ахуй, нийгэм соёл, захиргаа, төрийн байгуулалтын салбарт болон хууль ёсыг хангах хүрээнд гарсан хууль тогтоомж, тэдгээрт нийцэж гарсан эрх зүйн акт, бүх нийтээр дагаж баримтлах журам, дүрэм, технологи, стандартын шаардлага, нормативыг Монгол Улсын нутаг дэвсгэрт өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүх иргэн, байгууллага, аж ахуйн нэгжээс сахин мөрдүүлэх явдалд оршино.²¹⁵

Цагдаагийн байгууллага хуульд заасан тодорхой объект, үйл ажиллагаанд захиргааны нийтлэг болон тусгай хяналтыг хэрэгжүүлж байна. Эдгээр захиргааны хяналтыг доктор (Sc.D), профессор Ж. Долгорсүрэн өөрийн бүтээлдээ цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх захиргааны хяналтыг үйл ажиллагааны хамрах хүрээ, объектын онцлогоор нь дараах байдлаар төрөлжүүлэн хуваасан байна. Үүнд:

1. **Зохион байгуулалтын болон бусад ямар нэг талаар цагдаагийн байгууллагад захирагдахгүй тодорхой бус субъектэд тавих захиргааны хяналт.** Энэ нь олон нийтийн газар болон нийтийг хамарсан арга хэмжээ явагдах үеийн нийгмийн хэв журам, нийтийн аюулгүй байдалд тавих цагдаагийн эргүүл харуулын хяналт
2. **Тодорхой субъект, тодорхой асуудлын хүрээнд хэрэгжүүлэх захиргааны хяналт.** Үүнд зөвшөөрлийн тогтоогдсон журмыг иргэн, байгууллага, аж ахуйн нэгжээс хэрхэн сахин биелүүлж байгаад тавих хяналт /гэрээт харуул хамгаалалтын зөвшөөрөл олгох журам, галт зэвсэг, тусгай хэрэгсэл улсын хилээр оруулах тухай журам гэх мэт/
3. **Гэмт хэрэг үйлдсэн зарим хүний зан үйлд тавих захиргааны хяналт.** Шүүхээс ял хойшлогдсон этгээд болон хорих ял эдлээд суллагдсан зарим этгээдэд тавих захиргааны хяналт гэх мэт.

Гэмт хэрэг үйлдсэн зарим хүний зан үйлд тавих захиргааны хяналт нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээнд хамаарах бөгөөд түүнийг гэмт хэрэг, эрх зүйн зөрчил гаргаж болзошгүй этгээдийн гэмт зан төлөвийн элдэв илрэл болон

²¹⁵ Ж. Долгорсүрэн “Захиргааны албадлага” УБ . 1999. 74 дэх тал

нийгмийн сөрөг үзэгдлээс хамгаалах хэрэгсэл болгон оновчтой ашиглах явдал онцгой ач холбогдолтой юм.

Дахин гэмт хэрэг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлж хэдийд ч дуудан ирүүлж зөвлөгөө өгөх, шаардлага тавих, анхааруулах, засрал хүмүүжлийн байдалд хяналт тавих, амьдралаа зөв зохиож, хүмүүжихэд нь нөлөө үзүүлэх зэрэг хэлбэрээр, **гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээний** хүрээнд хэрэгжиж байна.

Энэ арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэх гол үндэс нь хүмүүжлийн болон албадах аргыг зөв хослон хэрэглэх боломж нөхцлийг бүрдүүлэн бий болгоход оршино. Нөгөө талаар зөвхөн гэм буруутны зан төлөвт оршин буй сөрөг үзэл бодлыг төдийгүй түүний үүсч бий болох, төлөвшин бэхжихэд нөлөө үзүүлдэг орчны тааламжгүй нөхцлүүдийг арилгахад чиглүүлэх ёстой юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээнд хамааруулах хүмүүсийн хувьд:

- а. Гэмт хэрэг тухайн үед үйлдээгүй боловч тааламжгүй нөхцөлд байгаа бөгөөд бусдын нөлөөгөөр гэмт үйлдэл хийж болзошгүй этгээд;
- б. Нийгмийн дэг журам зөрчиж, жижиг зөрчлүүд байнга гаргаж байгаа этгээд;
- в. Гэмт хэрэг үйлдэх санаа, сэдэлтэнд хөтлөгдөж, тодорхой гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж эхэлсэн этгээд;
- г. Гэмт хэрэг үйлдэж эхэлсэн боловч төгсгөлд хүргэж чадаагүй этгээд;
- д. Гэмт хэрэг үйлдсэн бөгөөд дахин үйлдэж болзошгүй эдгээр хүмүүсийг тус тус хамааруулан үздэг байна..

Энэ арга нь хорих ял эдлээд суллагдсан бүх хүнд биш, Эрүүгийн хуульд заасан тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгэгдээд суллагдсан зарим хүмүүст хэрэглэгдэнэ.

Өнөөдөр цагдаагийн байгууллага захиргааны хяналтын ажлыг хэрэгжүүлж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахдаа дараахь 2 үндсэн чиглэлийг барьж ажиллаж байна. Үүнд :

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, ЦЕГ-ын даргын баталсан “Хорих ял эдлээд суллагдсан хүмүүст захиргааны хяналт тогтоох журам”-ын дагуу дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилго бүхий захиргааны хяналтын ажил,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох заалт болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан журмын дагуу хорих ял нь шүүхийн шийдвэрээр хойшлогдсон этгээдэд дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, засрал хүмүүжилд нь хяналт тавих зорилгоор хянан харгалзах хэлбэр бүхий захиргааны хяналтын ажил.

Гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг шоронд хийвэл зохино, тэгвэл бид тайван амгалан амрах байх болно гэсэн иргэдийн хандлага байдаг бол шоронгоос суллагдсан хүмүүст хийсэн судалгааны дүнгээс үзэхэд тэд нийгэм дундаа орж хүмүүстэй ойлголцож чадахгүй байна, тэдэнд ажил олдохгүй байна, бичиг баримтгүй, орон гэргүй зэргээс гадна тэднийг шоронгоос суллагдахад бүгд л дөлж зугтдаг гэсэн гомдол, цөхрөл зонхилж байна.

Сүүлийн 3 жилийн дундажаас үзэхэд Нийслэл хотод нэг жилд шүүхээс хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн 1200 ялтан, хорих ял эдлээд суллагдсан 800 хүн, нийт 2000 орчим хүмүүст Цагдаагийн байгууллагаас тодорхой хугацаагаар захиргааны хяналт тогтоон ажиллаж байна.

Монгол Улсын хэмжээнд сүүлийн 3 жилд 17500 хүн баривчлах болон хорих ял шийтгэгдсэн ба жил тутам 100 орчим нэгжээр өсч, тэдний 42-48 хувь нь урьд өмнө ял шийтгэл эдэлж байсан хүмүүс байгаагаас үзэхэд хорих болон баривчлах ял эдлээд суллагдсан хүмүүсийг нийгэмд хүлээн авах, ажлын байраар хангах, тусламж дэмжлэг үзүүлэх ажил орхигдож байгаа зэрэг олон нөхцлөөс хамааран ял эдлээд дууссан болон, ял хойшилсон, өршөөл, уучлалаар суллагдсан хүмүүс дахин гэмт хэрэг үйлдэх явдал өсч, улмаар давтан ял шийтгүүлэн хорих газар дасан зохицох хандлага ажиглагдаж байна.

Монгол Улсын нийт хүн ам, бүртгэгдсэн гэмт хэрэг, гэмт хэрэгт холбогдогч, түүнээс урьд ял шийтгэгдсэн хүмүүсийн эзлэх хувь, динамик хөдөлгөөнийг сүүлийн 10 жилийн байдлаар авч үзвэл, урьд нь шүүхээр ял шийтгэгдсэн 18117 хүн дахин гэмт хэрэг үйлджээ. Энэ нь дээрх хугацаанд гэмт хэрэг үйлдсэн нийт хүмүүсийн 9.8 хувийг эзэлж байна.

Түүнчлэн өнгөрсөн 3 жилийн хугацаанд урьд ял шийтгэгдсэн 4817 хүн байгаагаас жилд дунджаар 1606 хүн дахин гэмт хэрэг үйлджээ. Үүнээс үзэхэд сүүлийн арван жилд урьд ял шийтгэгдэн суллагдсан хүмүүсийн 8-13 орчим хувь нь дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлжээ.

Нийслэл хотод жилд 36-50 хүртэл буюу сүүлийн 3 жилд дунджаар 120 орчим хүн дахин гэмт хэрэг үйлдсэн байх бөгөөд, улсын дундажтай харьцуулахад өмнө ял шийтгэгдсэн хүмүүсийн 6 орчим хувь нь дахин гэмт хэрэг үйлдэн ял шийтгэгдэж байна.

Захиргааны хяналтыг хэрэгжүүлэх үндсэн үүргийг гүйцэтгэж байгаа цагдаагийн ажилтан болон хяналт тавих чиглэлээр ажиллаж байгаа хуулийн ажилтнууд, мөн захиргааны хяналтанд байгаа хүмүүстэй уулзалт, ярилцлага хийх замаар судалгаа хийж үзэхэд дахин гэмт хэрэг үйлдэж байгаа шалтгаан нь “нийгэмд хэвийн амьдарч чадахгүй” байгаатай холбоотой төдийгүй гэмт зан үйл төлөвшсөн, эргээд гэмт хэрэг үйлдэх орчиндоо очдог зэрэг нөхцөлтэй холбоотой байна.

Ял шийтгэгдсэн болон хорихоос суллагдсан хүмүүсийг “нийгэмд аюултай хүмүүс” гэж үзэж “даван, рецидив гэмт хэрэгтэн” гэж ангилан нийгэм, хууль эрх зүйн шалгуур, үр дагаваруудыг бий болгож, тэдгээртэй хийх тэмцлийг чангатгахыг чухалчилсан өнөөгийн практик нь зарим нэг талаараа эсрэг үр дагаваруудыг бий болгож байна.

Тухайлбал Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2008 оны А/113, 547, 494 тоот захирамж, тушаалаар батлагдсан “Шүүхээр ял шийтгэгдсэн хүмүүсийн тоо бүртгэлийг хөтлөх, лавлагаа олгох заавар”-ын 23-д зааснаар эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хянан шалгах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад тухайн гэмт хэрэгт холбогдсон этгээдийн хувийн байдал, эрүүгийн хариуцлагын хэр хэмжээ, шинж чанарт нөлөөлөх нөхцөлүүдийг бодитой тогтоох зорилгоор Мэдээлэл, судалгааны төвөөс ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас, лавлагаа өгдөг асуудал юм. Энэхүү лавлагааны үр дагавар нь :

- Эрх зүйн талаас нь харахад 2010 оны эцсээр нийт ялтнуудын 50.4% нь хоёр ба түүнээс дээш удаа хорих ял шийтгүүлж байсан рецидив ялтнууд, тэдний 37.2 % нь хүч хэрэглэсэн болон шунахай сэдэлттэй гэмт хэрэг үйлдэж мэргэшсэн тусгай рецидив гэмт хэрэгтнүүд байна гэсэн судалгаа гарчээ.
- Нийгмийн талаасаа иргэн хүний Монгол Улсын Үндсэн хуулинд заасан зарим эрхэнд тодорхой хэмжээгээр саад болох нэг гол хүчин зүйл болж байна. Тухайлбал хорих газраас суллагдсан иргэн ажилд орох гэхээр өөдөөс нь ял, шийтгэл эдэлсэн эсэхийг үндэслэсэн ажлын шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж ирээд байдаг. Энэ тэднийг буцаад нийгэмшихэд тодорхой хэмжээний саад болж байна.

Өнөөдөр цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа захиргааны хяналтын үйл ажиллагаа нь “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын хууль”, ХЗДХ-ийн сайдын тушаалаар батлагдсан “Хорих ял нь шүүхийн шийтгэх тогтоолоор хойшлогдсон ялтны засрал хүмүүжилд хяналт тавих журам”, ЦЕГ-ын даргын тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын заавар”, “Хорих ял эдлээд суллагдсан хүнд захиргааны хяналт тогтоох журам”, “Хэсгийн байцаагчийн ажлын заавар” зэрэг хууль, журам, заавруудаар зохицуулагдаж байна.

Мөн дээр дурьдсан эрх зүйн актуудын хүрээнд, тэдгээрт заагдсан ажил, арга хэмжээнүүдийг цагдаагийн алба хаагч хэрэгжүүлэн ажиллахад хяналтанд байгаа хүн болон тэдний ар гэрээс дарамтын хэлбэрээр хүлээн авдгийг цагдаагийн байгууллага

болон прокурорд ирж байгаа санал хүсэлтүүдийн дийлэнх хувь ийм агуулгатай байгааг харж болох юм.

Түүнчлэн эрх зүйн актуудын хүрээнд хорих ял эдлээд суллагдсан хүнийг суллагдсанаас хойш 3 хоногийн дотор хүлээн авч, 1-3 жил хүртэл хугацаа тогтоон, хяналтын хувийн хэрэг нээж, 2 сар тутам нэг удаа бүртгэх, оршин суух газар өөрчлөгдсөн тохиолдолд 3 хоногийн дотор бүртгэж авах, шинээр хувийн хэрэг нээх, 14 хоногоос илүү хугацаагаар гадаад улсад зорчих болбол бүртгэл хийлгэх, мөн дахин гэмт хэрэг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай гэж үзвэл хугацаа харгалзахгүйгээр дуудан ирүүлж, зөвлөгөө өгөх, шаардлага тавих, анхааруулах, засрал хүмүүжлийн байдалд нь хяналт тавих, амьдралаа зөв зохиож, хүмүүжихэд нь нөлөө үзүүлэх хэлбэрээр хэрэгжүүлж байна.

Хорих ял эдлээд суллагдсан зарим хүмүүст хороодын хэсгийн байцаагч нар шууд захиргааны хяналт тавидаг бөгөөд тэдний тавих хяналтын хувийн хэргийн баяжилт бусад байдлыг судлаад үзэхээр дараах асуудлууд хангалтгүй хэрэгжиж байна. Тухайлбал хэсгийн байцаагч нар тэр болгон захиргааны хяналтанд орж байгаа этгээдийн эрх үүргийг тайлбарлаж өгдөггүй дутагдал байсаар байна. Тиймээс тэд өөрийнхөө эрх үүргийг мэдэхгүй байгаагаас хорих ял эдлээд суллагдсан хүмүүс захиргааны хяналтанд нэр төдий л хамрагдсанаас тэнссэн буюу захиргааны хяналтанд орсон, цагдаад бүртгэгдсэн гэсэн байдалтай явж байна.

Шүүхийн шийтгэх тогтоолын хувийг тухайн этгээдийг хяналтандаа авсан цагдаагийн байгууллага тэр болгон хүлээж авахгүй явдал байсаар байна. Үүний сөрөг үр дагавар нь тухайн ялтан хэзээ ямар үеэс эхэлж хяналтанд орсныг тогтоох боломжгүй байдалд хүрч байна. Ийм учраас шүүхээс ирж байгаа албан ёсны баримт бичгийг ордог бүртгэлүүдээр нь оруулаад тэмдэглэл үйлдээд дараагийн эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэж өгөх нь зүйтэй юм.

Захиргааны хяналтанд орсон этгээдийг хяналтандаа байлгахыг зөвшөөрсөн иргэн, хуулийн этгээдийн төлөөлөгч нарыг дуудаж тэдний эрх үүргийг нь танилцуулах ажиллагаа шаардлагын түвшинд хүрэхгүй байна. Хуулиндаа танилцуулах ёстой. Тэдэнд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардаж, шаардлага тавьж биелэлтийг тооцож байх ёстой байдаг.

Түүнчлэн хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хорих ялын хугацаа дуусч, цагдаагийн байгууллагын захиргааны хяналтад авагдвал зохих хүмүүсийн оршин суух хаягийг суллагдахаас нь өмнө дахин тодруулж, үнэн зөв тогтоодоггүй, суллагдаж байгаа талаар хяналт тавих боломжтой хугацааны өмнө харьяалах цагдаагийн байгууллагад албан ёсоор мэдэгддэггүй, суллагдсаны дараа тухайн хүнийг биечлэн хүлээлгэж өгөх үйл ажиллагаа хийгддэггүй бөгөөд зөвхөн овог нэр, хаяг бүхий нэг хуудас бүхий хяналт тавих боломж муутай материал ирүүлдгээс суллагдах үеэс нь эхэлж, захиргааны хяналт тогтоож чадахгүй байна.

Түүнээс улбаалан цагдаагийн байгууллага тухайн этгээдийн оршин суугаа хаягийг нь тогтоох, хяналтанд авах хүнээ олох, эрэн сурвалжлах зэргээр ихээхэн хугацаа алдаж, зарим тохиолдолд хуулинд заасан ялтай байх хугацааг нь дуусгаж, хяналт тавихгүй орхигдуулах, захиргааны хяналт тавих боломж хязгаарлагдах явдал гарч байна.

Захиргааны хяналтын ажлын хүрээнд цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа дээрхи ажил, арга хэмжээнүүдийг цаашид цагдаагийн байгууллага дангаараа хэрэгжүүлэх нь учир дутагдалтай байгаа бөгөөд нөхцөл боломжийн хувьд ч хязгаарлагдмал шинжтэй байгаа юм.

Тийм учраас хуулийн хүрээнд захиргааны хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хяналтанд байгаа хүмүүст тохиолдож байгаа хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудлуудыг аль болох шийдвэрлэх замаар тэднийг нийгэмшүүлэх арга хэлбэрийг сонгож, үүнийгээ хэрэгжүүлэхдээ төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах хэлбэрийг сонгож ажиллах нь зүйтэй гэсэн бодлого барих нь зүйтэй гэж үзэж байна.

Захиргааны хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа алба хаагчдын ажлын арга барил, хандлагыг өөрчлөх, цагдаагийн байгууллага, прокурор, хөдөлмөр нийгмийн хамгаалалын яам, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах, хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг төрийн хэмжээнд хийх, дээрх ажлын хүрээнд хамтран ажиллавал зохих төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагаагаа улам идэвхжүүлэх чиглэлээр хяналтад байгаа хүмүүсийн хүмүүжил төлөвшилд нөлөөлөх, нийгэмшүүлэх замаар дахин гэмт хэрэг үйлдэх явдлаас урьдчилан сэргийлэх бодлого барьж ажиллах нь өнөөдөр тулгамдаж байгаа асуудлын нэг болж байна.

Дүгнэлт

Өнөөдөр гэмт хэрэг үйлдээд шүүхийн таслан шийтгэх тогтоолоор зохих ялаа эдлээд суллагдсан иргэн дахин гэмт хэрэг үйлдэж байгаа шалтгаан нөхцөлийг хуулийн байгууллагаас явуулах урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй, тавих хараа хяналт дутсан гэхээсээ илүүтэй, тэдэнд нийгэм, хамт олноос үзүүлэх иргэнээ гэсэн бодитой бодлого, туслалцаа, дэмжлэг байхгүйгээс дахин гэмт хэрэг үйлдэх нөхцөл байдалд үүсэж байна гэж үзэх нь илүү бодитой юм.

Нөгөө талаар бодит байдал дээр цагдаагийн байгууллагаас тавьж байгаа захиргааны хяналт нь сард нэг удаа дуудаж, бүртгэдэг хэлбэрээс хэтрэхгүй байгаа ба захиргааны хяналтыг хэрэгжүүлж байгаа цагдаагийн ажилтан, хяналтанд байгаа хүмүүсээс ч энэ арга хэмжээг оновчгүй хэмээн хүлээн авах болсон нь хяналтыг хэрэгжүүлж байгаа хэлбэр, түүнээс хүлээгдэж буй үр дүнгийн тухайд шинэлэг арга хэлбэр, зорилго, зорилтыг дэвшүүлэн гаргаж ирэх цаг болсонтой холбоотой гэж үзэж байна.

Цагдаагийн байгууллага хуулийн хүрээнд захиргааны хяналтын ажлыг хэрэгжүүлэхдээ хяналтанд байгаа хүмүүсийн “бэрхшээлтэй асуудал”-ыг аль болох ойлгож, тэднийг нийгэмшүүлэх арга хэлбэрийг сонгож, үүнийгээ хэрэгжүүлэхдээ төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах эрх зүйн зохицуулалтыг шинээр бий болгох нь хяналтын ажлын үр нөлөөг тодорхой хэмжээгээр дээшлүүлнэ.

Захиргааны хяналтын чиглэлээр зохион байгуулж, удирдлагаар хангаж ажилласан тодорхой ажил, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангаж, эрчимжүүлэх, мөн гудамж, талбайд согтуугаар үйлдэгдэх гэмт хэргийн тоо төдийлөн буурахгүй байгаа, давтамж ихтэй тэмдэглэн өнгөрүүлдэг баяр ёслолын үеэр гэмт хэргийн гаралт ихэсдэг зэрэг цаг үеийн шинжтэй нөхцөл байдлуудыг харгалзан дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдэд захиргааны хяналтанд байгаа болон, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албанд шалгагдаж байгаа хүмүүсээс дахин гэмт хэрэг үйлдүүлэхгүй байх зорилгоор нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулах ажлыг тогтмолжуулах, үр дүнд нь байгууллага, эрх бүхий албан тушаалтнуудаас тавих хяналтыг чангатгах нь чухал байна.

Мөн тухайн нутаг дэвсгэрт оршин суудаг, идэвх санаачлагатай иргэдийг түшиглэн захиргааны хяналтанд байвал зохих иргэдийг хүлээн авч нийгэмшүүлэх, тэдгээрт тулгарч буй хүндрэл бэрхшээлийг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран шийдвэрлэх, захиргааны хяналтанд байгаа этгээдийн харъяалагдах нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллага хэрэв хяналтанд байгаа этгээдийг хүлээн авч нийгэмшүүлэх ажлыг гардан гүйцэтгэж, тодорхой үр дүн гарвал урамшуулдаг, төрөөс тодорхой дэмжлэг үзүүлдэг системд шилжих хэрэгтэй.

Хорих ял эдлээд суллагдсан зарим иргэдэд хэсгийн байцаагч нарын тавьж буй захиргааны хяналт болон түүний эрх зүйн зохицуулалт өнөөгийн нийгмийн шаардлагыг бүрэн дүүрэн хангаж чадахгүй байна. Хэсгийн байцаагч нар ажлынхаа ихэнхи цаг хугацааг өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлэх болон захиргааны зөрчилтэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулж байгааг анхаарах цаг нэгэнт болжээ.

ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ГЭМТ ХЭРГИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗАМУУД

Саяасийгийн Тилеуберди
ДХИС-ийн магистрант

Монгол улсад төр засаг төлөвшин тогтворжихгүй байсаар өнөөдөр замын хөдөлгөөний аюулгүй байдал хангах асуудалд хөдөлгөөнд оролцогчидоо хэрхэн бэлтгэх, автомашины ашиглалт, түүний найдварт ажиллагаа, замын орчноо сайжруулах гэсэн асуудлуудад анхаарал суларч, түүний сөрөг үр дагавар жилээс жилд өсөн нэмэгдсээр байна. Иймээс зам тээврийн осол, гэмт хэргийн гаралт, хэлбэр, хэмжээ, криминогений тоон үзүүлэлтүүдээс тодорхой харагддаг.

1.Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал

Улсын хэмжээнд үйлдэгдэж байгаа нийт гэмт хэргийг хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг чиглэгдсэн байдлаар нь авч үзвэл тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг ихээхэн хурдацтайгаар өсөн нэмэгдэж байна.

Сүүлийн 10 жилийн судалгаанаас үзэхэд нийт бүртгэгдсэн 206536 гэмт хэргийн улмаас 68777 хүн гэмтсэн байх бөгөөд жилд дунджаар 6978 хүн, хоногт 19 хүн гэмтжээ гэсэн тоон үзүүлэлт байна. Үүнээс замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс 12469 хүн гэмтсэн байгаа нь нийт гэмтэгсдийн тоотой харьцуулахад 17,9 хувийг эзлэх ба жилд 1247 хүн, хоногт 3 хүн гэмтээд байгаа юм. Энэ гэмт хэргийн улмаас 17276 хүн нас барсан бөгөөд жилд дунджаар 1728 хүн, хоногт 5 хүн нас барсан гэсэн үзүүлэлт гарч байна. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас 3513 хүн нас барсан нь бусад гэмт хэргийн улмаас нас барагсдийн тоотой харьцуулахад 20.3 хувийг эзэлж байхад жилд дунджаар 351 (388)²¹⁶ хүн буюу хоногт 1 хүн нас барсан байна. Нутаг дэвсгэрийн байдлаар нь авч үзвэл уг гэмт хэргийн улмаас нас барсан хүн 36.0 хувь нь нийслэлд, 64.0 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна.

Тээврийн хэрэгслийн бүртгэгдсэн тоог 2010 оны улсын үзлэг тооллогын мэдээнээс үзэхэд 296800 хүрээд байгаа нь сүүлийн 10 жилд 1.6-2.5 дахин өссөн байх ба нийслэлийн хэмжээнд 168800 тээврийн хэрэгсэл бүртгэгдээд байгаа нь дээрх хугацаанд 2 дахин өссөн дүнг харуулж байна.

Мөн зам тээврийн осол, гэмт хэргийн 78.3 хувь нь жолоочийн буруугаас, 17.5 хувь нь явган зорчигчийн буруугаас, үлдсэн 4.2 хувийг нь бүрэн бус тээврийн хэрэгслээс үүдэн гарсан байна. Жич дурьдахад: Дээрхи тоон хувь илэрхийлэлд хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл, зам-орчноос үүдэн гарч байгаа осол хэрэг тэмдэглэгдэхгүй байгаа нь олон улсын жишиг судалгаатай харьцуулахад хачирхалтай байгаа юм.²¹⁷ Энэ тал дээр төрөөс мэргэжлийн удирдлагаар хангах, туслах, улмаар чиглүүлж, олон улсын жишиг судалгаатай болох бодлого алдагдсан гэж судлаач хүний хувьд үзэж байна.

Монгол улсад үйлдэгдэж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас 100 мянган хүнд ногдох нас баралт дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан дунджаас 48.6 хувиар, 100 мянган тээврийн хэрэгсэлд ногдох дунджаас 7 дахин их байна.

Замын цагдаагийн газрын статистикийн бүртгэлээс харахад 2010 онд улсын хэмжээнд үйлдэгдсэн зам тээврийн осол, гэмт хэргийн 13,8 хувь /нийслэлд 12,3 хувь/ нь

²¹⁶ Доржсүрэнгийн Нямдорж дис."Монголын автотээврийн хэрэгслийн ашиглалтын болон хөдөлгөөний аюулгүй байдлын журмын зөрчлүүдтэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх криминологийн шинж байдал" Москва, 2009 он хуудас 49

²¹⁷ Доржсүрэнгийн Нямдорж дис."Монголын автотээврийн хэрэгслийн ашиглалтын болон хөдөлгөөний аюулгүй байдлын журмын зөрчлүүдтэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх криминологийн шинж байдал" Москва, 2009 он хуудас 50

согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон байна. Улсын хэмжээнд нийт 24200 жолооч үүнээс нийслэлд 15100 жолооч согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлийг илрүүлэн 20700 жолоочийн, үүнээс нийслэлд 13200 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, 4676 хүнд үүнээс нийслэлд 2418 хүнд захиргааны журмаар баривчлах шийтгэл ногдуулсан байна.

2011 оны 11 сарын байдлаар Монгол улсын хүн амын 41 орчим хувь нь нийслэл хотод оршин сууж амьдарч байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт тээврийн хэрэгслийн 45 хувь нь нийслэл хотод төвлөрч, 70 гаруй хувь нь зам тээврийн осол, гэмт хэрэг үйлдэгдэж байна.

Гэмт хэрэг, ослын улмаас 2011 оны эхний хагас жилийн байдлаар 152 хүн нас барж, 440 хүн хүнд, хөнгөн гэмтэж, 1 тэрбум 916,9 сая төгрөгийн хохирол учирч, нас барсан хүний 61,8 хувь нь орон нутагт, 38,2 хувь нь нийслэл хотод бүртгэгдсэн байна.²¹⁸

Монгол улсын Засгийн газрын 2006 оны 315 дугаар тогтоолоор баталсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” хөтөлбөр 2007-2010 онд 2 үе шаттай хэрэгжиж дууссан. Хөтөлбөр хэрэгжсэн хугацаанд улсын хэмжээнд үйлдэгдсэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг осол, түүний улмаас үүссэн хохирлыг өмнөх 4 жилийн байдалтай харьцуулахад нас барсан хүний тоо 14,2 хувиар, гэмтсэн хүний тоо 21,1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал

Дэлхийн даяарчлалын үйл явцад сэтгэл зовинуулж буй шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлын нэг болох замын хөдөлгөөний аюулгүй байдал чухлаар тавигдсан цаг үед, 2009 оны 11-р сарын 19-20-ны өдрүүдэд Москва хотноо зохион байгуулагдсан замын хөдөлгөөний аюулгүй байдлын асуудлаарх дэлхийн сайд нарын анхдугаар зөвлөгөөнөөс “Москвагийн тунхаглал”-ыг гарган хүргүүлснээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас тогтоол гарган 2011-2020 оныг “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны 10 жил” болгож дэлхий нийтэд зарлан тунхагласан билээ. ы

Москвагийн тунхаглалд НҮБ, бүс нутгийн болон олон улсын байгууллагууд, улс орнуудын засгийн газарт, тэр дундаа бага болон дунд орлоготой улс орнуудын Засгийн газарт хандаж ирэх 10 жилд хэрэгжүүлбэл зохих үйл ажиллагааны чиглэл, цаашид авах арга хэмжээг тодорхойлсон юм. Ази Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс /ESCAP/-ын бүс нутгийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын шинжээч нарын уулзалтыг 2010 оны 09-р сарын 21-23-ны өдрүүдэд Бангкок хотноо зохион байгуулж бүс нутгийн улс орнуудын Засгийн газарт хандаж нэгдсэн зөвлөмж дүгнэлтийг гаргаж “Замын аюулгүй байдлыг хангах талаар 2011-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан.

Монгол улсын хувьд 2010.11.17-нд ДХИСургууль /хуучин нэрээр Цагдаагийн академи/, Цагдаагийн ерөнхий газар, Замын цагдаагийн газар, ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төвөөс хамтран “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тулгамдсан асуудлууд” сэдэвт онол, практикийн бага хурлыг анх удаа зохион байгуулсан нь дээр дурьдсан тунхаглал, хөтөлбөр зөвлөмжүүдийг дэмжин ажиллаж тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэргээс үүдэн гарах гэмтэл бэртэл, нас баралт зэргийг бууруулах чиглэлээр Дотоод хэргийн байгууллагуудын хамтын эрдэм шинжилгээний орчинд хийсэн дорвитой алхам болсон юм.

Дээрх хуралд зам тээврийн осол, гэмт хэргийг бууруулах чиглэлээр сургалт, судалгаа явуулдаг Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний болон практикийн байгууллагын судлаач эрдэмтэд илтгэл тавьж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан

²¹⁸ ЗЦГ-ын гэмт хэргийн бүртгэл судалгаа 2011 он

зогсоох үйл ажиллагаа нь зайлшгүй тулгамдаж байгаа асуудал гэдгийг онцлон тэмдэглэсэн юм. Хуралд тавигдсан илтгэлүүдийг хэлэлцэн тодорхой шийдэлд хүрч Монгол улсын засгийн газарт хандан зөвлөмжүүдийг боловсруулан хүргүүлсэн билээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлыг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах тогтолцоогүй үндэсний стратеги төлөвлөлтгүй зам тээврийн осол хэргийн шалтгаан нөхцлийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлаж, бодлого чиглэлийг тодорхойлох чиг үүрэг бүхий Засгийн газрын бүтэц /институци/ байхгүй, замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой мэдээллийг илэрхийлэх үзүүлэлтүүд нэгдмэл бус, олон улсын стандартад нийцээгүй, эрх зүйн орчин оновчтой бус, төрөөс авч хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн үр дүн төдийлөн хангалттай бус байгааг хуралд оролцогчид онцлон тэмдэглэж, төр засаг, мэргэжлийн байгууллага, олон нийтийн зүгээс дараах арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх тулгамдсан асуудал гэдгийг тодорхойлсон.

Тэдгээрээс замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар онц чухлыг нь дурьдвал: Зам тээврийн осол, хэргийн шалтгаан нөхцөлийг шинжлэх ухааны үндэслэлтэй судалж, авч хэрэгжүүлэх бодлого чиглэлийг тодорхойлох чиг үүрэг бүхий эрдэм шинжилгээний институтийг шинээр байгуулах;

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах чиг үүрэг бүхий төрөл мэргэжлийн боловсон хүчин холбогдох бүх салбарт дутагдалтай байгааг анхааран үзэж, энэ чиглэлийн мэргэжилтнүүдийг гадаадад болон дотоодод бэлтгэх ажлыг хэрэгжүүлэх;

Цагдаагийн байгууллагын алба хаагчаас замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тухайн нөхцөлд тохирсон үйлдэл, шийдвэр гаргаж, үүргээ үр дүнтэй, шуурхай гүйцэтгэх горим стандартыг системчлэн боловсруулж, мэргэжлийн мэдлэг, ажлын ур чадвар, ёс зүйтэй боловсон хүчин бэлтгэн гаргах тогтолцоог бий болгох;

Хүн ам, тээврийн хэрэгслийн тооны эрчимтэй өсөлт, хуулиар хүлээсэн үүргүүдийг харгалзан замын цагдаагийн албыг орон тоо, хүн хүч, техник хэрэгслийн хувьд бэхжүүлэх;

Жолооч бэлтгэх, мэргэжлийн шалгалт авах үйл ажиллагаанд тавигдах стандартыг шинэчлэж, олон улсын жишигт хүргэх; /Шинээр жолооч бэлтгэх, ангилал ахиулах, үнэмлэх олгох шалгалт авахад хүний оролцоог багасгах, боловсронгуй болгох. Үүний тулд гадаад орнуудад хэрэглэгдэж байгаа шалгалтын төвийг нийслэлд бий болгох аймгуудад бүсчлэн байгуулах газар, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх/

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон барилга байгууламж, авто зам, гүүр, тэдгээрийн хиймэл байгууламжийг төлөвлөх, шинээр барих, өргөтгөх, засварлах зэрэг улсын стандартыг боловсронгуй болгож мөрдүүлэх;

Замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой мэдээллийг илэрхийлэх үзүүлэлтүүдийн нэгдмэл байдлыг хангаж, олон улсын стандартад нийцүүлэх; /Зам тээврийн осолд өртөж нас барсан хүний мэдээллийг бүртгэхэд гэмтэл авсанаас хойших 30 хоногийн хугацааг мөрдөх, хөнгөн хэлбэрээр гэмтсэн хүнийг заавал бүртгэх тогтолцоог бий болгох, хөдөлгөөний аюулгүй байдлыг илэрхийлэх тоон үзүүлэлтийг цуглуулах аргачлалыг боловсруулж нэвтрүүлэх гэх мэт/

Согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн эсэхийг шалгаж тогтоох арга зүйг боловсронгуй болгож, холбогдох байгууллагуудыг шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангах;

Тээврийн хэрэгслийн оношлогооны чанар, хариуцлагыг дээшлүүлэх тогтолцоог бий болгохын зэрэгцээ зам тээврийн осол, хэрэгт холбогдсон тээврийн хэрэгслийн техникийн байдлыг нарийвчлан шинжлэх, дүгнэлт гаргах лабораториудыг байгуулах;

Замын тэмдэг, тэмдэглэл, гэрэлтүүлэг, хурд сааруулагч, эсрэг урсгалыг тусгаарлах хашлага хайс, явган зорчигчийн гарам, хөдөлгөөнийг зохицуулах ухаалаг систем, хяналтын камер зэрэг техник хэрэгслийн шаардагдах тоо хэмжээг судлан тогтоож, шийдвэрлэх;

Улаанбаатар хотын авто замын сүлжээний зохион байгуулалтыг шинжлэх ухааны үндэслэл, судалгаатайгаар өөрчлөх, шинэчлэн тогтоох, авто зам барих засварлах ажлыг нэгдсэн бодлогоор уялдаатай зохион байгуулах;

Хот суурингийн доторхи болон хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх нэгдсэн бодлого төлөвлөлт бий болгож хөгжүүлэх;

Захиргааны зөрчилд торгуулийг бэлэн бусаар ногдуулах тогтолцоог бүрдүүлэх, зөрчил бүрт торгуулийн зохистой тоо хэмжээг тогтоож мөрдүүлэх зэрэг зөвлөмжүүд нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлууд зайлшгүй болохыг төр засгийн хэмжээнд гарган тавьж байгаа томоохон ажил юм.

Зөвлөмж

Одоогийн байдлаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, зохицуулах асуудлуудыг ганцхан Замын цагдаагийн газрын хариуцан явуулдаг үйл ажиллагаа биш гэдэг ойлголт нэгэнт ард иргэдийн оюун санаанд төлөвшсөн чөлөөт нийгэмд энэ ажил нь бүх нийтийн үйлс болоод байгаа юм.

Хийгдэх ажлуудыг дараах байдлаар хийж гүйцэтгэх нь чухал гэж үзэж байна. Үүнд:

1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр

- Зам, гүүр барих, засварлах, арчлах байгууллагуудын стандарт, үйл ажиллагааг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах стандарт, үйл ажиллагаатай холбож, ажлын уялдаа холбоотой ажиллах шаардлагатай

- Мэргэжлийн байгууллагуудын мэдээлэл судалгаа зөрөөтэй байгаад дүгнэлт хийж, энэ замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр хамтарсан эрдэм шинжилгээний ажил, онол практикийн бага хурал, семинаруудыг бүхий л хүрээнд чанартай, шинэлэг, бүтээлч байдлаар өрнүүлэх

-Жолооч нарын чадварыг дээшлүүлэх зорилгоор эдийн засгийн болон менежментийн олон талт арга хэмжээнүүдийг зарлан явуулах

-Замын хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл, тэмдэг тэмдэглэгээний ашиглалтанд хяналт тавьж, тэдгээрийн үүрэг гүйцэтгэж байгаа стандартыг шинэчлэх

- Зам дээр хөдөлгөөн зохицуулах эрх бүхий алба хаагч нарын ажил үүргийн хуваарьт шинэчлэл гаргах. Тухайлбал, 2 автомашин шүргэлдсэн жижиг зам тээврийн ослын үед хэргийн газарт бүдүүвч зураг үйлдэхэд заавал офицер байцаагч байх шаардлагагүй, түргэн шуурхай шийдвэрлэхэд тухайн цагт зохицуулагч үйлддэг болгох гэх мэтчилэн

- Замын түгжрэл бий болсон үед түүнийг шинжлэх ухааны онолын үндэстэйгээр зөв зохицуулах ажлыг захиргааны хүрээнд төлөвшүүлэх

-Замын түгжрэлээс үүдэн эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг үр дагавар, эдийн засгийн хор хохиролыг шинжлэх ухааны үндэстэй судалгаа хийж, дорвитой арга хэмжээ авах.

2.Сургалтын чиглэлээр

Замын хөдөлгөөн зохицуулах байгууллагын алба хаагч нарын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, шинжлэх ухаан техникийн шинэ дэвшилтэд технологийг тэдэнд зааж сургах мөн ард иргэд, байгууллагад замын хөдөлгөөний нөхцөл байдлыг танилцуулж замын хөдөлгөөний тухай хууль тогтоомжуудыг судлуулж мөрдүүлсэнээр зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлнэ:

• Хөдөлгөөн зохицуулах мэргэжлийн алба хаагч үндсэндээ бэлтгэгдээгүй гэж үзэж болно, учир нь эрх зүйн болон техникийн чиглэлээр замын хөдөлгөөн зохион байгуулах баклавар болон түүнээс дээш боловсролын зэргийн дагнасан сургалттай болох, техникийн их сургууль болон дотоод хэргийн их сургууль дээр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх анги нээх

- Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах сургалтын хөтөлбөрүүдийг хөдөлгөөнд оролцогчийн нас болон хууль дүрмийн хүрээнд хүлээх үүрэг хариуцлагаар нь ангилан шинээр боловсруулах;

- Нийтэд чиглэсэн замын хөдөлгөөний хууль дүрмийн сургалт, сурталчилгааны ажлуудыг өргөн хүрээтэй, хүртээмжтэй, тодорхой зорилготой явуулах;

- Хүүхдэд багаас нь замын хөдөлгөөний дүрмийн шат дараалсан мэдлэг олгох, хөдөлгөөнд зөв оролцох дадал эзэмшүүлэх сургалтын тогтолцоог бүрдүүлэх;

- Жолооч бэлтгэх сургалт, давтан сургалтын чанарыг дээшлүүлэх;

- Жолоочийн мэргэжлийн шалгалт авах, жолоодох эрхийн үнэмлэх олгох үйл ажиллагаа, жолоочийн болон зөрчлийн бүртгэлийн системийг олон улсын түвшинд хүргэх;

- Онцгой нөхцөл байдлын үүрэг гүйцэтгэдэг алба хаагчидын \ түргэн тусламж, цагдаа, ОБ-ын алба \ автомашин жолоодох ур чадвар, тэдгээрт зориулагдсан тусгай хөтөлбөр боловсруулан, сургалтын хүндрүүлсэн автодром байгуулан сургалт явуулах,

- Ослын үед хохирогчид эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх мэдлэг дадлагыг бүх насны хүмүүст олгох тогтолцоо, сургалтын бааз бий болгох,

- Техник технологийн дэвшилтэт эрин үед ОХУ, БНХАУ, Казахстан зэрэг улсуудад Замын хөдөлгөөн зохицуулах цагдаагийн захиргааны үйл ажиллагааг, төрийн хэмжээнд зэрэгцээ байдлаар авч үздэг туршлагыг судлах нь зайлшгүй шаардлагатай байна.

БИЧИГ СУДЛАЛЫН ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ НОТЛОХ БАРИМТЫН ЭХ СУРВАЛЖ БОЛОХ НЬ

Батжаргалын Эрдэнэхүү

ШШҮХ-ийн Криминалистикийн шинжилгээний хэлстийн
шинжээч, магистрант, цагдаагийн ахлах дэслэгч

Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь аливаа гэмт хэргийг шуурхай бүрэн илрүүлж, гэмт этгээдийг олж тогтоох, гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт зохих ялыг шударгаар оногдуулах, гэм буруугүй хэнийгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байхын тулд аман хийсвэр нотлох баримтаас илүүтэйгээр шинжлэх ухааны үндэстэй нотлон тогтоох зорилтыг хангахад криминалистикийн шинжлэх ухаан хамгийн чухлаар тавигдаж байна. Орос улсын криминалист Р.С.Белкин “Криминалистик нь гэмт хэргийн механизмын зүй тогтол, гэмт хэрэг болон түүнд холбогдсон этгээдүүдийн талаархи мэдээлэл үүсэх болон нотлох баримтуудыг цуглуулах, судлах, ашиглах зүй тогтол зэргийг судалж, мөрдөн байцаах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай арга, хэрэгслийг боловсруулдаг шинжлэх ухаан юм.”²¹⁹ гэж тодорхойлсон байдаг.

Кримианлистикийн бичиг судлал, гарын үсгийн шинжилгээ нь практикт 2006-2011 он хүртэлх хугацаанд нийт хийсэн шинжилгээнээс 8% эзэлж байгаа бөгөөд харьцуулах, оношлох болон техникийн шинжлэх ухааныг хослуулсаны үндсэн дээр шинжилгээ томилох эрх бүхий этгээдийн томилсон асуултанд шинжлэх ухааны үндэслэлтэй, нотолгооны ач холбогдол өндөртэй дүгнэлт гаргаж өгөхөд оршино. Бичиг судлалын шинжээчийн дүгнэлт нь бусад эд мөрийн баримтуудын зэрэгцээгээр иргэний болон эрүүгийн хэргийн бодит үнэнийг тогтооход шийдвэрлэх нотлох баримт болж өгдөг.

Бичгийн шинжилгээний үүсэл нь эртний Ромд манай тооллын 534 онд гарсан Юстиниангийн хуульд төрийн албаны тангараг өргөсөн хүмүүсийн бичгийн хэвийг харьцуулж хуурамч эсэхийг тогтоох бололцоотой гэж үзсэнээс улбаатай.²²⁰

Орос оронд анхны шинжилгээг 1508 онд Федров гэгч хүний нас барсаны дараагаар түүний эхнэр Анна нөхрийнхөө амьд ахуйд байхдаа бусдад худалдсан тосгоныг өгөхгүй гэж түүний хийсэн гэрээг хуурамч гэж маргасан хэрэг дээр шүүх шинжилгээ томилж асуудлыг шийдвэрлэж байжээ.²²¹

Харин Монгол орны хувьд 1930 оны 11 дүээр сарын 1-ний өдөр Дотоодыг хамгаалах газраас Ц.Доноров, судар бичгийн хүрээлэнгээс Д.Нацагдорж, Я.Цэвэл нар хамтран “Авзага” хайрхан уулын хошууны Аюушжаваас бусдын нэрийг барьж хүнд ноцтой үг үсэг бүхий бичиг зохиосныг анхны бичиг судлалын шинжилгээгээр нотолж дүгнэлт гаргаж байсан түүхтэй билээ.

Мөн шүүхийн шинжилгээний байгууллагад хийгдсэн криминалистикийн бичиг судлал, бичиг техникийн шинжилгээг криминалистикийн бусад төрлийн шинжилгээтэй тоон үзүүлэлтээр болон хувиар харьцуулан харуулав. \графиг№1,3\

²¹⁹ “Криминалистика” ред Р.С.Белкин 1992 год Москва

²²⁰ Ж.Хурцгэрэл “Криминалистик 1” УБ хот 2002он 402 дахь тал

²²¹ С.Бадарчи “Кримианлистикийн бичиг судлал” УБ 1989он 14 дэхь тал





График №1

2006-2011 он хүртэл хийгдсэн бичиг судлал, гарын үсгийн шинжилгээний хоорондын өсөлт бууралтыг тоон илэрхийллээр \график №2\ дүрслэн харуулав.



График №2



Бичиг судлал, гарын үсгийн шинжилгээний онцлог

Шинжилгээнд зарцуулж байгаа хугацаа бусад шинжилгээг бодвол харьцангуй богино хугацаанд хийж болдоггүй. Шинжлэгдэж буй зүйл болон шинжилгээнд ирүүлсэн загваруудыг шинжээч өөрийн дадлага туршлага, тусгай мэдлэгийн хүрээнд тал бүрээс нь бүрэн судалж, шинжлэх ухааны үндэслэлтэй дотоод итгэл үнэмшилд тулгуурласан дүгнэлт гаргадаг. Иймд шинжээчийн дүгнэлтийг хугацаагаар шахах нь дүгнэлт үнэн бодитой гарахад сөрөг нөлөөтэй.

Шинжээчийн дүгнэлт нь тусгай мэдлэг шаарддаг, нарийн чимхлүүр ажил учир түүний үнэн бодит байх нь шинжилгээнд ирүүлсэн объектоос шалтгаалдаг нь хэн бүхэнд тодорхой. ШШТХ-ийн 6.1.7-т “Шинжилгээний объект гэж шинжилгээ хийж байгаа ул мөр, эд мөрийн баримт, бичиг баримт, эд юмс, амьтан, хүний бие, цогцос болон түүний хэсэг, харьцуулан судлах хэв загвар, хэргийн бусад материал”²²²-ыг ойлгоно заасан байдаг.

Бичиг судлал, бичиг техникийн шинжилгээнд доорхи бэрхшээлтэй асуудлууд байгааг дурдвал:

- Шинжилгээний зүйлсийг эх хувиар нь бус хуулбар хэлбэрээр ирүүлдэг.
- ШШТХ-ийн 24.1-гд “Криминалистикийн шинжилгээнд шинжилгээний объект, бусад шаардлагатай баримт материалыг эх хувиар нь ирүүлнэ” гэж заасан.
- Шинжилгээний харьцуулах загвар нь тоон болон чанарын үзүүлэлтээрээ адилтгалын шинжилгээний шаардлага хангахгүй буюу дутуу ирүүлдэг. Тус хуулийн 10.4.1-гд “Шинжилгээ хийхэд шаардагдах тоо, хэмжээ, чанарын үзүүлэлтийг хангасан байх” гэж тус тус заасан байна.
- Давтан шинжилгээнд ирүүлж буй харьцуулах загварууд нь өмнөх шинжилгээнд ирүүлж байсан загваруудаас өөр байдаг зэргээс шалтгаалж шинжээчийн дүгнэлтүүд зөрүүтэй гарах нэг шалтгаан болж байна.
- ШШТХ-ийн 10.3-т “Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь шинжилгээний объектыг шинжилгээ хийх байгууллага, шинжээчид хүргүүлэх боломжгүй бол шинжээчийг шинжилгээний объектод чөлөөтэй нэвтрэх, шинжилгээ хийх нөхцлөөр хангах үүрэгтэй”²²³ гэж заасан байдаг боловч архивт байгаа объект дээр шинжилгээ хийх лабораторийн нөхцөл бүрдэхгүй байгаа нь шинжилгээ хийхэд шинжээч нарт хүндрэл учирч байна.
- ШШТХ-ийн 21-т “Шаардлагатай тохиолдолд шинжилгээг ижил буюу өөр өөр мэргэжлийн хоёроос дээш шинжээчийн бүрэлдэхүүнтэйгээр хийж болно.” гэж заасан байдаг. Бүрэлдэхүүнтэй шинжилгээ хийлгэхдээ 2-оос дээш шинжээчийн бүрэлдэхүүнтэй томилно гэдэг нь 3 шинжээчийн бүрэлдэхүүнтэй буюу сондгой тоогоор шинжээч томилж байгаа нь 2 шинжээч санал зөрөлдвөл 3 дахь нь хагална гэж ойлгогдож байна. Энэ нь шинжилгээний шинжлэх ухааны үндэслэлээр биш шинжээчийн тоогоор асуудлыг шийдвэрлэхийг оролдож байгаа энэ хуулийн алдаатай заалтыг засах хэрэгтэй болов уу.

ЭБШХ-ийн 85.4-т “Шинжээчийн дүгнэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх заавал баримтлах үүрэггүй боловч дүгнэлтийг зөвшөөрөхгүй байгаа бол үндэслэлээ заасан байвал зохино” гэжээ энэ байдал практик дээр эргэлзээтэй байдаг. Шинжээчийн дүгнэлт нь шүүхээр шийдэгдсэн хэрэгт үндэслэсэн эсэх талаар судалгаа хийх шаардлага тулгарч байгаа боловч Нийслэлийн шүүхийн харьяа иргэний хэргийн архивт хадгалагдаж байгаа иргэний хавтаст хэргүүд дээр судалгаа хийхэд хязгаарлагдмал байна. Учир нь архивт буй хэргийн эмх цэгц, бүртгэл боловсронгуй бус байгаагаас шалтгаалж хэргийн хавтас олдохгүйд хүрч байна.

²²² Тус хуулийн 6.1.7 зүйл

²²³ Тус хуулийн 10.3 зүйл

Тиймээс Улсын ерөнхий прокурорын дэргэдэх эрүүгийн хэргийн төрөлжсөн архив болон Нийслэлийн шүүхийн харьяа иргэний хэргийн архив, холбогдох бусад архивуудын бүртгэлийг цогц байдлаар боловсронгуй болгох шаардлагатай юм.

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 6.1.1-т “Шүүхийн шинжилгээ гэж эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид заасан тусгай мэдлэг шаардсан асуудал /шинжлэх ухаан, техник, урлаг, соёл, нягтлан бодох бүртгэл зэрэг/-ыг шийдвэрлэхийн тулд шинжилгээний объектод шинжилгээ хийж дүгнэлт гаргах ажиллагааг” ойлгоно гээд 6.1.5-т “Шинжээчийн дүгнэлт гэж шинжээч өөрийн тусгай мэдлэгийн хүрээнд хийсэн шинжилгээний явц, үр дүнг тусгасан нотлох баримтын эх сурвалж болох баримт бичгийг тус тус ойлгоно” гэж заасан байна.

Ийнхүү хууль зүйн хүрээнд шинжээчийн дүгнэлт нь нотлох баримтын эх сурвалж болох тухай тодорхой тусгагдсан байна. Нотлох баримтыг үнэлэх нь танин мэдэхүйн төрөл бүрийн аргуудыг өөрийн эзэмшсэн мэргэжил, ажлын ур чадварын үндсэн дээр нотлох баримтын шинж байгаа эсэхийг тодорхойлох, нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэх, шалгах, хэрэглэх явцад болон эрүүгийн хэргийн нотлох цогц үйл ажиллагаанд бүхэлд үнэлэлт дүгнэлт өгч байгаа сэтгэхүйн үйл ажиллагаа юм.²²⁴

Мөн практикт шинжилгээ томилох эрх бүхий этгээдүүд нь шинжээчид урьд хийгдсэн шинжилгээний дүгнэлт үндэстэй эсэх гэсэн асуулт тавих нь цөөнгүй байна. Энэ асуултанд шинжээч нь өөрийн шинжээчийн зүгээс дүгнэлт үндэстэй эсэхэд хариулт өгөхгүй. Учир нь шинжээч нь шинжээчийн дүгнэлтийг үнэлэх этгээд биш юм. Шинжээчийн дүгнэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч, прокурор үнэлэх бөгөөд дараах шалгууруудыг харгалзан үзэх шаардлагатай. Үүнд:

Хууль зүйн шалгуур, шинжлэх ухааны шалгуур, техникийн шалгуур, дүгнэлт гаргасан шинжээчийн тусгай мэдлэг, дадлага, туршлага, боловсролын зэрэг, шинжилгээний аргачлал болон журмыг нэг бүрчлэн мөрдөж гаргасан, шинжлэгдэж буй шинжилгээний ерөнхий болон дахин давтагдашгүй хувийн онцлог шинжүүдийг бүрэн дүүрэн гаргаж нэгтгэн дүгнэж чадсан эсэхийг харгалзан үнэлэх нь чухал юм.

²²⁴ Г.Б.Батзориг “Гэмт хэргийн нотолгооны ерөнхий онол” УБ хот 2002 он 254 дэхь тал

ЭРҮҮГИЙН ОРЧНЫ НИЙГЭМД ХАРШ СУРГАН ЗҮЙ

Л.И.Беляева

ОХУ-ын Гавъяат хуульч, ОХУ-ын ДЯЯ-ны Удирдлагын академийн
профессор, хууль зүйн шинжлэх ухааны доктор

(Орос хэлнээс орчуулсан С.Нармандах, ДХИС-ийн Гадаад хэлний төвийн
ахлах багш, цагдаагийн дэд хурандаа)

Хүн гэдэг нь амьдрах, үйл ажиллагаа явуулах, хөгжихийн тулд өөртөөгөө адил хүрээлэл, тэдэнтэй харилцах тогтолцоог шаарддаг нийгмийн бүтээл юм. Хувь хүний оршин байгаа орчин түүнийг төлөвшүүлж, хөгжүүлж, хүмүүжүүлдэг.

Эрүүгийн орчин гэдэг нь хэсэг иргэдийн гаж байдлаар хөгжих, эрүүгийн зан үйл бүрэлдэн тогтох, гэмт хэрэг үйлдэх, мөн гэмт амьдралын хэв маягт шилжихэд нөлөөлдөг, хууль бус, нийгмийн эсрэг зан үйлийг гүн ухаан, ертөнцийг үзэх үзэл, амьдрах хэв маяг болгож сонгосон хүмүүсийн амьдрал үйл ажиллагааны бүхий л онцлогийг хэлэх юм.

Уламжлалт ойлголтоор бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн зан үйлийн хэм хэмжээний үндсэн дээр нийгмийн харилцааг тогтоож, нийгэмд хэрэгтэй бие хүнийг төлөвшүүлдэг орчныг хүмүүжүүлэх ач холбогдолтой орчин гэж үздэг. Тийм учраас бүх нийтийн хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, дүрэм, зарчимд харшилсан орчинг сурган хүмүүжүүлэх шинжлэх ухаанд харш орчин гэж үздэг. Учир нь энэ нь ёс суртахууны, иргэний, хүнийг хайрлах болон бие хүний бусад зан чанарыг төлөвшүүлдэггүй юм.

Аливаа орчин хүмүүжүүлэх нөлөөтэй байдаг. Үүнд: эрүүгийн орчин мөн багтана. Энэ эрүүгийн орчин нь тохиолдлын чанартай оршин тогтнодоггүй гэдгийг тэмдэглэх шаардлагатай. Тэрээр өөрийн бүтэц зохион байгуулалттай, “хэм хэмжээний, сурган хүмүүжүүлэх онцлогуудтай байдаг” нь нийгэмд харш эрүүгийн сурган зүй гэж байдаг болохыг харуулж байна.

Эрүүгийн сурган хүмүүжүүлэх зүй гэсэн ойлголтыг 2 утгаар хэрэглэдэг: нийгмийн амьдрал болон хэсэг иргэдийн дунд орших бодит байдал ба энэ бодит байдлын тухай сурган зүйн шинжлэх ухааны мэдлэгийн салбар юм.

Эрүүгийн сурган зүй нийгэмд бодитойгоор дараах байдлаар оршдог.

1. Хүмүүсийн ухамсар, мэдрэмж, сэдэлд гаж сэтгэл зүйн нөлөө үзүүлж, сурган зүйн хувьд тэдний хүмүүжил, хөгжил, боловсролд нөлөөлсний улмаар тогтвортой эрүүгийн зан үйл амьдралын хэв маягт өдсөн зөвхөн эрүүгийн орчинд байдаг хүчин зүйлүүдийн тогтолцоо. Энэ нь хэсэг иргэдийн амьдрал үйл ажиллагааны нийгэм, сэтгэл зүйн уур амьсгалыг “эрүүгийн” хувьд хордуулах, эрүүгийн эсрэг дархлаа, ёс суртахууны хэм хэмжээ, шударга хуульд захирагддаг өмнө нь бүрэлдэн тогтсон зарчмуудыг сулруулах байдлаар илэрдэг”.

2. Эрүүгийн ертөнцийн лидерүүдын ухамсарласан, тусгайлан зохион байгуулагдсан, сурган хүмүүжүүлэх шинж чанарыг агуулсан үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл шинэ гишүүдийг элсүүлэх, гэмт ертөнцийн ёс журмаар тэднийг хүмүүжүүлэх, сургах, хөгжүүлэх, өөрсдийн байр суурь, нөлөөг батжуулах, мөн гэмт аргаар баяжих зорилгодоо хүрэхийн тулд тааламжтай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн байдаг.

Эрүүгийн ертөнцийн энэ үйл ажиллагааны гол хандлага нь өөрсдийн энэ ертөнцөөс гадуур байдаг, тухайлбал төрийн алба хаагч /тэдний авлигад автуулах/, төрөл бүрийн байгууллага, газрын ажилтнууд, залуучууд, өсвөр насныхан, иргэдэд нөлөөлөх явдал юм. Улам бүр зохион байгуулалттай, эрчимтэй шинж чанартай болж байгаа эрүүгийн ертөнцийн лидерүүдийн үйл ажиллагааны энэ хөгжил нь тэднийг нэгдэн нягтруулах, гэмт явдалд автуулах замаар төр нийгмийн амьдрал үйл ажиллагаанд

өөрсдийн гүйцэтгэх үүрэг, нөлөөллийг хүчтэй болгох, засгийг өөрийн эрх мэдэлд оруулах хүчин чармайлтаар илэрч байдаг.

Эрүүгийн ертөнцийн төлөөлөгчдийг хүмүүжүүлэх үйл ажиллагаа нь нийгэмд харш боловч зорилго, арга зүй, хэрэгсэл, объект, субъект зэрэг сурган хүмүүжүүлэх зүйн үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсгүүд илт харагдаж байгаа юм.

Дэлхийн эрүүгийн ертөнцийнхний лидерүүд нь өөрсдийн нөлөөний зорилго, хүсч буй үр дүнгийнхээ талаар ялангуяа насанд хүрээгүй хүүхдүүд, залуучуудад хэрхэн нөлөөлөх талаар нэлээд тодорхой ойлголттой байдаг²²⁵. Эдгээр зорилгуудад хуулийн эсэргүүцэн зогсож байгаа хүний мөн чанар, түүнийг хөдөлгөгч хүчин зүйлийн талаарх гүн ухаан, ёс суртахуун, гоо зүйн төсөөлөл тусгалаа олдог. Тухайлбал, эдгээр зорилгуудад:

- Авторитар, бие хүнийг дарангуйлахад чиглэгдсэн эрүүгийн ертөнцийн гишүүдийн хоорондын харилцаанд эрэмбэ тогтоох. Тодорхой хүрээний хүмүүст давуу байдлыг бий болгох, тогтоосон дүрэм журамд хатуу захирагдах;
- Амиа бодсон зөвхөн ашиг олоход чиглэгдсэн, өөрийн болон гэмт бүлэглэлийн эрх ашгийг хамгаалах;
- Гоё ганган, хөнгөн, чинээлэг амьдралыг гэмт аргаар олж болохыг сурталчилж байгаа гэмт романтик хандлага;
- Эрх мэдлээ гайхуулах, аливаа тэрс үзэл ба ардчилалыг нугачин дарах, хувийн зорилгодоо хүрэхэд саад болж байгаа тогторыг устгахын тулд ямар ч харгислалыг хийхэд бэлэн хүчтэй бие хүнийг тахин шүтэхтэй холбоотой неофашист үзэл;
- Сул дороо хүмүүсийг гутаан доромжлох, лидеруудад тал засах хандлага зэргийг хамааруулдаг.

Эрүүгийн харш сурган хүмүүжүүлэх зүй бие хүнийг магтан өргөмжлөх, бие хүний бололцоог хэрэгжүүлэх нөхцлийг хангахад бус, харин бие хүнийг ёс зүйн хувьд уруудан доройтох, хэт бүдүүлгээр ойлгож буй ашгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн байдаг. Эдгээр нөлөөлөл нь иргэний, ёс суртахууны, энэрэнгүй ёсны, ардчилалын, хүн хүнээ хайрлах, соелын болон хүний бусад нийтлэг эерэг шинжүүдийг төлөвшүүлэхэд бус харин өөрийгөө хуулийн эсрэг чиглүүлсэн, нийгэмд харш амьдралын байр суурийг хатуу баримталсан, өөрийн үзэл бодол нэгтнүүдийнхээс өөр ямар ч шүүхийг хүлээн зөвшөөрдөггүй этгээдийг төлөвшүүлэн хүмүүжүүлэхэд чиглэсэн байдаг. Нийгэмд харш сурган зүйн агуулга, мөн чанар нь В.Ф.Пирожковагийн үнэлсний дагуу, залуучуудыг эрүүгийн ертөнцөд татан оруулах үндсэн арга, агуулга, гэмт бүлэглэлүүд нягтрах үндсэн механизм, бие хүн нийгэмших процессыг хүндрүүлж, гажуудуулах, гэмт зан үйлийг өдөөн дэвэргэсэн эрүүгийн, нийгэмд харш соелын гэмт ажиллагаанд татан оролцуулах байдлаар илэрдэг.²²⁶

Ийнхүү эрүүгийн ертөнц болон түүний сурган зүй нь ямар нэгэн романтик, гэм хоргүй тоглоом биш бөгөөд сурган хүмүүжүүлэх зүй болон нийгэмд харш шинж чанартай болохыг тодоор харуулж байгаа юм.

Эрүүгийн орчин нь өөрийн онолын хувьд одоохондоо тогтоогүй сурган хүмүүжүүлэх тогтолцоотой юм.

XX-р зууны сүүл үеэс В.М.Анисимков, И.П.Башкатов, Д.Брейтуэт, Б.Ф.Водолазский, Ю.А.Вакутин, А.И.Гуров, В.Ф.Пирожков, В.Фокс, П.Ханиган нар эрүүгийн орчны дотоод ертөнцийг судлах талаар маш идэвхтэй ажиллаж эхлэсэн юм.

Энэ чиглэлд хийгдсэн ажлуудад эрүүгийн орчин дахь хүмүүсийн хоорондын харилцаа, түүнийг зохицуулдаг хэм хэмжээ, дүрэм, түүнд гүйцэтгэж байгаа үүргүүдийн талаар ихэвчлэн бичсэн байдаг.

²²⁵ Лебедев СвЯв Традиции и обычаи в системе криминологической детерминации: Автореферв дисс... канд. Юр. Наук . – М., 1995 С. 19-21

²²⁶ Пирожкова. В.Ф. Законы преступного мира молодежи. Криминальная субкультура. С. 12

Нийгмийн энэ үзэгдлийг шинжлэх ухаан, сурган зүйн талаас тайлбарлах, судлах оролдлого зөвхөн бий болох үе шатандаа байна.

Эрүүгийн ертөнц нь хэзээ ч ердийн хүмүүсийн хүлээн зөвшөөрсөн хууль, үнэт зүйлс, хэм хэмжээгээр амьдардаггүйгээс гадна тохиолдлын харьцааг ч хүлээн зөвшөөрдөггүй. Тэрээр өөрсдийн бий болгож боловсруулсан зохион байгуулалт, зан үйлийн болон сурганы асуудлуудтай холбоотой хууль, хэм хэмжээ, дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. Тэдгээр нь агуулга, хэлбэрийн хувьд нийгэмд харш юм. Тухайлбал “өөрөө үхсэн ч нөхрөө авар” гэдэг нь эрүүгийн ертөнцөд гэмт хэргийг ямар нэгэн байдлаар заавал дуусгах эсвэл шүүн таслах ажиллагаанаас мултран зайлах гэсэн агуулгыг илэрхийлдэг.

Эрүүгийн орчинд байгаа хүмүүсийн гүйцэтгэж буй үүрэг, эзлэж байгаа байр суурь, хувийн нөлөөлөлтэй холбоотой эрэмбэ /иерархия/ чухал үүргийг гүйцэтгэдэг. Үүнд тодорхой байр суурийг эзлэхийн тулд тухайн хүн өөрийн хувийн зан чанарын хувьд тохирох, тодорхой байр суурь эзлэх зөвшөөрөлтэй байх, зохих чиг үүргийг гүйцэтгэж байх шаардлагатай байдаг. “Хулгайчин нэр төр”, “шоронгийн хууль” зэрэг эрүүгийн ертөнцөд бичигдээгүй хууль дүрэм нь иймэрхүү байдлаар харилцааг зохицуулах боломжийг олгодог. Одоо байгаа урамшуулах, хориглох, харгисаар шийтгэх тогтолцоо нь энэ харилцаа, сахилга батыг хатуу чанд баримтлах нөхцлийг бүрдүүлдэг.²²⁷

Өөрийн эгнээнд элсүүлэх, нийгэмд харш хүмүүжил олгох, гэмт хэрэгт мэргэшүүлэхэд гэмт ертөнцийн лидерууд сурган хүмүүжүүлэх зүйтэй бүтцийн хувьд дүйцэхүйц үйл ажиллагааны тогтолцоог хэрэглэдэг. Тэрээр зорилго, зорилт, агуулга, тодорхой нөхцөл, /тухайлбал, гэмт бүлэглэлийн гишүүдэд галын бэлтгэл хийлгэх, байлдааны мэх заах г.м./, арга зүй, хяналт үнэлгээний аргуудтай байдаг боловч өнөөгийн байдлаар хуулийн сурган зүйн шинжлэх ухаан үүнийг бага судласан байна. Гэхдээ ийм тогтолцоо байдаг болохыг мэдэх нь зарчмын ач холбогдолтой учир нь эрүүгийн бүлэглэлийн гишүүдийн гэмт зан үйлийн учир шалтгаан зөвхөн гэр бүл, сургууль, ажил үйлдвэрлэл дээр байсан сурган хүмүүжүүлэх ажлын дутагдалд орших төдийгүй тэдний дунд тусгайлан зохион байгуулсан нийгэмд харш сурган зүйн тогтолцоо үр дүнгээ үзүүлж байдгийн илрэл юм.

Эрүүгийн ертөнцийн лидеруудын хүмүүжүүлэх үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж үзэхэд хүн төрөлхтөн эрт дээр үеэс мэдэж байсан хэд хэдэн хүмүүжүүллийн зарчмуудыг нийгмийн эсрэг хандлагатай болгож, нийгмийн нийтлэг хэм хэмжээ, дүрмээс тусгаарлахад чиглэгдсэн байдлаар ашигладаг болохыг харуулж байна.

Тухайлбал: Чиг зорилготой байх гэсэн зарчмыг тухайн хүний амьдрал, идэвхтэй, хамтарсан үйл ажиллагаанд оролцохтой холбогдуулан хэрэгжүүлэх байдал ажиглагдаж байна. Тухайн хүн энэ эрүүгийн орчинд хөгжин дэвшиж болох тодорхой хэтийн төлөвийг харуулж, түүнийг ашиглах эрмэлзлэлийг хөхүүлэн дэмждэг учир гэмт явдалд гүнзгий автаж, гэмт харилцаа холбоо нь улам нягт болдог байна.

Сурган хүмүүжүүлэх ажлын уламжлалт төрлүүд болох үзэл бодол, ёс суртахууны хүмүүжил, хөдөлмөр, сахилга бат, сургалт зэргийг нийгмийн эсрэг чиглэгдсэн зорилго, агуулгатайгаар ашиглах явдал ажиглагдаж байна. Жишээ нь ёс суртахууны хүмүүжилд амьдралын үнэт зүйлс нь эрүүгийнхний үнэт зүйлс, толгойлогчид болон гишүүдийн ёс суртахууныг дээдлэх үзлийг төлөвшүүлэхэд анхаардаг байна. Гаж үзэл бодол, хэм хэмжээ, үнэт зүйлсийн тусламжтайгаар эрүүгийн ертөнцийн оршин тогтнох нөхцлийг бүрдүүлдэг, учир нь энэ нь эрүүгийн бүлэглэлүүдийн гишүүдийг нэгтгэж, холбож, нягтруулдаг юм. Эрүүгийн орчны “ёс суртахууны” үндсийг бэхжүүлэх зорилгоор “шоронгийн хууль” гэгчийг сурталчлах, дэлгэрүүлэх талаар маш идэвхтэй ажлыг юуны өмнө залуучууд, насанд хүрээгүй хүмүүсийн дунд зохион байгуулж байна.

Харилцааны, нууцлалын болон ертөнцийг үзэх үзлийн гэсэн хэд хэдэн чиг үүргийг гүйцэтгэдэг этгээд хэллэг нь криминологийн ач холбогдлоороо онцгой байр

суурийг эзлэдэг.²²⁸ Түүний тусламжтайгаар эрүүгийн орчинд тогтоосон зан үйлийн дүрэм, хэм хэмжээг “үеэс үед “ дамжуулж бэхжүүлж байх нь маш чухал гэж үздэг. Этгээд хэллэг нь түүнийг хэрэглэгчдийг нэгтгэн нягтруулж, нийтлэг байдал, нэгдмэл ахан дүүст хамаардаг болохыг харуулахын зэрэгцээ бусдын эсрэг тавьж, тэдний “нууц хэл” болдог байна. Хэл нь хүний ёс суртахууны , амьдралын приоритетын тогтолцоог тусгадаг төдийгүй бүрэлдэн тогтоодог билээ. Эрүүгийн этгээд хэллэг нь сурч буй этгээдэд ертөнцийг үзэх гаж үзлийг бүрдүүлж, бие хүний үзэл суртал, ёс суртахууны төлөвшилд шууд нөлөөлдөг байна. Эхэн үед этгээд хэллэг нэр томьёо нь өдөр тутмын ярианд нэвтрэн шингэдэг бол дараа нь түүнийг хэрэглэгчийн ухамсарт нөлөөлж, үзэл бодлын тогтолцоо, үнэт зүйлст өгөх үнэлгээг өөрчилж, хориотой зүйлсийг боломжтой, байх ёстой, нийгмийн гажуудлыг нэр хүндийн асуудал, танхайрлыг эр зориг, эрх чөлөө, харгислалыг шудрага ёс, хүйтэн хөндий сэтгэлийг биеэ барих чадвар мэтээр гаж ойлголт, үзэл санааг бий болгон төлөвшүүлдэг байна. Этгээд хэллэг ярианы нөлөөн доор ердийн амьдралын хэм хэмжээнээс холдож, нийгэмд харш үзэл бодол, байр суурийг идэвхтэй хүлээн авч ертөнцийг үзэх гаж үзэл бодлыг маш хурдтайгаар бүрдүүлдэг.

Эрүүгийн гэмт орчинд амьдарч үйл ажиллагаа явуулахад шаардлагатай шинж чанарыг гэмт бүлгийн гишүүдэд төлөвшүүлж бэхжүүлэхийн тулд маш идэвхтэй зөвхөн нийгмийн эсрэг чиглэсэн төдийгүй, эрх зүйд харш үйл ажиллагааг явуулдаг юм. Зөвхөн үүнийг л эрүүгийн орчинд “хөдөлмөр”, “үр ашигтай ажил”, эрүүгийн орчинд хамаарч түүнд үнэнч байгаагийн нотолгоо, түүнд уях хэрэгсэл гэж үздэг байна. Тухайлбал энэ нь гэмт хэргийн ул мөр, гэмт хэрэг үйлдсэн зэвсэг хэрэгслэл, хулгайлагдсан хүмүүсийг нуун дарагдуулах зэрэг байж болох юм. Эрүүгийн аливаа бүлэглэлийн гишүүн бүр нийтийн хэрэгт өөрийн хувь нэмрийг оруулах үүрэгтэй. Ухралт байж болохгүй ба үүрэг даалгаврыг тухайн хүмүүжиж байгаа хүний хувийн шинж чанар, нөхцөл байдлыг харгалзан өгдөг юм. Эрүүгийн шинжтэй энэ үйл ажиллагааны явцад шийдэмгий шаргуу байдал, хүсэл зориг зэргийг гаж байдлаар бүрдүүлэн төлөвшүүлдэг байна.

Үүнээс гадна гэмт ертөнцийн толгойлогчдын үзэж байгаагаар зайлшгүй устгах ёстой зан чанарт нинжин зөөлөн, өрөвдөж хайрлах сэтгэл хамаардаг ба түүний оронд харгис хэрцгий байдлыг хөгжүүлэхэд гол анхаарлыг хандуулдаг байна.

Эрүүгийн орчинд зан үйлийн гадаад хэм хэмжээг хатуу тогтоож, сахилга, дэг журмыг чандлан мөрдүүлснээр зорилгодоо хүрдэг. Сахилга дэг журам гэдэг нь гадаад болон дотоод харилцаанд шууд хамааралтай иж бүрэн шаардлага, хориг, хязгаарлалтууд юм. Эрүүгийн орчинд сахилга, харилцааны тодорхой дэгийг хатуу баримталдаг учир нь энэ нь оршин тогтнох тогтвортой байдлыг хангаж, шаардагдаж байгаа зан үйлийн зуршил, дадлыг бүрэлдүүлж, уламжлалыг цаашид хэрэгжүүлэн дэмжих нөхцлийг бүрдүүлдэг. Тухайн бүлэгт хамааралтай мэдээсэлтийн нууцыг задруулахгүй байх, өөрийн эзлэж байгаа байр суурийн дагуу биеэ авч явж, тодорхой үйлдлийг хийх, “толгойлогчдын” шаардлагыг үг дуугүй биелүүлэх, хам хэрэгтнүүдийг барьж өгөхгүй байх зэрэг үүрэгжүүлсэн болон хориглосон шаардлагуудын дагуу сахилга батыг тогтоодог байна. Ийм дэг журмын хэм хэмжээ нь тухайн орчинд хатуу тогтоосон харилцааг үүсгэж, тодорхой зан үйлийг хүний ухамсарт шингээж өгдөг юм. Тогтоосон дүрмийг зөрчсөн нөхцөлд торгууль оногдуулах, өрийн хэмжээг нэмэх, нэмэлт үүрэг ноогдуулах, зодох, тэр ч бүү хэл устгах зэрэг хатуу шийтгэлийг хэрэглэдэг байна. Д.С.Лихачевын тэмдэглэснээр : “хулгайчийн ” өөрийн орчин дахь зан үйл олон тооны хязгаарлалт, дүрэм, журам, захирагдалтын хатуу тогтолцоогоор хамгаалагдсан байдаг. Эдгээр хэм хэмжээг зөрчих тохиолдол бүрийг “хулгайчийн шүүхээр” шүүж , харгис хэрцгий ял шийтгэлийг тэр дор нь гүйцэтгэдэг байна. “Хулгайчийн орчин” тухайн хүний өмнө асар их эрх мэдэлтэй байдаг. Зан үйлийн гаднах задгай байдлын цаана хатуу, харгис, бүх зүйлийг нарийвчлан тооцсон зан үйлийн журам үйлчилдэг юм”.²²⁹

²²⁸ Пирожков. В.Ф. Указ. Соч. Гл. I

²²⁹ Лихачев Д.С. Черты первобытного примитивизма воровской речи // Язык и мышление. - М., Л., 1935. Вып. 3-4

Эрүүгийн орчинд сургалтанд их анхаарал хандуулдаг. Залуучуудыг гэмт хэрэг үйлдэх арга, ул мөрөө хэрхэн далдлах, шаардлагатай харилцаа холбоог тогтоох, хууль хамгаалах байгууллагын хараа хяналтаас хэрхэн зайлсхийх зэрэг олон зүйлд сургадаг юм. Дэлхийн улс орнуудад сүүлийн жилүүдэд эрүүгийн орчинд өөрийн тагнуул, бие хамгаалагчид, зэвсэг үйлдвэрлэгчид зэрэг байдгийг хүлээн зөвшөөрсөн юм. Ийм хүмүүсийг бэлтгэхийн тулд дотоод нөөц бололцоог ашиглахын зэрэгцээ өмнө нь аюулаас хамгаалах алба, зэвсэгт хүчинд алба хааж байсан хүмүүсийг ашиглан сургалт явуулах мөн тусгай албадын үйл ажиллагааны хэлбэр, аргын талаар хамгийн шинэ соргог мэдээлэл олох зорилгоор улсын тусгай сургуулиудад нэвтрэн ордог байна. Рэкет, биеийг нь үнэлүүлэх замаар ашиг олох зэрэг шинэ хэлбэрийн гэмт хэрэгт сургаснаар эрүүгийн гэмт үйл ажиллагаа улам хүчээ авч байна.

Залуучуудыг эрүүгийн гэмт үйл ажиллагаанд татан оролцуулах сурган зүйн аргууд:

Эрүүгийн орчин нь хуулинд харш зан үйлд автсан хүмүүст илүү хүчтэй нөлөөлж, улам гүн өөртөө автуулан уяж, нийгэм, сэтгэл зүй болон сурган зүйн хувьд бие хүний гажуудлыг улам гүнзгийрүүлдэг байна. Мэдээллийн олон нийтийн хэрэгсэл, телевиз, уран зохиол, дуу, хөгжим, хэлний соелд нэвтрэн орсноор хуулийг даган мөрддөж байсан боловч, тогтвортой бус, хүмүүжлийн доголдолтой, амьдралд муу бэлтгэгдсэн, хэрэглээнээс дээгүүр хэрэгцээгээр амьдрахыг эрмэлздэг хүмүүст муугаар нөлөөлдөг юм. Энэ нөлөө нь тохиолдлын бус санаатай, зорилго бүхий, зохион байгуулалттай шинж чанартай байдаг.

Гэмт ертөнцийн толгойлогчид, олон жил гэмт хэрэг хийсэн туршлагатай, хатуу тогтсон гаж үзэл баримтлалтай гэмт хэрэгтнүүд эрүүгийн орчныг бэхжүүлэх, идэвхжүүлэх, түүнийг эгнээг шинэ хүчээр хангах, үеийн залгамж холбоог үргэлжлүүлэх шаардлага байгааг ухамсарладаг юм. Эрүүгийн ертөнцийн лидерууд өөрсдийн аюулгүй байдлыг хангах, тэдний шууд заавар, эсвэл өдөөн хатгалгаар үйлдэгдсэн гэмт хэргийн төлөө эрүүгийн хариуцлагаас мултрах, хууль хамгаалах байгууллагын хараанаас далд байх, гэмт хэрэгт холбоотойг нотлох баримтыг тэдэнд өгөхгүй байх, өөрөөр хэлбэл “хүний гараар могой барихын ” тулд залуучуудыг гэмт үйл ажиллагаанд татан оролцуулах хүсэл сонирхолтой байдаг байна.

Зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдийн толгойлогчдын гэмт идэвхжил нь насанд хүрээгүй залуучуудыг өөрсөддөө захируулж, тэдний зан үйлд хяналт тогтоож, эрүүгийн гаж соел, зан үйлд татан оролцуулахад чиглэгдсэн байдаг. Эрүүгийн бүлгийн толгойлогчид, тэдний үүрэг даалгаврыг гүйцэтгэгчдийн анхаарал нэн түрүүнд хараа хяналтгүй, тэнүүлч, тогтвортой бус гэр бүлийн хүүхдүүд, өнчин хүүхдийн асрах газрын хүүхдүүд, ерөнхий боловсролын дунд сургуулиас хасагдсан, танхай, нийгмийн хэв журмыг зөрчигчид, согтууруулах ундаа эхлэн хэрэглэгчид, жижиг хэмжээний хулгай хийдэг хүүхдүүдэд чиглэгддэг. Эдгээр насанд хүрээгүй хүүхдүүд эрүүгийн гэмт зан үйлийн объект болдог байна. Шинээр элсэгчдийг өөрийн мэдэлд оруулах, сэтгэл зүйн хувьд нугачин дарахын тулд толгойлогчид тэднийг ивээлдээ байлгах, элдэв зүйл өгөх, тусламж, хамгаалалт үзүүлэх, хууран мэхлэх, сэтгэл зүйн дарамт үзүүлэх, айлган сүрдүүлэх, хүч хэрэглэх аргуудыг хэрэглэдэг байна. Эхэн үед шинээр элсэгчдийг борлуулагч, тагнуул, холбоочин, үүрэг даалгавар гүйцэтгэгчээр татан оролцуулж, харин “итгэл” хүлээсэн залуучуудыг гэмт үйл ажиллагаанд татан оролцуулдаг юм. Шинэ цаг үеэ дагалдан залуучуудыг байлдааны самбогийн төрлийн секцид хичээллүүлэх, өр буцаан төлөх ажиллагаанд “дасгалжуулах”, цагдаагийн үйл ажиллагаанд эсрэг үйлдэл хийх, тусгайлсан сургалтын байгууллагуудад илгээх /тухайлбал ДЯЯ-ны/ зэрэг шинэ аргуудыг хэрэглэж эхлэж байгаа талаар эрдэмтэн судлаачид бичсэн байна.

Мөн замбраагүй бусдын хөдөлмөрөөр амьдардаг мөнгөний гачаалтай хүүхэд , залуучуудад материаллаг тусламж үзүүлж тийм амьдралын хэв маяг руу улам уруу татаж өөрсдөөсөө хамааралтай байдалд оруулж, ихэвчлэн өрөө төлөх чадваргүй байдаг тул гэмт үүрэг даалгаврыг хүчээр хийлгэдэг байна. Залуу хүмүүсийн айдас хүүдсийг гэмт ертөнцийн толгойлогчдын нэр хүнд, итгэл үнэмшлээр далайлган арилгаж, тэдний

жишээ нь дээр хэрхэн эрүүгийн хариуцлагаас заавал зайлсхийж болох, эрх мэдлийн хүч гэж юу болохыг харуулдаг байна. Үүний зэрэгцээ залуучуудын дунд ёс суртахуунгүй, ёс зүйгүй, соелгүй байдал, завхрал, юу ч үл хийн дэмий сэлгүүцэх, үнэнч шудрага хөдөлмөрийг үл ойшоох үзэл бодлыг төлөвшүүлэх ажлыг туйлын зорилготой, гэвчээртэйгээр явуулсны үр дүнд олон тооны залуучууд хэрээсээ хэтэрсэн хэрэгцээгээ хангах боломжгүй болж, зээл авах, дээрэм тонуул, хулгай хийх эрүүгийн үйл ажиллагаанд оролцохоос өөр аргагүй болдог байна.

Уламжлалт сурган хүмүүжүүлэх зүйн нийтэд түгээмэл болсон итгүүлэн үнэмшүүлэх, зан үйлийг зохион байгуулах, урамшуулах, албадах аргуудыг эрүүгийн зорилго, агуулгатайгаар өргөнөөр ашиглаж байна. Үүний тулд эрүүгийн ертөнцийн “баатруудыг” даган дууриах хүсэл эрмэлзлэлийг төрүүлэх мэдээллийг уйгагүй тарааж, залуучуудыг “хулгайчийн амьдралын романтик”, “тансаг амьдрал”, мөнгө хөрөнгөний эрх мэдэл, хүчирхийлэлийг тахин шүтэх, гэр бүл, нийгмийн өмнө хүлээх ямар ч хариуцлага байхгүй эрх чөлөөт амьдрал руу уруу татдаг юм. Үүнийгээ итгэл үнэмшил болгох зорилгоор согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх ажиллагааг зохион байгуулалттайгаар хийх, гуйх, аргадах, зааварлах, сургамжлах аргыг хэрэглэхийн зэрэгцээ өс хонзон санах, уур хилэнг бадраах, гэмт ертөнцөд карьер хийж болох талаар сургаж уруу татдаг юм. Залуучуудыг эрүүгийн гэмт бүлэглэлд татан оролцуулж, барьж байх зорилгоор шантажлах, айлган сүрдүүлэх замаар сэтгэл зүйн дарамтанд оруулах, зээл өгөх, мөрийтэй тоглоом тоглуулан өрөнд оруулах, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэж сургах, биеэ үнэлэгч нартай холбож өгөх, зодож нүдэх зэрэг аргуудыг өргөнөөр хэрэглэж байна.

Бүхэлдээ залуучуудыг гэмт хэрэг үйлдэхэд татан оролцуулах эрүүгийн ертөнцийнхний үйл ажиллагаа нь насанд хүрээгүй этгээдүүдийн үйлдэж буй гэмт явдал өсөн нэмэгдэхэд чухал хүчин зүйл болох төдийгүй гэмт явдлыг бүхэлд нь хөгжүүлэхэд чухал үүргийг гүйцэтгэж, эрүүгийн орчны амь бөхтэй байдлыг хангаж өгч, түүний уламжлалыг хадгалан хөгжүүлдэг юм.

Ийнхүү эрүүгийн орчинд гэмт бие хүнийг хүмүүжүүлэх, сургах, хөгжүүлэх өөрийн өвөрмөц тогтолцоо оршин тогтнож байна. Энд нэг талаас хүмүүнлэг, нийгэмрүү чиглэсэн, бие хүнийг дээдлэн дэмжсэн сурган хүмүүжүүлэх зүй нөгөө талаас эрүүгийн, нийгмийн эсрэг чиглэсэн, бие хүнийг үгүйсгэн эвдсэн нийгэмд харш сурган зүй нь сөргөлдөн зогсож байгаа юм. Иймээс хууль хамгаалах байгууллагын үйл ажиллагаанд сурган хүмүүжүүлэх зүйн аргуудыг нэвтрүүлж, нийгэмд харш сурган хүмүүжүүлэх тогтолцоог бүхэлд нь задлан унагаах системтэй ажиллагааг эрж хайн хэрэгжүүлэх шаардлагатай байна

Эрүүгийн орчин гэдэг нь хууль бус, нийгмийн эсрэг зан үйлийг гүн ухаан, ертөнцийг үзэх үзэл, амьдрах хэв маяг болгож сонгосон хүмүүсийн амьдрал үйл ажиллагааны бүхий л онцлогийг хэлэх юм.

Эрүүгийн сурган зүй нийгэмд бодитойгоор дараах байдлаар оршдог:

Хүмүүсийн ухамсар, мэдрэмж, сэдэлд гаж сэтгэл зүйн нөлөө үзүүлж, сурган зүйн хувьд тэдний хүмүүжил, хөгжил, боловсролд нөлөөлсний улмаар тогтвортой эрүүгийн зан үйл амьдралын хэв маягт өдсөн зөвхөн эрүүгийн орчинд байдаг хүчин зүйлийн тогтолцоо.

1. Эрүүгийн ертөнцийн лидерүүдын ухамсарласан, тусгайлан зохион байгуулагдсан, сурган хүмүүжүүлэх шинж чанарыг агуулсан үйл ажиллагаа юм.

Нийгэмд харш зорилго, арга зүй, хэрэгсэл, объект, субъекттэй байх

- Эрүүгийн ертөнцийн гишүүдийн хоорондын харилцаанд эрэмбэ тогтоох.
- Өөрийн болон гэмт бүлэглэлийн эрх ашгийг хамгаалах;
- Гэмт романтик хандлага;
- Хүчтэй бие хүнийг тахин шүтдэг неофашист үзэл:

В.Ф.Пирожкова “Нийгэмд харш сурган зүйн агуулга, мөн чанар нь залуучуудыг эрүүгийн ертөнцөд татан оруулах үндсэн арга, гэмт бүлэглэлүүд нягтрах үндсэн

механизм, бие хүн нийгэмших процессыг хүндрүүлж, гажуудуулах, гэмт зан үйлийг өдөөн дэвэргэсэн эрүүгийн, нийгэмд харш соелын гэмт ажиллагаанд татан оролцуулах байдлаар илэрдэг”.

Сурган хүмүүжүүлэх зүйтэй бүтцийн хувьд дүйцэхүйц үйл ажиллагааны тогтолцоотой.

- Зорилго
- Зорилт
- Агуулга
- Тодорхой нөхцөл /тухайлбал, гэмт бүлэглэлийн гишүүдэд галын бэлтгэл хийлгэх, байлдааны мэх заах г.м./
- арга зүй
- хяналт үнэлгээний аргууд

Сурган хүмүүжүүлэх ажлын уламжлалт төрлүүд болох үзэл бодол, ёс суртахууны хүмүүжил, хөдөлмөр, сахилга бат, сургалт зэргийг нийгмийн эсрэг чиглэгдсэн зорилго, агуулгатайгаар ашиглах явдал ажиглагдаж байна.

Этгээд хэллэг нь харилцааны, нууцлалын болон ертөнцийг үзэх үзлийн гэсэн хэдхэдэн чиг үүргийг гүйцэтгэдэг.

Сахилга дэг журам гэдэг нь гадаад болон дотоод харилцаанд шууд хамааралтай иж бүрэн шаардлага, хориг, хязгаарлалтууд юм.

Эрүүгийн орчинд сургалтанд их анхаарал хандуулдаг:

- Өөрийн тагнуул
- Бие хамгаалагчид
- Зэвсэг үйлдвэрлэгчид зэрэг байдгийг хүлээн зөвшөөрсөн юм.

Залуучуудыг эрүүгийн гэмт үйл ажиллагаанд татан оролцуулах сурган зүйн аргууд:

- Зорилго бүхий, зохион байгуулалттай шинж чанартай
- Итгэл үнэмшил төрүүлэх
- Зан үйлийг зохион байгуулах
- Урамшуулах
- Албадах аргуудыг эрүүгийн зорилго, агуулгатайгаар өргөнөөр ашиглаж байна.

НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮҮХДИЙГ ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ, ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХ АРГА ЗАМ

Л.И.Беляева

ОХУ-ын Гавъяат хуульч, ОХУ-ын ДЯЯ-ны Удирдлагын академийн
профессор, хууль зүйн шинжлэх ухааны доктор

(Орос хэлнээс орчуулсан С.Нармандах, ДХИС-ийн гадаад хэлний төвийн
ахлах багш, цагдаагийн дэд хурандаа)

Тухайн цаг үед дотоодод төдийгүй гадаад улс орнуудад хүүхэд худалдах явдал ихээхэн газар авч байсныг тэмдэглэх шаардлагатай.²³⁰ Энэ нь маш сайн зохион байгуулагдсан, нууцлагдсан гэмт ажиллагаа байсан юм. Энэ бизнесийг эрхэлдэг бүлэглэлүүдийг “хар дээрмийн бүлэг” гэж нэрлэдэг байв. Биеийг нь үнэлүүлэх зорилгоор хүүхэд худалдаалах нь олон орны эрх ашгийг хөндөж байсан учир уг гэмт үйл ажиллагааг таслан зогсооход чиглэн зохион байгуулагдсан олон улсын форумууд дээр нэг бус удаа хэлэлцэгдэж байсан.²³¹

Дэвшилтэт эрдэмтэд, сурган хүмүүжүүлэгчид, олон нийтийн төлөөлөгчид уг гэмт халдлагын нийгмийн аюул, эрүүгийн хууль тогтоомжийн боловсронгуй бус байгаа зэргийг ухамсарлан харж дотоодын болон гадаад орны туршлагыг судлах тал дээр ихээхэн анхаарал хандуулж байлаа. Тухайлбал, В.М.Сорокин “Англи улсад хүүхдийг дэмий тэнүүлэх, ядууран гуйлга гуйх нөхцлийг бүрдүүлж байсан хүмүүст хуулийн дагуу хатуу хариуцлага тооцдог.

Америкт өөрийн хүүхдийг мөлжүүлэх зорилгоор бусдад өгсөн этгээдүүдэд их хэмжээний мөнгөн торгууль, хорих ял оногдуулах арга хэмжээ авдаг. Гэтэл манай орны хууль тогтоомжинд иймэрхүү зүйл огт алга” гэж тэмдэглээд гадаад орнуудын туршлагыг ашиглан энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж буй хүмүүст эрүүгийн хариуцлага хүлээлгэн насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөрийг ашиглах явдалтай тэмцэхийг уриалсан байна.²³² Харамхсалтай нь эдгээр санал санаачлагууд ямар ч анхааралгүй үлдэж, насанд хүрээгүй хүүхдийг худалдаалах гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэх хэм хэмжээг хуулинд зааж өгөөгүй байна.

Хууль тогтоомжийг хөгжүүлэхэд олон асуудал гарч байсан боловч хүүхэд хамгаалах салбарт эрүүгийн хууль тогтоомж хөгжин боловсронгуй болж байсныг тэмдэглэх хэрэгтэй. Тухайлбал, хувьсгалаас өмнөх хууль тогтоомжинд хүүхэд хулгайлах гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагын хэм хэмжээ аажмаар боловсронгуй болж байсан. Хууль тогтоогч нь хүүхэд хулгайлах гэмт хэрэгт шунахай зорилгыг онцлож түүндээ насанд хүрээгүй хүүхдийг худалдаалах явдлыг багтаасан байна. Гэхдээ уг хэм хэмжээг боловсронгуй болгох тал дээр ихээхэн ач холбогдол бүхий ажил хийгдсэн боловч хүүхэд худалдаалах гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг тогтоож өгөөгүй юм.

1917-1925 онуудад дайн, хувьсгал зэргээс шалтгаалан хуучин гэр бүлийн харьцаа сүйрч эхлэсэн. Олон зуун хүүхдийн эцэг эх дайны талбар, өвчин гамшигаас болж үрэгдэх, хөдөө тосгодын хүмүүс хот руу нүүн шилжих зэргээс шалтгаалан тэдгээр хүүхдүүд гэр бүлийн хэвийн нөхцөлд өсч хүмүүжих бололцоогүй болсон юм. Гэр бүл

²³⁰ Гаверс. Международная торговля девушками. М., 1892

Окориков В.П. Международная торговля девушками для целей разврата и меры к ее прекращению. М., 1892
Мордовцев Д. Живой товар. Постыдная международная торговля молодостью и красотой и меры против безнравственных совратителей женщин. М., 1893

Продажа девушек в дома разврата и меры к ее прекращению. М., 1899

²³¹ Дерюжинский В. Международная борьба с торговлей женщинами. Спб. 1914

Дерюжинский . Пятый международный конгресс по борьбе с торговлей женщинами. // Журнал министерства юстиции, 1914, № 1

²³² Сорокин В.М. Охран детства. – Спб., 1893. С. 53

сүйрэх асуудалд өлсгөлөн ихээхэн хувь нэмрээ оруулсан. Ийм ч учраас тэр үеийн олон сурган хүмүүжүүлэгч, хуульч эмч нарын анхаарал насанд хүрээгүй хүүхдийн нийгэм эрх зүйн хамгаалалтанд ихээхэн төвлөрсөн байв. М.Н.Гернет насанд хүрээгүй хүүхдийн нийгэм эрх зүйн хамгаалалт нь тухайн цаг үеийн эн тэргүүний зорилт мөн гэж үзэж байв. Учир нь 1922 оны 12 сарын 1-ний байдлаар ЗСБНХУ-ын 24 губернид 444 412 хараа хяналтгүй хүүхэд байсан юм.²³³

Энэ үед хууль тогтоох түвшинд уг асуудлаар тодорхой ямар нэгэн арга хэмжээ хийгдэхгүй байв. Тухайлбал эрүүгийн хууль тогтоомжинд энэ асуудлыг тойрч үлдээсэн байв. /1919/ Гэхдээ 1921 онд Москвад болсон насанд хүрээгүй хүүхдийн эрх зүйн хамгаалалтанд чиглэсэн бага хурал сонирхол татаж байгаа юм. Энэ хурал дээр хараа хяналтгүй хүүхдийн асуудалд ихээхэн анхаарал хандуулсан байв. Хараа хяналтгүй хүүхдийн тоонд мөн “эцэг эх, асран хамгаалагч буюу тэдгээрийг орлох хүмүүс эрх мэдлээ ашиглан насанд хүрээгүй хүүхдийг гэмт явдал, ядуурал гуйланчлал, завхайралд уруу татсан, эсхүл хүчээр оруулсан, эсхүл аялдан дагалдсан, эсхүл гуйлгачин, гэмт хэрэгтэн, доншууч дуулаач нарын мэдэлд өгсөн хүүхдүүдийг хамааруулсан” байв.²³⁴ Өнөө үед ийм хэлэлцээрийн тоо хэмжээг яг тогтооход хүндрэлтэй боловч тухайн үед Москва хотод хүүхдийн 40,4 % гуйланчилж байсан тухай баримт байдаг.

20-иод оны үед хүүхэд, өсвөр насныхны хувь заяатай холбоотой олон нэн чухал шийдвэрүүдийг эх хүүхдийг хамгаалах асуудлаар хуралдсан Бүх Оросын эрдэм шинжилгээ практикийн их , бага хурлууд дээр гаргаж байсныг тэмдэглэх хэрэгтэй. Жишээ нь, 1918 онд хүүхдийг хамгаалах Бүх Оросын их хурал, 1920 онд хүүхдийн хараа хяналтгүй байдалтай тэмцэх Бүх Оросын их хурал, 1923 онд хүүхэд өсвөр насныхны нийгэм эрх зүйн хамгаалалтанд чиглэсэн Бүх Оросын 2-р их хурал хуралдсан юм.

Эдгээр их хурлуудаас гаргасан заавар зөвлөмж нь хууль тогтоомжийг боловсронгуй болгоход ихээхэн үүрэг гүйцэтгэсэн юм. Эдгээр он жилүүдэд насанд хүрээгүй хүүхдийн нийгэм эрх зүйг хамгаалах байгууллагуудын улсын тогтолцоог бий болгох, тэдэнд туслах, хүмүүжүүлэх, сургах талаар ихээхэн ажил хийгдсэн юм. Гэхдээ 30-аад оны дунд үед хүмүүнлэг энэрэнгүй зарчмаас татгалзсан гэж хэлж болно. Учир нь эн тэргүүнд цээрлүүлэх, шийтгэх арга хэмжээг хэрэглэж байсан тул төрөөс иж бүрэн нийгэм-хүмүүнлэг хандлагыг шаардсан эдгээр асуудлыг үр дүнтэй шийдвэрлэхэд сөрөг нөлөө үзүүлсэн юм.

Насанд хүрээгүй хүүхдийн эрх, эрх ашгийг хамгаалах салбарт ЗСБНХУ-ын хууль тогтоомж боловсронгуй бус байгаа асуудлыг хөндөж В.И.Куфаев нь орчин үеийн эрүүгийн хууль тогтоомж нь насанд хүрээгүй хүүхэдтэй хамааралтай хэдхэн гэмт хэргийг зүйлчилсэн болохыг онцлон тэмдэглэжээ. Үүнд өсвөр насны хүүхдийн хөдлмөрийн тухай дүрмийг зөрчих /132 зүйл/, амиа хорлоход ухуулан ятгах /148 зүйл/, бусдын хүүхдийг хулгайлах, нуух эсхүл солих /162 зүйл/, тусламжгүй үлдээх /163 зүйл/, бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг /166, 168 зүйл/, биеэ үнэлэхэд уруу татах /171 зүйл/ зэргийг хамааруулжээ.

1926 онд насанд хүрээгүй хүүхдийн эрхийг хамгаалах талаар явуулах эрүүгийн бодлогын үндсэн чиглэлүүдийг тусгаж өгсөн Эрүүгийн хуулийг баталсан юм. Тухайлбал, ЗСБНХУ-ын 1926 оны Эрүүгийн хуулинд “шунахай сэдэлтээр, өш хонзон авах эсхүл бусад зорилгоор бусдын хүүхдийг хулгайлах, нуух эсхүл сольвол гурав хүртэл жилээр хорих ял оногдуулна” гэсэн зүйл оруулсан байв.

Ингэхдээ хулгайлах, нуух гэдэг нь зөвхөн 14 насанд хүрээгүй хүүхдэд хамааралтай бол 14 дээш насны хүүхэдтэй холбоотой дээрхи үйлдэл нь “хорих” гэсэн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг бий болгож байсан юм. /147 зүйл/ М.Н.Гернет, А.Н.Траинин нарын хянан тохиолдуулсан ЗСБНХУ-ын Эрүүгийн хуулийн тайлбарт “шунахай зорилгоор ” гэдгийг тухайн гэмт хэрэгтэн үйлдсэн этгээд гэмт хэргээсээ

²³³ Гернет М.Н. Указ. Соч. С.20

²³⁴ Гернет М.Н. Указ. Соч. С.20

материаллаг ашиг хонжоо олохоор тооцоолох явдал²³⁵ гэсэн байв. Үүнд хулгайлсан хүүхдийг худалдснаар ашиг олох гэсэн санаа багтаж байна гэж үзэж болох юм.

20-50 оны гэмт явдлын бүтцийг судлан үзэхэд төр улсын хөгжлийн эдгээр үе шатанд хүүхэд хулгайлах явдалтай тэмцэх асуудал хурцаар тавигдаж байгаагүйг харж болно. Жишээ нь ЗСБНХУ-ын Статистикийн Төв Газрын 1928 оны тоо баримтаар Эрүүгийн хуулийн 149 зүйлийн дагуу хүүхэд хулгайлсан, нуун дарагдуулсан, сольсон 19 тохиолдолд бүртгэгдсэн байна. ²³⁶ Хүүхэд хулгайлах нь ихэвчлэн хүүхэд олж өгсний төлөө шан харамж авах, хувцас хунар, авч явсан эд зүйлийг нь авах, гуйлга гуйлгах зорилгоор ашиглах зэрэгтэй холбоотой байв.

(Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүлийн 2011 оны № 4-р дугаарт хэвлэгдсэн нийтлэлийн үргэлжлэл)

²³⁵ УК РСФСР. Научно-популярный практический комментарий. / Под ред. М.Н. Гернета, А.Н.Трайнина.- М., 1927. С.223

²³⁶ Преступность и репрессии в РСФСР - М., 1930. С.26